



Ш.ОДОНТӨР

АРДЧИЛЛЫН

АНХНЫ ОН ЖИЛҮҮД

1989-1996

УЛААНБААТАР 2019 ОН



Ардчиллын анхны он жилүүд 1989–1996

Зохиогч: Ш.Одонтөр
Редактор: Ч.Цэрэнчимэд
Б.Цээпил
Н.Галбаатар

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Сэрээтэр

Хэвлэлийн хэмжээ: 148x210

Хэвлэлийн хуудас: 15.5хх

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

1980-аад оны дундуур дэлхийн социалист системийн зарим оронд нийгэм, улс төрийн шинжтэй тэмцэл, хөдөлгөөн гарах болж, хуучнаар БНМАУ-ыг өөрийн хараандаа бүрэн байлгаж байсан ЗХУ-д “өөрчлөн байгуулалт” гэж дуугарах болсон нь дэлхийн хоёр том лагерийн нэг социалист систем задрах үйл явцэх эхэлснийг харуулж байв.

Энэ үед социалист системийн орнууд, түүний дотор БНМАУ-д нэг намын хүчтэй дарангуйлал тогтчихсон, хүний эрх, эрх чөлөөний талаар ярих ч юмгүй, иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх нь хаагдмал, тэр бүү хэл иргэн хүн улс орон дотроо “зам явах”-гүйгээр (зөвшөөрөлгүйгээр) зорчих эрхгүй, эдийн засагт нь хувийн өмчийг хүлээн зөвшөөрдөггүй тийм хатуу чанга, хаагдмал нийгмийн тогтолцоо хүчтэй ноёрхож байсан билээ. 1980-аад оны сүүлчээр энэ бүхнийг өөрчлөх үзэл санаа БНМАУ-ын хилийн дээсийг аль хэдийн даваад орчихсон байв. 1989 оны 11-р сард хуралдсан Залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөгөөний уур амьсгал хүчээ авсаар бүр хөдөө орон нутагт ч хүрчихсэн байлаа.

1989.12.07-ны өдөр алс баруун хязгаар Ховд хотод багшийн дээд сургуулийн зарим багш, оюутнууд цуглаан хийж, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо, Сайд нарын Зөвлөлийг огцрохыг шаардсан өргөх бичгийг МАХН-ын Төв хорооны VII бүгд хуралд хүргүүлж байв.

Энэ үеэр Улаанбаатар хотод улс төрийн анхны байгууллага-Монголын Ардчилсан Холбоо (МоАХ)-г

байгуулсан хэсэг нөхөд маань Олон улсын хүний эрхийн өдөр 12-р сарын 10-нд анхны улс төрийн цуглаанаа хийхээр бэлтгэж байв. Тэд маань манай улсад өрнөсөн ардчилсан хувьсгалыг эхнээс нь эцэс хүртэл нь үргэлжлүүлэн тэмцэж, хожмоо ардчиллын алтан хараацайнууд гэгдэх болсон манай анхдагч партизанууд юм. МоАХ-г оюун санаа, хүн хүч, үйл ажиллагаагаараа улс төрийн тавцанд илээр гарч ирж дэмжсэн улс төрийн хоёр дахь хүчин нь 12-р сарын 28-нд байгуулагдсан багш нар голдуу сэхээтнүүдээс үүсэлтэй Ардчилсан Социалист Хөдөлгөөн байлаа. Дараагаар нь эдийн засагчдаас голдуу бүрдсэн Шинэ Дэвшилт Холбоо, мөн Монголын Оюутны Холбоонууд хүч түрэн орж ирж, Ардчилсан хүчнүүдийн эгнээг өргөтгөв. 1990 оны 3-р сарын 4-нд зохион байгуулсан Ардчилсан хүчнүүдийн анхны хамтарсан цуглаанд урьд өмнөхөөсөө даруй 3-4 дахин илүү буюу 90-100 мянган хүн оролцсон нь ардчилсан хувьсгалын түүхэнд хамгийн олон хүн оролцсон цуглаан болсон бөгөөд энэ цуглаанаас Ардчилсан хүчнүүдийн хамтарсан мэдэгдлийг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдэд болон МАХН-ын Төв Хороонд хүргүүлсэн юм. Гэсэн хэдий ч тэд өөрийн байр сууриа тавьж өгөхийг огтхон ч хүсээгүйгээр барахгүй МАХН-ын Төв Хорооны болон төр, засгийн төлөөлөгчид Ардчилсан хүчнүүдийн хамтарсан мэдэгдэлд дурдсан шаардлагуудыг хүлээн авах боломжгүй гэж хоёр хоногийн дараа буюу 3-р сарын 6-нд мэдэгдсэн нь манай тэмцэгчдийг улс төрийн тэмцлийн дээд хэлбэр болох “өлсгөлөн” зарлахад хүргэсэн билээ.

1990 оны 3-р сарын 7-нд эхэлсэн улс төрийн өлсгөлөнгийн үеэр хийсэн хэлэлцээрүүдийн үр дүнд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсон тухай МАХН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх 3-р сарын 9-ний орой олон нийтэд радио, телевизээр мэдэгдсэнээр улс төрийн

өлсгөлөн зогсож, Ардчилсан хүчнүүдийн тэмцэл цаашид улам бүр ялалтад хүрэх эхний суурь тавигдсан юм...

... Ийнхүү Монгол улсад өрнөсөн Ардчиллын түүхийг улс төрийн намууд болон тэдний байгуулсан УИХ, Засгийн газрын үйл ажиллагаан дээр үндэслэн цуврал болгон бичихээр миний бие сэтгэл шулуудан Тэргүүн дэвтэрээ гаргаж та бүхэндэ өргөн барьж байгааг минь болгоон соёрхоно уу.

Зохиогч



ЗАЛУУ УРАН БҮТЭЭЛЧДИЙН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНӨӨР...

1989.11.27-28-ны өдрүүдэд Залуу уран бүтээлчдийн Улсын 2-р зөвлөгөөн болж, (тэр үеийн засаг захиргааны бүх нэгж) 18 аймаг, гурван хотын архитекторч, барималч, зохиолч, зураач, оюутнууд оролцсон юм. Уг нь нам засгийн бодлого шийдвэрийг олон түмэнд тайлбарлан ухуулах үйл хэрэгт МАХН-ын үзэл суртлын зэвсэг болохын хувьд залуу уран бүтээлчид ямар үүрэг гүйцэтгэх талаар зааж зааварлах гэсэн санаа бодлоор дээрээс (МАХН, МХЗЭ-ээс) зохион байгуулсан ажээ. Залуу уран бүтээлчдийн анхдугаар зөвлөгөөн 14 жилийн өмнө 1975 онд болж байсан гэхээр эрх баригчдын цаад санаа эрхгүй ойлгогдогдоно. Гэтэл Зөвлөгөөнд оролцогчид номхон хүлцэнгүй суугаад, заавар семинар авч, “МАХН-ын үйл хэргийн төлөө хэзээд бэлхэн!” гэж өндөр дуугаар илэрхийлэл өргөсөнгүй.

Зөвлөгөөн эхлэхийн өмнө уран бүтээлчид салбар салбараараа чөлөөт ярилцлага хийсэн нь үзэл бодол, зорилго нэгтнүүд бие биеэ танихад дөхөм болжээ. Цаг өөр болсныг илтгэж, нам засгийн алдаатай бодлого, нийгмээ өөрчлөхийн зайлшгүйг ярьж, чөлөөтэй шүүмжилцгээв. Зөвлөгөөний нээлтэд МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, намын ТХ-ны нарийн бичгийн дарга Ц.Намсрай, намын ТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн дарга Ц.Балхаажав нарын дээдэс хүрэлцэн ирээд, тэргүүлэгчдийн суудалд биш үзэгчдийн суудалд суусан байлаа. Үг хэлсэн Л.Нямсүрэн, Дарь.Сүхбаатар, Х.Цэгмид нарын төлөөлөгчид дарга нарын өөдөөс харж байгаад, нам засгийн удирдлагыг зоригтой шүүмжилсэн нь танхим

дахь айдсыг үргээсэн гэдэг. “Залуучууд” зочид буудалд өөр зуураа чөлөөтэй мэтгэлцэж, хэлэлцүүлэг өрнүүлсэн хэр нь төлөөлөгчид биеэ барьсан, бэргэсэн хэвээр байсан юм. Тус зөвлөгөөнд оролцсон зохиолч Ч.Галсан “Сайхан цаг ирж байна. Намын ТХ-ны үзэл суртал эрхэлсэн дарга Ч.Түмэндэмбэрэлийн дэргэд л зоригтой шүүмжилсэн шүү. Манай залуучууд мундаг байна аа” гээд зөвлөгөөний талаар ярьж байв¹. Тус зөвлөгөөнд зориулаад, Залуу уран бүтээлчдийн эвсэл холбоодын өдрийг 1989.11.27-ноос эхлэн тав хоног “Залуус” танхимд хийх тухай МХЗЭ-ийн ТХ-ны шийдвэр гарсан нь залуу уран бүтээлчид чөлөөтэй цуглаж, нүүр хагарч танилцахад дөхөм болжээ. Нийслэлийн Эвлэлийн хорооны уг танхимын дотоод зохион байгуулалт дугуй хэлбэртэй болохоор хожмоо ардчиллынханд “дугуй танхим” гэж нэршсэн байдаг. Залуу уран бүтээлчид долоо хоногт нэг удаа цуглан, санаа бодлоо солилцож байх тусгай өрөө Залуучуудын Соёлын төвд гаргаж өгөхөөр болжээ. Энэ нь залуучуудыг дэмжсэн талтай ч нөгөөтэйгүүр тандах, удирдлагын түвшинд мэдээлэлтэй байх, давхар хянаж байх бодлого ч агуулжээ. Энэ өдрүүдэд үзэл бодол нэгтэйгээ таньж мэдсэн залуучууд зохион байгуулалтад орж, улс төрийн байгууллага үүсгэн байгуулахаар санаа нэгдсэн нь Монголын Ардчилсан холбоо байлаа.

Харин энэхүү өөрчлөн байгуулалтын салхи Монголын хөдөө талд аль хэдийн оччихсон байсныг зарим Монголчууд хожим мэдсэн билээ.



ХОВДЫН БАГШИЙН ДЭЭДИЙНХЭН ЖАГССАН НЬ...

1989 оны 11 сарын сүүлчээс тус сургуулийн чөлөөт цагийн танхимд багш оюутнууд цуглаж, санаа бодлоо улам эрчтэй солилцох болжээ. “Өөрчлөн байгуулалтыг төр засгаас эхлэх ёстой” хэмээн нэгдэж, цуглаан хийхээр товлоод, 12.04-нөөс бэлджээ².



12.04-ний үдээс хойш тус сургуулийн оюутны зөвлөлийн гишүүд өргөтгөсөн хурал нэрийн доор хурлын танхимд цуглаж хуралджээ. Эндээс боловсруулсан Өргөх бичгийн эхийг гүйцээж боловсруулсан (хожмын эрдэмтэн) С.Энхбаяр “одоогийн удирдлага, улс орны цаашдын хөгжлийн зам мөрд шүүмжлэлтэй хандсан шаардлага-өргөх бичгийг аймгийн МАХН-ын хорооны бүгд хуралд

гардуулж өгөх тухай санал нэгдэж, хэл уран зохиолын багшийн мэргэжил эзэмшсэн ухаантай тул өмнө нь Оюутны зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өргөх бичгийн эх

АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ ХОТООС БИШ



ХОВДООС ЭХЭЛСЭН

-Ардчилсан хувьсгалын анхны цуглааныг 1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд Улаанбаатарт зохион байгуулсан. Гэтэл үүнээс өмнө тв нар Ховдод цуглаан зохион байгуулсан нь урьдчилэн тохирсон асуудал байсан уу?

-Энэ цуглаан хэн нэгэн ухаантай гаргасан нээлт биш. 1989-1990-ээд оны оюутнууд ардчилсан үйл явц, өөрчлөн байгуулалтыг хамгийн ихээр дэмжиж байсны тод ирлэл бөгөөд төр, засгийг эсэргүүцсэн анхны зохион байгуулалттай цуглаан—арванхоёрдугаар сарын 7-нд Ховд хотноо Ард Аюулийн талбайд зохион байгуулж 400 шахам хүн оролцсоны 320 гаруй нь оюутнууд байсан.

-Тэр үед тв нарыг цуглаан зохион байгуулах гэж байна гэдгийг сургуулийн удирдлагууд мэдэж байсан уу?

-Бидний цуглаан зохион байгуулж, уяан бодлоо илэрхийлэхэд манай сургуулийн зарим багш нарын нөлөө их байсан. Тэд бидэнд улс орны болон өөрчлөн байгуулалтын талаар их ярьдаг байсан. Тэгэхэд өөрчлөн байгуулалтыг түргэтгэхийн тулд төр, засгас эхэлж өөрчлөлийн зорилтгоор хийх ёстой гэдэг дээр санал нэгдэж байсан.

Цуглааны тухай арванхоёрдугаар сарын сүүлчээр нэлээн эрчимтэй яригдаж эхэлсэн бөгөөд арванхоёрдугаар сарын 4-нд бүх ангиудаар явж яриа хийсэн. Хэднйгээр бид их нууц байдлаар яригдаж

Монголд ардчилсан хувьсгалын анхны цуглааныг зохион байгуулсан анхны сургуулийн удирдлагач Ховд хотноо арванхоёрдугаар сарын 10-нд зохион байгуулсан 1989 онд Ховд-ын багийн дээд сургуульд сурч байсан залуустай уулзсан юм.

С.Э.ЭЛЭНЭЦЭГТ "Юности интернешл" олон улсын байгууллагын "Залуучууд" бүлгийн дарга, Ц.БУЯАДАЙ ИСЭН—И.ЭЖИЛЭН, Ц.МОНЯТОР—ийн хөлсөөр зохион байгуулсан уулзсан юм.

байсан ч сургуулийн захиргаа бидний төлөөлөгчий тухай урьдчилсан байдлаар мэдээлэл авчигдсан байсан. Тэгэхэд шууд болохгүй гэдэг хатуу шийдвэрийг таймгүй, ярий өр хэлбэрээр сургуулийн хүрээндээ халихгүйгээр хийлгэх гэж бүх өргө хэмжээ өссөн. Зурганавас эхлээд сургууль дээр жижүүр гаргах, долооны өглөө бүх багш нарыг ангиудаар явуулж цуглаан хийж болохгүй гэдгийг ухуулуулж байсан. Тэгэхэд багш нар ч дотроо дэмжсэн, эсэргүүцсэн, дундаг барьсан хэсэгт хуваагдчихсан байсан гэсэн.

-Нэгэнт төлөөлөгчөө чинь мэдэгдчихсэн болохоор нууцлаад байх шаардлагагүй болсон уу?

-Ернийхдөө сургуулийн удирдлага биднийг цуглаан биш сургууль дээр уулзалт маягаар хийх нь гээд ойлгогчихсон, аймгийн даргыг сургуулийн ректор өөрөө дагуулаад ирж яваад нь манай буурдлагыг, Ядмаа хоёр сургуулиас нууцаар авсан утас, уртасгагчаа аваад Аюулийн талбай руу зөөвд явж байсан гээд бол л доо. Цуглааны үед хэрэгтэй чанар ярих, өсгөх бүтэйд нь

сургуулиас янз бүрийн аргаар нууцаар авч цонхоор гаргаж бэлдэж байсан. Яг 14.00 цагт оюутны хоёр байрны хоорондоо талбайд 320 оюутан нэгэн зэрэг гарч ирж байсан амьдралдээ өөр гаруй оюутан л үлдсэн гэсэн. Тэд нар нь давдаа өмчлөж байгаад ирсэн, МАХН-д элсчихсэн оюутнууд байсан юм билээ.

-Цуглаан дээр тв нарыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж хүмүүс үг хэлж байсан уу?

-Цуглааныг зохион байгуулагчид оюутны эвэллийн дарга С.Эрдэнэцэгт, Ц.Мөнхтөр, МХУЗ-ын III нуруын Батболд, Багш нараас Ц.Батзангиа, Б.Сарантуяа нарын хүмүүс дэмжиж, Одохгүй багш эсэргүүцэж үг хэлж байсан.

Хэлсэн үгэнд нь өөрчлөн байгуулалтыг удирдлагаасаа эзлэж Төв Хорооны Улс Төрийн Төвхоог оцдор гэсэн сангаар хэлж "Бид хийхгүй юм бол хэн хийх юм бэ? Ордоо хийхгүй бол зэвсэг хийх вэ?". Улс төрийн төлөө олоод" гэсэн тосгоогууд оюутнууд барьж аймгийн намын хороонд өргөх бичэг бага хурлын төлөөлөгчид гардуулж байлаа.

-Жагсаалыг албадсан Таврагч ямар нэг өргө хэмжээ

аваагүй юу?

Ер нь чөлөөд бөгсогмох өргө хэмжээ өссөн байсан. Талбайг цагдаа нарыг хүрээлүүлж ардын цэргийн 123-р ангийг байрланыг баглан байдалд байлгасан гэсэн. Цуглаан дээр Ховдод үүсэж үүдсийн мөрийн бүслэглүүдийг төлөөлж хүмүүс үг хэлж мэргэж нь "Бастаган, Дөрвөн Ойрд" гэсэн "толгойтай биднийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн бичиг сургуулийн үүдэнд наасан байсан.

-Тэр үеийн жагсаалын тухай берийт материал тв нарт үлдсэн уу?

-Их олон хүн зураг авч, цуглааны бичлэгийг аймгийн намын хороо хийсэн гэдэг боловч бид олж үзээгүй.

-Цуглаан зохион байгуулж байсан оюутнууд дараа нь улс төрд өгцрөссөн уу?

-Бид тэр цуглааныг улс төрийн ямар нэг амьцг хөөцөгцөд зохион байгуулавгүй. Гэхдээ сүүлд нь ерөнхий ардчилсан хувьсгалыг дэмжиж үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байсныг олон хүн мэднэ.

Цуглааныг зохион байгуулахад түүх, нийгэм судлалын, физик математикийн дараагч дүүргээс курсийнхэн их үүрэг гүйцэтгэснийг дурдахдаа өндөр боломжгүй байна. Бид энэ сарын 7-нд Ховд хотод анхны оюутны цуглаан зохион байгуулгаснаа 40 жилийн ойгоо тэмдэглэж гэж байна.

Н.САРАНГЭРЭЛ

нооргийг засах, найруулгын алдаа мэдгийг хянах үүргийг надад ногдуулсан юм... Ганцхан хуудас тэр бичиг өнөөгийн өндөрлөгөөс харахад учир дутагдалтай ч хэмжээгүй эрхт нэг намын дарангуйлал хуульчлан тогтоогдсон тухайн цаг үед МАХН-ын албан ёсны удирдлагыг сөрж, эрс өөрчлөлт шинэчлэл хийхийг нээлттэй, ил тод, зохион байгуулалттайгаар шаардсан Монголын түүхэн дэх улс төрийн анхны жагсаал, цуглааны утга учрыг хураангуйлан томъёолсон үнэ цэнэтэй баримт байж дээ... мэдээлэл, харилцаа холбоо хөгжөөгүй цагт хөдөө нутгийн зах хязгаарт улс оронд огтхон ч мэдэгдэлгүй шахам өнгөрсөн тэр цуглаан дээр “МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох ёстой” гэж анх хэлснээрээ бахархдаг. Нэгэн цагт Ховдын цэнхэр хязгаарт бид залуу явлаа. Цэнхэр хязгаар бүү бүрхээсэй” гэж дурсжээ³.

1989.12.07-ны 14:30 цаг. Ховд хотноо Ард Аюушийн нэрэмжит талбайд Багшийн дээд сургууль (БДС)-ийн оюутнууд цуглаан хийсэн нь Ардчиллын анхны цуглаан байсан юм.

“Оюутнууд ардчиллын төлөө!”, “Өөрчлөн байгуулалтыг хурдасгахыг Намын ТХ-ны VII бүгд хурлаас шаардаж байна!”, “Өөрчлөн байгуулалт шинэ удирдлага шаардаж байна!”, “Удирдлагын нүсэр аппаратыг цомхотгоё!” гэсэн уриа, Чингис хааны хөрөг барьсан гурван зуугаад багш оюутан, улмаар бусад хүмүүс нэмэгдсээр таван зуу орчим хүн жагсжээ. Цуглааныг Оюутны зөвлөлийн дарга С.Эрдэнэцогт нээж, улмаар “Манайд төрийн сонгуулийг явуулж буй журмыг өөрчлөх хэрэгтэй байна. Бидний сонгосон депутатууд үүргээ биелүүлэхгүй байна. Цэдэнбал даргын үеэс л дээрээс нэр өгч сонгуулдаг болсон... Намын ТХ, Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах хэрэгтэй” (Ц.Батзангиа); “БДС-ийн оюутнуудын цуглааныг дэмжиж байна. Гэтэл аймгийн

намын хороо, захиргааны хүмүүс цонхоор хөшигний цаанаас харж, зураг авч байна. Биднийг дэмжихийн оронд айгаад, байшингаасаа гарч ирэхгүй байна” (н. Төмөрбат); “Жагсаал цуглаан хийж, залуучуудын нийгмийн идэвхийг дээшлүүлэх хэрэгтэй. Залуучууд бид бол өөрчлөн байгуулалтын гол хүч учраас жагсах ёстой. УТТ, Засгийн газрыг огцруулахыг шаардаж байна” (А.Эрдэнэбаатар) гэхчлэн хорь орчим хүн үг хэлжээ. Цуглаан дээр Улс орны хувь заяа шийдэгдэж буй энэ түүхэн цаг үед БНМАУ-ын хөгжил дэвшлийн баталгаа, улс төрийн дайчин манлайлагч хүч “МАХН-ын ТХ-ны УТТ, БНМАУ-ын Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох ёстой... Нам, өөрийн ТХ-ны УТТ-г эрс шинэчилж, улс төрийн дайчин манлайлагчийнхаа нэр төр, үүргийг шинээр сэргээвэл зохино” гэсэн МАХН-ын ТХ-ны VII бүгд хурал, БНМАУ-ын АИХ-ын ээлжит чуулганд өргөх бичгийг Оюутны зөвлөлийн дарга С.Эрдэнэцогт уншин сонсгоод, МАХН-ын ТХ-ны VII бүгд хуралд уламжлуулахаар аймгийн намын хорооны I нарийн бичгийн даргад Өргөх бичгээ хүргүүлэх төлөөлөгчдийг сонгон томилжээ. Төлөөлөгчид өргөх бичгээ гардуулж ирснээр 3-4 цаг үргэлжилсэн цуглаан өндөрлөжээ.



МоАХ-ны АНХНЫ ЦУГЛААН - 1989.12.10

1989 оны өвлийн тэр өдрийг эргэн дурсахад хэдийн хорин хэдэн жил өнгөрчээ. Гүн хөх цэлмэг тэнгэрт нар гийсэн өвлийн тэр нэгэн тунгалаг ням гараг 1989.12.10-ныг, Монголд (МАХН-аас ангид) анхны улс төрийн хүчин-МоАХ байгуулагдсанаа зарласан өдрийг, үй олон хүн өнөө ч санан дурсаж бахаддаг юм. Энэ өдөр Залуучуудын соёлын төвийн зүүн талын талбайд улс төрийн цуглаан хийж, Монголын Ардчилсан Холбоо хэмээх байгууллагыг үүсгэн байгуулснаа зарлан мэдэгдсэн нь Монгол орныг далан жилийн нойроос нь сэрээх угталга дохио, уриа дуудлага болсон билээ.



Цуглаанд оролцогчид:

“Хүнд суртлын аппаратыг УСТГАЯ!”,
 “Тусгай хангамж-хээл хахууль!”,
 “АРДЧИЛАЛ-БИДНИЙ ЗОРИЛТ!”,
 “Хүний эрхийг дээд зэргээр эрхэмлэе!”,
 “ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙН ТӨЛӨӨ!”

“SOLIDARITY for HUMAN RIGHTS!” зэрэг лоозон барьжээ.

Ц.Элбэгдорж цуглааныг нээж хэлсэн үгэндээ Монголын Ардчилсан холбоо хэмээх улс төрийн шинэ байгууллага үүсэн буй болсныг мэдэгдлээ. Ц.Элбэгдоржийн дараагаар С.Амарсанаа “Олон улсын Хүний эрхийн өдрийг тохиолдуулан МоАХ-ны гишүүдийн цуглаанд оролцогчдоос МАХН-ын ТХ-ны VII бүгд хурал, БНМАУ-ын АИХ-ын VIII чуулганд өргөн барих бичиг”-ийг уншиж сонордууллаа. Залуучуудын Соёлын төвийн талбайд гадаад дотоодын гэрэл зурагчид, сурвалжлагчид ч ирсэн байжээ.

МоАХ байгуулагдаж, эрх баригчдад хандан:

- БНМАУ-ын Үндсэн хуулинд Намаас төр засгийн үйл ажиллагааг шууд удирдан чиглүүлэх замаар нөлөө үзүүлэх явдлыг зогсоож, тус улсын улс төрийн амьдралыг олон намын системийн үндсэн дээр зохицуулах зарчмыг хууль эрхийн баталгаатай болгож, АИХ-аас Намын тухай хууль боловсруулан гаргах

- БНМАУ-ын АИХ-ыг байнгын ажиллагаатай парламентын хэлбэрт оруулж, төр засаг намын үйл ажиллагаанд дээдлэн хүндлэх зарчмыг нэгэн адил хатуу мөрдүүлэх...

- ... БНМАУ-ын сонгуулийн системийг үндсэнд нь шинэчлэн, АИХ-ын депутатуудыг сонгох бүх нийтийн сонгуулийг хугацаанаас нь өмнө 1990 оны эхний хагас жилд багтаан явуулах...

- Хэвлэлийн эрх чөлөөг баталгаатай болгох, тусгай хангамжийг устгах зэрэг улс төрийн 13 зүйл шаардлага тавьж, цуглаан хийсэн нь Монгол оронд Ардчилсан хувьсгал эхэлснийг зарласан үйл явдал болсон юм. Энэ үеэр “Хонх” хамтлаг ая дуугаа өргөж, “Хонхны дуу”

цуурайтсан нь цуглаанд оролцогчдод эрч хүч, урам өгсөн том үйл явдал болсон юм. Тэр цагаас хойш өнөөг хүртэл “Хонхны дуу” ардчиллын сүлд дуу болсон хэвээр байна.

Цуглаан тараад, ЕЗЗ-ийн гишүүд МУИС-ийн II байран дахь С.Зоригийн өрөөнд очиж, дүгнэн ярилцаад, орой 17:00 цагт уулзахаар товлоод таржээ. Энэ хэр бүгдийн сэтгэл нэн өөдрөг, урамтай баяртай байсан нь лавтай. Нэгэнт эхэлсэн ажлынхаа эрчийг алдахгүй байж, олон нийтэд улам хүргэх үүднээс дараа долоо хоногт дахин цуглаан хийхээр товлон ярилцжээ.

С.Зориг нарын ЕЗЗ-ийн гишүүд 12.11-ний даваа гарагт Засгийн газрын ордон (өдгөө Төрийн ордон)-ы арын хаалган дээр очиж, АИХ-ын чуулган, МАХН-ын ТХ-нд Өргөн барих бичгээ албан ёсоор гардуулжээ.

Мөн Эрдэнэт хотод 1989.12.10-нд “Уурхайчин” соёлын ордны өмнөх “Найрамдал” талбайд “Энх” клуб улс төрийн цуглаан хийжээ. Энэ өдөр “Хүний эрхийн түгээмэл тунхаг”-ийг бүрэн эхээр нь уншиж, зохиолчид шүлэг зохиолоо уншиж, хүмүүс сэтгэлийн үгээ хэлж, улс орны амьдралын нарийн ширийн асуудлыг хөндөн ярьсан нь хүмүүсийн сэтгэлийн гал дээр тос дусаах шиг болсон” ажээ.

Цуглаанаас АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ-нд хандан:

- МАХН-ын аппаратыг шинэчлэх
- Байгаль орчныг хамгаалах
- Хамтарсан үйлдвэрүүдийг хаах
- Зөвлөлтийн цэргийн ангийг Монголоос гаргах дөрвөн зүйл шаардлага бүхий Өргөх бичиг гардуулахаар болж, уншин сонсожээ. “Байгалиа бүх нийтээрээ хамгаалъя!”, “Нам төрийн аппаратад огцом өөрчлөлт хийхийг шаардаж

байна!” зэрэг уриа лоозон дэвшүүлжээ⁴.

Ер нь энэ үеэс улс орон даяар Ардчилсан холбооныхныг дэмжиж, ардчиллыг эрж тунхагласан тэмцэл өрнөөд эхэлжээ. Энд Эрдэнэт хотын нэг төлөөлөгч МоАХ-ны ЕЗЗ-д хандан “Хоёр ч клуб ил гарч, өөрсдийгөө зарлаж, жагсаал, цуглаан, ярилцлага зохион байгуулснаас хойш байдал ашигтайгаар эргэсэн боловч одоо нам, захиргаа, эвлэлийн байгууллага шууд дэмжиж, бүр туслахыг амлах боллоо. Ингэснээр нэг бодоход болоод явчихаж байгаа юм шиг, нөгөө талаар арганд орчихлоо гэсэн бодол санааны зөрчилдөөн гарч ирлээ... Бидэнд зөвлөгөө маш их хэрэгтэй байна” гэж зөвлөгөө хүсэн захидал бичсэн нэг жишээг дурдъя⁵.



МоАХ УЛАМ ӨРГӨЖСӨӨР...

Ерөнхий зохицуулагчийг сонголоо

МУИС-ийн хичээлийн II байр. НУФ-ийн багш аспирант С.Зоригийн өрөөнд МоАХ-ны Ерөнхий зохицуулагчийн сонгууль 1989.12.15-нд болжээ.

Хүн бүр дор дороо нэр дэвшүүлж, санал хураасанд Г.Бошигт олонхийн санал авчээ. Харин тэрээр “Би та нараас ахмад хүн. Намайг хүмүүс, ялангуяа залуучууд яаж хүлээж авах юм билээ. Хувьсгалыг залуучууд л хийдэг юм. Та нар залуу хүмүүс. Сайн бод. Та нар дундаасаа нэгийгээ сонговол тэдний дэмжлэгийг илүү авна. Би та нарын ард зөвлөх маягаар тусалж дэмжээд явъя” гээд нэрээ татаж, дахин сонгууль явуулахыг хүсжээ⁵.

Ингээд дахин сонгууль явуулжээ. Нэг ёсондоо хоёр шаталсан сонгууль нэлээд өвөрмөц байдал дунд болсон гэхүйц юм. Нууцаар санал хураасанд МУИС-ийн багш 27 настай С.Зориг олонхийн санал авч, МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагчаар, дэд зохицуулагчаар Б.Энхтүвшин сонгогджээ.

Хоёр дахь цуглаанаа 12.17-ны ням гарагт хийхээр товлож, цуглааны зараа гэрлийн шон дээр нэмж наагаад тарсан байдаг.

Энэ үес хүний эрхийн төлөө цогтой тэмцэгч, Нобелийн шагналт, нэрт эрдэмтэн, тэрс үзэлтэн А.Д.Сахаров нас барсан тухай Зөвлөлтийн ТВ-ээр мэдээлсэн юм. МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүд 12.16-нд Зөвлөлтийн ЭСЯ-нд очиж, МоАХ-ны өмнөөс эмгэнэл илэрхийлж, ЗСБНХУ-ын Ардын депутатуудын II их хуралд эмгэнэлийн цахилгаан утас

явуулав. Тэднийг ЭСЯ-ны зөвлөх Х.Р.Омаров, ЭСЯ-ны ажилтан В.С.Миронов нар хүлээн авч уулзан ярилцсан нь МоАХ-ны гишүүдийн анхны гадаад томилолт, гадаадтай харилцсан ажил болжээ.

МоАХ-ны эмгэнэлийг ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зориг албан ёсоор танилцуулжээ.

Эмгэнэл илэрхийлсний удаагаар харилцан яриа өрнөж, С.Зориг МоАХ-ны талаар товч танилцуулаад, МоАХ-ны анхны цуглааны талаар Зөвлөлтийн төв ТВ-ийн “Орбит” сувгаар үнэн бодит мэдээлсэнд талархал илэрхийлжээ.



Жич: Румыний хувьсгалын үеэр 1989.12.21-нд дарангуйлагч дэглэм нь хүч хэрэглэж, иргэдийнхээ тайван жагсаал цуглааныг тараасныг МоАХ-ны ЕЗЗ-ийн 12.24-ний хурлаас буруушаагаад, мянга гаруй хүн амь үрэгдэж, хэдэн зуун хүн шархдаж хохирсонд мөн эмгэнэл илэрхийлсэн юм.

С.Зориг тэргүүтэй ЕЗЗ-ийн гишүүд Румыний ЭСЯ-нд 12.25-нд очиж, эмгэнэлийн бичгээ уншин гардуулжээ.

Тангараг өргөсөн нь...

Хоёр дахь цуглаанаа хийхийн өмнөх өдөр 1989.12.15-ны орой МУИС-ийн Криминалистикийн лабораторид цуглаад, маргаашийн цуглааны бэлтгэлээ ярилцаж байх үеэр нэгэн санал гарсан нь ЕЗЗ-ийн гишүүд тангараг өргөх санал байв. Саналыг Дарь.Сүхбаатар гаргаж, тангаргийн үгээ хэлэлцээд бичжээ. Билгийн тооллоор Шинийн 15-ны бэлгэ дэмбэрэлтэй сайн өдөр байж таарчээ. Ингээд ярилцсаар, 12.15-16-ны шилжих шөнө болоход “Ардчилал, шударга ёс, хүнлэг, энэрэнгүй нийгэм байгуулахад амь биеэ хайргүй зүтгэж, өргөсөн тангаргаасаа няцвал журмын нөхдийнхөө өмнө ял хүлээхэд бэлэн” хэмээн баруун гараараа тангараглаж, Д.Баасан лам “Сундуйн жүд” судраар адислажээ. ЕЗЗ-ийн 13 гишүүн тангараг өргөж, анхны 13 гэгдэх болсон. Эд “Моод Монголоор дандаа дуусдаг байсан бол энэ удаа манайд өрнөсөн хувьсгалт хөдөлгөөн Зүүн Европтой бараг зэрэг эхэлж, ЗХУ-аас түрүүлж, зах зээл, ардчилалд орсон. Буудалцаан, байлдаангүйгээр ялалтыг авчирсан түүхэн үйл явдлын анхны автор нь 13 хүн гэж тэмдэглэгджээ” ⁶. хэмээн хожмоо дурсагджээ.

Жич: Г.Бошигт, Ч.Энхээ нар тангараг өргөөгүй ажээ.

Өмнөхөөс зургаа дахин олон хүн оролцсон Хоёр дахь цуглаан

1989.12.17-ны цуглааныг Д.Сүхбаатарын талбайд хийхээр төлөвлөсөн байсан ч тусгайлан тавцан бэлдээгүй байснаар ДБЭТ-ын өмнө хийхээр болжээ. Энэ удаагийн цуглаанд 2 000 гаруй хүн оролцож, 12.10-ны Өргөн барих бичгийн хариуг шаарджээ. “Айвал бүү хий, хийвэл бүү

ай!”, “Ардчилал-Бидний зорилт!”, “Хэвлэлийн эрх чөлөө!” зэрэг лоозон барьсан байв.

МоАХ-ны мөрийн хөтөлбөрийн төслийг танилцуулж, Үндсэн хуулин дахь “МАХН бол нийгмийн удирдан чиглүүлэгч хүчин мөн” гэсэн заалтыг хасахыг шаарджээ. Улс орон улс төр, эдийн засаг, оюун санаа, ёс суртахууны гүн хямралд ороод байгааг үг хэлсэн хүмүүс цохож, хэвлэлийн эрх чөлөө, дарга ямбатны тусгай хангамжийн талаар ширүүн шүүмжилжээ.

Өсгөгч муу ажилласан, үг хэлсэн ЕЗЗ-ийн гишүүд хамаагүй үг ярьсан гээд энэ удаагийн цуглаан зохион байгуулалтын хувьд тааруудуу болсон гэгддэг. Үдээс хойш Дугуй танхимд цуглаж ярилцах үеэр ЕЗЗ-ийг Цагаандарийн Энхтүвшин, А.Мурат, Ж.Равдандорж, Д.Төмөр-Очир нарын нарын шинэ гишүүдээр өргөтгөжээ.

Орой нь МУИС-ийн хичээлийн II байранд С.Зоригийн ерөөнд үргэлжлүүлэн хуралджээ. Зохион байгуулалтаа улам сайжруулж, салбар зөвлөл байгуулах, улам олон хүнийг хамруулахаар ярилцжээ.

Өргөн барих бичгийн хариу өгсөн нь...

Хоёр дахь цуглааны дараа 1989.12.22-нд АИХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Готов “Хөдөлмөрчдийг хүлээн авах байр”-нд МоАХ-ны удирдлагатай уулзаж, Олон нийтийн байгууллагын үйл ажиллагааны эрх хүсэх тухай МоАХ-ноос АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхөд өгсөн өргөдлийн хариуг өгөх болсон тухай Ерөнхий зохицуулагч С.Зоригт мэдэгджээ. Үүний дагуу С.Зориг, С.Амарсанаа, Д.Сосорбарам,

Дарь.Сүхбаатар, Д.Энхбаатар, Б.Энхтүвшин нар очиж уулзжээ. Уулзалт тун богино хугацаанд болж, АИХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Готов “БНМАУ-ын Үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ёстой” гэснээр өндөрлөжээ. Тэр үеийн Үндсэн хуулийн 87-р зүйлд, “БНМАУ-ын иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон болно” гэж заасан ч тийнхүү батлан олгосон хууль журам байгаагүй юм. Нэгэнт хуулиар хориогүй болохоор МоАХ цуглаан зохион байгуулах нь хууль зөрчсөн хэрэг биш болох нь ойлгогджээ.



АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ХӨДӨЛГӨӨН..., ШДХ

Р.Хатанбаатар, П.Улаанхүү, Д.Ламжав, А.Ганбаатар, Н.Алтанхуяг тэргүүтэй МУИС-ийн багш, инженер техникийн болон эрдэм шинжилгээний ажилтнууд 1989.12.28-нд Ардчилсан Социалист Хөдөлгөөн (АСХ)-ийг санаачлан байгуулсан юм. 10 хүний бүрэлдэхүүнтэй Гүйцэтгэх зөвлөлийг сонгож, нарийн бичгийн даргаар П.Улаанхүүг сонгожээ.

Хөдөлгөөнийхөн МУИС-ийн хичээлийн III байрны 307-р өрөөнд байрлаж байв.

АСХ байгуулагдсаныг мөн өдөр нь Монголын радиогоор зарлажээ. АСХ 1990.01.04-нд нийт ард түмэндээ хандан, “Бидний хэсэг нөхөд

Монгол улсынхаа нэр хүндийг өндөрт өргөх, ард түмнээ сайн сайхан амьдруулах гэсэн чин эрмэлзлээр АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ХӨДӨЛГӨӨН (АСХ)-д нэгдэж байна. АСХ нь өөрчлөлт шинэчлэлтийг өнгөлөн засах хэлбэрээр явуулах гэсэн аливаа эрмэлзлийг аялдан дагалдахгүй бөгөөд харин үндсээр нь өөрчлөх Өөрчлөн байгуулалтын төлөө ТАЙВАН ЗАМААР тэмцэх болно. Бид ганцаар ноёрхох аливаа улс төрийн бодлогоос ангид байх ба ажиллагааныхаа тэргүүн байранд ХҮН, ХҮНИЙ САЙН САЙХНЫГ авч үзэх болно. АСХ улс орноо нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий хямралаас гаргахын тулд дараах зорилтыг нэн тэргүүнд хэрэгжүүлэхийн төлөө тэмцэнэ” гэжээ. Үүнд:

- Олон намыг хүлээн зөвшөөрөх боловч аливаа нэг намд удирдан чиглүүлэх онцгой эрхийг дангаар нь эдлүүлэхгүй

- Одоогийн сонгуулийн тогтцыг ард түмний жинхэнэ эрх ашгийг илэрхийлэх ардчилсан хууль цаазат төр бий болохуйцаар өөрчлөх.
- Олон намын чөлөөт улс төрийн тэмцлийг хуульчлан зөвшөөрөх.
- Улс төр, олон нийтийн бүх байгууллагыг чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх эрхээр хангах. Эдгээр нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, мэдээллийг дангаар эзэмших эрхгүй, ард түмэн бүх талын мэдээлэл хүлээн авах эрхтэй гэдэг зарчмыг баримтална.
- НҮБ-аас гаргасан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, хүний эрхийг хөсөрдүүлсэн одоогийн НИЙГМИЙГ АЮУЛААС ХАМГААЛАХ ТОГТЦЫГ өөрчилж, үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд явуулах
- Нийгмийн бодлогын гол зорилго нь ард иргэдийн амьдралын баталгаат нөхцлийг хангах явдал гэж үзнэ. Энэ зорилгоор

ҮНДЭСНИЙ СОЁЛ, ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ, ОРОН СУУЦ, НИЙГМИЙН ДААТГАЛ, СУРГАЛТ ХҮМҮҮЖИЛ, ШАШИН ШҮТЛЭГ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ зэрэг салбарыг илүү анхаарах.

- ... ШУДАРГА ЁС, ТЭГШ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ нийгмийн амьдралын бүх хүрээнд эрхэмлэх...

- Монгол улсын үндэсний эрх ашигт нийцсэн оновчтой, өндөр үр ашигтай эдийн засгийн бүтцийг бий болгох. Энэ талаар үндэсний бие даасан бодлого явуулах. Өмчийн олон хэлбэр ХӨГЖИЛ, ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙ ижил нөхцөлд оршин тогтнохыг хүлээн зөвшөөрөх.

- МОНГОЛ УЛС олон улсын харилцаанд хүч үл

хэрэглэх, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим дээр хөрш улсууд болон дэлхийн бүх улс оронтой найрсаг харилцах бөгөөд биеэ даасан, төвийг сахисан бодлогыг эрхэмлэх. Өөрийн нутаг дээр гадаадын цэргийн бааз байрлуулахгүй байх явдлыг улс орноо нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий хямралаас гаргахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх зорилт хэмээн тунхаглажээ.

Улмаар хэд хоногийн дараа 1990.01.12-ны өдөр Монголын Сэтгүүлчдийн холбооноос зохион байгуулсан “Өөрчлөлт шинэчлэл-Хэвлэл мэдээлэл” уншигч, сэтгүүлчдийн Улсын шуурхай зөвлөгөөн дээр тэд өөрсдийгөө анх зарласан юм.

1990.01.21-нд МоАХ-ноос зарласан ээлжит цуглаан дээр АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, МУИС-ийн багш Д.Ламжав АСХ байгуулагдсаныг олон нийтэд мэдэгдэв.



Дараа өдөр нь буюу 01.22-нд “АСХ-ий мэдээ” гэсэн ухуулах хуудастай самбар нийслэлийн төв гудамжинд

ажиллаж эхэлсний сацуу АСХ-ийг байгуулсан тухай мэдээллийг (МУИС-ийн I байрны зүүн талын автобусны буудлын самбар гээд) хүн их цугладаг газраар зар, мэдээ хэлбэрээр бичгийн цааснаа бичиж нааж байв. Бас бие хүмүүс чанга яригчаар сурталчилж ухуулж байжээ. Үүнд, АСХ дөнгөж байгуулагдаад, зорилго, үйл ажиллагаагаа таниулга яриа хэлбэрээр хийж байсантай таарснаа тэр цагийн гэрч бээр ийн өгүүлжээ: Нэг өдөр УИД-ээр орж, хүнсээ цуглуулаад гарч явтал МУИС-ийн Үүлийн ангийн дарга Алтантуяа (Тэр үеэс л Алтанхуяг нэртэй болсон байх) урд талбай дээр нь зогсож байна... “Хүүе, сайн уу, мэнд амар уу?” гэсээр уулзлаа... Мөн л манайхных шиг картон самбар босгочихсон, дээр нь “Ардчилсан Социалист Хөдөлгөөн байгуулагдлаа” гээд биччихэж. Машинаар цохисон мөрийн хөтөлбөр, удирдлагынх нь танилцуулга, зураг хөрөг нь ч харагдах шиг.

“Бид ийм хөдөлгөөн байгуулаад, тэгээд танилцуулга хийгээд зогсож байна аа” гэлээ. Самбарыг ахиулаад хартал өөрийнх нь зураг, намтар ч байна. Гэтэл Их сургуульд бидэнд шугаман алгебр зааж байсан Ламжав багш, “Бүү март”-ыг бичдэг биологич Батбаяр ч байж байх юм... ойр хавиараа явсан хүмүүст танилцуулж яриад л. Энэ бол 12-р сарын хорин хэднээр болсон явдал” гэжээ⁷.

АСХ-ий дээрх үзэл санааг хүмүүс хэрхэн үзэж байгаа талаарх судалгааг албан газрууд, гудамж талбайгаар зорчигчдоос 02.03-нд авч, нийт 1200 хүнийг хамруулжээ. Тунхагийн үзэл санааг судалгаанд хамрагдсан хүмүүсийн 70-90% нь зөв зүйтэй, 3-9% нь буруу, 10-20 орчим хувь нь зөв бурууг мэдэхгүй гэж үзсэн байжээ. Мөн энэ өдөр АСХ-ий нарийн бичгийн дарга П.Улаанхүү гадаадын сурвалжлагчдад ярилцлага өгчээ⁸.

АСХ-ий түр журмыг 1990.01.15-нд баталжээ.



“МоАХ-ноос та нар юугаараа өөр юм бэ? гэсэн асуултад АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Б.Батбаяр: “Бидний эн тэргүүний шаардлага бол нийгмийг ардчилах зорилт юм... МоАХ, АСХ хоёр ер нь зорилгын хувьд адилхан. Ерөөсөө зорилгоороо ялгагдах гэж тэмүүлэх нь утга учиргүй зүйл... Харин аргын хувьд өөр. Бид ард түмэнд хандаж, тунхаглал гаргасан. Уншсан хүн бол ялгааг нь олоод харчих л байх. Жишээлбэл, МоАХ өөрсдийгөө оппозиц хүч гэж зарлаад байгаа. Бид өөрсдийгөө тэгж зарлаагүй. Манай хөдөлгөөн нээлттэй. МАХН, МоАХ алиных нь ч гишүүн бидэнтэй нэгдэж болно” гэж тайлбар өгчээ⁹.

АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн дарга Р.Хатанбаатар “Ер нь гишүүдийн тоо гол биш. Одоо манай Гүйцэтгэх зөвлөл нийгмийн ухааны багш нарыг оролцуулан 10 гишүүнтэй болоод байна. Манай салбар зөвлөлүүд МУИС-аас гадна бусад бүх дээд сургууль, ШУА-ийн Физик-техникийн хүрээлэн, Математикийн хүрээлэн, Шинжлэх ухаан, дээд, тусгай дунд боловсролын Улсын хороо, Ардын боловсролын

яам, ГЯЯ, Улсын банк, ХААХҮЯ, мөн хэд хэдэн эмнэлэг, үйлдвэр, аж ахуйн газар ажиллаж байна. АСХ-ий идэвхтэн 1 000 орчим хүн байна... Олон түмний санал бодлыг мэдэх зорилгоор социологийн судалгаа хийсэн. Мөн Улаанбаатар хотын АДХГЗ-ны дарга Л.Лантуутай тохиролцсоны үндсэн дээр нийслэлийн гурван гол гудамжинд “АСХ-ий мэдээ” самбар гаргахаар болсон. Одоогоор МУИС, УБДС-ийн орчим хоёр самбар ажиллуулж байна. Гурав дахийг нь Хүнсний 20-р дэлгүүрийн дэргэд гаргана. Энэ бүхэн бол бидний ажлыг илтгэх хэдхэн баримт” гэж (1990 оны I улирлын байдлаар) үйл ажиллагааныхаа эхэн үеийг тоймлон өгүүлжээ¹⁰.

ТусхөдөлгөөнданхныхандивыгиргэдээсР.Гончигдорж, байгууллагаас шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн “Хөгжил” хоршоолол өргөжээ¹¹.

“АСХ-ий мэдээ” самбарыг МУИС-ийн I байрны өмнөх Х.Чойбалсангийн хөшөөний дэргэд 01.29-нд байрлуулсан байв. Харин самбарыг эвдэх, самбараа хураахыг шаардах зэрэг өдөөн хатгасан үйлдэл их гарч байжээ. Тухайлбал, өдөөн хатгагчдаас 01.25-нд самбараа буулгахыг шаардаж байсан нь “зөөлдөөд”, 02.03-нд Мэдээллийн самбарын цоожийг эвдэж, мэдээг хуулж авсан бол 02.10-нд цонхыг хагалж, бүх мэдээллийг хуулж авчээ. 02.22-нд ч мөн чингэжээ. Өөрөөр хэлбэл, -“АСХ-ий мэдээ” самбарт шинэ мэдээ материал гарах бүрт дээрх мэт явдал давтагдаж байсан. Уул нь 01.30-нд Нийслэлийн намын хорооны I нарийн бичгийн дарга Л.Лантуутай уулзаж, нэмж гурван газар самбар тавихаар тохироод байсан ажээ¹².

Аюулаас хамгаалах хүчин, дотоодын цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүнийг АИХ, СнЗ-д харьяалуулах, аль нэг нам хүчнээс хамааралгүй байж, хүний эрх, шударга ёсыг

эрхэмлэн дээдлэх тухай “Өчих үг”-ийг НАХЯ-ны сайд А.Жамсранжавт АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд 1990.02.03-нд гардуулсан нь хожмын үйл явдал сайнаар өрнөхөд нөлөө тусгалтай байсан нь лавтай. Улмаар АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхөд хандан 02.08-нд “Ил захидал” илгээснийг МоАХ-ноос зохион байгуулсан Тав дахь цуглаан (02.11) дээр уншиж танилцуулав. Ил захидалд дэвшүүлсэн саналд эрх баригчид хариу өгөхгүй байсанд 02.22-нд захидлын хариуг албан ёсоор шаарджээ.

АСХ-ий талаар анхны дэлгэрэнгүй мэдээлэл-ярилцлагыг Д.Ламжав МОНЦАМЭ агентлагийн “Цаг үе” сэтгүүлд 02.10-нд өглөө.

Тус хөдөлгөөний хэвлэл “Социал-Демократ” сонины анхны дугаар 1990.03.01-нд 600 хувь хэвлэгдэн гарчээ.

АСХ-ий идэвхтний хурал 1990.03.13-нд болж, ШУА-ийн Математикийн хүрээлэнгийн захирал Р.Гончигдоржийг Гүйцэтгэх зөвлөлийн даргаар сонгосон байна.

1990.01.19-нд байгуулагдсан Шинэ Дэвшилт Хөдөлгөөн, мөн түүний дараахан 02.10-нд үүссэн Эвийн Холбоо нэгдсэнээр Шинэ Дэвшилт Холбоо 02.16-нд байгуулагджээ. 1990 оны эхээр Д.Батсүх, Д.Бүүвэйбаатар, Г.Ганхуяг, С.Дэмбэрэл тэргүүтэй Эдийн засгийн хүрээлэнгийн залуу ажилтнууд, Ж.Баасандаш, Да.Ганболд, Ж.Батхуяг, Д.Сүх-Эрдэнэ зэрэг сэхээтэн залуучууд “Залуу эдийн засагчдын клуб” байгуулж, улс орны эдийн засгийн байдлыг шүүмжлэн ярилцдаг болжээ. Бид эхлээд “Залуу эдийн засагчдын клуб” байгуулан, эгнээгээ нэлээд өргөжүүлсэн. Хожим нь клубээ “Эвийн холбоо” гэж нэрлэх болсон. Удирдлагын хүрээнд “хэсэг залуус цуглаж,

ямар нэг зүйл яриад байна” гэх хардлага мэдрэгдэх болсон тул бид ийнхүү нэрээ солиход хүрсэн” гэж ШДХ-г үүсгэн байгуулагчийн нэг Ж.Баасандаш дурсжээ¹³.

Тэд “Тэмцэхийн учир” гэсэн улс төрийн баримт бичгийг ч боловсруулжээ. Шинэ улс төрийн байгууллагаа “Шинэ Дэвшилт Хөдөлгөөн”-ий “Шинэ Дэвшилт” гэсэн үгийг, “Эвийн холбоо”-ны Холбоо-той нийлүүлж, “Шинэ Дэвшилт Холбоо” хэмээн нэрийдэж байгуулснаа МоАХ-ны Анхдугаар их хурал дээр Ц.Баатар зарлажээ. Энэ тухайд Н.Батбаяр “Албан ёсны нэрээр хурал цуглаанд оролцож эхэлсэн үе маань анхны улс төрийн өлсгөлөн, 3 сарын 4. ШДХ-г байгуулснаа зарласан өдөр бол 3 сарын 11” гэжээ¹⁴.

Тус холбооныхон ОХБДС (өдгөө ХИС)-ийн хашаанд хоёр монгол гэрт байрлаж, гишүүд нь монгол заншил, бурхан шашнаа сэргээнэ гээд монгол хувцсаа их өмсдөг байсан онцлогтой.



ГУРАВ ДАХЬ ЦУГЛААНАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголчууд мориндоо!

1990.01.14-нд “Ялалт” (өдгөө “Тэнгис”) кинотеатрын зүүн талын талбайд МоАХ гурав дахь цуглаанаа хийлээ. Цуглааны өмнөхөн Д.Сүхбаатарын талбайн зурагчнаас “Хонда” мотор түрээслэжээ.

Цуглаан дээр буюу 1989.12.10 болон 12.17-ны өмнөх цуглааны шаардлагынхаа хариуг эрх баригчдаас дахин шаардлаа. Үндсэн хуульд МАХН-ын хэмжээгүй эрхийг тунхагласан заалтыг хасах талаар ярьж, нэг намын дарангуйллыг халах, улс орноо хөгжүүлэхэд учирч байгаа буруу тогтолцоог үг хэлсэн хүмүүс шүүмжлэв. МоАХ-ны салбар зөвлөлүүд лоозон уриагаа өөрсдөө бичиж ирцгээсэн нь шинэлэг үйл явдал болсон төдийгүй “Монголчууд мориндоо” гэсэн лоозон уриа энэ цуглаанд анх өргөгдөж, улмаар Ардчиллын нэгэн УРИА болсон байна.

Гурав дахь цуглаанд маш олон хүн (10 мянга гаруй хүн) оролцжээ. Амралтын өдөр ням гараг байсан хэдий ч талбайн зүүн талын яамны өндөр барилга (өдгөө МХАҮТ)-ынхаа цонхоор албан хаагчид нь харж зогсоод, зарим нь цонхоо нээчихсэн ч байжээ.

Цуглааны талаар ЕЗЗ-ийн гишүүд МУИС-ийн II байрнаа Криминалистикийн лабораторид дүгнэж ярилцжээ. Энэ удаагийн цуглаанд 10 мянга гаруй хүн ирсэн нь их урам өдөөж, эрчээ алдалгүй ухуулгаа хүчтэй болгоод, дараа долоо хоногийн ням гарагт 01.21-нд дахин цуглаан хийх санал гарав. Ерөнхий зохицуулагч С.Зориг саналыг дэмжээгүй ч олонх дэмжсэнээр цуглаан хийхээр болсон байдаг.

Эрх баригчдын хоосон амлалт

Хотын гүйцэтгэх захиргааны байранд УТТ-ны орлогч гишүүн, Нийслэлийн намын хорооны I нарийн бичгийн дарга Л.Лантуу МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүдтэй 1990.01.19-ний 15:00 цагт уулзаж, МоАХ-ны шаардлагуудын хариуг өгөхөө мэдэгдсэн байв. Уулзалтад хоёр талаас С.Зориг, С.Амарсанаа, Д.Баасан, Д.Нинж, Н.Нямгарав, Ц.Элбэгдорж, Б.Энхтүвшин нар болон эрх баригчдыг төлөөлж УТТ-ны орлогч гишүүн, Нийслэлийн намын хорооны I нарийн бичгийн дарга Л.Лантуу, АИХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Готов, НАХЯ-ны сайд, дэслэгч генерал А.Жамсранжав, Улаанбаатар хотын АДХГЗ-ны дарга Н.Мөнхжаргал, “Улаанбаатарын мэдээ” сонины эрхлэгч Ц.Мөнхжаргал, Хотын Цагдан сэргийлэх газрын дарга Ж.Хурцгэрэл нар оролцжээ. Телевизийнхэн ч ирж, бичлэг хийжээ.

Л.Лантуу “Өргөн барих бичгийн утгыг Батмөнх даргад танилцуулсан... Манай энэ хариу бол албан ёсных юм шүү” гээд олон намын тогтолцоо, хүний эрх, байнгын ажиллагаатай парламент, ард түмний хэлэлцүүлэг, зах зээлийн талаарх үзэл баримтлал, банкийг АИХ-ын мэдэлд шилжүүлэх, хэвлэлийн эрх чөлөө гээд бүх шаардлагыг “ярьж болох асуудал, маш олон талаас нь ярьж хэлэлцэх, судлах зүйл, зүйтэй асуудал, хүний эрхийг хориод байгаа зүйл байхгүй” гээд уулзалт үргэлжилжээ. Д.Сүхбаатарын талбайд жагсаал цуглаан хийхийг зөвшөөрөхгүй гээд өөр газар хийхийг их ятгаж ярьжээ.

Эрх баригчид ТВ-ийн камерын өмнө ингэж сайхан загнасан юм. Тэд “Та нар сонин хийх гэж байгаа бол тэрийгээ аваад ир, бид ярилцаад хэвлүүлье. Чөлөөтэй уулзаж ярьж бай, бүх юмаа ингээд ингээд хийе, аваад

ир, бүгдээрээ ярилцаад хийчихье” гэж сайхан аашлан ярьж байсан нь, тэр хоосон үг нь мэдээлэл хомс энгийн иргэдэд; цуглааны талаар ямар ч мэдээлэл, ойлголтгүй хэвээр байгаа хөдөө орон нутгийнханд тун тааламжтай сонстож хүрсэн нь лавтай. Харин ачир дээрээ ямар ч үр дүн гараагүй юм. Бас мөнөөх хариу нь бичгээр бус амаар өгсөн хариу байлаа.

01.20-ны орой Их сургуулийн II байрнаа Криминалистикийн лабораторид МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүд эрх баригчдын хариу хүлээгээд сууж байцгаажээ. 20:00 цагт Хотын намын хорооны I дарга утасдаж, “Маргааш Сүхбаатарын талбайд цуглаан хийхийг зөвшөөрөхгүй” гэсэн нь эрх баригчдын албан ёсны жинхэнэ хариу байсан юм.



Анхны жагсаал... Д.Сүхбаатарын талбай дээрх дөрөв дэх цуглаан

1990.01.21-ний ням гарагийн цуглаанд Нийслэлийн дүүргүүдийн салбар зөвлөлийнхөн жагсаалаараа төв талбайд орж ирсэн юм. Ажилчны районы жагсаал УДЭТ-ын өмнөөс, Сүхбаатарын районых Залуучуудын Соёлын төвөөс, Найрамдлын районы жагсаал УБДС-ийн дэргэдээс, Октябрийн райончууд “Ялалт” кинотеатрын өмнөөс хөдөлж, гишүүд дэмжигчид дуу дуулан, уриа хэлж жагссан нь иргэд сайн дураараа, үзэл бодол, итгэл үнэмшлээрээ, хэнээр ч албадуулалгүй, шахаж шаардуулалгүй хийсэн анхны улс төрийн жагсаал байсан. Жагсагчид “Айвал бүү хий, хийвэл бүү ай!”, “Монголчууд мориндоо!”, “Олон намын систем!”, “Цэдэнбалыг ард түмний шүүхэд!”, “Шинэ цаг ирлээ, сэргээе!”, “Эрх зүйт төрийн төлөө!” зэрэг уриа лоозон барьсан байв.



Д.Сүхбаатарын талбайд цуглааныг хөтөлж байсан Ц.Элбэгдорж гэнэт “Өнөөдөр их жолоодогч Владимир Ильич Лениний таалал төгссөн өдөр учраас эмгэнэл

илэрхийлье. Малгайгаа авцгаая” гэсэн нь нэг талаар хачирхалтай мэт санагдсан ч хүмүүс коммунист үзэл санааны туйлын сайн сайханд итгэсэн хэвээр байсан цагдор олон нийтийг шинэ тулгар байгууллагадаа татах нэг ёсны тактик байсан юм.

Энэ удаагийн цуглаан дээр МУИС-ийн багш Д.Ламжав АСХ байгуулагдсан тухай олон түмэнд анх мэдээлсэн юм. Түүнчлэн ШДХ-ны гишүүн Д.Сүх-Эрдэнэ “Өнөөдрийн МАХН бол миний өвөөгийн байгуулсан нам биш” гэж, бас нэрт бөх, дархан аварга Ж.Мөнхбат гээд нэр алдартай хүмүүс ч үг хэлжээ. Д.Сүх-Эрдэнэ тийнхүү хэлснийхээ төлөө их хараалгуулж зүхүүлсэн. Түүнийг “Жанжин Д.Сүхбаатарын гуч хүү гэж өөрийгөө нэрлэсэн нэг залуу манай намыг Д.Сүхбаатарын байгуулсан тэр нам, нам биш” гэж шууд хэллээ. Тэгэхэд нь туг, лоозон барьсан бүлэг этгээдүүд илтгэгчдийнхээ хамт урай хашхирч, алга ташиж байв. Тэр юу хэлж байна вэ?” гэж хэвлэлээр намнаж байв¹⁵.

Цуглааныг жуулчны визээр ирсэн гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн дэлгэрэнгүй сурвалжилсан юм. Хэвлэлийн бага хурал ч зохион байгуулсан. Тэр үед Монгол оронд Ройтерс-ийн сурвалжлагчаар ажиллаж асан фин эмэгтэй Ирья Хаалаш 2012.03 сард гэрэл зургийн үзэсгэлэнгээ Уран зургийн галерэйд ирж нээсэн төдийгүй Ардчиллын үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор хөхүйлэн үнэлсэн билээ.



МоАХ-НЫ АНХДУГААР ИХ ХУРАЛ

Их хурлаа хийхийн өмнө

1989.12.30-нд МУИС-ийн хичээлийн I байрны дугуй танхимд оюутан залуучуудтай хийсэн ээлжит уулзалт дээр С.Зориг МоАХ-ны үйл ажлыг мэдээлэх явцдаа Ардчилсан холбооны их хурал хийх гэж буй талаар анх ярьжээ.



Энэ хэр МоАХ, АСХ-ий салбар зөвлөл улс орны өнцөг булан бүрд гэж хэлж болох түвшинд байгуулагдаад, дэмжигч олонтой болоод байв. Ардчиллын үйл хэргийг ард олон халуунаар талархан дэмжиж уухайлан түрсэн юм. Харин эрх баригч МАХН, түүний гар хөл бологч МХЗЭ зэрэг олон байгууллага ардчиллынхныг жадлан эсэргүүцэж, гишүүд дэмжигчдийг дарамталж байлаа. Жишээ болгож, тэр үеийн хамгийн том хэвлэл нам засгийн “Үнэн” сонины зөвхөн нэг дугаар (№35 (1990.02.10))-ыг дурдаж болох юм. “Монголын Ардчилсан Холбоо” гэгчийн тухайд᠎ малгай гарчгийн доор “Манай орны

хот хөдөөгийн хөдөлмөрчид, хамт олон, намын гишүүд, ахмад дайчид “МоАХ” гэгчийн талаар санал бодлоо илэн далангүй бичсэн захидлыг МАХН-ын ТХ болон Намын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Намын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын нэр дээр ирүүлсээр байна. Энэ оны I сард ирсэн захидлаар Намын ТХ-ны ерөнхий хэлтсээс бэлтгэж ирүүлсэн нүүр” гэсэн зүйл нийтэлжээ. Энд, “Хайрт нам засаг минь, энэ бузар булай зүйл сэдэгчдийг хөөн тараах нь зүйтэй байна. Бид намаа дагаж жаргалтай, нараа дагаж, дулаан яваа улс. “МоАХ” гэгчийг санаачлагчид хэний буянаар эрдэм ном сурснаа ойлгодог болов уу? Тэд нам төрийн эсрэг олон түмнийг уриалан турхирах нь өөрсдийгөө хэн болохыг харуулж байна” (ахмад дайчин), “Баруун Европын зарим орны тогтворгүй этгээдүүдийг дуурайжээ. “МоАХ”-ныхон аль нэгэн тааруухан үйлдвэрийг өөрсдийн биеэр удирдан оролцож, онцгой бүтээл гаргавал дээр санагдана” (намын гишүүн, ахмад дайчин), “МоАХ” гэгч утга учиргүй хэсэг залуус гарч ирээд байгаа нь гайхал төрүүлж байна... “МоАХ” гэгчийг тарааж, санаачлагчидтай хариуцлага тооцох нь зүйтэй байна” (намын гишүүн) гэхчлэн бүтэн нүүр бэлтгэн гаргажээ. Иймэрхүү хандлага дайрлага хэвлэлээр тогтмол гарч байв.

Гүжир гүтгэлгийг эсэргүүцэж, Тав дахь цуглаанаа хийлээ

Эрх чөлөөний талбай дээр болсон 5 дахь цуглаан дээр Ц.Элбэгдорж “Их түүхийн ээдрээт нугачаанд олдсон үүлэн чөлөөний наран мэт алтан хормыг алдах эрх та бидэнд байхгүй” гэсэн нь “үүлэн чөлөөний наран мэт боломж, бололцоо” хэмээгдэн хожмоо онч мэргэн үг болон хэвшсэн билээ.

МоАХ-ны их хурлын тов ойртох тутам эрх баригчид “МоАХ гэгч” хэмээн гүжирдэж, дайрч доромжилсон үгээр дүүрсэн “хөдөлмөрчдийн захидал”-ыг төвийн хэвлэлээр улам бүр тарааж, “Хөдөлмөрчдийн индэр” гэх том буланд тогтмол нийтэлж байв. МАХН-ын ТХ-ны УТТ тусгай захидал хүртэл гаргасан юм. Түүндээ:

-Бий болсон шинэ нөхцөл байдалд манай иргэдийн зарим хэсгийн дотор, ялангуяа зарим хот, суурин газарт өөрсдийн үүсгэл санаачилгаар эвсэл, холбоо байгуулж, санал бодлоо янз бүрийн хэлбэрээр илэрхийлэх боллоо... Гэвч эдгээр эвсэл холбоодын дотор олон нийтийн санаа бодолд эргэлзээ төрүүлсэн утгатай үг, уриа лоозон хэрэглэх, сөрөг утга агуулгатай хуудас, уриалга бэлтгэж наах, хот хөдөөгөөр явж, хөдөлмөрийн хамт олон, ялангуяа залуучуудыг тэдгээр эвсэл холбоонд элсэхийг уриалах, тулган шаардах, хооронд нь сөргөлдүүлэх зэрэг үйлдэл сүүлийн үед нэлээд газар авах боллоо. Түүнчлэн хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулах, хэв журам зөрчих, нам төрийн бодлогыг гуйвуулах, тэр ч байтугай манай нийгмийн байгууллыг өөрчлөх шаардлага тавих болсонд өргөн олон нийт илт дургүйцэж, намын ТХ-нд захидал цахилгаан ирүүлж байна...

- ...зохион байгуулалт, сахилга, дэг журам сулрахад хүрвэл улс орны байдал тогтворгүйтэж, өөрчлөн байгуулалтын зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн саад тотгор зохиомлоор нэмэгдэх болно...

- Бид өөрчлөн байгуулалтыг хийхдээ өөрийн орны онцлог, эдийн засгийн боломж, түүхэн уламжлал, зан заншил зэрэг бүхий л хүчин зүйлийг зайлшгүй харгалзах бөгөөд манай өөрчлөлт шинэчлэл нь Монголын гэсэн өнгө аястай, дүр төрхтэй байх учиртай. Ийм учраас нийгмийн

зарим хэсгээс намын үйл ажиллагаа, улс орны хөгжилд өгч байгаа үнэлэлт дүгнэлт, түүнээс урган гарч байгаа аливаа асуудлын талаар өндөр тэвчээр гарган, чөлөөтэй ярилцлага, соёлтой маргаан, тайван, ажил хэрэгч санал солилцоог явуулахыг МАХН чухалчлан үзэж байна хэмээн 1990.02.02-нд “МАХН-ын гишүүд, орлогч гишүүд, Монголын нийт ард түмэнд” ханджээ¹⁶.

Иймд, “МоАХ-ны Анхдугаар их хурал улам ойртох тутам түүний талаар элдэв цуурхал, ташаа мэдээллийг түгээх, нэр хүндийг нь коммунистууд болон хөдөлмөрчдийн дунд гутааж, Холбооны их хурлыг тасалдуулах, улмаар МоАХ-г устгах талаар зард гарсан сталинч аргаа улайран хэрэглэж эхэллээ... МоАХ улс төрийн аюулд орлоо! Иймд МоАХ, салбар зөвлөлүүдийнхээ хамт 1990 оны 2 дугаар сарын 11-ний Ням гарагийн 13:00 цагт “Ялалт” кинотеатрын өмнөх талбайд ЦУГЛААН хийх болсныг зарлаж байна” хэмээн 02.07-нд МоАХ олон түмэнд зарлан мэдэгдсэн юм¹⁷. Цуглааныг АСХ-тэй хамтран зохион байгуулжээ.

1990.02.11-ний цуглаан яльгүй оройтож эхэлсэн ч төлөвлөсний дагуу үргэлжилсэн байна. Салбар зөвлөлүүд байгууллагынхаа нэрийг том даавуун дээр бичин ирж оролцсон нь МоАХ өргөжин тэлснийг, улс төрийн бие даасан том хүчин болсныг илтгэн харуулж байлаа.

Цуглаан дээр АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнхөд АСХ-өөс 02.08-нд хүргүүлсэн улс төрийн шаардлага бүхий Ил захидал-ыг уншиж танилцуулжээ. Ил захидалд,

“Нийгмийг ардчилах үндсэн нөхцөлийн нэг бол Үндсэн хуулийг шинээр боловсруулан батлах, энэ үндсэн дээр улс төрийн хуучин тогтцыг өөрчилж, хууль цаазат төр байгуулах ёстой гэж АСХ үзэж байна.

БНМАУ-ын Үндсэн хуулийн төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлэхээс өмнө Ардын депутатын сонгуулийн хууль, МАХН-ын дүрмийн төслийг хэлэлцүүлэн батлах гэж байгаа нь “МАХН-нийгмийн манлай хүч” гэсэн зарчимд Үндсэн хуулийг захируулах гэсэн хэрэг мөн гэж бид үзэн, дараах улс төрийн шаардлагыг тавьж байна.

1. Монголын ард түмний эрх ашгийг илэрхийлсэн, соёл иргэншлийн хөгжлийн чиг хандлагатай тохирсон улс төрийн тогтоц байгуулах зорилгоор Ардын Түр Хурлыг 1990 оны эхний хагаст багтаан, сонгуулиар байгуулах.

Ардын Түр Хурал нь ҮНДСЭН ХУУЛЬ, төрийн СОНГУУЛИЙН ХУУЛЬ-ийг боловсруулан, ард түмнээр хэлэлцүүлэн баталж, төрийн сонгууль явуулан, шинэ төрийн тогтцыг байгуулаад, өөрөө огцрох.

2. Ардын Түр Хурлын сонгуулийн журмыг боловсруулахад улс төрийн бүх хүчний төлөөлөгчийг тэгш эрхтэйгээр оролцуулах ба төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлж, улс төрийн хүчнүүдийн дугуй ширээний ярилцлагаар батлах ёстой гэжээ.

Тус цуглаан дээр АСХ-ий гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Н.Алтанхуяг хэлсэн үгэндээ “МоАХ-ны үйл ажиллагаа нь эрчимжиж, хүрээ нь тэлэхийн хэрээр хүнд суртал захиргааны аппаратын эрх ашиг шууд хөндөгдсөнөөс тэд өнөөдөр хариу дайралтанд орж, МоАХ-г янз бүрээр мушгин гуйвуулж, захидал тарааж, нэр хүндийг нь унагаахыг оролдож байна. Энэ нь зөвхөн МоАХ төдийгүй ардчилал, эрх чөлөө, тэгш эрх, шударга ёсны төлөө тэмцэж байгаа бусад бүх дэвшилт хүчний эсрэг чиглэсэн үйл ажиллагаа гэж АСХ үзэж байна... Нийгмийг ардчилах олон намын тогтоц бий болгох гэсэн үндсэн асуудлаар АСХ нь МоАХ-той санал нэг байгаагаа мэдэгдэж байна” хэмээн тэмдэглэжээ.

Үг хэлсэн хүмүүс гүтгэлгийн кампаниа даруй зогсоох, МоАХ-нд данс нээж, байр олгох, хэвлэлийн эрх чөлөөг олон түмэнд тэгш эдлүүлэхийг, радио ТВ, сонин хэвлэлээр үнэн бодит мэдээлэл өгч байхыг шаарджээ.

Баабарын “Бүү март... Мартвал сөнөнө” номыг АСХ хэвлэн гаргасныг мөн өдөр олон түмэнд хүргэжээ.

Ардчилсан Холбооны Анхдугаар их хурал хуралдлаа

1990.02.18-ны ням гараг. МоАХ-ны Анхдугаар их хурал МҮЭСТО-д нээгдлээ. Хуралд гурван хот, 16 аймгийн олон салбар зөвлөлийн 611 төлөөлөгч, 200 гаруй зочид, хэвлэлийнхэн хүрэлцэн иржээ. Монголын талаас албан ёсоор виз өгөөгүй учир жуулчны шугамаар орж ирсэн гадаадын 30 орчим сурвалжлагч оролцсон байна. Хурлын урилгыг эрх баригчдад ч өгсөн бөгөөд СнЗ-ийн нэгдүгээр орлогч дарга Д.Бямбасүрэн, Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны сайд П.Очирбат, эрдэмтэн К.Зардыхан нар СнЗ-ийн “чиглэл өгөн зөвшөөрснөөр... дээд давхарт зэрэгцэн сууж, хурлын үйл явцыг ажигласан” ажээ¹⁸.



Улаанбаатар хотын АДХГЗ-ны дарга Н.Мөнхжаргал нарын албаны хүмүүс ч хүрэлцэн иржээ.

Хурлын нээлтийн ажиллагааг радио ТВ-ээр орон даяар шууд дамжуулан нэвтрүүлсэн байна. Харин радиогоор нэвтрүүлж байснаа тасалсанд дургүйцсэн олон түмэн төв замын хөдөлгөөнийг хаасан төдийгүй МАХН-ын ТХ-ны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч Д.Цахилгааныг гадаа явж байхад нь тааран авчраад, Үйлдвэрчний соёлын төв ордноос радио, ТВ-рүү яриулж, орон даяар нэвтрүүлэх үүрэг өгүүлсэн юм.

МоАХ үнэхээр Монгол даяар үйл ажиллагаагаа хүргэж таниулсан улс төрийн хүчин болсныг өөрчлөлт шинэчлэлт ард иргэдэд ямар их хэрэгтэй шаардлагатай байгааг ганц энэ үйлдэл л харуулаад өгсөн гэхэд болно.

Хурлын улс төрийн илтгэлийг жүжигчин Д.Сосорбарам уншиж, олон түмэнд хүргэсэн байна.

Мөн-Сүсэг бишрэлийн эрх чөлөөл, -Хуулийн шинэчлэл хийх нь манай хувьсгалын амжилт ялалтын баталгаа мөн! хавсралт илтгэл хэлэлцжээ. МоАХ-ны мөрийн хөтөлбөр, дүрмийг баталлаа.

Хурлаас нийт ард түмэндээ хандан Анхдугаар их хурлын уриалга, Тулгар төр сэргэн мандсаны 80 жилийн ойн тухай уриалга гаргажээ. Мөн хурлаас БНМАУ-ын АИХ, МАХН-ын ТХ-нд хандан,

- Эрх баригч намын ТХ-ноос шууд томилогдсон, ард түмний итгэл найдварыг биелүүлж чадахгүйгээ нэгэнт харуулсан СнЗ-ийг огцруулж, АИХ-ыг тараах

- Засаг төрийн бүх эрхийг гартаа авч, ард түмний эрх ашигт харш бодлогоо муйхраар үргэлжлүүлэн, хувьсгалт өөрчлөн байгуулалтыг хазаарлан барьж байгаа өнөөгийн

намын ТХ-г огцруулж, хэмжээлшгүй эрх мэдлийг нь халах

- Засгийн бүх эрхийг гартаа авч, улмаар улс орны хувь заяагаар тоглон, хөдөлмөрчдийг ядуу зүдүү амьдралд байлган, нийгмийн өмчийг сүйтгэж, эдийн засгаа их ерөнд унаган доройтуулж, өөрсдийн эрх ямбаар ард олноо золиослосон этгээдүүдийн хэргийг ард түмний онц зөвлөлөөр шалган шүүж яллах

- ...Монгол орны эд хөрөнгө, үнэт баялгийг хойч үеийнхэндээ үлдээхгүй тонон дээрэмдэх бодлого, үйл ажиллагааг таслан зогсоож, Мардайн ураны, Эрдэнэтийн зэсийн, Заамарын алтны, Асгатын мөнгөний уурхайнуудыг нэн даруй хааж, цаашид газрын баялгийг ашиглах асуудлыг... ард түмнээр хэлэлцүүлж шийддэг журам тогтоохыг шаардсан байна.

Харин эрх баригчид МоАХ-ны 1989.12.10-наас эхлэн тавьсан шаардлага бүхэнд ямар ч хариу өгөөгүй хэвээр байсан юм.

“Шинэ толь” сонины анхны дугаар Их хурлын эхний өдөр гарч түгээгдэжээ. Ингэснээр Монгол шинэ чөлөөт хэвлэлийн анхны дугаар гарсан юм.

Ардчилсан Холбооны их хурал 35 хүний бүрэлдэхүүнтэй ЕЗЗ-ийг сонгож, С.Зориг, С.Амарсанаа, Я.Батсүх, И.Жавхлант, Д.Нинж, Д.Сосорбарам, Дарь.Сүхбаатар, Ц.Элбэгдорж, Ц.Энхтүвшин нарыг тэргүүлэгч гишүүнээр, С.Зоригийг Ерөнхий зохицуулагчаар баталсан байна.

Олон хүн баяр хүргэж, үг хэлснээс АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Б.Батбаяр (Баабар) “Хаан шалдан байна” хэмээн гал цогтой үгээ хэлсэн билээ. “Үг хэлэх эрхээр боогдсон ард түмэн “хааны гоё ганган хувцсыг” шагшин магтах эрхээр бүрэн хангагдсан байдаг төдийгүй

ерөөс ийм үүргийг үүрч явдаг жамын дагуу бид 50-60 жилийн турш шалдан хааныхаа дэгжин хувцсыг зогсоо зайгүй магтан дууллаа... Бид тос өөхөнд положтож буйгаа шүлэглэн сайрхахын хэрээр өлсөж байв. Сүүлдээ биологийн хувьд оршин тогтнож, турж үхчихээгүй л бол түүнийгээ хангалуун амьдрал гэж ойлгодог болчихжээ... Гэтэл бидний дундаас гэнэт Андерсены жаал хүү гарч ирээд, “Хаан шалдан байна!” гэж хашхирах нь тэр ээ! Олон жилийн турш “хувцасны магтаал”-аар гэдсээ тэжээж явсан хүмүүс, мөн хувцастай байна гэж ярьсаар байгаад, сүүлдээ түүндээ үнэмшин, нүцгэн хүнийг хувцастайгаар хардаг болчихсон хүмүүс энэхүү гэнэтийн үнэнд балмагдан сандарч, “Арай ч үгүй шүү!”, “Байчихаад хааныгаа шүүмжилдэг болох нь уу?”, “Ичгэврээ хаасан самбай байх нь ч байна аа хө!”, “Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөв гэгчээр!” гэгцгээн. “Хаан шалдан байна” гэсэн яриа гаргахгүй байхад хамаг ажил нь чиглэгдсэн олон олон аппарат одоо жаал хүүг намнахаар лантуугаа далайн хөөж явна. Гэвч өнөөдөр цаг өөр болжээ... “БИДНИЙ НҮД НЭЭГДЛЭЭ. ХААН ШАЛДАН БАЙНА” гэж өнгөрсөн ба одоогийн байдлыг уран сайхнаар харгуулан хэлсэн нь одоо ч хүмүүсийн цээжнээ хадаатай дурсагдсаар байна¹⁹.

“Ер нь социал-демократууд, МҮАН-ынхан МоАН-ыг марксист-ленинист зарчмаас татгалзахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж би хувьдаа үздэг” гэж тус хурлын төлөөлөгч Т.Отгонбаяр хожим дурсжээ²⁰.

Ийнхүү хурлаа хийсэн нь бүхий л түүхэндээ анх удаа эрх баригч хүчин эн сацуу өрсөлдөгч сөрөг хүчинтэй болсон буюу хэчнээн дарж дарамталж, “МоАХ гэгч” хэмээн ад үзсэн ч хүлээн зөвшөөрөгдөөд, даян дэлхийн сонорт Монголын ардчиллыг улам цуурайтуулан дуулгасан түүхэн үйл явдал болсон гэж болно.

Хурлын эхний өдрийн орой МоАХ-ны 70 хоногийн ойн өдөр их хурлын 24 төлөөлөгч МоАН-ыг санаачлан зохион байгуулахаар шийдсэн нь түүхэн тэмдэглэлт үйл явдал болсон юм. Энэ тухай шийдвэрээ буюу Монголын Ардчилсан нам 1990.02.17-ны өдөр байгуулагдсан тухай хурлын хоёр дахь өдөр 02.19-нд Ц.Элбэгдорж мэдэгдсэнд зочид төлөөлөгчид халуун дэмжиж, уухайн дуу хадаан хүлээж авсан. Ийнхүү Монгол орноо эрх баригч хүчинтэй эн зэрэгцэн өрсөлдөж ухаанаа уралдуулах улс төрийн хүчин, улс төрийн шинэ нам мэндэлсэн түүхтэй. МоАХ улс төрийн анхны намаа өлгийдлөө.

Шинэ намын зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МоАН-ын Ерөнхий зохицуулагчаар Э.Бат-Үүлийг, дэд зохицуулагчаар Д.Дорлигжавыг, нарийн бичгийн даргаар А.Муратыг сонгожээ.

1990.02.22-ны орой (шөнө болохын хэрд) Улсын Нийтийн номын сан (өдгөө Улсын Төв номын сан)-гийн өмнөх И.В.Сталины аварга том хөшөөг буулгасан юм. 1951 онд босгож, улсын хамгаалалтад авсан эл хүрэл хөшөө дарангуйлал, колоницлолын бэлгэдэл болж байлаа. Монгол хэлний үгийн сангаас “Сталины номын сан” гэдэг үг энэ цаг мөчөөс гээгдсэн. Хөшөө буулгахыг олон хүн ирж харсан бөгөөд догдлон хөөрцгөөж байсан юм.

АРДЧИЛСАН ХҮЧНҮҮДИЙН ЭВСЭЛ

1990.02.24-ний 14:00 цагт МУИС-ийн хичээлийн III байрнаа АСХ-ий байр (Математикийн тэнхим)-д ардчилсан хүчнийхэн (МоАХ, АСХ, ШДХ, МОХ-ны удирдлагууд) хамтын ажиллагаагаа хэлэлцэн уулзжээ. Р.Гончигдорж, Б.Батбаяр, Д.Ламжав, П.Улаанхүү (АСХ), Л.Болд (МОХ), МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүд, Д.Батсүх нарын ШДХ-ны тэргүүлэгчид иржээ.

Ирэх сарын 04-нд хийх хамтарсан цуглааны бэлтгэл, зохион байгуулалт, хамтарсан цуглаан жагсаалаас АИХ, НТХ-нд тавих шаардлагаа хэлэлцэн тохирчээ. Үүнд, АСХ Мардайн ураны ордын талаар асуудал дэвшүүлэх, Д.Сүхбаатарын талбайд жагсаал цуглаан хийхийг хориглож, 1990.01.17-ны өдрийн хотын АДХГЗ-ны Тэргүүлэгчдийн баталсан журмыг МОХ эсэргүүцэх, Зөвлөлтийн цэргийг Монгол улсын нутгаас гаргах, НАХЯ-ыг татан буулгахыг МоАХ шаардах, Үндсэн хууль, Сонгуулийн тухай хуулийг тухайн АИХ-аар батлуулахгүй байхыг ШДХ шаардахаар хэлэлцэн ярилцжээ.

Түүнчлэн 02.08-ны өдөр нам, төрийн тэргүүн Ж.Батмөнхөд явуулсан ил захидлыг улам дэлгэрүүлж, Ардчилсан хүчнүүдийн хамтарсан мэдэгдэл болгон гаргав. “Ер нь ингэж тус тустаа яваад байж болохгүй юм байна, хамтарья, хамтарч ярьдаг больё гэсэн процесс эндээс эхэлж байгаа юм” (Н.Алтанхуяг)²¹.

Тэр үед АСХ нь Ардчилсан хувьсгалын.. холбогдох улс төрийн бүх бичиг баримтыг эмхэтгэн гаргаж тарааж байжээ²².

АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ-нд хандан гаргасан Хамтарсан мэдэгдэлд,

Гүнзгий хямралд орсон улс төрийн тогтцыг үндсээр нь өөрчилж, нийгмийг ардчилахын төлөө тэмцэлд МоАХ, АСХ, ШДХ, МОХ-ны төлөөлөгчдийн Анхдугаар хуралдаанд оролцогчид зорилго нэгтэй байгаагаа албан ёсоор мэдэгдэн, дараах шаардлагуудыг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ-нд тавьж байна.

1. МАХН-ын ТХ-ны Онц их хурлыг 1990 оны 3-р сард зарлан хуралдуулж, МАХН-ын ТХ-ны бүрэлдэхүүнийг өөрчилж, намын үйл ажиллагааг ардын төрөөс тусгаарлах

2. Улс төрийн бүх хүчнийг тэгш эрхтэйгээр оролцуулан Ардын Түр Хурал-ыг 1990 оны 3-р сард багтааж байгуулах. Ардын Түр Хурал нь БНМАУ-ын ҮНДСЭН ХУУЛЬ, төрийн СОНГУУЛИЙН ХУУЛЬ-ийг боловсруулан баталж, ардын шинэ төрийг ардчилсан сонгуулиар байгуулаад огцрох.

3. Дээрх асуудлыг шийдвэрлэх явцад эх орны тусгаар тогтнол, улс үндэсний эв нэгдэл, ард түмний аюулгүй байдал ямар нэг хэлбэрээр хөсөрдөх ёсгүй.

4. Энэхүү мэдэгдлийн албан ёсны хариуг 1990 оны 3-р сарын 7-ны дотор радио ТВ-ээр өгөх. Хариу өгөх цагаа нийтэд урьдчилан мэдэгдэх гэжээ.

Ардчилсан хүчнүүд БХЯ, НАХЯ-ны бие бүрэлдэхүүнд хандан, хүч үл хэрэглэх, хүлээцтэй байхыг уриалан, 02.28-нд мэдэгдэл гаргасан байна.



03.04-НИЙ СҮРТ ЖАГСААЛ ЦУГЛААН

Ардчилсан хүчнүүдийн анхны хамтарсан цуглаан хаврын энэ сайхан өдөр болсон юм. “Ажилчдын цалинд хэмжээ хэрэггүй!”, “Ашигт малтмал, байгаль ээж маань сүйдэж байна!”, “Бид хямд ажиллах хүч биш!”, “Зээлийн социализмыг халъя!”, “МАХН-ын онц их хурлыг яаралтай хуралдуулъя!”, “Монгол авлагатай гэхээс өртэй байх ёсгүй!”, “Монгол-Түүхий эдийн бааз байх ёсгүй!”, “Томилолтын депутатууд хууль батлах эрхгүй!”, “Уран, Алт, Мөнгө, Зэс-Ард түмний өмч!”, “Хүний эрхийг дээд зэргээр эрхэмлэе!”, “Ю.Цэдэнбалын хамсаатнууд үгээ хэл!” гээд хэдэн арван уриа лоозон барьж жагссан байв.



Оролцогч хүчнүүд дэвшүүлж буй шаардлагаа цуглаан дээр танилцуулж тайлбарласан юм. АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын Төв хороонд илгээж байгаа Ардчилсан хүчнүүдийн 02.24-ний өдрийн хамтарсан мэдэгдлийг сонордуулаад, “мэдэгдлийн албан ёсны хариуг 1990 оны 3-р сарын 7-ны дотор радио ТВ-ээр өгөх. Хариу өгөх цагаа нийтэд урьдчилан мэдэгдэхийг шаардаж байна” хэмээн Ц.Элбэгдорж уншиж танилцуулжээ.

АСХ-ий Д.Ламжав “Өнөөдөр Монгол улс ЗХУ-д 9.5 миллиард рублийн өртэй гэж нөгөө тал тооцоолжээ. Манай нэг хүн, түүний дотор өлгийтэй хүүхэд хүртэл 4 670 рубль (23 000 төгрөг)-ийн өртэй байх нь. Хагас зуу гаруй жилийн турш хотоо хоосортол малаа өгч, гэрээ нүцгэртэл ноос ноолуураа албадуулан өгсөн монголчууд яагаад өртэй байдаг билээ? Хязаалан гунаа 37 рубль (150 орчим төгрөг)-ээр, хязаалан хонио 6 рубль (30 хүрэхгүй төгрөг)-ээр өгч байжээ... Ийм шударга биш гэрээ хэлэлцээрт МАХН-ын ТХ буюу Засгийн газар ах дүүгийн найрамдлыг эрхэмлэхийн үүднээс гарын үсэг зурсаар иржээ. Түүгээр ч үл барам 2005 он хүртэл зурчихаад байна!! гэсэн нь Зөвлөлт гүрний өгөөмөр буян гэж бүтээн байгуулалт, аливаа сайн сайхнаа бодож шүтэж ирсэн түмэн олонд тун хүчтэй туссан. “Гэгээн Зөвлөлт орон, ах нар” гэж харж найдаж, алгаа тосоод “бэлэг” гэж авч ирсэн бүхэн нь ачир дээрээ өр байсан үнэнийг энэ цуглаан дээр анх гаргаж тавьсан. Нээрээ ч хожим Их өр-ийг тооцоход “буцалтгүй тусламж, бэлэг”-ийн шугамаар барьж босгосон байшин бүр өрийн дансанд тусаад бодогддог байсан нь олонд ил болсон. Бас нэгэн малчны “гаднаа нэгдэл нийгмийн мянган хонь ямаатай хэр нь амаржсан эхнэртээ гаргаад өгөх туранхай төлөгний мэдэлгүй, хэчнээн км давхиж байж, сумын даргаар цохуулж авдаг, мал хорогдуулбал төлдөг, үс ноос

дутаавал торгууль ялд унадаг” гэж өчнөөн олон жишээ хэлсэн нь талбай дээрх олны түрхрээнийг чамгүй өдөөсөн аж.

Цуглааны үеэр АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн дарга Р.Гончигдорж “Монгол улсаа сэргээн мандуулж, шинэ дэвшлийн зам дээр гарган, өнөө үед бид аль нэг анги, нам, бүлэглэл өөрийн улс төрийн ноёрхлыг дан ганцаар тогтоох боломжийг бүрдүүлэхгүй байх тийм улс төрийн шинэ системийг тогтоохын төлөө тэмцлээс бид ажлаа эхэлсэн... АСХ үүсэхээсээ л баримталж байгаа социал-демократ үзэл бодлоо улам улам тодруулсаар... **АСХ-ий бүрэлдэхүүнд МСДН байгуулагдсаныг** өргөн олон түмэндээ тунхаглан зарлаж байна... МСДН улс орны улс төрийн амьдралын онцлог байдлыг харгалзан үзээд, аливаа намын гишүүдийн хувьд ч нээлттэй байхаар шийдлээ” гэжээ. Үүгээр Монгол орноо улс төрийн шинэ нам-МСДН байгуулагдсаныг зарлан мэдэгдсэн юм.

Жич: Зөвлөлтийн “Известия” сонин (1990.03.02)-д “1989.11.01-ний байдлаар ЗХУ 61 орноос нийт 85.8 тэрбум рублийн авлагатай, нийт 12 социалист орон 43.8 тэрбумын өртэй, түүний дотор БНМАУ 9.5 тэрбум рублийн өртэй” гэж гарсан байв.

Хүмүүс үг хэлж, шударга тэмцэлд уриалсан цуглаан үд дунд хүрч 12:00 цаг өнгөрөөгөөд өндөрлөж, Хамтарсан мэдэгдэл, шаардлагаа эрх баригчдад гардуулахаар олон мянган хүн цөм Д.Сүхбаатарын талбай тийш хөдөлсөн юм.

Энэ өдөр 90 гаруй мянган хүн Ялалтын талбайгаас хөдөлсөн нь үнэхээр сүрлэг дайчин жагсаал байлаа. Хөөрч бахадсан үй олон хүн хоолой нийлүүлэн “Шаардаж байна... шаардаж байна”, “Огцор... огцор!” гэхэд талбай тэр аяараа

доргиж, эрх баригчид ордон дотроо чичирч байсан.

Засгийн газрын ордноос АИХ-ын Тэргүүлэгч гишүүн, МҮЭ-ийн Төв зөвлөлийн дарга Г.Лувсанцэрэн гарч ирж, Ардчилсан хүчнүүдийн хамтарсан мэдэгдэл, шаардлагыг хүлээн авсан байна.



УЛС ТӨРИЙН ӨЛСГӨЛӨН ЗАРЛАЖ ТЭМЦЭВ

Тэмцлийн хурц хэлбэрийг сонголоо

Ардчилсан хүчнүүдийн төлөөлөгчдийг МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга, АИХ-ын орлогч дарга Ц.Намсрай тэргүүлэн Б.Даш-Ёндон, Н.Мишигдорж, Б.Чимид нар Засгийн газрын ордонд хүлээн авч уулзсан байна. Үүгээр, 03.04-нд тавьсан шаардлагын алийг ч хүлээн авах боломжгүй буюу,

1. МАХН-ын ээлжит их хурлыг хуралдуулах хугацааг нааш татахгүй...

2. АИХ бүрэн эрхээ хууль ёсоор эдэлж байгаа нөхцөлд нийт хөдөлмөрчдийн хүсэл зоригоос гадуур, Үндсэн хууль тогтоох эрхтэй “Ардын түр хурал”-ыг байгуулах нь манай ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагааг дур мэдэн зогсоож, Үндсэн хуулиа ноцтой зөрчихөд хүргэх юм...



Иймээс Үндсэн хуулийг шинэчлэн найруулах ажлыг түргэтгэхийн хамт төрийн эрх барих дээд байгууллагын шинэ тогтолцоог бий болгох, сонгууль хийх хугацааг наашлуулах саналыг АИХ-ын ирэх чуулганд оруулах нь зүүйтэй гэж үзсэн урьдах шийдвэрээ АИХ-ын Тэргүүлэгчид дахин нотолж байна хэмээн хариу өгсөн юм. Энэ хариуг 03.06-07-ны өдөр радио, ТВ-ээр давтан давтан нэвтрүүлжээ.

Ийнхүү эрх баригчид Ардчилсан хүчнийхний шаардлагыг цаг хожих үүднээс хүлээн аваагүй тул (03.07-ны 12:00 цаг гэхэд албан ёсоор хариу ирүүлэхгүй нь тодорхой болоод байгаа тул) улс төрийн тэмцлээ цаашид хэрхэн өрнүүлэх талаар МоАХ-ны ЕЗЗ дээр ярилцаж хуралджээ. Хурал дээр улс төрийн өлсгөлөн зарлах санаа (Л.Хадбаатар) анх гарч дэмжигджээ. Шийдвэрийг 03.06-07-нд шилжих шөнө дүл болгож Монументал чимэглэлийн үйлдвэрт үргэлжилсэн МоАХ-ны ЕЗЗ-ийн хурлаас гаргасан байна. Шийдвэр амаргүй гарчээ. Өлсгөлөн зарлах эсэх дээр 03.06-ны оройдоо санал зөрөлдөж байсан ч олонх нь дэмжжээ.

Эхний ээлжинд 10 хүн өлсгөлөнд оролцохоор болсон хийгээд тэдний цээж зураг, намтар бүхий ухуулах хуудас, самбар гаргахаар болжээ. Ингээд МоАХ-МоАН-ын гишүүн Д.Батбилэг, Э.Бат-Үүл, Б.Батцэнгэл, Г.Бошигт, Б.Галсандорж, Д.Дорлигжав, И.Жавхлант, Д.Нинж, Д.Энхбаатар, З.Эрдэнэбат нарын 10 хүн **03.07-ны өдрөөс УЛС ТӨРИЙН ӨЛСГӨЛӨН ЗАРЛАЛАА.** Тэдний цээж зураг, мэдэгдэл бүхий ухуулах хуудаст, "ӨЛСГӨЛӨН зарлаж байна. Монгол ах дүү нар аа!... МоАХ-ны эсрэг өнөөгийн удирдлагын аппарат бүх чиглэлээр дайран довтолж байгааг хүн бүр андахгүй мэднэ. МоАХ-г данс, байр, хэвлэлгүй байлгах зорилгоо эрх мэдэл бүхий хүмүүс махран хэрэгжүүлсээр өнөөдрийг хүргэлээ... Монголын ардчилсан хүчнүүдийн

шаардлагыг үл тоомсорлож, хариуг Хамтарсан мэдэгдэлд заасны дагуу өгсөнгүй... МАХН-ын ТХ-ны бүрэлдэхүүнийг өөрчилж, намын үйл ажиллагааг засаг төрөөс тусгаарлах, МАХН-ын Онц их хурлыг хуралдуулах, мөн улс төрийн бүх хүчин тэгш эрхтэй оролцсон БНМАУ-ын Үндсэн хууль, Сонгуулийн хуулийг баталж, ардын шинэ төрийг ардчилсан сонгуулиар сонгох Ардын түр хурлыг байгуулах хугацааг тус тус 3-р сард багтааж тогтоохыг албан ёсоор шаардаж, МоАХ-ны ЕЗЗ-ийн 10 гишүүн 1990 оны 3-р сарын 7-ны 14:00 цагаас эхлэн Сүхбаатарын талбайд ӨЛСГӨЛӨН зарлаж байна. Монголын Ардчилсан Холбоо” гэжээ.

АСХ —Хамтарсан мэдэгдлийн шаардлагуудыг хүлээн авахгүй гэдгээ 3-р сарын 6-ны өдөр АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ албан ёсоор мэдэгдсэн нь АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ХӨДӨЛГӨӨН (АСХ)-ий дургүйцлийг хүргэж, улс төрийн цаг үеийн байдалд бодит дүгнэлт хийж хүлээн авна гэж итгэж байсан итгэлийг хөсөрдүүлээ. Энэ байдал нь зарим хүмүүсийг эсэргүүцлээ илэрхийлж, ӨЛСГӨЛӨН ЗАРЛАХАД хүргэлээ. Хүний эрх, хүнлэг энэрэнгүй ёсыг эрхэмлэн дээдэлдэг АСХ эдгээр хүмүүсийн эрүүл мэнд, амь насанд аюул занал учирсныг ухамсарлан ойлгож, гүнээ сэтгэл түгшихдээ БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ-нд улс төрийн хүчнүүдийн өнөөгийн байдалд эрүүл саруул дүн шинжилгээ хийж, ардчилсан хүчнүүдийн ХАМТАРСАН МЭДЭГДЛИЙН шаардлагыг хүлээн авахыг дахин шаардаж, 03.07-нд мэдэгдэл гаргав.

Харин эрх баригчид мөн өдрийн орой нь “Өнөөдөр Улаанбаатар хотод МоАХ, АСХ-ий 11 хүн өлсгөлөн зарлаж... энэ сарын 4-ний өдөр... зохих шугамаар өгсөн хариуг хүлээн авахгүй гэдгээ илэрхийлсэн байна... МАХН-ын ТХ-ны VIII бүгд хурал энэ 3-р сарын 12-нд, АИХ-ын чуулган 3-р сарын 21-нд болж, улс төрийн шинэчлэлийн

асуудлуудыг авч хэлэлцэнэ гэдгийг манай ард түмэн сайн мэднэ... Зөвхөн өөрсдийн байр суурийг тулган хүлээлгэхийг оролдож байгаа зарим эвсэл холбооны доторх хүчнүүдийн оролдлого өөрчлөн байгуулалтад тус хүргэхгүй... Энэ нөхцөлд МоАХ, АСХ-ий зарим гишүүд өлсгөлөн зарлаж байгаа нь хүнлэг энэрэнгүй ёсонд нийцэхгүй бөгөөд нийгмийн ашиг сонирхолд харшлахаас гадна өлсгөлөн зарлагчдын эрүүл мэндэд хохирол учруулж, олон нийтийн санаа сэтгэлд сөрөг нөлөө үзүүлж болох юм. Үүнээс үндэслэн өлсгөлөн зарлах явдлаа зогсоож, улс орны өөрчлөн байгуулалтын үйлсэд хууль ёсыг хүндэтгэж, бүтээлчээр оролцох талаар ард түмэндээ өгсөн амлалтаа биелүүлэхийг МоАХ, АСХ-д БНМАУ-ын Засгийн газар уриалж байна” хэмээн буруутгасан мэдэгдэл хийсэн билээ.

Үйл явдал маш хурдан өрнөж байлаа. Өлсгөлөн зарлагчид эхний өдөр 03.07-ны орой 17 болж нэмэгджээ. Д.Сүхбаатарын талбайд иргэдийн цуглаан болж, чөлөөт индэр ажиллаж байв.

Бас энэ үеэр Эмэгтэйчүүдийн баяр-Мартын 8 таарсан нь эрх баригчдад ардчилсан хүчнийхнийг гүжирдэн муулах шалтаг болж, тэд үүнээ суртал нэвтрүүлэгтээ чадамгай ашигласан юм. Ар гэрийнхнийг нь ч харааж зүхэн дарамталжээ. “Төрүүлсэн эхийг нь гичий, хүүг нь гөлөг гэж хараах нь ийм цагт юу чиг биш бөгөөд хэрвээ манай удирдлага хүн ёсны хор шараа барьж чадалгүй, мэдээжээр цус урсгахаас буцахгүй зарим нэг харгис хатуу этгээдийн шаардлагыг угтан авах юм бол тэр хэдэн банди нарыг хумиад хаях ёстой нохойн наадам”²³. гэж С.Эрдэнэ зохиолч өгүүлсэн байдаг.

“Маргааш өглөө нь хүмүүс ирээд л, үзээд л, шаваад л... Гэтэл нэг жагсаал орж ирлээ гэдэг юм байна. Энэ юу юм



бол гэтэл Зоос гоёлын ажилчдын жагсаал гэнэ. Тэд хашгирч, ордныг нэг тойрлоо... Ер нь байгууллагын хамгийн анхны жагсаал тэр байсан шүү. Баасангийн зохион байгуулсан лам нарын жагсаал, түүний дараа шүү дээ” хэмээн Засгийн газрын ордны комендатур (Төрийн ордны хамгаалалтын албаны дарга) байсан Ц.Батдорж дурсжээ²⁴.

Өлсгөлөн зарлагчид, тэднийг дэмжигчдийг эрх баригчдын үзэл суртлын хэрэгслээр “монголоо алдсан, амьдрал мэддэггүй, монгол ёс заншлыг уландаа гишгэсэн, муусайн эрлийзүүд, хулигаанууд” гэхчлэн харааж, элдвээр зүхэж байлаа.

Өлсгөлөнгийн хоёр дахь өдөр 03.08-ны үдээс хойш СнЗ-ийн орлогч дарга Д.Бямбасүрэн Д.Сүхбаатарын талбайд ирж, өлсгөлөн зарлагчидтай уулзжээ. Оройн 18:00 цагаас эрх баригчид, сөрөг хүчнийхэн дугуй ширээний уулзалт хийж, ТВ-ээр шууд дамжуулах талаар ярилцжээ.



Ингээд СнЗ-ийн дарга Д.Содном, орлогч дарга Д.Бямбасүрэн нартай ТВ-ийн шууд ярилцлагад орохоор

Д.Баасан, Э.Бат-Үүл, Б.Галсандорж, Д.Дорлигжав, С.Зориг, Ц.Энхтүвшин нар ТВ-рүү түргэний машинаар явжээ. Гэсэн ч халз ярилцлага төдийлөн бүтэлтэй болоогүй юм.

Засгийн газрын тэргүүн Д.Содном, Д.Бямбасүрэн нараас гадна олон нийтийн төлөөлөгчид, эмэгтэйчүүд ирсэн бөгөөд тэд “Мартын 8-наар өлсгөлөн зарлалаа, эмэгтэйчүүдийн баярыг, эхчүүдийн баярыг гутаав! гэж дайрлан, зарим нь уйлж сүрдүүлж байсан. Мартын 8 бол баярын өдөр биш, харин та нарын эрхээ хамгаалж тэмцэх өдөр гэж С.Зориг тайлбар хийсэн ч сонсоогүй (юм уу ойлгоогүй) байрын харагдаж байлаа. Уулзалт үр дүнгүй болсон. Эрх баригчид Ардчилсан хүчнүүдийн удаа дараа тавьсан шаардлагыг хангах талаар огт санаачилга, бэлтгэлгүй байсан нь тодорхой болсон юм.

Ардчиллыг нухчин дарах гэсэн оролдлого бүтэлгүйтсэн нь...

Өлсгөлөн зарласан гурав дахь хоног 03.09-ний өдөр. Жихүүн салхитай, шороо шуурсан бүрхэг өдөр байлаа. Д.Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлагсад, тэднийг дэмжигсдийг цэргийн хүч хэрэглэн тараах гэж байгаа гэсэн яриа тархаад байв. МОХ хичээл хаялт зарлаж, сургууль сургуулийнхаа үүднээс жагсаалаар талбайруу орж ирж, үзэл бодол, эв санаа нэгдэлтэй байгаагаа илэрхийллээ. Сануулах хичээл хаялт 03.09-ний үдээс өмнө болж, 7 000 гаруй оюутан оролцсон байна. МОХ-ны дэргэд их, дээд сургууль, техникумуудын оюутныг төлөөлсөн 60 гаруй гишүүнтэй Хичээл хаялтын хороо байгуулагдаад байсан юм. Хэд хэдэн аймгийн төвд жагсаал цуглаан болж, Улсын барилгын зургийн институтын инженер техникийн ажилтнууд мөн өдөр дөрвөн цагийн сануулах ажил хаялт

зарлаж, Барилгын машин механизмын үйлдвэрийн 39 ажилтан ажил хаяхад бэлэн байгаагаа мэдэгдлээ²⁵.

Харин Улаанбаатар хотын дэлгүүрүүдэд архи чөлөөтэй худалдаж эхэлсэн байдаг. Ардчилсан хүчнүүд сэрэмжлэн, улс төрийн нөхцөл байдал түвэгтэй ээдрээтэй байгаа үед архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байхыг уриалж, 03.09-нд уриалга гаргав. Үдээс хойш хүмүүс улам нэмэгдээд, эмх замбараагүй байдал ч гарч болзошгүй болоод, Мартын 8-ныг тэмдэглэгсэд, бас бус өдөөн хатгагчид, хийрхэж хөөрсөн хүмүүс ирж байв. Тиймээс хамгаалалтдаа их анхаарч, улам хүчилжээ. Өлсгөлөнд оролцогчдын тоо 03.09-ний 19:00 цагийн үед 32 болоод, цаашид ч нэмэгдэх аястай болоод иржээ.

Нийслэлд төдийгүй хөдөө орон нутагт ч өлсгөлөн дэмжсэн жагсаал цуглаан тасралтгүй болж байв. Энэ хэр Дорнод аймагт жүжиг бичих томилолтоор ажиллаж байсан нэрт зохиолч С.Эрдэнэ “Чойбалсан хотын хэдэн залуу маргааш талбай дээр гарч, өлсгөлөн зарлахаар шийджээ. Аймгийн удирдлага бөөн сандраан болж буй гэнэ”²⁶, “буудалдаа ирж, аймгийн радиогийн сурвалжлагч, танил залуу шүлэгчид утасдвал “Манайхан эхэлчихсэн. Гурван залуу Халх голын ялалтын талбайд “Хонда” мотор асааж, телевизор тавьчихаад, дах нөмрөөд сууж байна” гэв”. хэмээн зөвхөн эл газрын улс төрийн агаарыг хүүрнэсэн нь бий²⁷. Улаан загалмайн нийгэмлэгээс эмч нар ирж, эмчийн үзлэгт оруулан, хяналт тавьж байв. Д.Баасан лам Гандантэгчинлэн хийдээс лам нарыг залж, уншлага ном хийлгэсэн нь сэтгэлийн их дэм, урам өгсөн төдийгүй олон нийтэд ч их эерэг сэтгэгдэл төрүүлсэн юм. Мөн өдөр (03.09)-ийн 15:00 цагт Засгийн газрын ордны А танхимд МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд, НТХ-ны нарийн бичгийн дарга нар, ТХ-ны хэлтсийн эрхлэгч, АИХ-ын Тэргүүлэгчдийн зарим гишүүн, СнЗ-ийн гишүүдийг урьж цуглуулж, нөхцөл

байдлыг танилцуулжээ. Энд олон асуудал яригдсан боловч хоёр гол асуудал дээр анхаарчээ. Үүнд, нэг нь МоАХ-ны үйл ажиллагаа хууль зөрчиж байна гэж үзэж, Прокурорын мэдэгдэл гаргах, нөгөө нь “Улаанбаатар хотод нийгмийн хэв журам сахиулах онцгой арга хэмжээний тухай” АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг гаргах гэсэн хоёр санал байжээ²⁸. Уг зарлигийн төслийг хэлэлцүүлэхээр бэлдсэнийг АИХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Готов уншиж танилцуулжээ. Энэ нь “1990 оны 3-р сарын 9-ний өдрөөс эхлэн мөн оны 7-р сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлийн их тойргийн доторх бүх гудамж талбай, түүнчлэн галт тэрэг, нисэх онгоцны буудал, тусгай харуул, хамгаалалттай газрын дэргэд хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх, нийтийг хамарсан бусад арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай... зарлиг зөрчсөн хүмүүсийг 100-1000 төгрөгөөр торгох буюу 30 хоног баривчлах, хууль ёсоор зөвшөөрөл олгогдоогүй болон хууль тогтоомжийн заалт зөрчиж хийсэн цуглаан, хурал, жагсаал ёслолыг тараах шаардлага тавих, түүнчлэн эмх замбараагүй байдал бий болсон тохиолдолд техник хэрэгсэл хэрэглэх, энэ зарлигийг 3-р сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэсэн зарлигийн төсөл байв. Үүнийг “зарим нь дэмжээд, ихэнх нь амандаа ус балгасан юм шиг дүнсийлдээд, Батмөнх дарга ширээ тоншисхийн, дуугүй суугаад байж. Цөм баргар царайтай. Тэгтэл генерал Жамсранжав “Хөл хорих цаг юм уу Онц байдал тогтоох зарлиг та бүхэн гаргаж болох л юм биз. Харин тэр Онц байдлыг хянаж барьж байх цэрэг цагдаагийн хүч миний мэдэлд байхгүй. Тиймээс хэрэв ийм зарлиг гаргах дээр хүрэх юм бол миний бие огцрохоос өөр замгүй” гэжээ. Цугларагсдын ихэнх нь түүнд зэвүүрхэн шуугилдав. Гэвч босоод загнах хүн бас гарсангүй! хэмээн НТХ-ны цэрэг, аюулаас хамгаалахыг хариуцсан захиргааны хэлтсийн

орлогч эрхлэгч асан Л.Пүрэвдорж ярьсан байдаг²⁹.

НАХЯ-ны сайдын эсэргүүцсэн үг танхимын уур амьсгалд нөлөөлжээ. ТХ-ны гишүүн Ц.Гомбосүрэн, Ш.Гунгаадорж, Ч.Сүрэн нарын хүмүүс ч зарлигийн төслийг эсэргүүцжээ. “Зарлиг гаргахыг дэмжсэн хүмүүс ч цөөнгүй байсан. Эцэст нь Батмөнх дарга ийм зарлиг гаргах хэрэггүй гэж хэлсэн. Үүгээр санал солилцол дууссан” байна³⁰.

“Монгол оронд Онц байдал зарласан тохиолдолд дагаж мөрдөх хууль эрхийн актуудыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Батлан хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, шаардлагатай үед эрх олгогдсоноор уг зөвлөлийн дарга Ж.Батмөнх гарын үсэг зурж, нарийн бичгийн дарга тамга даран баталгаажуулах ёстой байсан юм. Тийм эрхийн акт 10 гаруйг гарын үсэг зурахад бэлнээр нэгэн тусгай хавтаст битүүмжлэн, хатуу лац хайлуулан, БНМАУ-ын Батлан хамгаалах Зөвлөл гэсэн тамга даран онцгойлон хадгалсан байлаа” гэж Батлан хамгаалах Зөвлөлийн нарийн бичгийн дарга асан хурандаа бээр дурсан бичжээ. Тэр үед түүнд 03.07-ны шөнө НАХЯ-ны сайд А.Жамсранжав хүнээр дамжуулж, 03.08-нд УТТ-ны гишүүн Б.Дэжид (НТХ-ны хэлтсийн эрхлэгч Н.Жанцан зэрэг бусад хүнтэй байгаад), дараа нь СнЗ-ийн орлогч дарга Ч.Сүрэн (өрөөнд нь СнЗ-ийн орлогч дарга Б.Шаравсамбуу цуг байжээ) нар тус тусгаа дуудан уулзаад зарлигийн төсөл өгөхийг хэлж байжээ. “Би ер нь сайд дарга нарын үгнээс төдийлөн зөрдөггүй, дуулгавартай ажилтан байсан боловч цаг үеийн урсгалд автсан уу, алсын хариуцлагаа бодсон уу, тэдний саналыг хүлээж аваагүй юмдаг” гэжээ³¹.

Энэ хэр хүмүүс нэмэгдэж ирсээр, Засгийн газрын ордныг гороолон жагсах боллоо. “Шаардаж байна,... огцор, огцор!” гэж уухайлан шаардаж жагсаж байв. Талбай дээр хэдэн мянган хүн цуглаж, арын эгнээнийхэн нь өмнөх улсаа түрж шахаад, зохицуулахад улам бэрх болж байжээ.

Нөхцөл байдал хурцдан, цугларсан олон хяналтаас гарч байв. Энэ үед ардчилсан хүчнүүд хүлээцтэй хандсанаар мөн өдрийн 19:00 цагт хэлэлцээр үргэлжилсэн байна. Өлсгөлөн зарлагсад болон МоАХ, МоАН-ын төлөөлөл Э.Бат-Үүл, Б.Галсандорж, Д.Дорлигжав, Ц.Элбэгдорж, АСХ-ий төлөөлөл Б.Батбаяр, Р.Гончигдорж, Д.Ламжав, П.Улаанхүү нар яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр Засгийн газрын ордон тийш явжээ. СнЗ-ийн орлогч дарга Д.Бямбасүрэн, АИХ-ын Тэргүүлэгчдийн хэлтсийн дарга Б.Чимид, МАХН-ын ТХ-ны хэлтсийн эрхлэгч Д.Цахилгаан нар энэхүү дугуй ширээний уулзалтад оролцсон юм.

Улс төрийн товчоо огцрохоо мэдэгдлээ

1990.03.09-ний орой МАХН-ын ТХ-ны УТТ хуралдаж Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шийдвэр гаргав. Х э л э л ц э э р т оролцогчдод Засгийн газрын төлөөлөгч Д.Бямбасүрэн МАХН-ын ТХ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсныг мэдээлсний сацуу ардчилсан хүчний тавьсан бусад шаардлагыг зарчмын хувьд хоёр тал тохиролцсон тул Д.Сүхбаатарын талбай дахь улс төрийн өлсгөлөнг 22:00 цагт зогсоолоо.

Дэвшүүлсэн үндсэн асуудал, тавьсан шаардлагын хүрээнд тохиролцоонд хүрч, УТТ огцрох болсныг АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх радио, ТВ-ээр хэлсэн үгэндээ оройн 23:00 цагт мэдэгдлээ.

Нам, төрийн тэргүүн бээр “Нэгдүгээрт,... эвсэл холбоодын тавьж байгаа нэг гол шаардлага бол МАХН-ын Онц их хурлыг зарлан хуралдуулах саналыг НТХ-ны одоо болох бүгд хуралд оруулж хэлэлцүүлэх асуудал юм. Энэ

асуудлаар өчигдөр тодорхой ярилцсан...

НТХ-ны УТТ авч үзэж байна. Бид энэ сарын 12-нд хуралдах НТХ-ны ээлжит бүгд хурлаар энэ онд намын Онц их хурлыг хуралдуулах тухай асуудлыг зориуд санал болгон оруулах болно. Бүгд хурал энэ асуудлыг бүрэн хүлээж авна гэдэгт итгэж байна... Хоёрдугаарт, одоо болох бүгд хуралд НТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох саналаа оруулах нь зүйтэй гэж үзэж байна... Бид одоо аймаг хотын намын хороодод бас энэ тухай мэдэгдэж байна. УТТ ийнхүү огцорч, шинэ товчоог сонгох нь намын одоогийн удирдлагын бүрэлдэхүүнийг шинэчилж байгаа хэрэг юм. Энэ бүрэлдэхүүн бол шинэ бүрэлдэхүүн байх нь мэдээж..." хэмээн мэдэгдсэн юм.

Ингэж Монголын ардчилсан хувьсгал оготно хулганы хамраас цус гаргах нь бүү хэл ганц цонхны шил хагаралгүй ялсан түүхтэй. Энд монгол хүний саруул ухааны цараа харагдсан хэрэг ээ. Зохиолч Ч.Галсан "... Эртхэн хөдөлж, газар хороож авах учиртай байсан өөрчлөн байгуулалтын хөсөг сая гараагаа авсанд өөрийн хувьд ногдох буруутай ч гэсэн тэрээр улс орны хувь заяанд шийдвэрлэх өдрүүдэд нам, төрийн удирдагчийн бат нуруу, уужим ухаан гаргаж, МАХН сууриасаа бүрмөсөн хөндийрөх аюулын хар үүлийг хаан сарниулж чадсан гэж хэлмээр бодогдоно" гэжээ. Мөн түүнчлэн "Бурхны авралаар бидэнд монгол Чаушеску заяагаагүй нь яамай. Хэрэв Чаушеску шиг хүн төрийн эрхэнд байсан бол, зэвсгийн хүчээр дарья гэсэн УТТ-ны хоёр ч гишүүнийхээ саналыг няцаагаагүй бол ямар эмгэнэлт байдалд орж болох байсныг бодохоос ч шимширмээр... Улс төрийн асар их эр зориг, зөвхөн монгол хүнд л баймаар ууч сэтгэл, ард түмнээ гэсэн үнэн итгэл удирдагчаас маань эгзэгтэй бөгөөд хэрэгтэй үед гарч чадлаа! (Ц.Батбаяр)³², "Ямар ч ноцтой үр дагаварт хүрч болзошгүй улс төрийн

хямралыг ухаалаг зохицуулахад төр, Засгийн газраас гол үүрэг гүйцэтгэсэн цөөн хүний эхний хоёрын нэг нь Батмөнх гуай, нөгөөх нь Бямбасүрэнг гэж би боддог.



Нөхцөл байдлыг зөв ойлгон үнэлж, зөв шийдвэрлэх, түүнийг зөв хэрэгжүүлэхээс асуудлын хувь заяа шалтгаалдаг шүү дээ. Энэ бол Монголын ардчиллын үүсэл хөгжилд энэ хоёр хүний оруулсан хувь нэмэр мөн. Үүнийг түүх гэрчилнэ” (Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат)³³ хэмээн үнэлжээ.

УЛС ТӨРИЙН ЭРГЭН ТОЙРОНД (1990)

МОХ-ны Онц IV бага хурал 1990.03.02-03-нд болж, хот хөдөөгийн 37 их, дээд, тусгай мэргэжлийн сургуулийн 30 гаруй мянган оюутны төлөөлөл 200 оюутан оролцжээ.

Тус хурлаар МОХ-ны даргын үүрэг гүйцэтгэгч Л.Болдын “МОХ-ны үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх зорилтын тухай” сонсгол хэлэлцжээ. Хурлаас,

- МОХ-г өөрчлөн шинэчлэх баримтлал

- Цаг үеийн чухал асуудал, оюутны байр суурь (МОХ-ны мөрийн хөтөлбөр)

- Оюутны эрхийн түгээмэл тунхаг баталж, Оюутны эрхийн өдөр (03.02)-ийг тэмдэглэж байхаар болсон юм.

МОХ-ны сонины тухай, Монголын оюутны эрхийн өдрийг бий болгох тухай, Оюутны хөдөлмөрийг зохион байгуулах тухай, Оюутны эмнэлгийн тухай, Оюутны дотуур болон хичээлийн байрны нөхцөлийг сайжруулах тухай тогтоол баталсан юм. Оюутны байгууллага шинэчлэгдэж, “оюутан залуучуудын бие даасан олон нийт-улс төрийн байгууллага байна” гэж зарлалаа.

Мөн зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар Л.Болдыг сонгож, Тэргүүлэгчдийг сонгон баталжээ.

МОХ-ны хэвлэл-“Бамбар” сонины анхны дугаар 1990.04.06-нд гарчээ. Дээрх IV хурлын материалыг эмхэтгэсэн “Мэдээлэл” туршилтын дугаар 03.30-нд гарч байв.



МоАХ, Монголын Сүсэгтний холбоо байгуулах санаачлагч хэсэгтэй хамтран Чойжин ламын сүм-музейн өмнөх талбайд, Д.Нацагдоржийн хөшөөний тэнд 03.11-нд цуглаан хийж, Монголын Сүсэгтний холбоог байгуулсан юм. Тус холбоог Д.Баасан лам санаачилжээ. Энэ хэр Зуун айл орчмоор лам нарын нууц цугларалт болдог байсан гэдэг.

Өндөр настнууд, сүсэгтнүүд, залуучууд хуран цуглаж хэлэлцээд,

- Тус сүм-музейн уншлагыг сэргээж, хурал номын газар болгох

- Гандантэгчинлэн хийдийн ойр орчмын газрыг хийдийн харьяалалд шилжүүлэх

- Бүх шатны шашны сургууль нээх

- СнЗ-ийн дэргэдэх Шашны хэрэг эрхлэх газрыг татан буулгах

- Санваартан хүний АИХ-ын депутатад сонгогдох эрхийг эдлүүлэх зэрэг шаардлагыг АИХ-ын чуулганд өргөн мэдүүлэхээр тогтжээ.

Сүсэгтний холбоо байгуулахыг цуглаанд ирсэн хүмүүс, сүсэгтнүүд халуунаар дэмжиж, хандив өргөцгөөжээ. Тус холбоо орон нутагт салбар байгуулах ажилдаа дараа өдрөөс нь л орсон төдийгүй Монголын сүсэгтний холбооны Анхдугаар их хурал 07.01-нд СТӨ-нд болж, 75 мянган гишүүдийн төлөөлөл 700 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирж байв. Холбооны тэргүүн С.Баянцагаан “Шашин ба хүнлэг энэрэнгүй ёсон” илтгэл хэлэлцүүлжээ. Мөн хурал дээр Монголын Шашинтны Ардчилсан Нам (МШАН) байгуулагдсан тухай зарласан юм.

МШАН-ыг УДШ 1991.02.14-нд бүртгэжээ.

1991 оны хавар МоАХ урилга илгээн залснаар 13 дахь дүрийн Далай лам зун нь Монгол орноо морилсон түүхтэй.

МАХН-ын ТХ-ны VIII бүгд хурал 03.12-13-нд болов. Холбогдуулан 03.12-нд АСХ-өөс МАХН-ын ТХ-ны гишүүд, орлогч гишүүдэд хандаж, “Та бид улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засаг гүнзгий хямралд байгаа хариуцлагатай үед ажиллаж амьдарч байна... Энэ хямралт байдлаас гарахын тулд өнөөдөр манай орны улс төрийн амьдралд үүсэн бий болсон Ардчилсан хүчнүүдтэй МАХН зүй зохистой байр сууринаас хандсан нь улс төрийн хэлэлцээний замаар ямар ч эгзэгтэй асуудлыг саруул ухаанаар шийдэж болохыг ард түмэнд бэлхнээ харууллаа. Та бид бүгдээрээ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ-ын амин сүнс Ардчиллын төлөө ажиллаж байгаагаараа нэгэн зорилготой. Иймд хямралыг дахин гаргахгүйн үүднээс МАХН-ын Онц их хурлыг хуралдуулж, намын үйл ажиллагааг засаг төрөөс тусгаарлах бодит алхам хийх, үүнийгээ баталгаажуулахын тулд Үндсэн хуулинд заасан онцгой эрхээсээ МАХН өөрөө татгалзан, намаа шинэчлэх шийдвэр гаргах түүхэн хариуцлага ТАНЫ гарт байна” хэмээн амжилт хүсэж, уриалга гаргажээ.

МАХН-ын ТХ-ны бүгд хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад “БНМАУ-ын АИХ-ын ээлжит чуулганд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, СнЗ-ийн даргын талаар оруулах саналын тухай” гэж байсанд Ардчилсан хүчнүүд эсэргүүцэл илэрхийлж, 03.13-нд хамтарсан мэдэгдэл гаргав. Мэдэгдэлд, “БНМАУ-ын АИХ-аас уг албан тушаалд сонгогдон ажиллаж байгаа хүмүүсийн цаашид ажиллах эсэхийг БНМАУ-ын АИХ-ын чуулган л шийдэх ёстой. Намын бүгд хуралд ямар асуудал хэлэлцэх нь уг намын

дотоод хэрэг боловч төр, засгийн тэргүүнтэй холбогдсон асуудал нь Монголын ард түмэн, улс төрийн нам, хүчнүүдийн эрх ашгийг хөндөж байгаа учир уг асуудлыг хэлэлцэх шалтгаан болон зорилгын талаар бүгд хурлаас бидэнд тайлбар өгөхийг хүсэж байна... Нэгэнт дугуй ширээний уулзалт хэлэлцээгээр тохиролцсон зүйлийг аль нэг нам, хүчний зүгээс дур мэдэн зөрчиж, бусдын санаа бодол, эрх ашигт харш үйлдэл явуулах нь урьдчилан харж боломгүй үр дагавар үүсгэж, улс төрийн хурцадмал байдлыг даамжруулах аюултай. Улс орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлах үүднээс аливаа асуудалд ухаалгаар хандахыг МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүдэд уриалж байна” гэжээ (МоАН, МСДН, МоАХ, АСХ, ШДХ, МОХ).

VIII бүгд хурал нам төрийн тэргүүн Ж.Батмөнхийн 03.09-нд радио ТВ-ээр мэдэгдсэн МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох тухай саналыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм. Энэ дагуу тус намын нарийн бичгийн дарга нар огцорч, ТХ-ны олон гишүүн өөрсдийн хүсэлтээр сонгуульт үүргээсээ чөлөөлөгджээ.

Эрх баригч нам зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, намын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар Г.Очирбат, нарийн бичгийн даргаар Ц.Гомбосүрэн, Н.Мишигдорж нарыг сонгосон байна.

Мөн 1960-аад онд хэлмэгдүүлээд, хавчин гадуурхсаар ирсэн Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав, Д.Төмөр-Очир нарын намын шийтгэлийг хүчингүй болгож цагаатгажээ.

Тэрчлэн үндсэн хуулин дахь “БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөнл гэсэн заалтаас татгалзах талаар 03.21-нд нээгдэх АИХ-ын

чуулганаар оруулж шийдвэрлүүлэх, МАХН-ын Онц их хурлыг хуралдуулах комисс байгуулахаар болжээ.

МАХН-ын Онц их хурал 04.10-13-нд хуралдаж, “Өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлж, МАХН-ыг шинэчлэх ойрын зорилтын тухай” (Г.Очирбат) улс төрийн илтгэл сонсжээ. Намын доторх сөрөг бүлэглэлийн боловсруулсан мөрийн хөтөлбөр, дүрмийн төслийг албан ёсоор баталж, Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах комисс (Б.Сумьяа)-ыг байгуулжээ.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МАХН-ын ТХ-ны даргаар Г.Очирбат, ТХ-ны Тэргүүлэгч гишүүн (хуучнаар УТТ-ны гишүүн)-ээр Ц.Гомбосүрэн, Н.Мишигдорж, Ц.Өөлд, Б.Сумьяа, Л.Түдэв нарыг сонгон баталжээ.

(1990.03.09-нд байгуулагдсанаа зарласан) МНН-ын зохион байгуулах хурал 05.13-нд боллоо. Монголын Ногоонтны эвсэл, “Хатан Туул” зэрэг нэгдэж, МНН-ыг үүсгэн байгуулжээ. Төлөөлөгчид улс төрийн илтгэл хэлэлцэж, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангахуйц эрүүл, цэвэр орчинд амьдрах хүний эрхийг баталгаажуулахын чухлыг онцолж ярьжээ. Хуралд 213 төлөөлөгч оролцож, Д.Басандоржийг МНН-ын даргаар сонгосон байна. Тус нам УДШ-д 05.26-нд бүртгүүлээ.

Монголын Ногоонтны Хөдөлгөөн, МНН-ын хэвлэл-“Ертөнц” сонины анхны дугаар 1990.06.10-нд гарчээ.

Тус намын Анхдугаар их хурал 11.19-нд болсон байна.



Шинэ тутам байгуулагдаж байсан үйлдвэр, үйлчилгээний хоршоо, пүүсийн гишүүдийн санаачилгаар Монголын Чөлөөт Хөдөлмөрийн нам (МЧХН) байгуулагдсаныг Намыг санаачлагч хэсгийнхэн 1990.03.12-нд радио өргөн нэвтрүүлгээр зарлав.

Хоршооллын болон хувийн өмчид тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийг хөхүйлэн дэмжих нь улс орны эдийн засгийн цаашдын хөгжлийг түргэтгэхэд нэн чухал хүчин зүйл гэж бодлого зорилгоо тунхагласан тус намын гишүүд Анхдугаар их хурлаа 03.29-нд хийлээ. Хуралд 376 төлөөлөгч оролцож, намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлан, зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Хурал НТХ-ны даргаар Х.Маамыг, нарийн бичгийн даргаар Р.Баясгалан, Н.Даваашарав нарыг сонгожээ.

Тус нам үзэл баримтлал, зорилгоо:

- МЧХН нь чөлөөт хөдөлмөр эрхэлсэн нийт хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан улс төрийн байгууллага мөн.

- Оюуны болон биеийн хөдөлмөрийнхөө үр дүнг эзэмшин, хөдөлмөрөө зохион байгуулж удирдахад сайн дураараа биечлэн оролцож байгаа хүмүүсийг эгнээндээ нэгтгэнэ.

- Бүхий л тэмцэл, үйл ажиллагаагаа Монгол оронд соёлт хоршоологчдын нийгмийг цогцлоон байгуулахад чиглүүлнэ.

- Эх орондоо хүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгэм байгуулахыг эрмэлзэж байгаа улс төр, олон нийтийн бүх хүчинтэй хамтран ажиллахад бэлэн байна хэмээн тунхагласан юм.

МЧХН-ын хэвлэл “Чөлөөт хөдөлмөр” сонин (эрхлэгч Ч.Мөнхбаяр)-ы анхны дугаар 1990.05.01-нд гарчээ.

Тус нам 1990 оны АИХ-ын сонгуульд оролцож, хууль тогтоох дээд байгууллагад 1 төлөөлөл-депутат (Н.Пүрэвдорж)-тай болсон юм. Түүнчлэн 1992-1996 онд Ерөнхий сайдаар ажилласан П.Жасрай 1990 оны АИХ-ын сонгуульд тус намаас нэр дэвшин өрсөлдөж байжээ.

МЧХН нь 1992.10.25-нд БНН, Нэгдсэн намтай нийлж, МҮАН-д нэгдсэн билээ.

АИХ-ЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНААР...

АИХ-ын ээлжит бус VIII чуулган нээгдэхийн өмнөх өдөр 03.20-нд Ардчилсан хүчнүүд Д.Сүхбаатарын талбайд цуглаан хийж, “улс төрийн зүтгэлтний холч саруул ухаантайгаа харуулан, эрх ямбаа хадгалахын тулд ямар ч гэмт хэрэг хийхээс буцахгүй этгээдүүдийн санаархлыг таслан зогсоож чадсан нь өнөөдөр нэгэнт тодорхой боллоо. Цаашдаа ч Ж.Батмөнх улс төрийн түүхэн дэх туйлын эмзэг эгзэгтэй энэ үед улс орны цаашдын хувь заяаг осолд оруулалгүй хариуцлагатай хандан ажиллаж чадна гэж шинээр гарч ирсэн ардчилсан хүчнүүд гүнээ найдаж байна” хэмээн “төрийн тэргүүнийг ардчилсан байдлаар сонгох хүртэл” буюу ирэх зуны парламентын сонгууль хүртэлх шилжилтийн хугацаанд АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын хариуцлагатай албан тушаалд Ж.Батмөнхийг хэвээр байлган ажиллуулахыг АИХ-ын чуулганаас хүсэж, ил захидал өргөн барьсан юм.

Улс төрийн өлсгөлөнгийн үеэр эрс хатуу арга хэмжээ авахыг шаардаж байсан нэг гол хүн гэх УТТ-ны гишүүн асан, АИХ-ын орлогч дарга Ц.Намсрай АИХ-ын Тэргүүлэгчдийн даргад нэр дэвшин сонгогдож болзошгүй байдалтайд сэрэмжлэн, дээрх хүсэлтийг гаргажээ. Цуглаанд оролцогчид “МАХН, МХЗЭ-ийн эрүүл саруул хүчинд найдаж байна”,

“Намсрай=Цэдэнбал” зэрэг лоозон барьсан байв.

АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн ээлжит бус VIII чуулган хуралдахтай холбогдуулан АСХ-өөс тус чуулганд хандан, “тодорхой хүчин хууль зөрчиж, ард түмнээс нууцгайгаар архивын материал устгах явдал нэгэнт эхлээд буйг төрийн дээд эрх барих АИХ-ын чуулганы сонорт” хүргэж, чуулганы нээлтийн өдөр 03.21-нд захидал илгээсэн юм. Захидалд “Бидэнд буй баттай мэдээгээр Лоохууз, Нямбуу, Сурмаажав, Төмөр-Очир нартай холбоотой 37 боть архивын материалыг ердөө хэдхэн хоногийн өмнө устгажээ. Иймээс нэн даруй улсын, намын, НТХ, УТТ-ны, НАХЯ-ны зэрэг онц чухал архивуудыг битүүмжлэх шийдвэр гаргахыг” хүсжээ³⁴.

1990.03.21-23-нд АИХ-ын ээлжит бус VIII чуулган хуралдаж, урьд байгаагүй олон чухал асуудал хэлэлцэн, бүтээлч шийдвэрүүдийг гаргасан юм. БНМАУ-ын Үндсэн хуулиас, МАХН-ын онц эрх дархыг баталгаажуулсан заалт “БНМАУ-ын төр, нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон МАХН мөн” гэсэн оршил хэсгийн заалтыг хүчингүй болгож хассан юм. Ингэснээр нэг намаар жолоодуулдаг цаг халагдсаныг, нэг нам жолоодоод байх үе өнгөрснийг эрх баригчид эрхгүй хүлээн зөвшөөрлөө.

Үндсэн хуулийн 82-р зүйл (Улсын ба хөдөлмөрийн олон түмний бусад бүх байгууллагын манлайлагч бөгөөд жолоодогч МАХН-д ажилчин, хоршоолсон хөдөлмөрчид, хөдөлмөрч сэхээтний эгнээнээс шалгарсан

хамгийн идэвхтэй, ухамсартай иргэд эвлэлдэн нэгдэнэ)-ийг “БНМАУ-ын иргэд хүмүүнлэг, ардчилсан социалист нийгэм байгуулах зорилт, ард түмнийхээ язгуур эрх ашиг, эв нэгдэлд нийцсэн мөрийн хөтөлбөр, дүрэм бүхий улс төрийн нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж өөрчилжээ.

Түүнчлэн БНМАУ-ын АИХ-ын төлөөлөгчдийн сонгуулийн хуулийн төсөл, түүнтэй холбогдуулж Үндсэн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, БНМАУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, БНМАУ-ын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай, БНМАУ-ын Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль бус ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирлыг арилгах журмын тухай зэрэг хуулийн төслийг баталжээ.

Чуулганаар зохион байгуулалтын асуудал мөн хэлэлцсэн байна. АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хэлэлцэж шийдвэрлэжээ.

Сайд П.Очирбат АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар, Хэнтий аймгийн МАХН-ын хорооны I нарийн бичгийн дарга Ч.Дашдэмбэрэл АИХ-ын орлогч даргаар, АИХ-ын Тэргүүлэгчдийн Төрийн байгуулалтын хэлтсийн эрхлэгч Б.Чимэд АИХ-ын нарийн бичгийн даргаар сонгогдов.

Д.Содном СнЗ-ийн даргын үүрэгт ажлаас хүсэлтээрээ чөлөөлөгдөж, Ш.Гунгаадорж томилогдлоо. СнЗ-ийн I орлогч дарга П.Жасрай, орлогч дарга Ч.Сүрэн, М.Пэлжээ нарыг чөлөөлж, СнЗ-ийн орлогч дарга Д.Бямбасүрэн, Нийгмийн ухааны институтын хэлтсийн эрхлэгч К. Зардыхан, сайд Б.Шаравсамбуу нарыг шинээр томилжээ.

Ийнхүү төр засгийн дээд удирдлага шинэ хүмүүсээр бүрдэв. МАХН-ын шинэ тэргүүн төр засгийн удирдах бүтцэд ороогүй нь төрийг намаас тусгаарлахын эхлэл болсон гэлтэй.

АИХ-ын чуулганаар Улс төрийн намуудын тухай хуулийг баталсангүй. Иймд чуулган өндөрлөсний дараах ням гараг 03.25-нд АСХ, МоАХ, Монголын Ногоонтны холбоо, Нам бусчуудын холбоо зэрэг 10 гаруй шинэ байгууллага Д.Сүхбаатарын талбайд хамтарсан цуглаан хийж,

- Бүх нийтийн санал асуулга явуулахад цаг их алдахаар байгаа тул Ардын Түр хурал байгуулах

- Улс төрийн намуудын тухай хуулийг яаралтай батлах

- Улс төрийн шинэ хүчнүүд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа радио ТВ-ийг ашиглах боломж хомс байгааг харгалзан, хэвлэл мэдээллийн байгууллагыг МАХН-ын нөлөө, харьяаллаас гаргах шаардлага тавьлаа.



МСДН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ



АСХ-ий дэргэд Социал-демократ нам байгуулах санаачлагчдын хэсэг 1990.02.21-нд байгуулагдаж, намын тунхаглал боловсруулжээ. Нам үүсгэн байгуулагч санаачлагчид 03.02-нд хуралдан, МСДН байгуулагдсаныг зарлалаа. МСДН нь 53 гишүүнтэй байгуулагдаж байжээ. Энэ тухайд Баабар хожим, “Гурван жилийн өмнө 53 гишүүнтэй байгуулагдаж байсан манай нам

өнөөдөр 20 мянган гишүүнтэй, төрийн сонгуульд нийт ард түмний 18%-ийн санал авдаг, парламентад суудалтай, өнөөгийн Монголын улс төрийн хамгийн нөлөө бүхий хүчний нэг болоод байна” хэмээн онцолсон нь буй³⁵.

Дараа өдрийн нь буюу 1990.03.03-ны АСХ-ий идэвхтнүүдийн хурлаас МСДН-ын Тунхаглалыг сайшаан баталж, намд гишүүн элсүүлэх комисс байгуулан, анхны гишүүдээ бүртгэсэн юм.

1990.03.31-нд МСДН-ын Анхдугаар их хурал болж, 463 төлөөлөгч хүрэлцэн ирж оролцжээ.



*МУИС багш Н.Алтанхуяг, А.Ганбаатар нар намын
Их хурал удирдаж байгаа нь. 1990.3.31*

Хурлыг намын дэд дарга Д.Ламжав нээж “Ардчилсан хүчний идэвхтэй ажиллагааны дүнд манай улсад олон намын систем тогтож, төрийг ардчилах чиглэлд чухал алхам хийгдлээ. Өнөөдөр бид АСХ-ий дотор үүсэн бий болсон МСДН-ын Анхдугаар их хурлаа хийхээр цуглараад байна” хэмээгээд “хуралд уригдан оролцож байгаа бусад нам, холбооны төлөөлөгчдөд, манай хүндэт зочдод, ардчиллын төлөө үйл хэргийг дэмжигч бүх хүмүүст, Монголын нийт ард түмэнд, бидний үзэл нэгт дэлхийн бүх социал-демократуудад халуун! баяр хүргэн, үг хэлжээ. МоАХ, МАХН-ыг Шинэчлэх хүчний санаачилгын зөвлөл, МОХ, Малчдын төлөө хөдөлгөөн, МЧХН-ын ТХ, МНН, Өмнөговь аймаг дахь -Говь! хөдөлгөөн, Монголын Сүсэгтний холбоо, -Хатан Туул! хөдөлгөөн, Эмэгтэйчүүдийн дэвшилт хөдөлгөөн, АСХ, МоАХ-ны салбар зөвлөлүүд, бусад хамт олон, хувь хүмүүс Их хурлын үйл ажиллагаанд

баяр хүргэн, амжилт хүсэж байв. Их хурлаар:

- МСДН-ын улс төрийн илтгэл
- МСДН-ын тунхаглал
- МСДН-ын мөрийн хөтөлбөр
- МСДН-ын дүрэм
- Монголын бүх ард түмэнд хандаж гаргах уриалга
- МСДН-аас бусад нам, улс төрийн хүчнүүдэд хандаж

гаргах уриалга

- Монголын сүсэгтэн олонд хандаж гаргах уриалга
- Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, тогтоол

баталсан юм.

Намын дарга Б.Батбаярын улс төрийн илтгэлдээ “Монгол орон, монголчуудын ХХ зууны түүхийг цоо шинээр дүгнэж цэгнэсэн байна. 1911 онд Монголын эх орончид Монгол орон даяар өрнөсөн ардын тэмцэлд тулгуурлан, Оросын хаант засгийн дэмжлэгтэйгээр шийдвэртэй алхам хийж, Манж-Хятадын ноёрхлыг түлхэн унагаж, Монголын тусгаар тогтнолыг сэргээх зорилгоор 1911 оны зун “Түр ерөнхийлөн шийтгэх газар” буюу Түр Засгийн газрыг байгуулав. Энэ бол манай түүхчдийн нотлон бичдэгчлэн ердийн нэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн биш ээ.

Харин Монголын үндэсний сэргэн мандалтын хувьсгалын анхдугаар үеийн эхэн байв. Энэ хувьсгалыг Монголын эх оронч феодалууд толгойлжээ. Ер нь тэр үед ардын хөдөлгөөнийг удирдан толгойлох нийгмийн өөр бодит хүчин ч байсангүй...”³⁶, харин **1921 оны ардын хувьсгалаар “Монголын үндэсний сэргэн мандалтын хувьсгалын хоёрдугаар үе шат эхлэв”³⁷...**

Их хурлаас:

- Удам төрлөөсөө тасарч, бусдыг хэт өрөөсгөл даган дуурайхаа больж, ургийн бичгээ сэргээж, удам угсаагаа

таньцгаая! Монгол айл гэрийн тооныг тэгшилж, баганыг түшигчид ээ! Эх орныхоо ирээдүйн төлөө хариуцлага бүрэн хүлээх чадвартай ардчилсан хүчний төлөөлөгчдийг төрийн дээд эрх барих хэрэгт өргөн оролцуулцгаая! □ гэж Монголын ард түмэнд,

- Улс төр, нийгэм-эдийн засаг, оюун санааны бүх хүрээг хамарсан гажуудал, хямралт байдлаас улс орноо гаргаж, эх орноо цэцэглүүлэн хөгжүүлэх их хэрэгт тэгш эрхт олон ургальч үзлийн үндсэн дээр бие биеэ харилцан хүндэтгэж, хүнд сурталт захиргаадалтын бурангуй тогтолцоог үндсээр нь өөрчлөх ардчилсан тэмцэлд хамтрахыг МАХН, МоАН, МҮДН, бусад нам, холбоо, эвсэл, улс төрийн бүх хүчинд,

- Олноороо Бурханы гэгээний энэрэл нигүүлсэнгүйн эрхэм зарлигийг үнэн сүслэн, эвтэй найртай, үнэнч шударгуу ёсыг дээдлэн, ариун сайхан үйлсдээ бие, хэл, сэтгэл гурваа зориулахыг сүсэгтэн олонд хандан уриалжээ.

Их хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МСДН-ын Бага хурлыг 60 гишүүнтэйгээр, УТЗ-ийг 10 гишүүнтэйгээр байгуулж, намын даргаар Б.Батбаяр, дэд даргаар Д.Ламжав, нарийн бичгийн даргаар Н.Алтанхуяг, С.Мэндсайхан нарыг, Хэвлэлийн ерөнхий эрхлэгчээр Ч.Лхагважавыг, намын Хяналтын зөвлөл (Я.Балгансүрэн)-ийг 10 гишүүнтэйгээр сонгожээ.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалтай харшилсан хууль эрхийн баримт бичиг, гадаад орнуудтай байгуулсан тэгш бус гэрээ хэлэлцээрийг магадлах комиссыг байгуулсан байна.

МСДН-ын Анхдугаар их хурлын үеэр байгууллага, хувь хүмүүсээс нийт 3 610 төгрөгийн хандив өргөсөн байв.

Намын дэд дарга Д.Ламжав хурлыг хааж хэлсэн үгэндээ

“МСДН-ын Анхдугаар их хурал Монгол улсын сүүлийн наяд жилийн амьдралд улс төрийн дүн шинжилгээ хийх, намын тунхаг, мөрийн хөтөлбөр батлах үндсэн зорилгоо биелүүллээ. Улс төрийн илтгэл нэг намын дарангуйллын системээс ардчилсан эрхт ёст төрд шилжих, төвлөрсөн төлөвлөгөөний системээс зах зээлийн системд шилжих концепцийг дэвшүүлэн тавьснаараа чухал ач холбогдолтой боллоо.

Биднийг байраар хангаж, ажиллах бололцоо олгосон МУИС-д, хэвлэл нийтлэлийн асуудлыг хөл дээр нь босгож өгсөн Шинжлэх ухаан, техник, тусгай дунд боловсролын Улсын хорооны дэргэдэх АСХ-ий зөвлөлд, “Хөгжил” хоршоонд, уран сайхны гэрэл зургийн “Монгол фото” хоршоонд, Автомашин механизмын комбинатын хамт олонд, нойр хоолоо хасан, олон хоног ажлынхаа хажуугаар зүтгэсэн МСДН-ын гишүүд, АСХ-ий идэвхтнүүдэд, өнөөдөр манай их хурлыг бүх бололцоогоор ханган хийлгэж байгаа Пионер сурагчдын төв ордны нийт хамт олонд, түүний АСХ-ий салбар зөвлөлд гүн талархал илэрхийлэн, “Одоо МСДН, АСХ-ий өмнө ардчиллын төлөө ард түмнийхээ язгуур эрх ашгийг хамгаалан, тайван аргаар тэмцэх бүр ч хариуцлагатай цаг тулгарлаа” гэж онцолсон юм.

МСДН-ын хэвлэл -Үг сонины анхны дугаар 1990.05.01-нд гарчээ.

“Үг” сонины анхны дугаарын титэм үг болгож, сонины ерөнхий эрхлэгч Ч.Лхагважав “Бидэнд төдийлөн анзаарагддаггүй атлаа тийм их хэрэгцээтэй “Үг” гэдэг үгээр бид сониноо нэрлэлээ. Энэ сонин Танд таалагдаж ч болно. Эс таалагдаж ч болно. Гагцхүү энэ үг бидний үг юм гэдгийг л онцолж хэлье” гэжээ.

МОАН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ

1990.04.08-09. МоАН-ын Анхдугаар их хурал СТӨ-нд хуралдав. Нийслэл, 17 аймаг, Дархан, Эрдэнэт хотоос 865 төлөөлөгч, 574 зочин урилгаар ирж, гадаад орнуудын зарим ЭСЯ-дын ажилтан, хэвлэл мэдээллийн найман хэрэгслийн 30 гаруй сэтгүүлч оролцож сурвалжилжээ. Төлөөлөгчдийн 53% нь сэхээтэн, 40% нь ажилчин, 7% нь малчин, 44.9% нь дээд боловсролтой хүмүүс байв. Их хурлаар,



- Улс төрийн илтгэл (Д.Дорлигжав)
- Намын мөрийн хөтөлбөр
- Намын дүрэм
- Зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэж, 300 орчим байгууллага, хувь хүн цахилгаан утас, захидал илгээлт ирүүлжээ. Хуралд баяр хүргэж хэлсэн үгэндээ МСДН-ын

дарга Б.Батбаяр Ардчилсан хүчний эвсэл байгуулахыг уриаллаа.

МоАН-д гишүүд дэмжигчдээс 5 723 төгрөг бэлэн мөнгөөр хандивласан бөгөөд нийт 25 000 төгрөгийн хандив өргөсөн тухай мэдээлжээ³⁸.

Улс төрийн илтгэлд, “Гүн хямрал Монголын нийгмийг нөмөрч, хүнд сурталт засаг, ардчилсан шинэлэг хүч халз тулан сөргөлдөж буй хариуцлагатай үед” хуралдаж байгааг тэмдэглэжээ.

Илтгэлийн “Үндэсний ардчилсан хувьсгалын түүхэн замнал” хэсэгт 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь харийн дарангуйллаас ангижран, тусгаар тогтнолоо сэргээж, нийгмийн томоохон асуудлыг дэвшүүлж байснаараа ардчилсан шинж чанартай байсан бол 1921 оны үйл явдал нь тусгаар тогтнолоо тогтоох Ардчилсан хувьсгалын томоохон алхам болсныг тэмдэглээд, “1921 оны дараагийн үйл явдал бидний улсын сэргэн мандах замыг нээлгүй явсаар өдийг хүрлээ” хэмээн дүгнэж, эрх баригч нам, түүний байгуулсан төр засгийн гол гол алдааг шүүн дурджээ.

“Монголчууд үндэсний эв нягтралаа умартан, бусдын эрхшээлд орсноос хойш эдүгээ 300 шахам жилийн түүхэнд та бидэнд төр улсаа засах, тулгар төрөө сэргээх тийм боломж хоёр дахь удаагаа олдож байна” гэж онцолжээ.

Мөн тус хурлаар “Эрх баригч нам, төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын асуудалд”, “Нам, шашны асуудалд” хавсралт илтгэл хэлэлцжээ.

Намын хөтөлбөр, дүрмийг хэлэлцэж батлав.

МоАН-ын Их хурлаас АИХ-д хандан Өргөх бичиг гаргалаа. Үүнд,



- МоАХ-ны Анхдугаар их хурлаас баталж гаргасан Өргөх бичигт тусгагдсан Ард түмний Онц зөвлөл байгуулах шаардлагад 04.18-ны дотор хариу өгөх, ардчилсан сонгууль явуулах

- Сонгуулийг ардчилсан тэгш эрхийн үндсэн дээр явуулах, сонгууль болж дуусах хүртэл хугацаанд Ардын түр хурлыг байгуулах

- Ардчилсан шинэ Үндсэн хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг улс төрийн бүх нам, хүчний шууд оролцоотой боловсруулах боломжийг хангах

- МАХН-ын ТХ-г Засгийн газрын ордноос гаргах, улсын төсвөөс санхүүжилт, татаас авдагийг нь 04.20-ны дотор зогсоож мэдээлэх

- Өндөр албан тушаалтны тусгай хангамжийг нэн даруй таслан зогсоож, улс төрийн хүчнүүдэд үйл ажиллагаагаа бүрэн чөлөөтэй явуулах материаллаг болон эрх зүйн баттай үндсийг бий болгон хэрэгжүүлэхийг шаардсан байна.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, 15 гишүүнтэй Улс төрийн зөвлөлдөх төвийг байгуулж, гишүүнээр Э.Бат-Үүл, Ц.Баярмаа, Д.Баярсайхан, Б.Болд, Б.Галсандорж, Ц.Даш, Д.Дорлигжав, Б.Жаргалсайхан, А.Мурат, М.Оюунбилэг, О.Очиржав, Д.Төмөр-Очир, Ц.Цолмон, Г.Чулуунбат, Д.Энхбаатар нарыг сонгожээ. Э.Бат-Үүл Улс төрийн Зөвлөлдөх төвийн Ерөнхий зохицуулагч буюу намын даргаар, Д.Дорлигжав зохицуулагчаар, А.Мурат нарийн бичгийн даргаар сонгогдов. Намын Бага хурлыг 84 хүний бүрэлдэхүүнтэй сонгон баталжээ.

Намын туг, бэлгэдлийг баталжээ.



“Ардчилал” сонины анхны дугаар (цаас хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар бүтэн сар хүлээгдээд) 04.07-нд гарч, 100 мянган хувь хэвлэгдсэн юм. Мөн өдрийг тохиолдуулан Дөрөвдүгээр сарын эхний ням гарагийг -Ардчилал, -Шинэ толь сонины баяр болгон тэмдэглэхээр тогтжээ. Баяр 04.10-нд Д.Сүхбаатарын талбайд болсон юм. (—Шинэ толь сонины анхны дугаар 1990.02.10-нд гарчээ).



МҮДН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ БОЛОВ

1990.03.11-ний ням гарагт МҮДН-ын зохион байгуулах хурал Улсын циркэд болж, улс төрийн шинэ нам байгуулагдсаныг зарлаж байв. Тус нам 1990.05.22-нд УДШ-д бүртгүүлсэн юм.

МҮДН-ын Анхдугаар их хурал 05.13-нд болж, 648 төлөөлөгч хүрэлцэн иржээ. Хурлаар,

- Монгол түмэндээ өргөн толилуулах бичиг, холбогдох Толилуулга, хавсралт айлтгалууд

- МҮДН-ын мөрийн хөтөлбөр

- МҮДН-ын дүрэм

- Зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Хурлын эхэнд сайн үйлсийн өлзий хутгийг тэтгэж, эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд бурхны ном “Дашчирэв”-ийг уншиж, Монгол улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэгчид, түүх соёлын суу билигтнүүдийн дурсгалд зориулан “Жамбалбаза” хэмээх ерөөл айлджээ³⁹.

Хурлыг нээж хэлсэн үгэндээ ШДХ-ны тэргүүлэгч Д.Батсүх “Арван долдугаар жарны энэ цагаан морин жил Монголчууд та бидний, манай уудам дэлгэр Монгол оронд амьдран суугаа хүн бүрийн хийморийн он болж байна” хэмээн онцолсон юм.

Их хуралд баяр хүргэж МоАН-ын Улс төрийн зөвлөлдөх төвийн ерөнхий зохицуулагч буюу намын дарга Э.Бат-Үүл, МСДН-ын УТЗ-ийн гишүүн Р.Хатанбаатар, МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Болд, Монголын Казах хэл соёлын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн С.Харжаубай, Монгол зурхайн холбооны гишүүн Д.Очиржав нар үг хэлжээ.

Монгол түмэндээ өргөн толилуулах бичиг, холбогдох Толилуулга-д тус намын эдийн засаг, улс төрийн бодлогоо боловсруулж буй чиг баримжааг чөлөөт зах зээлийн эдийн засагт улс ардын аж ахуйн бүх салбарыг нэгэн зэрэг шууд оруулах явдал гэж дэвшүүллээ. Үүнээ “үйлдвэрлэлийн хэрэгслээ эзэмшигч чөлөөт үйлдвэрлэгчийн зах зээлийн харилцаанд нэн даруй шилжих бодлого явуулна. Зах зээлийн харилцаа бол гаднаас хараад эзэмшиж чадахгүй, заавал “дотор” нь байж л сурдаг зүйл юм... Энд тэнд элдэв янзын туршилт хийсний дараа сая зах зээлд шилжинэ гэж бодож болохгүй. Нэг бол зах зээлд бүрмөсөн бүх хүрээг хамран шилжинэ, эсвэл огт шилжихгүй, гурав дахь зам байхгүй” гэж тодорхойлсон юм⁴⁰.

МҮДН эдийн засгийн үзэл баримтлалаа тийнхүү тодорхойлсноор тус намыг улс төрийн сонгодог утгаар нь Монголд анх удаа либерал нам буй болсон гэж үзэж болох юм хэмээн дүгнэсэн нь буй⁴¹.

“Нийгмийн хямралыг гэтлэн давж, үндэснийхээ дэвшлийг хангах хүмүүнлэг ардчилсан иргэний журамт нийгэм байгуулах”-ыг гол зорилгоо болгож, намын мөрийн хөтөлбөр, дүрмийг баталжээ.

Их хурлаар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, 61 хүний бүрэлдэхүүнтэй МҮДН-ын зөвлөл (намын удирдах дээд байгууллага)-ийг байгуулж, зөвлөлийн даргаар Да.Ганболд, дэд даргаар Д.Сүх-Эрдэнийг сонгожээ. Мөн намын зөвлөлийн тэргүүлэгчээр 21 хүнийг, намын хянан тохинуулах зөвлөлийг есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгон, Хянан тохинуулах зөвлөлийн даргаар Ж.Бор, хэвлэлийн ерөнхий эрхлэгчээр Л.Дашням нарыг сонгосон байлаа.

Хурлаас Түмэн олны сонорт өргөх бичиг-ийг батлан гаргажээ.

МҮДН, ШДХ-ны хэвлэл—Үндэсний дэвшил| сонины анхны дугаар 1990.05.15-нд гарчээ.

Намын Анхдугаар их хурлын 1 жилийн ойн хэвлэлийн бага хурал дээр МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд: “МҮДН чөлөөт ардчилсан үзэл баримталдаг либерал нам мөн” хэмээн онцолсон байдаг⁴².



МӨРГӨЛДӨӨН ГАРЧ МЭДЭХ БАЙДАЛ ҮҮССЭН IV САР

Ардчилсан хүчнүүдийн эвсэл байгуулагдав

МоАН-ын Анхдугаар их хуралд баяр хүргэж хэлсэн үгэндээ МСДН-ын дарга Б.Батбаяр Ардчилсан хүчнүүдийн эвсэл байгуулахыг уриалсан юм.

Уриалгыг талархалтай хүлээн авсан ардчилсан хүчнүүд 1990.04.15-нд эвсэл байгууллаа. “Ардчилсан хүчний эвсэл байгуулах гэрээ”-нд Б.Батбаяр (МСДН), Д.Батсүх (ШДХ), Э.Бат-Үүл (МоАН), Да.Ганболд (МҮДН), Р.Гончигдорж (АСХ), С.Зориг (МоАХ) нар гарын үсэг зуржээ. Эвсэлд МОХ мөн нэгджээ.

Ардчилсан хүчнүүд шаардлага тавив

МоАН-ын Анхдугаар их хурлаас АИХ-д хандан гаргасан өргөх бичигт эрх баригчид хариу өгөөгүй тул 04.21-ний өдөр МоАН, МоАХ удирдах бүрэлдэхүүнээрээ энэ талаар хэлэлцээд, АИХ-ын Тэргүүлэгчид, СнЗ, МАХН-ын ТХ-нд тулган шаардах бичиг өгөхөөр болжээ. Ингээд 04.24-ний өдөр,

- Ардын түр хурлыг нэн даруй байгуулах

- Ард түмний Онц зөвлөлийг улс төрийн хүчнүүдийн тэгш оролцоотойгоор байгуулах

- МАХН-ын ТХ-ны аппаратыг Засгийн газрын ордноос гаргаж, МоАХ, МоАН-ын ажиллах хэвийн нөхцөлийг хангаж, байр олгох

- Дээрх шаардлагуудыг 04.25-наас эхлэн бүрэн төгс биелүүлэх хүртэл согтууруулах ундаа худалдахыг орон даяар түр зогсоовол зохино гэж шаарджээ.



Тулган шаардах бичгийн хариуг 04.27-ны өдрийн 12:00 цагт Д.Сүхбаатарын талбайд болох цуглаан дээр уншиж танилцуулахыг мэдэгджээ.

Тулган шаардах бичгийн хариуг АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат “Бид эрх баригч намаа Засгийн газрын байрнаас гаргах үндэс байхгүй. Харин Засгийн газрын ордонд намын ТХ-ны аппаратын байрлаж байгаа сууцнаас гэрэл цахилгаан, үйлчилгээний зардлыг авах замаар эхлүүлье гэж бодож байна. Саяхан бид “Монгол улс” сэтгүүл, “Новости Монголии” сонины хоёр давхар байрыг энэ холбоо, намд өгье гэж санал болгосон. Гэтэл тэд голоод авахүй байгаа. Нэгэнт бидний саналыг хүлээж аваагүй учир байрны асуудлыг шийдвэрлэж чадаагүй байна... Би энэ тавьсан шаардах бичиг гээчийн хариуг 27-ны өдрийг хүлээлгүйгээр өнөөдөр өөрсөдтэй нь ярьж, манай АИХ, Засгийн газар, намын ТХ-ноос өгч байгаа хариуг ард түмэндээ сонсгоё гэж шийдсэн юм. Ер нь сүүлийн үед янз бүрийн жагсаал цуглаан хийж, орон нутаг, аймгийн төвүүд, хөдөө аж ахуйн газруудад иймэрхүү жагсаал цуглаан хийж, ажил цалгардуулах, сахилга дэг журам сулруулах явдал ихсэж байна... Харин 04.27-ны баасан гараг нь ажлын өдөр тул жагсаал цуглаан хийхгүй байхыг хүсье”гэх хариуг радио, ТВ-ээр 04.26-нд өглөө.

МоАХ, МоАН хариуг хангалтгүй гэж үзэж, улс төрийн томсоохон цуглааныг 04.27-нд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Засгийн газрын ордныг цэрэг цагдаагаар бүслэн хамгаалуулж, ордонд байрлуулсан чанга яригчаар АИХ-ын 86-р зарлигийг дахин давтан уншиж байлаа. Тэр бүү хэл цуглаанд хүрэлцэн ирэгсдийг —“өвс дагасан мал шиг” гэж доромж үгээр дайрсан нь сөргөлдөөнд уриалсан хэрэг байв. Энэ талаар тухайн үед АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга байсан П.Очирбат “МоАХ удирдан, бусад хүчний

дэмжлэгтэйгээр Төрийн ордныг бүсэлсэн цуглаан хийхээр төлөвлөж байгааг Улсын Аюулгүй байдлыг хангах газар, Цагдаагийн байгууллагын мэдээллээс мэдэв. Бүслэлтийн зорилго нь тулган шаардсан бичгийнхээ хариуг автал ордныг тайван суугаа бүслэлтэд байлгах, гаднаас хүн машин нэвтрүүлэхгүй дотроос нь гаргахгүй ажээ... Ийм байдалд хүргэж болохгүй гэж ойлгов. Тэгээд бид өрсөж, ордныг цагдаа болон цэргийн дээд сургуулийн сонсогчдоор бүслүүлэв” гэж дурссан нь бий⁴³.

Байдал хурцдаж болзошгүй болсонд “МоАХ-ны гишүүн, “Идэр” рестораны үйлчлэгч Батсайхан болон хоёр гурван залуу С.Зоригийг мөрөн дээрээ суулгахад”⁴⁴. С. Зориг тэргүүлэн чанга яригчаар “Залуус аа, тайван байцгаа... Ухраад, нэг хоёр гурав... дэмжиж байгаа нь суугаарай, суугаарай” гэснээр жагсагчдын түрэлт намдаж, улс төрийн суулт зохион байгуулагджээ. Эхний эгнээнийхэн суухад арын эгнээнийхэн ч сууж эхэлсэн билээ. Хэсэг хугацаа болоод, талбайн голд хуран цуглагсад сууцгаасны хойно Э.Бат-Үүл, С.Зориг, Ц.Элбэгдорж нар улс төрийн нөхцөл байдал, тэмцлээ эрчимжүүлэх болсон учир шалтгааныг тайлбарлаж ярьсан байна.

“Засгийн газрын ордноос биднээр эмх замбараагүй байдал гаргуулах зорилгоор хэл амаар доромжлон турхирч, өдөөн хатгалга хийхийг оролдох шиг боллоо. Иймд энэхүү хатгалгад автахгүй байх нь чухал. Дахин шаардлага гарвал бид үүнээс ч илүү хүчтэйгээр энд хуран цугларч чадна. Харин одоо үүгээр цуглаанаа дуусгавар болгон, цаашид хэрхэн яах тухайгаа оройн зургаан цагт Зохицуулах зөвлөл дээрээ шийдье! (С.Зориг) гэснээр жагсагчид тарж, 18:00 цаг гэхэд Д.Сүхбаатарын талбай нам гүм, тайван болсон байлаа.

Мөн өдрийн орой, зурагтаар, “Цаг үе, үйл явдал” мэдээллийн хөтөлбөрөөр С.Зориг хот орчмын цэргийн анги нэгтгэл, түүний дотор хуягт тэрэг байлдааны бэлэн байдалд орсон тухай мэдээлэл хүлээн аваад байгаагаа ярьжээ. Залгаад Улсын прокуророос МоАХ, МоАН нь АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигийг зөрчиж, ажлын өдөр гудамж талбайд цуглаан жагсаал хийснийг буруушаан, сануулга өгөөд, цуглаан зохион байгуулагчид нь нийслэлийн үйлдвэрийн газруудын тэр өдрийн 800 мянган төгрөгийн алдагдлын хариуцлагыг хүлээх ёстой гэж мэдэгдлээ⁴⁵.

Үүний дараах өдөр 04.28-нд “Ялалт” кинотеатрын өмнөх талбайд цуглаан болсон юм. Үг хэлсэн хүмүүс П.Очирбатын мэдэгдэл, Улсын прокурорын сануулгыг хүч хэрэглэж болзошгүй байгаагаа харууллаа хэмээн шүүмжилсэн юм. Харин Засгийн газар цуглаан зохион байгуулагчид нь Эрүүгийн хуулийн 68, 75, 117, 217, 239-р зүйлийг зөрчсөн гэж мэдэгдэв.



(ХӨВСГӨЛЧҮҮДИЙН) ТЭМЦЛИЙГ НУХЧИН ДАРАХ ГЭЭД...

Нийслэл хотноо 1990.04.27-ны цуглаан тараад байтал Хөвсгөл аймагт томилолтоор очиж ажилласан МоАХ-ны ЕЗЗ-ийн зохицуулагч Д.Төмөр-Очир, орон нутгийн салбар зөвлөлийн дөрвөн зохицуулагчийг Мөрөн хотод зөвшөөрөл авалгүйгээр цуглаан зохион байгуулсан гэж онгоцны буудал дээрээс баривчилж хорьсон тухай мэдээ иржээ. Бас МоАХ-ны дөрвөн гишүүнийг торгохоор болжээ.

Үйл явдлын эхлэл

Ардчилсан хүчнүүдээс АИХ-ын Тэргүүлэгчид, СнЗ, МАХН-ын ТХ-нд хандан 04.24-нд тавьсан шаардлага, шаардлагын хариуг хангалтгүй гэж үзэж зохион байгуулсан 04.27-ны цуглааныг дэмжиж, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын төв талбайд 04.27-ны 11:00 цагаас цуглаан хийсэн ажээ. Цуглаанаа эхлэхээр бэлдэн байх үест Мөрөнгийн радиогоор “АИХ-ын Тэргүүлэгчдийн 86-р зарлигийг зөрчиж, цуглаан зохион байгуулах юм бол аймгийн Ардчилсан холбооны ерөнхий зохицуулагч Д.Чилхаажавт хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдье” гэсэн Аймгийн прокурорын мэдэгдлийг дахин давтан нэвтрүүлж байжээ.

Цуглаан цаг гаруй үргэлжилж, цагдаагийн олон ажилтан иржээ. Тэгэхдээ цуглааны үеэр баривчилгаа хийсэнгүй, харин АИХ-ын Тэргүүлэгчдийн 86-р зарлиг, Мөрөн хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор (аймгийн Нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийн даргын 04.27-ны албан бичгийн дагуу) хүч хэрэглэж, онгоцны буудал дээр баривчилгаа явуулжээ.

Болсон явдлыг Д.Чилхаажав “Аймгийн ардчилсан холбооны удирдлагууд бүгд баригдсан тул би гишүүд дэмжигчиддээ биднийг баригдсаны дараа ямар үйл ажиллагаа явуулах талаар зөвлөгөө чиглэл өгөхийн тулд харанхуй болтол нуугдаж байгаад, зарим гишүүдтэйгээ уулзаж ярилцсаны дараа 20:00 цагт цагдаагийн хэлтэс дээр өөрөө явж очиход жижүүрийн офицер маргааш өглөө найман цагт аймгийн шүүх дээр очихыг үүрэг болгоод, биднийг явууллаа...” хэмээн дурсжээ⁴⁶.

МоАХ-ны гишүүд дэмжигчид болсон явдлын талаар шөнөдөө мэдээлэл бичиж, Мөрөн хотын бүх гудамжаар наасан байжээ.

04.28-ны өглөө Шүүхийн даргын өрөөнд шүүгчийн шийдвэрийг уншин сонгожээ. Ингээд Д.Чилхаажавыг 25, Л.Батсуурь, Л.Жамбалдорж, Б.Олзбаатар нарыг 20 хоног баривчлах, Т.Баяржаргал, Д.Бохьшарга, Ч.Ганхүү, Д.Цогбадрах нарыг тус бүр 500 төгрөгөөр торгох арга хэмжээ авчээ.

Цагдаагийн газрын урьдчилан хорих байранд хоригдсон (Л.Батсуурь, Л.Жамбалдорж, Б.Олзбаатар, Д.Чилхаажав нарын) гишүүд Цагдан сэргийлэхийн байранд тэр өдрөө өлсгөлөн зарлажээ.

Үүний дараахан, торгуулийн арга хэмжээ авагдсан 4 хүн мөн өлсгөлөн зарласнаа мэдэгдэн, Л.Даваадоржийн талбайд суужээ.



Тэмцэл улам өргөжлөө

Тус аймгийн МоАХ-ны гишүүд эл бусармаг ажиллагааг эсэргүүцэж, маргаашаас нь буюу 04.28-наас Улсын баатар Л.Даваадоржийн нэрэмжит талбайд суулт хийжээ. Өлсгөлөн зарлагсдыг дэмжигчид нэмэгдсээр нийт 18 хүн улс төрийн хурц тэмцэлд нэгдсэн байна. Тэд,



- Ардын түр хурал байгуулах
- Ард түмний зөвлөл байгуулах
- АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990.04.07-ны өдрийн 86-р зарлигийн зарим заалтыг өөрчлөх
 - Мөрөн хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүчингүй болгох
 - МоАХ, МоАН-ын гишүүдийн эрхийг хамгаалахыг шаарджээ.

Нийслэл хотноо 04.28-нд Ялалтын талбайд ардчилсан хүчнүүд цуглаан хийжээ. Хөвсгөлд хэлмэгдүүлэл гарч, баривчилгаа явагдсаныг эсэргүүцэж, АИХ-ын 86-р зарлигийг хүчингүй болгохыг шаардсан юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгч байгаа Засгийн газрын мэдээлэл нь Ардчилсан хүчнүүдийн үйл ажиллагааг мушгин гуйвуулж тайлбарлах, төрийн эсрэг чиглэсэн гэмт хэргийн чанартай гэж олон нийтэд ойлгуулахыг оролдож байгааг буруушаан эсэргүүцлээ.

Хөвсгөл дэх гишүүдээ дэмжих зорилгоор С.Зориг, Ц.Элбэгдорж нар эмч Д.Баярсайханы хамтаар 04.30-наас Мөрөн хотод ажиллажээ. “Ардчилал” сонин тусгай сурвалжлагчаа 05.02-ны онгоцоор Хөвсгөл аймагруу явуулав. 05.03-нд Д.Баасан лам Улаанбаатар хотоос Мөрөнд очжээ. МоАХ, МоАН Хөвсгөлийн ардчилагчдыг дэмжихийг нийт салбар зөвлөл, ард иргэддээ уриаллаа.

Харин СнЗ-ийн дарга Ш.Гунгаадорж “Ардчилсан хүчний хэт даварсан өрөөсгөл хандлагатай үйл ажиллагааны улмаас улс төрийн байдал дахин хурцдаж, хот хөдөөд удирдлагаа эсэргүүцэн огцруулах шаардлага тавьж, ажил хаялтад турхирч, ардчиллыг эмх замбараагүй байдлаар солихыг илтээр оролдох боллоо” хэмээн 04.30-нд радио ТВ-ээр буруушаан мэдэгдсэн юм.

Энэ хэр Майн баяр буюу 05.01-нд нийтээр амарч тэмдэглэдэг Хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн баярын өдөр тохиосныг завшаалан, Хөвсгөл аймагт болж байгаа явдлыг төдийлөн мэдээлэхгүй байсан. Харин “5-6 хоног өнгөрч, өлсөгчдийн дөрвийг МУЗН-ийн итгэмжлэгдсэн эмчийн шаардлагаар албадан эмчилгээ хийлгэх болоход тэд “өлсгөлөнгөө тэндээ үргэлжлүүлнэ” гэж мэдэгдсэнээс

хойш уг үйл явдал нийт хүмүүсийн сэтгэл санааг түгшээсэн, нийгмийн тогтолцоонд ямар ч талаар нөлөөлж болохуйц, улс төрийн хувьд ихэд эмзэгхэн асуудал болж” хувирчээ⁴⁷.



05.02-нд Мөрөн хотод 100 орчим хүн өлсгөлөн зарлагчдыг дэмжин, суугаа цуглаан хийсэн юм. Ардчилсан хүчний эвсэл Хөвсгөл аймаг дахь гишүүдийнхээ шаардлагыг бүрнээ дэмжиж, мөн өдөр 05.02-ноос Д.Сүхбаатарын талбайд хугацаагүй улс төрийн суулт зарлалаа. -Хонхл-ны дуу цуурайтаж, эрх баригчдыг буруушаасан эсэргүүцлийн үгийг олон түмэн чөлөөтэй хэлж байв.

Дархан хотод мөн өдрийн 12:00 цагаас гурван хүн өлсгөлөн зарласан мэдээ ирж, Өвөрхангайд дөрвөн хүн, Дорнодод долоон хүн улс төрийн суулт хийсэн, Ховдын Багшийн дээд сургуулийн Хөвсгөлөөс очсон хоёр оюутан хичээл хаясан, Хэнтийн Өндөрхаан хотод 200-гаад хүн цуглаан хийсэн гээд газар газраас мэдээ ирсээр байсан

талаар тухайн үеийн Батлан хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга, СнЗ-ийн референт Ж.Хүрэлжанцан тэмдэглэжээ⁴⁸.

“МоАХ-ны салбар зөвлөлүүд Сүхбаатар, Ховд, Дархан, Эрдэнэт, Багануур, Сэлэнгэ, Зүүнхараа, Шарын гол, Хэнтий, Өвөрхангай, Хэнтийн Батширээт, Булган, Дорнод, Завхан, Завханы Тосонцэнгэл, Дорноговийн Чойр зэрэг олон аймаг, хот, сумын төвүүдэд цуглаан, суугаа эсэргүүцэл зохион” байгуулжээ⁴⁹. Мөн Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар болон Дархан хотод МоАХ, МоАН-ын гишүүд улс төрийн өлсгөлөн зарлажээ. УБДС, ХААДС, ОХБДС, Ховдын БДС-ийн оюутнууд хичээл хаяж, суугаа эсэргүүцэлд нэгджээ⁵⁰.

Хөвсгөлийн ардчилагчдын тэмцлийг эрх баригчид нухчин дарах гэж оролдсоноор сөргөлдөөнт байдал бий болоход ойртоод, аль аль тал гарц олохгүй болоод иржээ. АИХ-ын Тэргүүлэгчдийн мэдэгдлийг нарийн бичгийн дарга Ч.Дашдэмбэрэл 1990.05.04-нд радио, ТВ-ээр уншин сонсгов. Үүнд:

- Ардын Түр хурал гэгчийг байгуулах тухай шаардлага өмнө нь тавигдаж байсан... уг асуудлаар нийт ард түмний санал асуулга явуулахаар урьд нь тохиролцоод байхад гагцхүү МоАХ татгалзаж, уг шаардлагаасаа ухарсныг нийтээр мэднэ. Нийт ард түмэн, төр улсын хувь заяаны ийм асуудал нь ардчиллын далбаан доор хэсэг хүчний явуулж буй хэт даварсан ажиллагаа, дур зоргын хэрэг байж таарахгүй, бас албан ёсны ба албан ёсны биш хэдэн байгууллагын төлөөлөгчдийн хэлэлцээрээр шийдвэрлэх асуудал ч биш.

- Ард түмний Онц зөвлөл гэгчийн тухайд гэвэл түүний гүйцэтгэхээр тогтож буй асуудлыг нягтлан хянах үүрэг бүхий комисс МАХН-ын Онц их хурлаас нэгэнт

батлагдаж, үйл ажиллагаагаа эхлээд байгаа учраас зэрэгцүүлэн давхардуулах шаардлагагүй. Хууль ёсоор авч үзэх асуудлыг төрийн хуулийн дагуу хууль хамгаалах байгууллага шалгаж байгааг ч үгүйсгэх аргагүй.

- Ардчилсан ёс, ил тод байдлыг нийгмийн аль нэгэн хэсэг бүлгийн явцуу эрх ашгийг хангах зорилгоор илт мушгиж, олон түмнийг цочирдуулан, нэн ялангуяа хаврын хахир хатуу нөхцөлд бүтээлч хөдөлмөрөөс нь хөндийрүүлэх замаар улс төрийн идэвхжлийг гуйвуулан ашиглах явдал улс үндэсний нийтлэг эрх ашигт явч нийцэхгүй. Төл хүлээн авах, хаврын тариалалтын ажил ид өрнөж, дээр нь цаг агаарын хүндрэл нэмэгдэж, улс орны ажил амьдралд нэмэлт бэрхшээл учирч байгаа зэргийг ухаарч, ард түмнийхээ санаа сэтгэлийг балмагдуулан, ажил цалгардуулж, аж ахуйд асар их хор уршиг тарьж байгаа зохисгүй ажиллагаагаа МоАХ, МоАН зогсоох нь чухал байна.

- 1990 оны 4-р сарын 7-ны өдөр гаргасан “БНМАУ-ын хот, суурингийн гудамж талбайд хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх журмын тухай” зарлиг нь БНМАУ-ын Үндсэн хуульд тунхагласан жагсаал цуглаан хийх эрхийг баталгаажуулсан юм. Түүнчлэн НҮБ-аас зорилт болгон дэвшүүлсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 28, 29, 30-р зүйлд заасанчлан хэн бүхэн эрхээ эдлэхийн хамт нийгмийнхээ өмнө үүрэг хүлээх, хүн бүр амгалан тайван амьдарч ажиллахын наад захын хэрэгцээ болсон нийгмийн баттай дэг журамтай байх эрх эдэлнэ гэсэнтэй бүрнээ нийцсэн юм.

.. Энэ бүхнийг эш үндэс болгон, ардын төр, ардчилсан хуулиа хүндэтгэж, Монгол үндэсний уламжлал, эв эеийг хичээн, эх оронч бус, хүнлэг бус үйлдлээ зогсоохыг Мөрөн

хотод өлсгөлөн зарласан хүмүүст уриалж байна... хэмээсэн байлаа.

Үүгээр эрх баригчид Ардчилсан хүчнүүдийн шаардлагыг хүлээн авах боломжгүй гэсэн нь нөхцөл байдлыг улам хурцатгасан юм.

Хэлэлцээрийн ширээнээ...

Иймд, үүсээд байгаа улс төрийн хурцадмал байдлыг яриа хэлэлцээрийн аргаар зохицуулах нь зүйтэй гэсэн саналыг АСХ, МСДН-аас 05.04-нд дэвшүүлснээр улс төрийн нам хөдөлгөөн, олон нийтийн байгууллагууд хэлэлцээрийн ширээний ард суусан юм. Хэлэлцээрт АИХ-ын Тэргүүлэгч гишүүн Б.Чимид (АИХ), Засгийн газрын ХЭГ-ын орлогч дарга Б.Цэрэндорж (СнЗ), Э.Бат-Үүл (МоАХ-МоАН), Р.Гончигдорж, Б.Батбаяр, Б.Энэбиш (АСХ-МСДН), Да.Ганболд (МҮДН), Н.Жанцан (МАХН) нар талуудыг төлөөлөн оролцжээ. МОХ, МЧХН, МХЗЭ-ийн төлөөлөл ажиглагчаар оролцсон байна.

Энэ хэр 05.04-ний 18:00 цагийн байдлаар Мөрөн хотноо өлсгөлөнд оролцогчдоос зургаан хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, талбайд 10 хүн, 200-гаад дэмжигч... Дарханд найман хүн (гурав нь эмэгтэй) улс төрийн өлсгөлөнгөө үргэлжлүүлсээр, Сүхбаатарт таван хүн, Эрдэнэтэд 30-аад хүн, Архангай, Завханы Тосонцэнгэл, Арвайхээрт улс төрийн суулт хийсээр байжээ⁵¹.

Гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалан МоАХ, МоАН 05.05-нд “Сүүлийн хэдэн хоногт бидэнд ирсэн мэдээнээс үзэхэд зарим аймгийн удирдагчид МоАХ, МоАН-ын төлөөлөгчдийг нутаг дэвсгэрээсээ хөөн зайлуулах оролдлогуудыг үйлдсэн байна. Увс аймгийн эрх баригчид ард түмний нэрээр түрээ барин, хууль бус шийдвэр гаргаж,

манай төлөөлөгчдийг нутаг дэвсгэрээсээ хөөн зайлуулж амжсан байна. Ховд, Хөвсгөл аймагт томилолтоор яваа МоАХ-ны төлөөлөгчдийг ард түмний нэр барин хөөн зайлуулахыг оролдсон авч энэ булхай нь илэрч, тухайн аймгуудын олон түмний дургүйцлийг зүй ёсоор төрүүлээ. Ард түмний ухамсрын түвшинг хэт дорд үнэлж, “харанхуй бүдүүлэг”, хууль эрхийн нарийн ширийн заалтуудыг ойлгодоггүй, мэддэггүй хэмээн басамжилж, хөдөө орон нутгаас хөөн зайлуулах хууль бус үйл ажиллагааг явуулж буй аймгуудын эрх баригчдаас энэ бүдүүлэг үйлдлээ зогсоохыг шаардаж байна. Монгол улсын иргэнийг манай эх нутаг дээр хэн ч хааш нь ч хөөх эрхгүй” хэмээн мэдэгдэл гаргахад хүрэв.

Шударга тэмцэл ялалтаар өндөрлөлөө

Хэлэлцээр хоёр өдөр үргэлжлээд, 05.05-ны бямба гарагийн сүүлийн уулзалтыг ТВ-ээр шууд дамжуулсан нь өөр өөр байр суурь, үзэл бодолтой улс төрийн хүчин, эрх баригчдын зөвшилцөлд их тустай арга хэмжээ болсон байна.

Яриа хэлэлцээрийн дүнд УБХ-ын асуудлаар зөвшилцөж, АИХ-ын сонгуулиар намуудад өгсөн саналын хувиар УБХ-ыг байгуулахаар тохирчээ. УБХ нь шинэ Үндсэн хууль боловсруулж, АИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулаад, шинээр сонгогдох байнгын ажиллагаатай парламентад эрх үүргээ шилжүүлэхээр зөвшилцжээ. Мөн

- Улс төрийн харилцааны холбогдолтой хууль тогтоомжийн төслийг хамтран боловсруулах, урьдчилан санал солилцож байх Зөвлөлдөх зөвлөлийг АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэд намуудын төлөөлөл, холбогдох

байгууллагын мэргэжлийн хүмүүсийг оролцуулан байгуулж ажиллахаар

- Сонгуулийн комисст улс төрийн бүртгэлтэй намуудын төлөөллөөс оролцуулах зэрэг асуудлаар тохиролцжээ.

Энэ хэр МоАХ-МоАН-ыг төлөөлж хэлэлцээрт оролцсон Э.Бат-Үүл зөвшилцөлд гарын үсэг зурахаа нэг өдрөөр хойшлуулж түдгэлзээд байжээ. Яриа хэлэлцээрийн протокол “Үнэн” сонинд нийтлэгджээ.

Хэлэлцээр үргэлжилж, **АИХ-ын Тэргүүлэгчдийн 86-р зарлигийн зарим заалтыг өөрчлөх, Мөрөн хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн Баривчлах, торгох тухай тогтоолыг хүчингүй болгох, 05.10-нд эхлэх АИХ-ын чуулганаар Улс төрийн намуудын тухай хууль батлах болон 23 хүртэл насны залуучуудын сонгогдох эрхийг сэргээх асуудлаар зөвшилцөж чадсанаар Хөвсгөл аймагт өрнөсөн улс төрийн өлсгөлөнг зогсоох шийдвэр гарч, 05.06-ны 20:00 цагаас өлсгөлөн зогссон байна.**

Ард түмний Онц зөвлөл байгуулах шаардлагаа МоАХ-МоАН татаж авсан юм. Харин П.Нэргүй тэргүүтэй зарим гишүүд нь Ард түмний Онц зөвлөл байгуулахыг дэмжсэнгүй гэж яриа хэлэлцээрийн дүнгийн талаар хэлэлцсэн хурал дээр маргажээ.

Хэлэлцээрт оролцсон талууд “Төр засгийн шинэ механизм бүрэлдэн тогттол олон нийтийг хамарсан жагсаал цуглаан хийхгүй байх, Үндсэн хуульд УБХ-ын талаарх заалтыг оруулж батална” хэмээн зөвшилцөж, 05.07-нд гарын үсгээр баталгаажууллаа.

Маргааш өдөр нь 05.08-нд АСХ, МСДН, ШДХ, МҮДН хамтран Хэлэлцээрийн үр дүнг таниулах цуглааныг Д.Сүхбаатарын талбайд хийв. МоАХ, МоАН-ын

удирдлагууд Хөвсгөл аймагт өлсгөлөнг зогсоох талаар хэлэлцэн тохирох ажлаар өглөө нь явсан тул цуглаанд оролцоогүй ажээ.

АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн IX чуулган 05.10-нд хуралдлаа. Улс төрийн намуудын тухай хууль батлагдав. Мөрийн хөтөлбөр, дүрэм нь Үндсэн хуульд нийцсэн, 451-ээс доошгүй гишүүнтэй байгууллагыг -намл гэж бүртгэж болох тухай уг хуулинд заажээ. Олон намын тогтолцоо Монгол оронд бодит зүйл болох, төр засгийн бүтцэд зарчмын чанартай том өөрчлөлт оруулах хууль зүйн үндэс ийнхүү тавигдав.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, “АИХ-ын депутатаар 23 насанд хүрсэн БНМАУ-ын иргэд сонгогдох эрхтэй” гэсэн заалтыг хассанаар 23 хүртэл насны залуучуудын сонгогдох эрх сэргэв. Улс төрийн намуудын тухай хууль, Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль баталжээ. АИХ, УБХ-ын тухай болон БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тухай заасан шинэ бүлгийг Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд оруулжээ.

Улс төрийн намуудын тухай хууль батлагдсанаар албан газар, үйлдвэрт улс төрийн нам үйл ажиллагаа явуулахаа байж, нутаг дэвсгэрийн засаг захиргааны хуваариар салбар хороо, зөвлөлөө байгуулан ажиллахаар болсон байна.

АИХ-ын депутатыг бүх нийтээр сонгох, Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, УБХ-ын дарга, гишүүд, Ерөнхий сайд,



Улсын прокурор, Дээд шүүхийн даргыг парламентын намууд болон Ерөнхийлөгчийн саналын дагуу АИХ-ын депутатууд сонгон батлахаар болжээ.

УБХ-ын 50 мандатыг намуудад өгсөн саналын дагуу хуваарилах хийгээд дунджаар 1 суудлыг 20 мянга орчим санал (нийт сонгогчийн 2% санал)-д өгөхөөр болжээ. УБХ-ын гишүүдийн (37) нь АИХ-ын депутат, бусад 13 нь депутат бус хүн байж болохоор заажээ. Ерөнхийлөгчийг АИХ-аас сонгох нь зүйтэй гэж үзсэн байна.



АНХНЫ АРДЧИЛСАН СОНГУУЛЬ (1990)

Улс төрийн намууд бүртгүүлээ

1990.05.10-ны АИХ-ын чуулганаар Улс төрийн намуудын тухай хууль батлагдаж, энэхүү хуулийн зохих заалт ёсоор Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн нам хүчин хуулийн хүрээнд албан ёсоор бүртгэгдэн ажиллах болсон билээ. Ингэснээр, эрх барьж байгаа хүчин (МАХН) ч албан ёсоор бүртгүүлэх шаардлагатай болжээ.

МАХН-ын II бүгд хурал (1990.05.11) хуралдаж, улс төрийн намын хувьд өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжин, жил бүр авдаг 30 сая төгрөгийн татаасаасаа татгалзахад бэлэн байгаагаа мэдэгджээ. МАХН-ын ТХ-ны дарга Г.Очирбат МАХН-ыг дэмжигч олны эвсэл байгуулан, сонгуульд оролцохыг нийтэд уриалсан юм. Монголын Ажилгүйчүүдийн Холбоо, Монголын Малчин, Тариачдын Холбоо, МХЗЭ, Монголын Сэтгүүлчдийн Холбоо, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Монголын Эх Оронч Нэгдлийн Фронт зэрэг олон нийтийн олон байгууллага Олны эвсэлд нэгдэх санал хүргүүлжээ.

АИХ-ын Тэргүүлэгчид 75 хоногийн дараа бүх нийтийн сонгууль явуулах тухай 05.15-нд зарласнаар олон нам оролцох анхны ардчилсан сонгуулийн кампанит ажил эхэллээ. Улс төрийн гол намууд, ажилчин, малчин, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн зарим давхаргын төлөөлөл оролцсон 25 хүний бүрэлдэхүүнтэй Сонгуулийн Нутаг дэвсгэрийн Төв комиссыг 05.17-нд АИХ-ын Тэргүүлэгчдийн 120-р зарлигаар байгуулжээ.

Комиссын даргад АИХ-ын орлогч дарга Ж.Гүррагчаа, орлогч даргад МАХН-ын ахмад ажилтан

Б.Хурметбек, нарийн бичгийн даргад Б.Шарбанди (АИХ-ын Тэргүүлэгчдийн ахлах референт) нарыг баталжээ.

Улс төрийн намууд УДШ-д бүртгүүлж, батламжаа гардан авч эхлэв. 05.16-нд МАХН, 05.22-нд МҮДН, 05.23-нд МЧХН, 05.24-нд МоАН, 05.26-нд МНН бүртгүүлэв. Энэ хэр МАХН 94 мянга, МҮДН 1 800, МоАН 7 200, МСДН 8 900, МНН 806 гишүүнтэй гэж бүртгэгджээ.



МСДН Монгол оронд өрнөсөн Ардчилсан үйл явцын “алтан хараацай” МоАН-ын удаагаар бүртгүүлнэ гэж мэдэгдээд, Улсын бүртгэлд албан ёсоор бүртгэхийг хүссэн өргөдлөө 05.11-нд УДШ-д гаргасан юм. БНМАУ-ын Дээд шүүхийн Иргэний хэрэг эрхэлсэн коллегийн хурлын 05 тоот тогтоолоор МСДН-ыг бүртгэж, 05 тоот батламжийг 05.25-нд олгожээ. Харин УДШ-ээс МоАН-ыг дураараа загнадаг,

МСДН-ыг Ленин болон социализмыг шүүмжилдэг хэмээн бүртгэхээс цааргалж байв⁵².

АИХ-ын сонгуулийн өмнөх үйл явдлууд

Сонгууль зарлагдсантай холбогдуулан 06.10-нд бүх улс төрийн нам Д.Сүхбаатарын талбайд Хамтарсан чөлөөт ярилцлага хийлээ. МАХН-ын төлөөлөл анх удаа олон нийтийн өмнө талбай дээрх арга хэмжээнд оролцов. Ярилцлагад оролцсон МоАН, МСДН, МҮДН, МНН, МЧХН-аас АИХ-д хандан, дараах мэдэгдлийг гаргасан юм. Мэдэгдэлд,

- Сонгуулийн хуулийн 24-р зүйлийн 4 дэх хэсэгт “Нэг депутатын төлөө 3 буюу түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол 2-ыг нь шалгаруулахын тулд нэр дэвшигч бүрийг ижил тооны дэмжигчээр төлөөлүүлэн Төлөөлөн сонгогчдын зөвлөгөөн хийж, нууцаар санал хурааж шийднэ” гэсэн нь нэгдүгээрт, дийлэнх сонгогчийн шууд сонгох эрхийг хязгаарлан, цөөн тооны төлөөлөл сонгогчдод илүү эрх мэдэл олгох болж байна, хоёрт, төлөөлөн сонгогчдын нууц санал хураалтаар ялахын тулд хуурамч нэр дэвшигч олширч, сонгуулийн ажиллагааг хүндрүүлэх, улмаар сонгуулиар зохион байгуулагдах төрийн чадавхид муугаар нөлөөлөх алсын ноцтой зөрчил агуулж байна. Иймээс хоёр нэр дэвшигчийг шалгаруулах шаардлагатай тохиолдолд бүх сонгогчоос нууцаар санал хурааж, сонгогчдын олонх оролцсон бол нууц санал хураалтыг хүчинтэйд тооцох тодотгосон заавар гаргах нь зүйтэй гэж үзэж байгаагаа илэрхийлжээ.

Улс төрийн намуудын Зөвлөлдөх зөвлөл 06.14-нд хуралдаж, дээрх заалтын талаар дөрвөн өөр хувилбараар

ярилцжээ. Чингээд, 2-оос дээш хүн нэр дэвшсэн тойрогт Төлөөлөн сонгогчдын зөвлөгөөн хийхийн оронд тухайн тойргийн бүх сонгогчийн саналыг 07.08-нд нууцаар хурааж, хамгийн олон санал авсан 2 хүнийг шалгаруулж, 07.29-нд болох АИХ-ын депутат сонгох санал хураалтад оролцуулах нь зүйтэй гэж үзэн, АИХ-ын Тэргүүлэгчдэд уламжилжээ.

Ардчилсан хүчнүүдийн санаачилгын дагуу Сонгуулийн хуульд зохих нэмэлт өөрчлөлтийг 06.16-нд оруулсан байна.



МоАН сонгуульд оролцохоос татгалзсан нь...

МоАХ, МоАН-ын хамтарсан чуулган 06.27-нд болж, АИХ-ын сонгуулийн ардчилсан бус, тэгш бус болж байгаа кампанит ажилд оролцохоос татгалзах шийдвэр гаргасан юм. Нийт 15 аймаг, 3 хотыг төлөөлөн чуулганд хүрэлцэн ирсэн 144 төлөөлөгчийн 131 нь сонгуульд оролцохгүй байхыг дэмжжээ.

МОХ энэ шийдвэртэй нэгджээ. Харин эл шийдвэр урьдаас мэдэгдэлгүй гэнэт гарсан болохоор Ардчилсан хүчний эвслийн бусад хүчин “асуудлыг нэгэнт шийдэгдсэн хойно нь хэлэлцэх болох нь” гэж үзээд, дэмжсэн байр суурь илэрхийлээгүй юм.

Дараа өдөр нь 06.27-нд МСДН, МҮДН хамтран “МоАН, МоАХ-ны нөхдөд сонордуулах нь” хэмээн мэдэгдэл гаргалаа. Мэдэгдэлд,

1. МоАН, МоАХ нь Ардчилсан хүчний эвслийн гэрээг дан ганцаар эвдэж байна.

2. Та нөхөд хэрэв ард олныхоо сэтгэл санааг үл хүндэтгэж, энэ сонгуульд оролцохгүй шийдвэр гаргавал МоАН, МоАХ-ны нэр хүнд ихээхэн буурч, цаашид АРДЧИЛАЛ-ын төлөө бидний тэмцэл хохирох болно.

3. МАХН ухралт хийгээд байгаа дүр үзүүлж, ард түмэнд үүнийгээ итгүүлж байна. Ийм нөхцөлд дахин тулгалт хийснээр олон түмний дургүйцлийг улам хүргэнэ.

4. Хүн ардынхаа сэтгэлээр тоглохоо болих, ард түмнийхээ оюунд тулгуурлан, тэмцлээ үргэлжлүүлэх хэрэгтэйг анхаарахгүй байна.

5. Та бидний зорилт зөвхөн энэ удаагийн сонгуульд оролцох оролцохгүйн тухайд биш, ард түмнийхээ сайн сайхны төлөө гэсэн зорилт биш билүү.

6. МСДН, МҮДН нь өөрсдийн түүхэн хариуцлагыг гүнээ ухамсарлаж, сонгуульд оролцох өөрсдийн шийдвэрүүдээсээ татгалзах бодолгүй байна.

7. Сонгуулийн бүхий л явц Их хурал, Бага хурлын бүрдлээр энэ сонгуулийн үнэн мөн чанар ард түмний өмнө

илрэх болно.

8.МоАН, МоАХ-ны энэ үйл ажиллагаа нь манай орны одоогийн байдлыг бодитойгоор үнэлээгүй, цаашид улс орны байдлыг ихээхэн тогтворгүй болгож мэдэх бөгөөд эцэстээ МАХН-д тусалж мэдэх юм.

МоАН, МоАХ-ны нэр хүндийг анхдагч ардчилсан хүчний нь хувьд гүнээ хүндэтгэж байдгийн учир хамтран нэгэн эвсэлд тэмцэгчдийн хувиас энэхүү ДҮГНЭЛТ-ийг хийж байна.

ТА БҮХЭН-ийг өндөр хариуцлагатайгаар УХААЛАГ ШИЙДВЭР гаргана гэдэгт БИД итгэж байна! гэсэн байв.



МСДН байр сууриа илэрхийллээ

МСДН-ын Анхдугаар их хурлын 2-р Бага хурал 06.30-нд хуралдаж, бүх шатны ардын хурлын сонгуулийн ажлын явц, цаг үеийн бусад асуудлыг хэлэлцжээ. Бага хурлаас “Сонгуулийн хуулийн төслийг 3-р сарын өлсгөлөнгийн сүүлээр бусад хүчнүүдтэй хамтран шинэчилье гэсэн ч МАХН өөрийн боловсруулж ирсэн хувилбараараа онцын өөрчлөлтгүйгээр АИХ-ын VIII чуулганаар оруулж батлуулсан. Гэвч сүүлийн гурван сард ардчилсан хүчнүүдийн шаардлагаар багагүй өөрчлөлт орсон. Иймд сонгуульд оролцох хэрэгтэй юм. Харин нэмэлт өөрчлөлтийг дараа нь оруулж болно” гэсэн шийдвэрийг гаргажээ.

МСДН-ын Бага хурлаас АИХ-ын Тэргүүлэгчид, МАХН-ын ТХ-нд таван зүйлт өргөх бичгийг хүргүүлж, дурдсан шаардлагын хариуг 07.06-ны дотор өгөх, шаардлагыг эс хүлээн авбал сонгуульд оролцох эсэх тухай эргэн хэлэлцэх болно гэжээ. Өргөх бичигт,

1. АИХ, УБХ-ын харьцааг Үндсэн хуулийн нэмэлтэд зааснаар байлгаж, УБХ-ын эрхийг хязгаарласан ямар нэг өөрчлөлт хийхгүй байх

2. Улс төрийн намуудын тухай хууль батлагдсан өдрөөс хойш улсаас МАХН-ыг санхүүжүүлж байгааг зогсоож, авсан мөнгийг эргүүлэн төлүүлэх

3. Сонгуулийн кампанид зориулж, намуудад мөнгө хуваарилах

4. Ардын арми, цагдан сэргийлэх, улсын аюулгүй байдлыг хангах албууд дахь МАХН-ын байгууллагуудыг татан буулгах

5. Гадаадын ажиглагчдыг сонгуульд урьж оролцуулах



шаардлага тавьжээ.

Шаардлагын хариуг 07.04-нд өгөв. Үүгээр, УБХ-ын эрх хэмжээг хязгаарласан ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байх, арми, цагдан сэргийлэх, аюулаас хамгаалах байгууллагууд дахь МАХН-ын АШБ-уудыг төрийн шинэ тогтолцоо бүрэлдэн тогттол түр татан буулгаад, цаашдын асуудлыг парламентаар шийдүүлэх, гадаадын ажиглагчдыг сонгуульд урьж оролцуулах, МАХН-ын II бүгд хурлаараа, тус нам 1990.05.15-наас эхлээд улсаас татаас авахгүй байгаа тухайгаа мэдэгдэх, намуудын сонгуулийн сурталчилгаанд зориулж МАХН-ын жилийн төсөв 30 сая төгрөгийн үлдэгдэл болох 17 сая төгрөгийн 10%-ийг албан ёсоор бүртгэгдсэн намуудад гишүүдийн нь тоонд үндэслэн хуваарилах (МАХН-д 500 мянга, МоАН-д 400 мянга, МСДН, МҮДН-д тус бүр 300 мянга, МНН, МЧХН-д тус бүр 100 мянган төгрөг олгох) болжээ.

Шаардлагын хариу хангагдсан гэж үзэж, МСДН АИХ-ын сонгуульд оролцохоо албан ёсоор мэдэгджээ.

МҮДН-ын Зөвлөлдөх зөвлөл хуралдлаа

МҮДН, ШДХ-ны Зөвлөлдөх хурал 07.01-нд болов. Хурлын зарим төлөөлөгч, ялангуяа хөдөө орон нутгаас ирсэн гишүүд сонгуульд оролцохгүй байхыг намын удирдлагадаа уриалж шаарджээ. Зөвлөлдөх хурлаас АИХ-ын Тэргүүлэгчдэд хандан,

1. Намууд АШБ-аа үйлдвэрлэлийн зарчмаар байгуулж болох тухай Улс төрийн намуудын хуульд заасан байгааг хүчингүй болгох

2. АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга (Ерөнхийлөгч) намын харьяалалгүй байх



3. Хууль сахиулах байгууллага, цэрэг цагдаа, төрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрууд дахь МАХН-ын байгууллагуудыг тараах

4. Засгийн газрын ордныг зөвхөн төр засгийн мэдэлд байлгах

5. Намууд өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг ижил тэгш, тэглэх хувилбараас эхлэн хэрэгжүүлэх

6. Намуудын хоорондын маргаантай асуудлыг ард түмний эрх ашигт захируулан шийдвэрлэхэд шударга ёсны дэмжлэг үзүүлэх

7. Сонгуулийн үр дүнгээс манай орны гадаад харилцаанд үзүүлэх нөлөөллийг ухамсарлан, Монгол улсын гадаад бодлогод гарсан өөрчлөлтийг ажил хэрэг болгох үүднээс Цэдэнбалын дэглэмийн гадаад суурь нь болж ирсэн элчин сайдууд, дипломатуудыг нэн даруй огцруулж, дипломат албыг үндэсний мэдрэмж бүхий шинэлэг үзэл санаатай боловсон хүчнээр ээлбэж, хүнд сурталт үе залгамжлагчдаас цэвэрлэх

8. Тэгш, ардчилсан, чөлөөт сонгуулийн хуулийг улс төрийн намуудын бүрэн эрхт төлөөллийн оролцоотойгоор дахин шинээр боловсруулан баталж, сонгууль явуулаад, үйл ажиллагаагаа зогсоох онц эрх бүхий комиссыг АИХ-ын дэргэд байгуулах

9. Хот, орон нутагт хүний эрхийг ноцтой зөрчиж, үзэл бодлоор нь хэлмэгдүүлж байгаа аливаа хэлбэрийг нэн даруй зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх

10. Сонгуулийн кампанийн үед радио ТВ-ийн цагийг улс төрийн намуудад үнэ төлбөргүйгээр тэгш хувааж өгөх баталгаа гаргах зэрэг шаардлага тавилаа.

Талууд яриа хэлэлцээрт оров

1990.07.05-нд АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат, МоАН, МҮДН-ын удирдлага, гишүүдтэй АИХ-ын Хурлын танхимд уулзаж, сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд учирч байгаа бэрхшээл хүндрэлийн талаар ярилцаж, санал солилцсон юм.

Уулзалт хагас өдөр үргэлжилж, уулзалтын явцыг зурагтаар хэсэгчлэн нэвтрүүлж байв. Ингээд,

- Сонгуулийн хуульд зааснаар тойргийн комиссууд сонгууль зарласнаас хойших 15 хоногийн дотор байгуулагдах ёстой юм. Шинэ намууд бүртгэгдэж амжаагүй байх үед сонгуулийг зарласан учир МАХН-аас бусад нам бүрэлдэхүүнд нь бараг орсонгүй. Сүүлд МоАН, МҮДН-ын хамтарсан мэдэгдэл (06.18)-ийн дагуу шинэ намуудын салбар зөвлөл байгуулагдсан тойрогт Комиссыг өргөтгөн зохион байгуулсан боловч нэгэнт бий болсон тэгш бус нөхцөл байдалд зохих ёсны өөрчлөлт орсонгүй.

- Эрдэнэт, Улаанбаатараас бусад газарт орон нутгийн эрх баригчид сөрөг хүчнийхнээс нэр дэвшсэн хүмүүсийн үйл ажиллагаанд саад тотгор их учруулж байна.

- Шинэ намуудад телефон холбоо, бусад төрлийн харилцаа холбоо, үйлчилгээний хэрэгсэл ашиглах боломж туйлын бага байгаа талаар ярилцжээ. Уулзалт дээр,

П.Очирбат: - Сонгуульд орох орохгүйн цаад наад утга ийм байна. Та бүхэн ойлгооч. Сонгуулийн өмнөх явцад хууль зөрчигдөж, Ардчилсан холбоо, МоАН-ын гишүүдийг хасна гэх мэтийн зөрчил гарсан нь буруу, арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэх ёстой гэдгийг хэлнэ.



С.Зориг: - Цаг хугацааны хувьд л хэцүү байна.

П.Очирбат: - Амжуулъя.

Э.Бат-Үүл: - Хугацааг өөрчлөх эрх хэмжээ АИХ-д бий шүү дээ... Сонгуульд оролцох тухай яаж ч бодоод үзсэн ерөөсөө хугацааны хувьд багтахгүй болоод байна.

С.Зориг: - Сонгуульд оролцох нь утгагүй болчихоод байгаа юм. Бид нар депутатуудаа татгалзуулчихаад одоо ор гэх хэцүү байна.

П. Очирбат: - Татгалзсан хүн олон байна уу?

С.Зориг: - Бараг бүгд татгалзсан

П.Очирбат: - Ер нь тоглоомын байдлаар хандаж болохгүй шүү. Орон даяар, дэлхий даяар зарласан сонгуулийг нэг нам нь санаачлаад өөрчлөөд байвал юунд хүрэх болж байна аа. Ямар тодорхой санал байна?

Да.Ганболд: - 7 дугаар сарын 22-нд шалгаруулалтаа явуулаад, 7-р сарын

29-нд саналаа хураая...

Да.Ганболд: - Бид нарт 400, 400 мянган төгрөг өгье гэж байна. Аль статьяанаасаа өгч байна аа? Сүүлд нь нөгөө намууд чинь улсын халааснаас мөнгө авлаа гээд яриа гарна шүү.

П.Очирбат: - МАХН-ын татаасыг зогсоосноос чөлөөлөгдөх хөрөнгөнөөс л гаргана.

Д.Батсүх: - Бид улсын төсвөөс авмааргүй байна. Харин МАХН-ын татааснаас бол авч болох юм...

Б.Чимид: - Сонгуульд оролцохыг уриалах тухайд энэ хоёр намтай Очирбат дарга ярьж болох юм. Харин 22-ны тухайд бусад намтай ярихгүй бол болохгүй. Тэр ч

байтугай депутатууд юу гэхийг мэдэхгүй байна. Урьд нь зарлигт өөрчлөлт оруулахад ард түмнээр хэлэлцүүлсэн хуулийг АИХ-ын Тэргүүлэгчид өөрчлөх гэж байна гэсэн яриа гарсан. Бид бүх хүчин зүйлийг харж байж, өдрийн тухайд ярихгүй бол түүхэн хариуцлага гэж юм байна шүү гэхчлэн ярилцжээ⁵³.

Уулзалтын үр дүнд,

1. Урьдчилсан сонгуулийн тов 07.08-нд байсныг 07.22 болгож шилжүүлэх

2. Аймаг, хотын МоАХ-МоАН-ын салбар зөвлөлийн зохицуулагчид, АДХГЗ-ны дарга нар, МАХН-ын салбар хорооны дарга нарыг АИХ-ын зардлаар Улаанбаатарт яаралтай дуудаж ирүүлэх

3. Бий болсон нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах, дээрх уулзалтын дүнгийн талаар таниулж мэдүүлэх хийгээд сонгуульд оролцохын чухлыг сурталчлах зорилготой АИХ, МАХН болон сөрөг намын төлөөлөгчид оролцсон тусгай комиссуудыг орон нутагт илгээх

4. Гадаадаас ажиглагч урьж оролцуулахаар болжээ.

Мөн Ерөнхийлөгчийн алба хаших хүн намын харьяаллаас татгалзах нь зүйтэй гэсэн санааг П.Очирбат дэмжжээ.



МОХ, Гадаадад суралцагч Монгол оюутны холбоо (Анхдугаар бага хурал)-ноос АИХ-ын Тэргүүлэгчид, улс төрийн бүх намуудад хандаж “Монголын хагас бум шахам... оюутнуудад төрийн байгууллагын ажилд оролцох боломж нэг ч удаа олдож байсангүй. Манай оронд оюутны эрх ашгийг хайхрахгүй байх ужиг өвчин газар авах нэг шалтгаан үүнтэй ч холбоотой гэдэг нь ойлгомжтой. Гэтэл оюутнууд бүх шатны депутатуудын энэ удаагийн сонгуульд зохион байгуулалттай оролцох асуудлыг анхнаас нь бүтэлгүй байдалд оруулсныг хүн бүхэн харж байна. Ийм учраас Монголын оюутнууд БНМАУ-ын АИХ-д 2, УБХ-д 1 суудал МОХ-нд олгохыг шаардах нь зүй ёсны хэрэг гэж үзэж байна” хэмээн 07.07-нд мэдэгдэл гаргалаа. Мэдэгдлийн хариуг АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат 07.18-ны өдөр 1216 албан тоотоор өгч,

1. Одоо дагаж мөрдөж буй Сонгуулийн хуулиар АИХ-ын депутатыг гагцхүү нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулсан тойргуудаар нэр дэвшүүлэн, сонгогчид шууд сонгож байгаа тул бусад зарим оронд баримталдаг шиг нам, олон нийтийн байгууллагад депутатын мандат буюу суудал хуваарилах журмыг хэрэглэх боломжгүй юм... одоо үед уг асуудлыг чуулганд оруулах боломжгүй байгааг Та бүхэн гүнээ ойлгоно гэж үзэж байна...

2. УБХ-д 1 оюутан гишүүн буюу оюутны байгууллагын ажилтан-гишүүнийг сонгох саналыг дэвшүүлэхийг тус Бага хуралд зохих тооны суудал бүхий улс төрийн намуудтай хэлэлцэн зохицуулж, БНМАУ-ын АИХ-ын Анхдугаар хуралдаанд санал оруулж болно! гэж үзэж байгаагаа илэрхийлжээ.

МоАН, МСДН, МҮДН-ууд 07.19-нд “Ардчилсан хувьсгалт үйл явцад Монголын оюутнууд, тэдгээрийн байгууллагын гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлэн, Ардчилсан хүчний эвсэлд нэгдсэн манай намууд харилцан тохиролцсоны үндсэн дээр УБХ-д авсан суудлаасаа нэгийг оюутны төлөөлөгчдөд олгох болно” хэмээн мэдэгджээ⁵⁴.

Сонгуулийн дүн гарлаа

АИХ-ын сонгууль өмнө нь нийт 11 удаа, орон нутгийн сонгууль 15 удаа болж байжээ.



1990 онд АИХ-ын 12 дахь, орон нутгийн Ардын хурлын 16 дахь сонгууль зэрэг явагдсан юм. Сонгогчид дөрвөн саналын хуудас бөглөхдөө гуравт нь АИХ, хот (аймаг), дүүрэг (сум)-ийн депутат сонгох, нэгд нь УБХ-д суудал эзлэх намын төлөө саналаа өгч байв.

АИХ-д 430, орон нутгийн хуралд 13 мянга орчим хүн сонгогдох байжээ. Хотод 10 мянган хүн тутамд, сумдад хүн амын тоог үл харгалзан АИХ-ын сонгуулийн тойрог байгуулах болсноор хуучин 370 байсан депутатын тоо 430 болон нэмэгдсэн байна. АИХ-д нийт 2 413 хүн нэр дэвшиж, 430 тойргийн 274-т хоёроос дээш хүн, тэдгээрийн дотор нийслэлийн Ажилчны районы нэг тойрогт бүр 70 гаруй хүн нэр дэвшжээ⁵⁵.



1990.07.22. АИХ-ын сонгуулийн эхний шат болж өнгөрлөө. Үүгээр 3 ба түүнээс дээш нэр дэвшигчтэй тойргуудад санал хураалт болж, тойрог тус бүрт шалгарсан хоёр хүний нэрийг нэр дэвшигчийн жагсаалтад үлдээсэн байна.

1990.07.29-ний ням гарагт хоёр дахь санал хураалт болж, нийт сонгогчийн 97.8% нь сонгуульд оролцож, саналаа өгчээ. Урьдчилсан сонгуулийн үеэр зарим тойрогт

ирц хүрээгүйгээс, мөн нэр дэвшигчдийн хэн нь ч 50-аас дээш хувийн санал авч чадаагүй, Сонгуулийн хууль зөрчигдсөн зэрэг шалтгаанаар хуулийн хүчинтэйд тооцох боломжгүй зарим тойрогт дахин сонгууль явуулах байдалд хүрчээ.

Сонгуульд АНУ, ЗХУ, Их Британи, Польш, Энэтхэгийн 27 ажиглагч, 20-оод орны 110 шахам сэтгүүлч хүрэлцэн ирж оролцсон аж.

Шинээр сонгогдсон нийт депутатын 84.6% (357) нь МАХН-ын, 3.8% (16) нь МоАН-ын, 1.4% (6) нь МҮДН-ын, 1.0% (4) нь МСДН-ын гишүүн, нам бус 36 депутат байжээ. Депутатуудын 90.4 % (381) дээд боловсролтой, 4.2% (18) нь тусгай дунд, 4.2% (18) нь ерөнхий боловсролын бүрэн ба бүрэн бус дунд, 1.8% (5) нь бага сургуулийн боловсролтой. Нэгдэлчин 120 (үүнээс 6 нь малчин), үйлдвэр үйлчилгээний ажилтан 22 (үүнээс 6 нь ажилчин), албан хаагч 188, мэргэжлийн сэхээтэн 92 байв.

Мөн 1924 оноос хойш анх удаа санваартан сонгогджээ. Депутатуудын 87% (367) нь анх сонгогдсон 118 хүмүүс байв.

Улс төрийн намууд сонгуулийн дүнтэй холбогдуулан хэвлэлийн бага хурал зарлан хийлгэлээ. МоАН-ын Улс төрийн зөвлөлдөх төвийн ерөнхий зохицуулагч Д.Дорлигжав, МоАХ-ны ЕЗЗ-ийн ерөнхий зохицуулагч С.Зориг нар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултад хариулахдаа “өнгөрсөн сонгуулийн үеэр нэр дэвшигчдэд нь дарамт шахалт үзүүлж, сөрөг ухуулга хийгдэж байсан” тухай, сонгуулийг боловсронгуй болгох талаар ярьжээ.

МСДН-ын дарга Б.Батбаяр, АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн дарга Р.Гончигдорж нар “МСДН УБХ-д 2-3 суудал эзлэх бололцоотой боллоо...МСДН УБХ-д олон

суудал авахыг чармайгаагүй, харин ардчиллыг мэдүүлэх, социал-демократ үзэл санааг ойлгуулахыг гол зорилгоо болголоо. Хэрэв бид дайчин шуурхай ажилласан бол илүү үр дүнд хүрч чадах байсан. Дараагийн сонгууль хоёроос илүүгүй жилийн дараа болно гэж үзэж байна” гэжээ.

МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд “Шинэ намууд үүсэж бий болсноос хойш богино хугацааны дараа сонгууль явагдсан нь намууд өөрсдийн үзэл бодол, мөрийн хөтөлбөрийг ард түмэнд хүргэж чадаагүйгээс энэ удаагийн сонгууль бидний хүссэн хэмжээнд хүрсэнгүй. Иймээс удахгүй болох чуулганаар ирэх сонгуулийн хугацааг нааш татаж, хоёр жилийн дараа сонгууль явуулах тухай асуудлыг тавих болно. Энэ нь шинээр сонгогдсон депутатуудын бүрэлдэхүүн бидний санаанд нийцэхгүй байгаатай холбоотой юм” гэлээ.

МЧХН-ын дарга Х.Маам “АИХ-ын депутатыг сонгох сонгуулийн 52-р тойрогт Хоршоологчдын хурлаас нэр дэвшсэн П.Жасрай, МоАН-аас нэр дэвшсэн Э.Бат-Үүл нарын аль аль нь сонгогчдын 50%-ийн санал авч чадаагүйг эс тооцвол МЧХН-аас одоогоор нэг хүн БНМАУ-ын АИХ-ын депутатаар сонгогдоод байна. Манай нам энэ удаагийн сонгуулиар харьцангуй олон хүний санал авч чадаагүй нь намаа сурталчлах бэлтгэл ажлын хугацаа богино, намын нэр хүнд, нөлөө бага байгаатай холбоотой⁵⁶. хэмээн сонгуулийн амжилтаа тус тус дүгнэжээ.

Намуудын төлөөх санал хураалтаар:

МАХН 61.74%

МоАН 24.33%

МҮДН 5.95%

МСДН 5.52%

МНН 1.24%

МЧХН 1.22% -ийн санал авчээ.

Сонгуульд оролцсон намуудын удирдлагууд 08.01-нд УБХ-д суудал хуваарилах талаар хэлэлцэж зөвшилцжээ. Үүгээр УБХ-ын мандатыг хуваарилахад дараах байдлаар оногджээ. Үүнд:

- МАХН 31
- МоАН 13
- МҮДН 3
- МСДН 3

суудалтай байхаар тохиролцож, АИХ-ын чуулганы хуралдаанд өргөн мэдүүлэхээр болжээ.

Зарим тойрогт дахин сонгууль явуулахаар болсон ч АИХ-ын нийт бүрэлдэхүүний -аас дээш хувь нь (420 гаруй депутат) сонгогдсон тул АИХ-ын чуулганы ажиллагаа 09 сард эхлэхэд зөрчилдөх зүйлгүй, саад тотгоргүй байв.

СнЗ МоАХ, МоАН-д өдгөө “Ардчиллын ордон” байгаа байрыг (хуучин Соёлын яам), АСХ, МСДН-д СТӨ-ний хүзүүвч-Шилэн байр (2011 онд буулгаад, буурин дээр нь АН-ын шинэ байрны шав тавьсан)-ыг, ШДХ, МҮДН-д Төв шуудангийн урд талын байр (өдгөө АН-ын байр)-ыг өгч, тогтоол гаргажээ.

ШИНЭ АИХ-ЫН ЧУУЛГАН ХУРАЛДЛАА

Анхны Ерөнхийлөгч сонгогдож, тангараг өргөв

БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн Анхдугаар хуралдаан 1990.09.03-нд эхэлж, нээлтийн ажиллагаанд 422 депутат хүрэлцэн иржээ. Тус чуулган 03-11-ний өдрүүдэд амралт, завсарлагагүй цаг сунган хуралдаж, шинэ тогтолцоо, цаг үеийн тулгамдсан олон чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн юм.

Хуралдааны эхэнд зохион байгуулалтын асуудал хэлэлцээд, АИХ-ын даргаар Төв аймгийн АДХГЗ-ны дарга Ж.Гомбожавыг, орлогч даргаар Ц.Адьяасүрэн (МСДН), тэргүүлэгч гишүүнээр Л.Дашням (МҮДН), О.Долгорсүрэн, Х.Хүзкей (МАХН) нарыг сонгожээ.

БНМАУ-ын Ерөнхийлөгчид АИХ-ын сонгуулийн дүнгээр олонхийн санал авсан МАХН-ын бүлэгт нэр дэвшүүлэх эрхийг үлдээн, МоАН-аас Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхгүй гэж Э.Бат-Үүл мэдэгдсэн юм. Р.Хатанбаатар (МСДН), Да.Ганболд (МҮДН) нар санал нэг байгаага илэрхийлсэн байна.

МАХН-ын дарга Г.Очирбат П.Очирбатыг, танхимаас Ц.Лоохуузын нэрийг БНМАУ-ын Ерөнхийлөгчид дэвшүүллээ. Депутат Ц.Лоохууз “П.Очирбатын удирдлагаар Монгол улс урагшаа хөгжин цэцэглэнэ гэдэгт найдаж байна” гэж талархал илэрхийлээд, сонгуульд өрсөлдсөн юм.

Санал хураалтаар П.Очирбат 88.15% саналаар БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдов. Ц.Лоохууз 44 хүний санал авчээ.

П.Очирбатын тангараг өргөх ёслол 09.04-нд болж, АИХ-ын дарга Ж.Гомбожав “БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат тангараг өргөнө” хэмээн ёслолыг нээжээ. Ерөнхийлөгчид зориулж тусгайлан хийлгэсэн Төрийн ёслолын (дээл, титэм, бүс, малгай, гутал бүхий) хувцас өмссөн П.Очирбат Хуралдааны танхимд орж ирэн, гурвантаа ёслоод, АИХ-ын Анхдугаар хуралдааны Ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Дашдэмбэрэлийн өргөн барьсан БНМАУ-ын Үндсэн хуулийн эх дээр баруун гараа тавиад, “БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ үндэсний эв нэгдлийг тууштай хамгаалж, БНМАУ-ын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн үүргээ шударгаар биелүүлэхээ батлан тангараглаж байна” хэмээн андгайлаад, ёслолын ширээнээ сууж, гарын үсэг зуржээ. “Дараа нь төрийн далбаанд мөргөж, адис аваад, тангараг бичгээ АИХ-ын даргад гардууллаа. Их хурлын дарга нанжвандан хадган дээр залсан Ерөнхийлөгчийн тамгыг надад өргөхөд нь би адис аваад, ёслолын ширээнээ ирэхэд хөгжимд төрийн сүлд дуулал эгшиглэн, хүмүүс суудлаасаа бослоо. Эрхэм дэг жаягтай энэ ёслолыг үйлдсэн хэн ч гэсэн эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ гүн гүнзгий ухамсарлана аа” хэмээн Ерөнхийлөгч асан П.Очирбат бахдан дурсжээ⁵⁷.

БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, УБХ-ын даргыг сонгов.

1990.09.04. БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, УБХ-ын даргад нэр дэвшүүлэх асуудлаар Ерөнхийлөгч П.Очирбат намуудтай зөвшилцжээ. МАХН-аас СнЗ-ийн дарга Ш.Гунгаадоржийг, МоАН-ыг төлөөлөн Улс төрийн зөвлөлдөх төвийн Ерөнхий зохицуулагч Э.Бат-Үүл (2-р тойрог) МоАХ-ны ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагч С.Зоригийг, МСДН-ыг төлөөлөн АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн

Р.Хатанбаатар (24-р тойрог) АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн дарга Р.Гончигдоржийн нэрийг тус тус дэвшүүлэв.

АИХ-ын чуулганы дэгд “Дэд Ерөнхийлөгчөөр сонгох хүний нэрийг БНМАУ-ын Ерөнхийлөгч АИХ-ын депутатуудын дотроос дэвшүүлэн оруулна. Ерөнхийлөгч нь дэд Ерөнхийлөгчөөр нэрийг нь дэвшүүлэх талаар депутатуудын намын бүлгийн ахлагч нартай урьдчилан зөвлөлдсөн байвал зохино” (43:1) гэж заасан байв.

Мөн СнЗ-ийн I орлогч дарга Д.Бямбасүрэн, СнЗ-ийн орлогч дарга К.Зардыхан, МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд нарын нэрийг танхимаас Т.Очирхүү, С.Баяр, Л.Дашням нар дэвшүүлсэнд Д. Бямбасүрэн, К.Зардыхан нар нэрээ татан татгалзжээ. Ингээд эхний гурван хүн дээрээ тогтож ярихыг Чуулганы хуралдааныг даргалагч (П.Очирбат) санал болголоо. Гурван нэр дэвшигчээс асуулт асууж хэлэлцсээр чамгүй хугацаа өнгөрөхөд дөрөв дэх өдрийн оройн хуралдаан дээр 428-р тойргийн депутат До.Ганболд (Эрдэнэт хотын МоАХ-ны салбар зөвлөлийн зохицуулагч) “Дээрх гурван хүн дээр үнэхээр олон талаас нь ярилаа, их ч цаг хугацаа зарлаа. Гэтэл эцсийн шийдвэрийг депутатууд арай эрт гаргаад байх шиг надад санагдаж байна. Нэг хүнийг яагаад ийм эрт данснаас хасаад байгаа юм бэ? МҮДН-аас нэр дэвшсэн Да.Ганболдыг та нар тийм сайн мэддэг улс уу? Нэг уриалга гаргая. МҮДН-аас нэр дэвшсэн тус намын дарга Да. Ганболдыг хэлэлцүүлэхийг хүсэж байна” гэсэнд АИХ-ын дарга Ж.Гомбожав энэ тухайд Ерөнхийлөгчийн саналыг асуужээ. Ерөнхийлөгч бээр “Тавдугаар тойргийн депутат Даваадоржийн Ганболдыг БНМАУ-ын дэд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлье гэсэн саналыг би түрүүнд дэмжээгүй ээ. Саналаа ч хэлсэн. Тэгэхээр уг нь энэ өдрүүдэд Их хурал, Бага хурлаар олон албан тушаалыг та бүхэн хэлэлцэж,

томилохыг нь томилж, сонгохыг нь сонгох юм. Бас нэг жижигхэн бодлого ч бид нарт байгаа. Тэгэхдээ би депутат нөхдүүд дэд Ерөнхийлөгчид Да.Ганболдын нэрийг дэвшүүлж ярилцъя гэдэг хүсэлт тавьж байгаа байдлыг харгалзаж бодоод, депутатуудын намын бүлгийн дарга нартай бас зөвлөлдсөнийг үндэс болгон, нөхөр Да.Ганболдын нэрийг дэд Ерөнхийлөгчөөр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэхийг депутат та бүхэнд зөвшөөрч байна” гэснээр Да.Ганболд бусад гурван нэр дэвшигчийн хамт депутатуудын асуултад хариулах болсон байна. Депутатуудын асуултад хариулсныхаа удаагаар Да.Ганболд “Юуны түрүүнд Ерөнхийлөгчийн саналыг харгалзаж, улс төрийн намууд дэд Ерөнхийлөгчийн албан тушаалд олон түмнийхээ сайн сайхны төлөө, Монгол улсыг цэцэглэн хөгжүүлэхийн төлөө энэ ажлыг хийж чадна гэсэн үүднээс бүлгүүдээрээ дамжуулж, нэг нэг хүний нэрийг дэвшүүлсэн. Хувь хүний хувьд энэ албан тушаалд өөрийнхөө нэрийг дэвшүүлэх тийм санал надад уг нь байгаагүй юм. Энэ гурван өдрийн хуралдааны явцад манай намын журмын нөхдөөс ч надад их олон санал ирсэн. Орой үдшийн цагаар хуралдааны дараагаар шөнө дунд хүртэл бид бас ярилцаж, тал талаар энэ асуудлыг авч үзлээ. Журмын нөхдийн саналыг, байдал нөхцөлийг тусгаж судалсны үндсэн дээр нэгэн шийдвэрт би хүрч ирлээ. Өнөөдрийн байдлаар дөрвөн хүний нэр дэвшигдээд байна. Хэн нь ч сонгогдсон манай улс орны энэ өндөр албан тушаалыг хашаад явж чадах хүмүүс гэдэг нь тодорхой. Тэгэхээр янз янзын шалгуураар биднийг хэмжиж байна. Ерөнхийдөө бүгдийг нь харгалзан үзэх ёстой... Би ингээд энд өрсөлдөж байгаа энэ дөрвөн хүний жагсаалтаас өөрийнхөө нэрийг татаж авах, ийм саналыг гаргаж байгаа юм” гээд нэрээ татсан. Да.Ганболд С.Зоригийг дэмжиж, нэрээ татсан гэдэг.

Дэд Ерөнхийлөгч, УБХ-ын даргын сонгууль ихээхэн маргаан талцал өдөөсөн ажээ. Чуулганы танхимд төдийгүй Засгийн газрын ордны гадаа ч ардчилсан хүчний төлөөллийн хэнийг нь дэмжих, дэмжүүлэх эсэх дээр маргажээ. Маргаан ширүүн өрнөсний гол учиг нь ардчилсан хүчнүүд хоёр өөр хүний нэрийг дэвшүүлээд, санал нэгдэж чадахгүй байснаас үүджээ.

Санал хэлэлцүүлэг хэдэн өдөр үргэлжлээд, 1990.09.07-нд санал хураалт болсон байна. Эхний санал хураалтад 422 депутатын 99.5% (420) оролцож, Ш.Гунгаадорж 25.9% (109), С. Зориг 28.6% (121), Р. Гончигдорж 45% (190)-ийн санал авчээ. Нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй тул хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дээр дахин санал хураалт болж, Р.Гончигдорж 279 (66.11%), С.Зориг 140 (33.17%) санал авчээ.

Р.Гончигдоржийн УБХ-ын дарга, БНМАУ-ын дэд Ерөнхийлөгчөөр сонгогдсоныг баталсан АИХ-ын 12 тоот тогтоол (1990.09.07) гарлаа.

Жич: Р.Гончигдорж мөн сарын 08-ны өдөр МСДН-ын Улаанбаатар хотын зөвлөлийн дарга (С.Рэндорж)-д “Намын гишүүнээс түдгэлзэх албан тушаалын тухай БНМАУ-ын хууль, МСДН-ын дүрмийн 1.5 “ж” заалтын эхний хэсгийг үндэслэн... МСДН-ын гишүүн байхаа түр зогсоосон болохыг толилуулж” намын харьяаллаасаа түдгэлзсэн байна.

Танхимын уур амьсгалыг 31-р тойргийн депутат, зохиолч, сэтгүүлч Д.Дождорж тэмдэглэн үлдээжээ. “Дэд Ерөнхийлөгчөөр Р.Гончигдоржийг сонгогдсоны дараа нэн ялангуяа ардчилсан хүчнийхний дотор их шуугиан дэгдлээ. Биднийг завсарлахад ч ордны үүдэн дээр бөөн

амьтан оволзож байв... намуудын удирдагчид, сэтгүүлчид, зарим депутаттай уулзаж ярилцсанаа сийрүүлье” гээд “Зоригийг ялагдахад та нар гутарсан уу?” гэсэн асуултад нь Ц.Элбэгдорж “Нуулгүй хэлэхэд сэтгэлээр унасан, уур ч хүрч байсан, одооноос жаахан тайвширлаа гэж хэлж болно” гэсэн тухай, мөн Р.Хатанбаатараас “С.Зоригийн ялагдсан явдал нь юутай холбоотой гэж та бодож байна вэ?” гэхэд “С.Зориг улс төрийн байр суурийн хувьд, тал бүрийн мэдлэгийн хувьд дутсан болов уу. Хамгийн гол нь МоАН одоо хүртэл мөрийн хөтөлбөргүй байгаа нь их нөлөөллөө. Анх доктор Нэргүйн хийсэн мөрийн хөтөлбөрөөс татгалзсанаа албан ёсоор зарласан мөртлөө өнөө хүртэл боловсруулсан юу ч үгүй, нэг үгээр хэлбэл, огт мөрийн хөтөлбөргүй яваа нам шүү дээ. МоАХ их хүч гаргасан. Би түүнийг үгүйсгэхгүй. Хуучин юмыг эвдэх амархан, гагцхүү цаашаа хэрхэн яаж, ямар замаар явах вэ гэдгээ их хол харах хэрэгтэй юм.



Энэ талаар МоАН бэлтгэлгүй байсантай холбоотой” гээд, болж өнгөрсөн сонгуулийн талаарх асуултад “Хэрэв нэрээ татаж авах юм бол Зориг Гунгаадорж гуайд ялагдана. Яагаад вэ гэвэл Гончигдоржийн төлөө өгсөн санал чинь Гунгаадорж гуайруу шулуухан орно, энэ мадаггүй хэрэг. Тэгэхээр ардчилсан хүчний эвсэл тэр чигээрээ хохирох аюултай тулгарсан юм... Гончигдоржийг нэр дэвшүүлэх үеэс эхэлж МоАН шахалт үзүүлж эхэлсэн”⁵⁸. гэж хариулсан ажээ.

Р.Гончигдорж давуу санал авсан нь ардчилсан хүчний нэг томоохон удирдагч түүний зөвшилцлийг эрэгч үзэл баримтлал, эелэг эвлэг харьцаа, үг яриа, орчны мэдрэмжтэй (бас харьцангуй нас тогтсон) байдал илүү нөлөөлж, жин дарсантай холбоотой.

АИХ-ын чуулган Монголын парламентийн бүлгэмийг байгуулж, С.Зориг тус бүлгэмийн даргаар сонгогдсон.

УБХ, Засгийн газрын удирдах бүтцийг хэлэлцсэн нь

АИХ-ын чуулган УБХ-ын зохион байгуулалтын асуудлыг дараа өдөр нь 09.08-нд үргэлжлүүлэн хэлэлцэхэд, УБХ-ын даргын зүгээс Ц.Өөлдийг УБХ-ын орлогч даргад, Б.Чимидийг нарийн бичгийн даргад нэр дэвшүүлээ. Танхимын зүгээс С.Баяр, Ш.Гунгаадорж, К.Зардыхан, Д.Лүндээжанцан нарын нэрийг УБХ-ын дэд даргад дэвшүүлэхэд С.Баяр, Ш.Гунгаадорж, Д.Лүндээжанцан нар нэрээ татаж, Ц.Өөлд, К.Зардыхан нар үлджээ. Ц.Өөлд намын удирдлагатайгаа зөвшилцөж ирээд, нэрээ татжээ. УБХ-ын дэд даргаар К. Зардыхан сонгогдов.

УБХ-ын нарийн бичгийн дарга Д.Чимидтэй өрсөлдүүлж, Н.Жанцан (МАХН-ын ТХ-ны зөвлөх), Д.Лүндээжанцан (ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэнгийн секторын эрхлэгч), Л.Цог (Улсын прокурорын Ерөнхий хяналтын газрын дарга) нарын нэрийг дэвшүүлжээ. С.Баяр, Н.Жанцан нар нэрээ татаж, Л.Цог Д.Лүндээжанцанг дэмжихийг уриалаад, мөн нэрээ татсанаар Б.Чимид, Д.Лүндээжанцан нар үлдэхэд, Д.Лүндээжанцан нэрээ татжээ. УБХ-ын нарийн бичгийн даргаар Б.Чимэд сонгогдсон юм.

“Би багштайгаа тунаж үлдээд байгаагаа, мөн маш хариуцлагатай ажил гэдгийг ойлгож байлаа. УБХ-ын нарийн бичгийн дарга бол УБХ-аар хэлэлцэгдэх бүх асуудлыг хариуцдаг, хуулийн засварыг хийдэг, хийлгэдэг, мэргэжлийн маш өндөр ур чадварыг шаарддаг албан тушаал бөгөөд дээр нь УБХ-ын Тамгын газрыг удирдах ёстой байв. Тиймээс нэгдүгээрт би барахгүй, хоёрдугаарт багштайгаа өрсөлдөнө гэдэг маш хүнд, ялангуяа сонгогдчихвол их эвгүй тул... нэрээ татлаа” гэж тэр үеийг Д.Лүндээжанцан дурсжээ⁵⁹.

АИХ-ын дэргэд Депутатын бүрэн эрхийн асуудал эрхлэх (Ю.Жаргал), Байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах (Ц.Балдорж), Хүний эрх, Үндэстний асуудлын (Ц.Лоохууз), Хөдөлмөр, Хүн ам зүй, Эрүүл мэндийн (С.Лхагвасүрэн), Батлан хамгаалах, Улсын аюулгүй байдлыг хангах (Р.Барсболд) гэсэн таван байнгын комиссыг байгуулжээ.



АИХ-ын чуулган 1990.09.10-ны хуралдаанаараа Ерөнхий сайдын томилгоог хэлэлцээд, Д.Бямбасүрэнг БНМАУ-ын Ерөнхий сайдаар томилсон юм. Ерөнхий сайдад МоАН, МСДН-аас Зах зээлийн хүрээлэнгийн захирал М.Энхсайханыг, МҮДН-аас МҮДН-ын дэд дарга Д.Сүх-Эрдэнийн нэрийг дэвшүүлж, харин Ерөнхийлөгч АИХ-аар хэлэлцүүлэхээс татгалзсан байна.

Д.Бямбасүрэнг Ерөнхий сайдаар томилохыг 403 депутат дэмжиж, 6 хүн татгалзаж, 2 нь түдгэлзжээ.

Түүний өмнө Ш.Гунгаадорж 1990.03.02-09.20-ны хугацаанд БНМАУ-ын Ерөнхий сайдаар ажилласан юм.



УЛСЫН БАГА ХУРАЛ

УБХ-ын бүрэлдэхүүн

АИХ-ын Анхдугаар чуулганы 1990.09.09-ний өдрийн хуралдаанаар (намуудын удирдлагуудын 08.01-ний зөвшилцлийн дагуу) УБХ-ын гишүүнд нэр дэвшсэн 50 хүнийг гишүүнээр сонгож баталсан тухай АИХ-ын 16-р тогтоолыг батлав.

УБХ-д МАХН 31, МоАН 13, МҮДН 3, МСДН 3 суудалтай болсон юм. Эдгээр суудлаасаа МАХН 2 суудлыг МХЗЭ-д, 1 суудлыг МҮЭ-ийн холбоонд, МоАН 1 суудлаа МОХ-нд шилжүүлжээ.



УБХ-ын гишүүнээр

- Д.Баттулга, Д.Баярцэнгэл, Л.Болд, Б.Галсандорж, До.Ганболд, Д.Дамдин, Д.Дорлигжав, О.Очиржав, Н.Самат, Д.Чилхаажав, Ц.Элбэгдорж, Д.Энхбаатар, М.Энхсайхан (МоАН)

- Д.Ламжав, Р.Хатанбаатар, П.Улаанхүү (МСДН)

- Д.Батсүх, Да.Ганболд, Ш.Шагдарсүрэн (МҮДН) нар Ардчилсан хүчнийг төлөөлөн сонгогдож ажиллахаар болов.

УБХ-ын гишүүдийн 2-оос бусад нь дээд боловсролтой, нь АИХ-ын депутатаар сонгогдож байжээ. Нам бус долоон хүн гишүүнээр сонгогджээ.

Хөдөө орон нутгаас шилжиж ирсэн 16 гишүүн, мөн зарим гишүүн орон байрны гачигдалтай байсан тул УБХ-аас орон сууцанд оруулжээ.

АИХ-ын чуулганы үеэр 1990.09.11-нд УБХ-ын гишүүн Д.Дэмбэрэлцэрэн УДШ-ийн даргаар томилогдсон тул МАХН-ын ТХ-ны зааварлагч Н.Ганбаярыг УБХ-ын гишүүнээр нөхөн баталжээ. Мөн Да.Ганболд, Д.Дорлигжав нар Засгийн газрын гишүүн болсон тул тэдний УБХ-ын гишүүний бүрэн эрхийг АИХ-ын дараачийн чуулган хүртэл хугацаанд түдгэлзүүлээд, 1991.11.11-ний өдрийн 01-р тогтоолоор АИХ-ын депутатын бүрэн эрхийг 1990.10.04-ний өдрөөр дуусгавар болсонд тооцсон. Мөн Д.Дамдинг сонгогчид нь огцруулсан тул түүний депутатын бүрэн эрхийг 1991.05.12-ны өдрөөр дуусгавар болсонд тооцжээ.

Засгийн газрын дээрх албан тушаалууд нь Үндсэн хуулийн нэмэлтийн хуульд заасанчлан хавсарч болохгүй албан тушаал байсан юм.

УБХ-ын гишүүний сул гарсан орон тоонд АИХ-ын 1991.01.25-ны өдрийн 24-р тогтоолоор Л.Баяндалай, Ж.Бямбадорж, Н.Ганбямба (МАХН), Да.Ганболдын сууринд Д.Гүнджалам (МҮДН), Д.Дорлигжавын оронд Ц.Энхбат (МоАН), МоАН-ын суудалд сууж асан нам бус Д.Дамдины оронд Б.Пүрэвдорж (МоАН) нарыг нөхөн сонгожээ.

МХЗЭ-ээс сонгогдоод, МАХН-ын суудалд сууж байсан С.Баярцогт, СнЗ-ийн референт байгаад УБХ-ын гишүүн болсон Гү.Лхагважав нар МСДН-д элссэн байдаг.

УБХ-ын гишүүд тангараг өргөлөө

УБХ-ын чуулган нээгдэхээс өмнө гишүүний тангаргийн үгийг хоёр өдөр нэлээд хэлэлцэж ярилцаад, зохиолч гишүүн Д.Маамын санаачилж томъёолсноор Эзэн Чингис хааны андгай үгийг даган барихаар зөвшилцжээ.

1990.09.13. УБХ-ын Анхдугаар чуулган эхэлж, УБХ-ын дарга Р.Гончигдорж нээснээр байнгын ажиллагаатай парламентын үйл ажиллагаа эхэлсэн юм. Нээлтэд БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат оролцжээ.

УБХ-ын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, “Алд бие мину алжаавал алжаатугай Аху төр мину бүү алдартугай!

Бүтэн бие мину алжааваас алжаатугай Бүрэн улс минь бүү алдартугай!

БНМАУ-ын Бага хурлын гишүүн би эх орон, ард түмнийхээ эрх ашгийг дээдэлж, төрт ёсныхоо уламжлалыг эрхэмлэн ажиллахаа андгайлъя” хэмээн тангараг өргөснөөр УБХ-ын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн билээ.

“Хамгийн бахархаж явдаг зүйл маань УБХ-ын гишүүд... тангараг өргөдөг байсан... Энэ эрхэм үгээр тангараг өргөсөн хамгийн азтай цөөхөн хүмүүс бол УБХ-ын гишүүд байлаа. Тийм ч учраас төрийн ажил хийсэн ч, эс хийсэн ч Монголын төрд тангараг өргөсөн хүн гэж би өөрийгөө боддог” гэж Д.Дорлигжав бахархсан нь зүй ёсны омогшил юм⁶⁰.

Бага хурлын ажлын гараа... БХ-дыг байгуулсан нь

УБХ-ын Анхдугаар чуулганаар,

- УБХ-ын Анхдугаар чуулганы дэг батлах
- БХ-дыг байгуулах
- Засгийн газрын бүрэлдэхүүнийг батлах
- Дээд шүүхийн бүрэлдэхүүнийг сонгох
- Ерөнхий прокурорын орлогчдыг томилох
- Үндсэн хуулийн төсөл боловсруулах зэрэг асуудал хэлэлцэхээр төлөвлөжээ.



УБХ-ын бүрэлдэхүүнд Төрийн байгуулалтын, Хууль зүйн, Эдийн засгийн, Нийгмийн бодлогын, Эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын гэсэн таван БХ-г байгуулж, тус тус БХ-ны даргаар С.Баяр, Л.Цог, М.Энхсайхан, Т.Очирхүү, Р.Хатанбаатар, нарийн бичгийн даргаар Д.Дорлигжав, Д.Лүндээжанцан, Да.Ганболд, Ц.Элбэгдорж, Ж.Бямбажав нар сонгогджээ.

УБХ-ын Анхдугаар чуулганы эхний өдөр-09.13-ны хуралдаан оройн 21:00 цаг хүртэл үргэлжилжээ.

Чуулганы хуралдааныг 09.24-нийг хүртэл түр завсарлуулаад, БХ-д, Засгийн газрын танхимыг байгуулах, УДШ-ийн бүрэлдэхүүн, Улсын прокурорын орлогчдыг томилох асуудлыг хэлэлцэхээр болсон байна.



АРДЧИЛСАН ХҮЧИН ЭВСЛИЙН ГЭРЭЭГЭЭ ДҮГНЭВ

Ардчилсан хүчнүүд 1990 оны АИХ-ын сонгуульд оролцох эсэх тал дээр санал зөрөлдөж байгаад зөвшилцсөнөөр сонгуульд оролцсон. Гэсэн ч АИХ-ын чуулганы үеэр дэд Ерөнхийлөгчийг сонгох асуудлаар төдийлөн нэгдэлтэй байж, зөвшилцөж чадаагүй юм. Ардчилсан хүчнүүд эв нэгдэлтэй байгаа эсэх тухай яриа ч гарч байв.

Сонгуулийн ажиллагаа дууссаны дараа Ардчилсан хүчний эвслийг татан буулгах юм уу цаашид хамтран ажиллах чиглэлийг тогтоох тухай Эвслийн гэрээний 5-р зүйлд заасан байжээ. Иймд Эвслийн гэрээний хугацаа нэгэнт дууссан учир намууд дэд Ерөнхийлөгчид тус тусдаа нэр дэвшүүлж болно гэж нэг хэсэг нь үзэж байхад зарим хэсэг нь тодорхой хүнийг хамтраад, нэр дэвшүүлэхийг тулгаж, шаардаж байжээ.

Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнтэй холбоотойгоор “Ардчилал”, “Үндэсний дэвшил” зэрэг сонинд МСДН-ын нэр дэвшигчийн талаар “Албан тушаалтны хожоо буюу төөрсөөр төрөлдөө” (С.Цогтсайхан), “Р.Гончигдорж гэж хэн бэ?” (Ц.Дашдорж) зэрэг нийтлэл материал ч гарсан байна.

Эвслийн гэрээг дүгнэх хурлыг 10.06-нд хийжээ. Олон намын тогтолцооны үе дэх анхны чөлөөт ардчилсан сонгуульд нэгдэн оролцсон Ардчилсан хүчний эвслийнхэн 40%-ийн санал авсан нь багагүй амжилт болсон гэж дүгнэжээ. Нийгмийн тогтвортой байдлыг хангахад болон үндэсний эв нэгдэл, улс орны эрх ашгийн тулгамдсан асуудлаар цаг тухайд нь санал солилцож байхаар нам, холбоо, хөдөлгөөнүүд тогтжээ.

Гэрээнд гарын үсэг зурсан Хэлэлцэн тохирогч талууд (Б.Батбаяр, Д.Батсүх, Э.Бат-Үүл, Да.Ганболд, Р.Гончигдорж, С.Зориг нар) гэрээний 5-р зүйлд үндэслэн сонгуулийн 2 дахь шатны үйл ажиллагаа дууссан 1990.08.26-наас Гэрээний хүчин төгөлдөр байх хугацааг дуусгавар болсонд тооцлоо⁶¹.

Энэ тухайд “Эвслээ дүгнээд, хугацаа дуусгавар боллоо гээд больсон. Ер нь бол олигтой ажиллаж чадаагүй гэсэн үг. Харилцан ойлголцож, хамтран ажиллах чадвар муу байсан гэсэн үг” хэмээн тухайн үед МСДН-ын нарийн бичгийн дарга байсан Н.Алтанхуяг дурсан өгүүлж байна⁶².



УБХ-ЫН ХУУЛЬ ТОГТООХ АЖЛЫН ГАРАА

Шинэ айлд юм бүхэн хэрэгтэй байдаг шиг шинэ Монгол Улсад хууль болгоныг шинэ цаг, шинэ орчин, шинэ тогтолцоонд нийцүүлэн шинээр гаргах хэрэгтэй болсон юм. Үүнд, намын АШБ-ыг нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулах, өмч хувьчлал, банк, санхүү, ААН-ийн тогтолцооны гээд олон шинэ хууль шаардагдаж байлаа.

УБХ-ын чуулганаар Тэтгэврийн хуулийг эхлэн хэлэлцэж баталсан юм. Үүгээр 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийг тэтгэврийн нас гүйцээгүй ч тэтгэвэрт гарч болно гэж хуульчилсан нь нэг талаас хөдөлмөрийн чадвартай залуу эмэгтэйчүүд эрт тэтгэвэрт гарах нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Олон хүүхэдтэй охин нь ээжээсээ түрүүлж, тэтгэвэрт гарахаар байдал үүсжээ.

УБХ дээр маргаан мэтгэлцээн их өрнөдөг байсан нь асуудал бүхэн шинэ байсантай, хуучнаасаа хагацахад амаргүй байсантай эрхгүй хамаатай. Тухайлбал, улаан хувьсгалын өдөр Октябрийн баяр (11.07)-ыг тэмдэглэсэн хэвээр байх эсэх талаар хоёр өдөр мэтгэлцэж маргажээ. Хуучин тогтолцооны үед 1917 оны Оросын хувьсгалын ойг жил бүр тэмдэглэн, хоёр өдөр амардаг байсныг шинэ нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх (улс даяар амардагийг зогсоох, хуучнаасаа даруу энгийн тэмдэглэх) шаардлага зүй ёсоор урган гарсан юм. Чухам энэ шалтгаанаар УБХ-ын ээлжит бус чуулганы 1990.10.30-ны хуралдаан сунаж үргэлжилжээ.

Хуралдаанаар,

- Венесуэл, Намиб улстай дипломат харилцаа тогтоох

- Бүгд Найрамдах Ардчилсан Герман улстай байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны гэрээг хүчингүй болгох

- Хөдөлмөрийн хуулинд зарим өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцжээ.

Хөдөлмөрийн хуулийн өөрчлөлтөөр “Октябрийн баярын амралтын өдрүүд (11.07-08)-ийг хасаж, 11.26-нд Бүгд Найрамдах улс тунхагласан баярын өдрөөр 1 хоног амарч байх” санал оруулсан төслийг хэлэлцсэн байдаг.

Санал хураалтаар (нэрээр хураажээ) 20 гишүүн дэмжиж, 18 татгалзаж, 3 түдгэлзэн, аль аль санал нь хүчинтэй болох ёстой 75%-д хүрээгүй байна. Ингээд нэлээд ширүүн маргалдаж, МСДН, МоАН-ын гишүүд хурлын танхимаас гарснаар хуралдаан завсарлажээ.

Маргааш (11.01) нь хуралдаан үргэлжилж, Үндэсний баяр-Улс тунхагласан өдөр 11.26-ныг амралтын өдөр болгон, бүх нийтээр тэмдэглэж байх саналыг 100% дэмжиж баталсан ажээ. Октябрийн баярын амралтын өдрүүдийг хэвээр тэмдэглэж байх тухайд 11.07-08-ны өдөр тус бүрээр нь гишүүдийн нэрээр санал хураахад санал нэгдээгүй тул батлагдаагүй ажээ⁶³.

Шилжилтийн үед түүхэн үүрэг гүйцэтгэсэн УБХ-ын бүрэн эрх 1992.07.06-наар дуусгавар болсон юм.



Д.БЯМБАСҮРЭНГИЙН ЭВСЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР

МСДН сөрөг хүчин байхаа зарлав

1990.09.01-нд МСДН-ын Бага хурал боллоо. Тус хурлаар

- Бүх шатны ардын хурлын сонгуулийн явцын үр дүн, түүнээс хийх дүгнэлт (Ц.Адьяасүрэн)

- МСДН-ын үйл ажиллагаа, цаашид тавих зорилт (Б.Батбаяр)

- АИХ-ын чуулганаас сонгогдох төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх

- МСДН-ын төв, орон нутгийн зөвлөлийн аппаратыг зохион байгуулах асуудал хэлэлцсэн байна.

Хурлын үеэр МСДН-ын УТЗ-ийн гишүүнээр Н.Алтанхуяг, С.Мэндсайхан нарыг нэмж сонгожээ.

УТЗ-ийн гишүүн Ц.Адьяасүрэн илтгэлдээ,

“Улс оронд өрнөсөн ардчиллын үйл хэргийг илүү найдвартай үр дүнд хүргэх зорилгоор МСДН бусад шинэ намууддаа хандан, сонгуульд эвсэн зохицож ажиллахыг санал болгосныг МоАН, МҮДН дэмжиж, нэг эвсэлд ажиллахаар гэрээ хийсэн.

Сонгуулийн хууль боловсронгуй биш, сонгуульд оролцох шинэ намуудыг сонгуулийн кампанийн үеэр л албан ёсоор бүртгэсэн. МАХН улсаас авсан хур хөрөнгөтэй, бусад нам үндсэндээ огт хөрөнгө мөнгөгүй байсан зэрэг саад бэрхшээл байсан ч ард түмний язгуур эрх ашгийг хамгаалж, улс төрийн тогтвортой байдлыг хангахын үүднээс МСДН энэ удаагийн сонгуулийг явуулахын тулд

хүчин чармайлт гаргасан билээ.

МоАХ, МоАН сонгуульд оролцохгүй тухай шийдвэр гаргасан үед ч нөхцөл байдлыг авч хэлэлцээд, ард түмэн, улс орны эрх ашиг нь бусад аливаа эрх ашгаас илүү эрхэм дээд гэж үзээд, шударга бус зарим байдлыг арилгах шаардлага тавьж, сонгуульд оролцох шийдвэр гаргасан.

Сонгуулийн эцсийн дүнгээр МСДН нийт сонгогчийн 5.52% (53 545 сонгогчийн) санал авч, АИХ-ын депутатаар 4 хүн сонгогдлоо. УБХ-д 3 суудал эзэлж, төр засгийн эрх барилцах 4 намын нэг болсон нь том амжилт боллоо. Аймгуудаас Архангай, Увс аймгийн хөдөлмөрчид МСДН-ыг илүүтэй дэмжсэнийг талархан тэмдэглэж байна” хэмээн онцлов.

МСДН-ын даргын илтгэлийг хэлэлцээд, Бага хурал дараах дүгнэлтийг гаргажээ.

- МАХН урьдын хийсэн нүгэл, хэлмэгдүүлэлтээ дурдахын төдий өнгөрч, элдэв аргаар авсан, цуглуулсан хөрөнгөө ард түмэнд буцаан өгөхөөс цааргалан, арга заль хэрэглэсээр байна. Ийм нөхцөлд МАХН-ын дотор байгаа улс орноо өөрчлөн шинэчлэх эрүүл хүчин хуучныг баримтлагчидтайгаа зоригтой тэмцэл явуулж, салан тусгаарлах нь Монгол Улсын цаашдын хөгжлийг түргэтгэх нэг арга зам гэж үзлээ.

- МоАХ, МоАН-ыг Монгол оронд ардчиллын очийг анх бадраасан шийдвэртэй тэмцэгч гэж бид үнэлэн хүндэлж байдаг. Гэвч АСХ, МСДН, МоАХ, МоАН ардчиллын төлөө мөр зэрэгцэн тэмцэж ирсэн хугацаанд болсон үйл явдалд бид бодитой үнэлэлт өгөх нь шударга ёсонд нийцэх юм...

Ардын Түр хурал байгуулах, УБХ-ыг намуудын нэрээр ард түмний саналыг хурааж, шууд байгуулах, сонгуульд

зориулж, намуудад хөрөнгө хуваарилах, гадаадын ажиглагч урих, арми, аюулаас хамгаалах байгууллагад байгаа МАХН-ын байгууллагуудыг татан буулгах зэрэг улс төрийн нэн ач холбогдолтой саналыг АСХ, МСДН-аас санаачлан дэвшүүлж хэлэлцэн тохирох замаар нааштай шийдвэрлэсэн билээ. Гэвч МоАХ, МоАН-ын зарим хэт хувьсгалч удирдах хүмүүсийн байр сууринаас болж МСДН-д “бөөрөнхийлөгч, зохицуулагч, урвагч, харалган” зэрэг нэр хоч зүүж, бидний эсрэг ухуулга сурталчилгаа хийсэн нь ардчиллыг дэмжигч олон түмнийг төөрөгдүүлж, бидний нийтийн үйлс-ардчилах үйл явцад ихээхэн хохирол учруулав.

Өнөөдөр МоАН-ын удирдах зарим нөхөд өөрийн намаа либералчлагдаж байна хэмээн зарлаж байгаа боловч МоАН-ын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаанд неокommунист (шинэ коммунист) хандлага илэрч байгаа юм...

- Монгол оронд 70 жил явуулсан “социализм, коммунизм байгуулах” туршилтын үр дүнд монголчууд өөрийн зан заншил, шашин шүтлэг, уламжлал, түүх соёлоосоо бүрэн хагацахад хүрсэн нь түүхийн гашуун үнэн билээ. Гэтэл ард түмний үндэсний уламжлал, бахархал, шашин шүтлэгийг МҮДН улс төрийн ашиг хонжоо хайх зэвсэг болгон ашиглах болов. Сүсэг бишрэл, шашин шүтлэг бол хувь хүний эрх, эрх чөлөө юм.

Бүх шатны ардын хурлын депутатуудын сонгуулийн явц, үр дүн, ардчилах үйл явцыг МСДН ийнхүү үнэлэн дүгнэлээ..

Шинэ Засгийн газрын танхимын бүрэлдэхүүнд орж ажиллахгүй гэсэн шийдвэрийг МСДН-ын Бага хурлаас гаргажээ. “Сөрөг хүчин байж, шүүмжилж ажиллах нь

зүйтэй гээд Засгийн газарт ороогүй байхгүй юу” хэмээн тухайн үед МСДН-ын УТЗ-ийн гишүүн асан Н.Алтанхуяг дурссан юм⁶⁴.

Ерөнхий сайд Засгийн газраа бүрдүүлээ

Ерөнхий сайд шинэ Засгийн газрыг 15 яам, улсын хороо, Засгийн газрын дэргэдэх найман газартайгаар байгуулахаар санал боловсруулж, Улсын банкиг Засгийн газрын мэдэлд ажиллуулах саналыг 09.24-нд өргөн барив. Засгийн газрын бүтцийн тухай саналыг УБХ гурван өдөр хэлэлцээд, 12 яам, улсын хороотойгоор, Ерөнхий сайд, тэргүүн шадар, (хоёр) шадар сайд, 11 сайд, нэг Улсын хорооны дарга, нийт 16 гишүүнтэйгээр Засгийн газрыг байгуулан ажиллуулахаар 1992.07.31-нд хуульчилжээ.

Ардчилсан хүчний төлөөлөл Да.Ганболд (МҮДН), Д.Дорлигжав (МоАН) нар 09.26-ны өдөр тэргүүн шадар сайд, шадар сайдаар томилогдлоо. Хоёр шадар сайдын нэгээр МАХН-ын төлөөлөл (СнЗ-ийн орлогч дарга асан) Ч.Пүрэвдорж томилогдон ажилласан.

Жич: Тэргүүн шадар сайдад Да.Ганболд, Ч.Пүрэвдорж нар нэр дэвшээд, Да.Ганболд батлагдсан юм. Засгийн газрын гишүүнээр томилогдсон УБХ-ын гишүүн Да.Ганболд, Д.Дорлигжав нарыг УБХ-ын гишүүнээс чөлөөлжээ.

Эвслийн Засгийн газрын танхим 1990.10.01-нд бүрдэж гүйцсэн байна. Засгийн газрын танхимыг Ж.Амарсанаа (Хууль зүй), А.Базархүү (Сан), З.Батжаргал (Байгаль орчныг хамгаалах Улсын хороо), Ж.Батсуурь (Үндэсний хөгжил), С.Баярбаатар (Худалдаа, үйлдвэр), Ц.Гомбосүрэн (Гадаад харилцаа), Ш.Жадамбаа (Батлан хамгаалах), Б.Жигжид (Эрчим хүч), П.Нямдаваа (Эрүүл мэнд), Д.Раднаарагчаа (Хөдөө аж ахуй), Н.Уртнасан (Боловсрол), Ц.Цолмон

(Хөдөлмөр) нар бүрдүүлжээ.

Хөдөлмөрийн яамны сайдад нэр дэвшсэн Ч.Бадамханд, С.Лхагвасүрэн нар, Хууль зүйн яамны сайдад нэр дэвшсэн Б.Цэрэндорж нар УБХ-аас 50-аас дээш хувийн санал авч чадалгүй унаж байжээ. Засгийн газрыг МАХН-аас 14 хүн (87.5%), МҮДН-аас 1 хүн (6.2%), МоАН-аас 1 хүн (6.2%) бүрэлдүүлсэн юм.

Жич: 1990-1992 онд Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж байсан МАХН-ын гишүүдээс шинэ нам (МСМН) байгуулсан, намаасаа гарсан нь цөөнгүй юм. Ж.Амарсанаа, Н.Уртнасан, Ц.Цолмон нар МСМН-ыг байгуулаад, улмаар МҮАН-д нэгдсэн, 1992 оны сүүлээр Д.Бямбасүрэн МАХН-аас гарч, улмаар МАСМН-ыг үүсгэн байгуулсан бол Ц.Гомбосүрэн, Ж.Батсуурь нар 1997 онд МАХН-аасаа гарчээ.

Засгийн газраа бүрдүүлсэн талаар Д.Бямбасүрэн гуай “Би чинь кабинетээ өөрөө бүрдүүлэх эрх авсан анхны Ерөнхий сайд. Ардчилсан хүчнээс С.Зоригт санал тавихад татгалзаж, бид ярилцаж байгаад өөр хүний нэрийг оруулъя гэсэн. Танхимаа бүрдүүлэхээс өмнө долоодугаар сард ярилцлага өгөхдөө Д.Дорлигжав, Да.Ганболд хоёрыг чадварлаг сайн залуус гээд дурдсан байсан юм... Да.Ганболд тэр үед Үндэсний дэвшлийн намын дарга байсан. Соцдекүүдэд санал тавихад бид УБХ-ын даргын суудал авчихаад ханаад байна, хоёр дэд сайдын суудал л авъя гэж хэлж байсан юм. Тэгээд би намын төлөөллүүдийг оруулж, эвслийн Засгийн газрын танхимыг бүрдүүлэн ажилласан”⁶⁵ гэж өгүүлсэн байдаг.

ЗАСГИЙН ГАЗАРТ ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭСЭХИЙГ ХЭЛЭЛЦЭВ

Засгийн газар огцорч болзошгүй болов

Засгийн газрын үйл ажиллагааг байгуулагдсан цагаас нь л жадлан эсэргүүцэж шүүмжилж байлаа. Хямралт байдал гүнзгийрч, бэрхшээл нэмэгдэхийн хэрээр нийгэмд буруутныг олж тогтоох аян даамжирч, буруутнаа ч амархан илрүүлсэн нь ардчиллын хоёр хүнийг бүрэлдэхүүндээ багтаасан Засгийн газар болжээ.

Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай яриа 1991.03 сараас газар авч, мөн оны 4 сард Засгийн газрын үйл ажиллагааны тайланг УБХ хэлэлцлээ.

1990–1992 онд МАХН төр засгийн бүх эрх мэдлийг атгаж байсныг АИХ-ын депутатын 84.6%, УБХ-ын гишүүдийн 60%, Засгийн газрын гишүүдийн 87.5%, аймаг, хот, сумын засаг дарга, төрийн өмчит үйлдвэр, хоршооны удирдлага бүгд 100% МАХН-ын харьяалалтай байснаас харж болно. Өөрөөр хэлбэл, МАХН-ын тэргүүлж оройлсон Засгийн газар ажиллаж байсан хэрэг.

Засгийн газрын бүрэлдэхүүнээс ардчилсан хүчний төлөөллийг эгүүлэн татах тухай яригдаж, “Засгийн газар цаашдаа ийм хэлбэрээр ажиллах юм бол МоАН-ын гишүүн, шадар сайд Д.Дорлигжавыг Засгийн газарт ажиллуулах эсэх талаар МоАН авч үзэх болно” гэж Ц.Элбэгдорж мэдэгдэж байв⁶⁶.

Засгийн газрын тайланг хэлэлцэхийн өмнө Төр, нийгэм судлалын академи 258 депутатын дунд социологийн судалгаа хийсэнд, Хоршоологчдын бүлгийн 87.5%, Үл хамаарах чөлөөт бүлгийн 83.7%, Ардчилсан эвсэл бүлгийн 76.3%, МАХН-ын бүлгийн 75.0%, Залуучууд ардчиллын төлөө бүлгийн 57.2%, МоАН-ын бүлгийн 22.2% нь Засгийн

газар огцрох ёстой гэж үзсэн дүн гарчээ. “Засгийн газарт хамгийн нааштай хандсан МоАН-ын бүлэг 30, МҮДН-ын бүлэг ердөө 11 гишүүнтэйг бодолцон үзэх юм бол Засгийн газар огцрох нь бүр ч ойлгомжтой” гэж дүгнэж болохоор байв⁶⁷.

Засгийн газрын тэргүүн огцрох хүсэлт гаргав

Тийнхүү засгийн газрын бүрэлдэхүүнээс ардчилсан хүчний төлөөллийг гаргахыг шаардаад, Засгийн газрыг огцруулах тухай яригдах болов. Нэг үгээр хэлбэл, Засгийн газрыг дийлэнх хувиар бүрдүүлсэн хэрнээ эрх баригч нам сөрөг хүчин шиг аашилж Засгийн газраа чичилсэн хэрэг. Иймд Ерөнхий сайд санаачлан “АИХ-ын депутатуудын дийлэнх нь 1991.12.31-ний өдрийн “АЭ” сонинд нийтлэгдсэн социологийн асуулгаар Засгийн газрыг огцруулах саналаа илэрхийлснийг харгалзан, нийгмийн ардчилал шинэчлэлийн төлөө тууштай байр суурь баримталж байгаа улс төрийн хүчнүүд улс орныхоо хөгжил дэвшил, эв нэгдлийг дээдлэх зарчим дээр өөрсдийн хүчин чармайлтыг нэгтгэхэд анхаарлаа хандуулах шинэ бололцоо олгох үүднээс Засгийн газрын Ерөнхий сайдын албан тушаалаас огцрох саналыг өргөн барьж буйг минь хүлээж авна уу” гэж огцрох өргөдлөө Ерөнхийлөгчид болон АИХ-д өргөн барьсан⁶⁸ байна.

Мөн “Засгийн газрын үйл ажиллагааг төрийн дээд байгууллага АИХ дэмжихгүй байгааг саяхан сонинд гарсан социологийн судалгаа харуулав. Депутатуудын 60-77% нь Засгийн газрыг огцруулах саналтай байгаа юм байна. Үүний дотор манай нам (МАХН)-ын парламент дахь бүлгийн 75% нь Засгийн газрыг дэмжихгүй гэжээ. Төрийн дээд байгууллагын дэмжлэг хүлээгээгүй Засгийн газар огцрох ёстой. Манай Засгийн газрын талаар миний

харьяалагддаг намын сонинуудад маш ихээр гүжир гүтгэлэг явуулсан зэрэг нь огцрох өргөдлөө өгөх үндэслэл болсон” гэж тайлбарлажээ⁶⁹.

Ерөнхий сайд бээр АИХ-ын чуулганы хуралдаанаар Засгийн газрын тайланг хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан, улс төрийн намуудын дарга нартай 1992.01.16-нд уулзаж зөвлөлджээ.

1992.01.23-ны өдрийн АИХ-ын чуулганы хуралдаанаар Засгийн газарт итгэл үзүүлэх эсэхээр санал хураалт болж, 59%-ийн саналаар итгэл үзүүлэн, “БНМАУ-ын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэж байгааг илэрхийлсүгэй” хэмээсэн АИХ-ын 17-р тогтоолыг баталсан. Холбогдуулан Ерөнхий сайд Д.Бямбасүрэн “АИХ-ын эрхэм депутат та нөхөд Засгийн газрын тайланг хэлэлцэн, Монгол орныхоо хувь заяаны нэн тулгамдсан асуудлаар санал бодоо солилцоход өөрсдийгөө сонгосон ард түмнийхээ хүсэл бодлыг илэрхийлсэн, манай нийгмийн нэн түвэгтэй, бэрхшээлтэй, ээдрээтэй энэ үед надад итгэл олгосон явдалд чин сэтгэлийн талархал илэрхийлж байгааг хүлээж авна уу” хэмээн талархал илэрхийллээ⁷⁰. Гэсэн ч Засгийн газарт хаягласан шүүмжлэлийг ардчилсан хүчинд, ардчилсан хүчнийг төлөөлөн Засгийн газарт ажилласан хоёр сайдтай тун дадамгай холбодог байлаа. Иймд шадар сайдыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс эгүүлэн татах асуудал МоАН-ын удаа дараагийн хурал дээр яригдсаар, МоАН-ын Үндэсний хорооны ээлжит хурал (1992.02.25) дээр бүр хүчтэй хэлэлцжээ.

Сөрөг хүчний байр суурин дээр ажиллахаа илэрхийлсэн МСДН Засгийн газар эмхлэгдэн байгуулагдаад 10 сар болсны ойн дээр УБХ-ын ээлжит бус чуулганы хуралдаан дээр үйл ажлыг нь дүгнээд, “Засгийн газарт итгэхгүй байна” хэмээн мэдэгдлээ. П.Улаанхүү хэлсэн үгэндээ, “Өнөөдөр

Бямбасүрэнгийн Засгийн газрын үйл ажиллагааг ажиглавал ерөнхийдөө нийгмийн бүх давхарга, улс төрийн хүчнүүдэд тал алдахгүй байх гэсэн шийдмэг бус байр суурь юм... зах зээлд шилжинэ гэхихээд хямрал ярин, доороо хий эргэж байна... Засгийн газар ард иргэдэд шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг ойлгуулах талаар юу ч хийхгүй байгаа учраас Засгийн газар ямар нэг алхам хийхэд ажил хаялт, өлсгөлөн, суулт гэх мэт зүйлтэй тулгарч, мухардалд орж байна... н.Бямбасүрэнгийн Засгийн газар зах зээлд шилжих талаар 20-р тогтоол, бензиний үнэнд алаг цоог өөрчлөлт хийснээс өөр ямар нэг зоригтой алхам хийсэнгүй... Засгийн газарт итгэх эсэх талаар УБХ-д санал хураалт явуулж өгнө үү” гэсэн байв⁷².

Үүнээс өмнө 1991.06.10-нд МоАН, МҮДН-д хандан Засгийн газраас гарч, хамтарсан сөрөг хүчин болохыг МСДН уриалаад байлаа.

Засгийн газрын талаарх үнэлэлтүүд

1992.04.22-нд ГХЯ-нд болсон хэвлэлийн бага хурлын үеэр эрх баригч намын удирдлага (Б.Даш-Ёндон, Н.Багабанди нар) “Өгсөн үүрэг даалгаврыг Ерөнхий сайд сайн биелүүлж байна. Ерөнхий сайд НТХ-ны тэргүүлэгчидтэй ажил төрлөө байнга зөвлөлдөж байгаа. Өгсөн даалгавраас бүрэн биелэгдээгүй нэг асуудал бол алт дилер юм. Тэр л хэвээр үлдлээ” гэжээ. Харин зарим нэг улс төрчийн хувьд “Д.Бямбасүрэн үнэн чанартаа МҮДН-ыг үүсгэн тэтгэгч, МСМН-ыг үндэслэгч, МоАН-ын удирдагчийг өөгшүүлэн түлхэгч, МАХН-ыг улс төрийн хүчний хувьд устгахыг мөрөөдөгч болохыг нуух хэрэггүй” (МАХН-ын ТХ-ны гишүүн М.Зэнээ) нэгэн байв⁷³.

1990–1992 онд ажилласан Эвслийн Засгийн газар Монгол орны нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий хямралын

үеийн ачааг үүрсэн юм. Хямрал дэлхийн тэн хагаст нэгэн зэрэг давалгаалсан. Энэ тухайд тэргүүн шадар сайд Да.Ганболд “Монгол орныг донсолгож буй энэ хямрал нь ардчиллын үйл явц, олон намын тогтолцоо, ЗХУ-ын эдийн засгийн хямралт байдал, өнөөгийн Засгийн газрын үйл ажиллагааны аль алианаас нь шууд бүхэлдээ шалтгаалаагүй, бие даасан бодит зүй тогтолт үзэгдэл юм” гэж тайлбарласан нь буйн дээр шинэчлэлийн бодлого хууль эрх зүйн баталгаагүй орчинд хэрэгжих гээд, нийгмийн сэтгэл зүй бэлэн биш байсантай, хуучинсаг улс төрийн хүчний сүр нөлөө хэвээр байсантай, тэр хүчин төр засгийн эрх барьж, бодлого тодорхойлж байсантай ч холбоотой юм⁷⁴.

Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат, “Бямбасүрэнгийн Засгийн газар үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг УБХ-аар батлагдсан өдрөөс хойш 42 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр бодож боловсруулсан боловч шинэ Үндсэн хууль батлагдаж, төрийн шинэ тогтолцоог Үндсэн хуулийн дагуу бүрэлдүүлэх шаардлага тулгарч, 18 сар ажиллаж, богинохон зуур нийгмийн шинэчлэлийн анхны морин замыг гаргах түүхэн хариуцлагыг хүлээсэн юм” хэмээн эвслийн анхны Засгийн газрыг дүгнэж цэгнэжээ⁷⁵.

Монгол улсын 16 дахь Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн “гол гавьяа нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзан, зах зээлийн тогтолцоонд орох шилжилтийг удирдан гүйцэтгэсэн. Өмч хувьчлах ажлыг эхлүүлсэн” явдал мөн билээ⁷⁶.

Жич: Ерөнхий сайд Д.Бямбасүрэн 1992 оны УИХ-ын сонгуулиар МАХН-аас нэр дэвшин сонгогдсон юм. Үзэл бодол нийлэхгүйн улмаас 1992.12.12-нд МАХН-аас гарах өргөдлөө өгч, улмаар мөн оны 12.27-нд УИХ-аас чөлөөлөгдөхийг хүсжээ. УИХ-ын гишүүний орон гарсан суудалд н.Ган-Өлзий (Хэнтий) нөхөн сонгогдсон.

УЛС ТӨРИЙН ЭРГЭН ТОЙРОНД (1990–1991)

АСХ-д шинэ удирдлага сонгогдов

АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн өргөтгөсөн хурал 1990.09.19-26-ны өдрүүдэд болж, Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнд орох зохион байгуулалтын асуудал, МСДН, АСХ-ий хамтын ажиллагааны уялдааны талаар хэлэлцжээ.

АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн дарга Р.Гончигдорж БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, УБХ-ын даргаар, АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн нарийн бичгийн дарга П.Улаанхүү УБХ-ын гишүүнээр сонгогдсонтой холбогдуулан АСХ-ий сонгуульт ажлаас чөлөөллөө.

АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн даргаар А.Ганбаатарыг, нарийн бичгийн даргаар Г.Чулууныг сонгов.

МСДН, АСХ-ий хамтын ажиллагааны уялдааны талаар хэлэлцэх явцад олон нийтийн хөдөлгөөн АСХ нь нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралын үйл явцын онцлогийг тусгаж, харьцангуй бие даасан хэлбэртэй, уян хатан ажиллах нь зүйтэй гэж үзжээ.

МСДН-ын УТЗ, АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлд давхардан сонгогдсон Ц.Адьяасүрэн, Н.Алтанхуяг, Б.Батбаяр, Ч.Баярманлай, Д.Ганхуяг, Д.Ламжав, Р.Хатанбаатар нарыг АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээс чөлөөлсөн байна.

МСДН-ын УТЗ-ийн 1991.01.07-ны өдрийн хурлаар Ж.Бямбасүрэнг намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томиллоо. Энэ хэр тус намын дарга Б.Батбаяр гадаад улс (Лондон хот)-д мэргэжил дээшлүүлэх ажлын шаардлагаар явах болоод байв.

МҮДН, ШДХ хуралдсан нь

МҮДН-ын Зөвлөлийн хурал 1991.01.05-07-нд болж, цаг үеийн болоод зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Намын байгуулалтын ажлыг шинжлэх ухаанч үндэслэлээр боловсронгуй болгож, аймаг, хотын АШБ-ыг шуурхай удирдлагаар хангах, боловсон хүчнийг бэлтгэх, мэдээллийн шуурхай байдлыг сайжруулах талаар ярилцжээ.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцээд, Намын зөвлөлийн тэргүүлэгчдийг Ш.Алтангэрэл, Ж.Баасанбаш, Н.Батбаяр, Б.Буянмөнх, Д.Бүүвэйбаатар, С.Бямбаа, Да.Ганболд, Даш.Ганболд, Д.Мөнхбаатар, Л.Нацагдорж, Д.Сүх-Эрдэнэ нарын 11 хүний бүрэлдэхүүнтэй сонгож, МҮДН-ын Зөвлөлийн хоёр дахь дэд даргаар С.Бямбааг сонгожээ.

МҮДН-ын Зөвлөлийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Тэргүүлэгчдийн хурал 01.20-нд болж, улс төрийн намуудтай шууд харилцан ажиллах тэргүүлэгчдийн хуваарийг баталжээ. Үүгээр,

- УБХ-тай АИХ-ын депутат, намын зөвлөлийн тэргүүлэгч Н.Батбаяр, Б.Буянмөнх, ШДХ-ны дарга Л.Батсүх, тэргүүлэгч Ш.Шагдарсүрэн

- Засгийн газартай МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд, дэд дарга Д.Сүх-Эрдэнэ нар,

- МАХН-тай МҮДН-ын дэд дарга С.Бямбаа, тэргүүлэгч Даш.Ганболд, Д.Мөнхбаатар нар,

- МоАН-тай дэд дарга Д.Сүх-Эрдэнэ, тэргүүлэгч Ш.Алтангэрэл, Б.Буянмөнх нар,



- МСДН-тай дэд дарга С.Бямбаа, тэргүүлэгч Н.Батбаяр, Д.Бүүвэйбаатар нар,

- МНН-тай тэргүүлэгч Даш.Ганболд,

- МЧХН-тай тэргүүлэгч Ж.Баасандаш, Л.Нацагдорж нар тус тус ажиллах хуваарь гарчээ.

ШДХ-ны Анхдугаар их хурал 03.23-24-нд болж, 632 төлөөлөгч оролцов. Улс орны нийгэм, эдийн засгийн байдалд ШДХ-ноос өгөх Улс төрийн дүгнэлт, Эдийн засгийн дүгнэлт баримт бичгийг баталсан байлаа.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, ШДХ-ны тэргүүлэгчээр Ц.Баатартогтох, Д.Батсүх, Б.Гүнджалам, Ч.Сайнбаяр, Р.Энх-Амгалан нар сонгогджээ.

МҮДН-ын Зөвлөлийн ээлжит хурал 1991.10.26-27-нд болж, “Монголын өнөөгийн улс төр, эдийн засгийн байдалд МҮДН-ын хийх дүгнэлт, баримтлал, байр суурь” (Да.Ганболд) үндсэн илтгэл, “Их цаазын төсөлд МҮДН-ын баримтлах байр суурь” хавсралт илтгэл, АИХ, УБХ-д МҮДН-ын бүлгийн явуулсан үйл ажиллагаа, түүнд өгөх дүгнэлтийн тухай АИХ-ын депутат, АИХ дахь МҮДН-ын ахлагч Н.Батбаяр, АИХ-ын депутат, УБХ дахь МҮДН-ын бүлгийн ахлагч Д.Батсүх нарын мэдээлэл сонордуулгыг сонсжээ.

Үндэсний сэргэн мандлын үзэл санааны суурийг тавьж, Үндэсний тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэж, амь эрсэдсэн Д.Бодоо, С.Данзан нарын гэгээн дурсгалыг хуралд оролцогчид босож хүндэтгэсэн юм.

АИХ дахь МҮДН-ын гишүүн дэмжигч депутатуудын бүлгийн ахлагч Н.Батбаяр АИХ-ын орлогч даргаар сонгогдсон тул бүлгийн ахлагчаас чөлөөлөгдөж, Л.Дашням бүлгийн ахлагчаар сонгогджээ.

Зөвлөлийн хурлаар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МҮДН-ын Зөвлөлийн тэргүүлэгчээр Р.Амаржаргал, Л.Бат-Очир, Ч.Баттулга, Ж.Ганболд нарын гурван хүнийг, Зөвлөлийн гишүүнээр Х.Дашзэвэг, Ю.Должинсүрэн, Ц.Доржпалам, С.Очирбал, Р.Түмэнжаргал, Ж.Цогбадрах, Д. Энхтөр нарыг сонгожээ.

Хурлаас “Нийгмийг бүхэлд нь хамарсан хомсдолын хямрал үндэсний эрх ашиг, ардчиллын ололтыг хөндөх түвшинд хүртлээ гүнзгийрч байгааг ухамсарлан... нэгэнт эхэлсэн эрс өөрчлөлтийг эргэж буцалтгүй үргэлжлүүлэхэд чиглэсэн Засгийн газрын үндсэн бодлогыг дэмжихийн хамт зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих зарчимч зоримог алхмуудынх нь төлөө өөрт ногдох хариуцлага хүлээхэд МҮДН бэлэн байна” гэсэн мэдэгдэл гаргав.

Улс төрийн намуудын тухай хууль батлагдав

Олон намын тогтолцоо, зах зээлийн эдийн засагт шилжих талаар тодорхой цэгцэрсэн баримтлалгүй байсан үед цагийн аяст шахагдан гаргасан БНМАУ-ын Улс төрийн намуудын тухай хууль нь улс төр, эдийн засгийн цоо шинэ тогтолцоонд эргэлт буцалтгүйгээр орсон үед амьдралаас хочорч байгаа нь тодорхой болоод байв⁷⁷.

Тиймээс улс төрийн намууд (МоАН, МСДН, МҮДН, МНН, МЧХН) УБХ-д хандан,

“УБХ-ын 2-р чуулганы төлөвлөгөө ёсоор 1990.12.06-наас эхлэн хэлэлцэгдэх байсан “Улс төрийн намуудын тухай” БНМАУ-ын хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл уг чуулган дуусахад долоо хоног хүрэхгүй хугацаа үлдчихээд байхад батлагдахгүй байгаа нь манай намуудын сэтгэлийг түгшээж байна. Иймд уг хуулийг УБХ-ын энэ удаагийн чуулганаар батлахыг шаардаж байна.

Үйлдвэр, аж ахуй, албан газар, байгууллага дээр олон намын анхан шатны байгууллагууд байгуулагдаж ажиллах болсноор хөдөлмөрийн хамт олны үйл ажиллагаа хэт улс төржиж, намуудад хуваагдах, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг нь нэг намын эрх ашигт нийцүүлэхийг оролдох, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа алдагдах, ажил үүрэг эзэнгүйдэх зэрэг сөрөг үзэгдэл газар авч, манай туйлдсан эдийн засгийг улам бүр доройтуулахад түлхэц болж байна. Мөн улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа нь аливаа улс төрийн үзэл бодлоос ангид байж, гагцхүү төрт ёсоо дээдлэн, эх орон, ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн байх бодит нөхцөлийг бүрдүүлэн, үндэсний эв нэгдлийг хангах, эдийн засгийн шилжилтийн үед улс, байгууллага, хамт олны хөрөнгийг аливаа намд ашиглуулахгүй байх баталгааг бий болгохыг манай өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна” гээд Улс төрийн намуудын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа:

- Намын байгууллагыг зөвхөн нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулах

- Батлан хамгаалах, шүүх, прокурор, цагдаа, гадаад харилцааны болон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудад алба хашиж байгаа иргэд тухайн алба хаах хугацаандаа аль нэг намд харьяалагдахгүй байх

- Намын харьяанд ямар нэг үйлдвэр, аж ахуйн газар байгуулахыг хориглох

- Төр, улсын байгууллага аливаа нэг намд хандивын хэлбэрээр өөрийн өмчөөс шилжүүлдэг явдлыг хориглох заалт оруулахыг санал болгоод, “Эдгээр саналууд уг хуулинд тусгалаа олоогүй нөхцөлд мэдэгдэлд нэгдсэн намууд төр, улс, хоршоолол, олон нийтийн болон үйлдвэр

аж ахуйн бүх байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүдэд хамтарсан үйл ажиллагаа явуулах"-аа дурдсан мэдэгдлийг 1991.01.19-нд гаргажээ.

Мэдэгдэлд улс төрийн намуудын тэргүүн нар МоАН-ын Улс төрийн зөвлөлдөх төвийн ерөнхий зохицуулагч Э.Бат-Үүл, МСДН-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Бямбасүрэн, МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд, МНН-ын дарга Д.Басандорж, МЧХН-ын ТХ-ны дарга Ч.Дөл нар санал нэгдэн гарын үсэг зуржээ. Харин МАХН-ын ТХ-ны дарга Г.Очирбат нэгдэхээс татгалзсан юм. Тиймээс УБХ-ын чуулганы хуралдаан дээр МоАН-ын дарга Э.Бат-Үүл дээрх мэдэгдлийнхээ талаар "аливаа улс төрийн намын эсрэг чиглэсэн бус гагцхүү Монголын нийгэм, улс төрийн тогтолцоог өөрчлөн байгуулах шаардлагаас урган гарсан юм. Гэвч МАХН нь эрх баригч хэмээн өөрөө өөрийгөө өргөмжлөн, хуулиар баталгаажуулахыг санаархаж байгаагаас үзэхэд улс оронд нэг намын дэглэм дахин сэргэж болзошгүйд сэтгэл зовниж байна" хэмээн тайлбарлан ярихад хүрсэн ажээ.

УБХ-ын 1991.01.26-ны хуралдаанаар Улс төрийн намуудын тухай хуульд ардчиллын төлөө намуудын шаардсанчлан өөрчлөлт оруулснаар Намын байгууллагыг зөвхөн нутаг дэвсгэрийн хуваариар байгуулах болж, түүхэн шийдвэр гарсан.

1990–1992 онд УБХ-аар батлагдсан хуулиудаас хамгийн маргаантай шийдвэрлэгдсэн хуулиуд нь Улс төрийн намуудын тухай болон Сонгуулийн хуулиуд гэж хэлж болно.



Ардчиллынхан Чөлөөт Үйлдвэрчний Эвлэлийг дэмжив

1991.02.25. Монголын Чөлөөт Үйлдвэрчний Эвлэлүүдийн нэгдсэн холбоо, МоАХ, АСХ, ШДХ-ноос “Хөдөлмөрчин хүн, хамт олон, мэргэжлээрээ ялгаатай бүлэг хүмүүсийн болон нийт хөдөлмөрчдийн хохирсон эрх ашгийг тухайн түвшин бүрт найдвартай хамгаалах асуудал талуудын нэгдмэл зорилготой нийцэж байгаа тул нийгмийн улс төрийн тогтолцоог шинэчлэх тэмцлийн явцад олсон туршлагадаа тулгуурлан, Чөлөөт үйлдвэрчний хөдөлгөөнийг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулахаар шийдвэрлэлээ” хэмээн хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллахыг гишүүд дэмжигчиддээ уриаллаа.

Дээрх байгууллага, хүчнүүд 1991.03.10-нд хамтын ажиллагааны зарчмаа баталж:

- Талууд нь хөдөлмөрчин олны эрх ашиг гэсэн нэгэн зорилгод захирагдаж, харилцан бие даасан байдлаа хүндэтгэн, тэгш эрхийн үндсэн дээр хамтын үйл ажиллагаа явуулна

- Засгийн газрын явуулж буй бодлого, нийгмийн дунд бий болсон нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, харилцан мэдээлэл солилцон, хамтарсан дүгнэлт гаргаж, үйл ажиллагаа явуулна...

- Шинэчлэлийг түргэтгэх, олон ургальч үзэл санааг хөгжүүлэхийн зэрэгцээ үйлдвэрчний эвлэлийн удирдлага аливаа нэг намын нөлөөлөлд автагдахгүй байх зарчмыг баримтална...

- МоАХ, АСХ, ШДХ нь Чөлөөт ҮЭ-ийн хөдөлгөөнийг өрнүүлэхийн төлөө үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Чөлөөт ҮЭ-үүдийг хүнд сурталд автагдаж, хөдөлгөөний шинж чанараа алдахаас урьдчилан сэргийлнэ хэмээн



тодорхойлжээ.

МҮЭ-ийн холбооны Төв зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийлгэхээр 1991.05.05-нд АСХ ҮЭ-ийн бусад байгууллагатай хамтран мэдэгдэл гаргав.

Улмаар АСХ хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу сайн дураараа эвлэлдэн нэгдэж, ҮЭ-үүд байгуулахыг уриалсны дээр Нийгэм судлалын хүрээлэн байгуулахыг УБХ, Засгийн газарт санал болгосон байдаг.

АСХ нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулагдав

1991.03.09-10-нд АСХ-ий салбар зөвлөлийн төлөөлөгчдийн Анхдугаар чуулган болов. Чуулганаар “Өөрчлөн байгуулалтын нөхцөлд нийгмийн бодлогын талаарх АСХ-ий үзэл баримтлал” (А.Ганбаатар), “АСХ-ий бүх шатны салбарын өнөөгийн зорилт, үйл ажиллагааны чиглэл” (Р.Нарангэрэл) илтгэл хэлэлцжээ.

Улс орны байдал, АСХ-ий үзэл баримтлалыг тодорхойлсон үндсэн илтгэлд нийгмийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн нөхцөлд иргэдийн хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн утга агуулга, нөхцөл, хөдөлмөрийн хүмүүсийн амьдрал ахуй, Засгийн газрын бодлого олон түмний эрх ашигт хэрхэн нийцэж байгаа талаар өргөн хүрээг хамруулан, үнэлэлт дүгнэлт өгчээ. Удаах илтгэлд АСХ нь хөдөлгөөнийхөө онцлогийг хадгалж ажиллах, олон нийтийн байгууллагынхаа хувьд цаашид ямар зохион байгуулалтаар, хэрхэн үйл ажиллагаагаа өрнүүлэх үндэслэлүүдийг гаргаж тавьжээ.

Чуулганаас тогтоол гаргахын хамт, Засгийн газарт хандан, мэдэгдэл гаргажээ.

Мөн АСХ-ийг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион



байгуулахаар шийдвэрлэж, салбар зөвлөл, анхан шатны салбар зөвлөлийн тамгыг гардуулсан нь онцлог үйл явдал байлаа.

1991.04.11-нд МоАН, МСДН, МҮДН, МНН, МЧХН-ууд улсын нууц хадгалалт, хамгаалалт, зарим иргэдийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажил ихээхэн доголдож байгааг анхааран зөвлөлдөж, “тохиролцсоны үндсэн дээр УБХ-ын гишүүдэд” хандан

1.Ю.Цэдэнбал, түүнийг тойрон хүрээлэгчдийн асуудлыг шалган шийдвэрлэх парламентын комиссыг 1991.04.20-ны дотор зохион байгуулж, хууль зүйн дагуу ил тод ажиллах нөхцөл бололцоогоор хангах

2. Монгол орныг 60-70 жилийн турш дангаар захирч, төр засаг болж хувирсан МАХН-ын архив нь манай улсын түүхэнд шууд холбогдох чухал баримт юм. Үүний тулд энэ архивын баримт материалыг төрийн хяналтад авах

3. Урьд нь нам, төр засгийн өндөр албан тушаалд байсан, Улсын нууцыг ихээхэн хэмжээгээр мэдэх хүмүүс ямар ч хяналтгүй байж, дур зоргоор гадаадад явах, тэр ч байтугай улсын чухал баримт бичгийг үрэгдүүлэх зэрэг зохисгүй байдал гаргах боллоо. Учир иймд тэдгээр хүмүүсийг хувь хүний нь хувьд аюулгүй байдлыг нь хангаж, улсын хараа хяналтад авах шаардлага тавьсан байна⁷⁸.

Социал-демократуудын соёлтой жагсаал

Монгол Улсын төр засгийн тэргүүн асан Юмжаагийн Цэдэнбал 1991.04.21-нд ОХУ-ын нийслэл Москва хотноо таалал төгсөв.

АСХ-ий Гүйцэтгэх зөвлөл “Төр засгийн тэргүүнээ

эх оронд нь эгүүлэн авчирч, төрийн хамгаалалтанд авахыг шаардаж байсан бидний тэмцэл талаар болсон харамсахын зэрэгцээ Юмжаагийн Цэдэнбал нь ЗХУ-д насан өөд болсон Монгол Улсын дөрөв дэх тэргүүн болсон нь бидэнд нэгийг бодогдуулж байна...

Туурга тусгаар Монгол Улсаа сэргээн тохинуулах гэж байгаа өнөө үед манай төр засгийн тэргүүн асан Юмжаагийн Цэдэнбал Москва хотноо таалал төгссөнд бид гүнээ харамсаж байна.

Юмжаагийн Цэдэнбалын шарилыг чандарлалгүйгээр эх оронд нь залан авчирч, хүндэтгэл үзүүлэн оршуулахыг БНМАУ-ын Ерөнхийлөгч, БНМАУ-ын Бага Хурлаас бид хүсэмжилж байна” хэмээн төр засгаа дээдлэх, хүнийг эрхэмлэх үзлээ эш үндэс болгон мэдэгдэж, гүн эмгэнэл илэрхийллээ.

Талийгаачийг 04.29-нд эх оронд нь Алтан-Өлгийд нутаглуулсан. Салах ёслолд хүрэлцэн очсон ардчилсан хүчний төлөөлөгчид хүндэтгэлээ тун өвөрмөц илэрхийлсэн юм. Энэ тухайд Ю.Цэдэнбал асны бага хүү ийн дурсжээ: Хэдийд ч юм бэ танхимд дөрвөн хүн ороод ирсэн байлаа (Хожим нь бид саяхан байгуулагдсан Социал-демократ намынхан гэдгийг мэдсэн). Тэд гартаа дөрвөн хүний хөрөг зураг барьжээ. Шарил бүхий авсыг тойрч, талийгаачийн магнайд очиж, хөрөг зургаа барьсан хэвээр хэсэг зогсов. 1921 оны хувьсгалаас хойш (ЗХУ-д амь үрэгдсэн) Монголын дөрвөн удирдагчийн хөрөг зургийг барьж зогссон нь энэ билээ... Энэ нь тун ойлгомжтой, онцгой соёлтой улс төрийн жагсаал байв⁷⁹.

АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛИЙГ БАТАЛЛАА (1992.01.13)

Үндсэн хууль боловсруулах комисс

Монгол улсад нийгмийн байгуулал солигдсон нь шинэ нийгмийн харилцааг тодорхойлж зохицуулах тулгуур хууль- Үндсэн хуулийг өөрчлөх, шинээр боловсруулах түүхэн шаардлага, нийгмийн захиалгыг тулган тавив.

Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссыг УБХ 1990.10.04-нд БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр ахлуулан 16 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. Комиссын орлогч даргаар УБХ-ын орлогч даргаар К.Зардыханыг, нарийн бичгийн даргаар УБХ-ын нарийн бичгийн дарга Б.Чимидийг баталжээ. Комиссын гишүүдэд Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, Хууль зүйн сайд Ж.Амарсанаа, УБХ-ын БХ-дын дарга С.Баяр, Т.Очирхүү, Р.Хатанбаатар, Л.Цог, М.Энхсайхан, МоАН, МСДН, МҮДН, МНН, МЧХН, МАХН-уудын дарга Э.Бат-Үүл, Б.Батбаяр, Да.Ганболд, Д.Басандорж, Ч.Дөл, Г.Очирбат нар батлагджээ. Комисс 1991.03.01-ний дотор Үндсэн хуулийн төслийг боловсруулж, УБХ-д хэлэлцүүлэх үүрэг хүлээжээ.

Үндсэн хуулийн төслийн анхны хувилбарыг Б.Чимид нар 1990 онд боловсруулсан ажээ. Чингээд Д.Лүндээжанцан нарын хэсэг хуульчдын, МСДН-ын дарга Б.Батбаярын, МНН-ын гэсэн гурван хувилбар боловсруулсан байжээ⁸⁰.

Ажлын хэсэг Үндсэн хуулийн төслийг боловсруулж, 1991.04.19-нд УБХ-аар хэлэлцүүлэн засварлаад, “Монгол улсын Их цааз”-ын төсөл нэрээр ард нийтээр хэлэлцүүлсэн юм. Хэлэлцүүлгийг 1991.06.10-09.01-ний хооронд явуулжээ.

Үндсэн хуулийн төслийг 7000 гаруй байгууллага, хамт олон хэлэлцэж, 900 мянган хүн оролцож, давхардсан

тоогоор 2 сая гаруй санал гарчээ⁸¹. Үндсэн хуулийн төслийг УБХ хоёр удаа хэлэлцүүлэг хийж, АИХ-д оруулан хэлэлцүүлжээ. П.Очирбатын дурссанаар, "... давхардсан тоогоор 220-оод мянган санал гаргасныг үзэхэд олон түмэн шинэ төрийн төлөө ямар их санаа тавьж байсныг мэдэж болно" хэмээжээ⁸².

Б.Чимэд ахлагчтай 37 хүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллажээ. Иргэдээс 20 мянга орчим санал бичгээр ирүүлсэн байжээ⁸³.

Үндсэн хуулийн төслийг өргөн барив

Үндсэн хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлсний дагуу төслийн удиртгал, 5 бүлэг, 81 зүйлийн 90 гаруй хэсгийн зохих заалтыг засаж найруулснаас гадна 70-аад хэсэгт зарчмын шинэ нэмэлт өөрчлөлт хийж найруулсан тухайгаа 1991.10.07-нд УБХ-д илтгэж, АИХ-д өргөн барихыг хүсжээ⁸⁴.

БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р чуулганы хуралдааны эхний өдөр 11.11-нд АИХ-ын сонгуулиар маргаантай үлдсэн 8 тойрог, өмнө сонгогдсон депутатууд нь өөр ажилд томилогдсон 7 тойрогт шинэ сонгогдсон депутатуудын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн байна. Ардчилсан хүчнээс Д.Моондой (МСДН) 278-р тойрогт АИХ-ын депутатаар сонгогджээ⁸⁵.

Мөн Н.Батбаяр (МҮДН), Д.Моондой нар АИХ-ын орлогч даргаар сонгогдов.



АИХ-ын чуулганы 1991.11.12-ны өдрийн хуралдаанд “Монгол улсын Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлийг БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат тавив.

Ажлын хэсгийн анх төлөвлөснөөр АИХ-ын чуулган Үндсэн хуулийн төслийг ажлын 9 хоногт багтаан хэлэлцэж, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр 11.26-нд Үндсэн хуулиа батлахаар бодож байсан ажээ. 12.23-ны өдрийн 12:00 цаг хүртэл хугацаанд АИХ-ын чуулганаар Үндсэн хуулийн төслийн эхний хэлэлцүүлэг явагдсан. Нийт 427 депутатын 425 нь хүрэлцэн ирж, ирц 98.4% бүрдсэн байжээ.

Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн явцад депутатуудын дунд “Ардчилсан эвсэл” бүлэг байгуулагдаж, МАХН-ын төлөөлөл нэлээд олон депутат нэгдсэн нь шинэ хуучин үзэл бодлын ялгарал чуулганы танхимд хэр гарч байсныг илтгэдэг. Уг бүлэг байгуулагдсан тухай мэдээллийг 11.18-ны хуралдаан дээр депутат Л.Пүрэвдорж зарлажээ.

Ардчилсан эвсэлд МоАН-аас (Э.Бат-Үүл ахлагчтай) 32, МСДН-аас (Р.Хатанбаатар ахлагчтай) 7, МҮДН-аас (Л.Дашням ахлагчтай) 5, МАХН-аас (Д.Баасанжав ахлагчтай) 28, “Залуучууд ардчиллын төлөө” бүлэг (С.Баярцогт ахлагчтай) 10, Нам бусчуудын бүлгээс (Л.Пүрэвдорж ахлагчтай) 7 депутат оржээ. Эвслийн бүлгийн зөвлөл байгуулж, Зөвлөлийн даргаар Р.Барсболд, нарийн бичгийн даргаар К.Сайраан, зөвлөлийн гишүүнээр Д.Баасанжав (МАХН), Э.Бат-Үүл (МоАН), С.Баярцогт (“Залуучууд ардчиллын төлөө” бүлэг), Л.Дашням (МҮДН), Л.Пүрэвдорж (нам бусчуудын төлөөлөл), Р.Хатанбаатар (МСДН) нар сонгогджээ.

Жич: Тус бүлэгт У.Баянбилэг, С.Баяр, Д.Гантөмөр,

С.Ёндонцоо, Б.Лигдэн, К.Мизамхан, М.Нямсүрэн, С.Пүрэвдорж, Б.Чимид нарын 10 депутат мөн нэгдсэн.

Ардчилсан Үндсэн хууль батлагдан гарахад эвслийн бүлгийн депутатуудын ардчилсан шинэлэг үзэл, нэр нөлөө, хүчин зүтгэлийг үнэлж баршгүй юм.

Үндсэн хуулийг баталлаа

Үндсэн хуулийг нэгтгэн боловсруулж эцэслээд бүх депутатад хувилан тарааж өгсөн эхээ 1992.01.13-ны өглөө УБХ-ын нарийн бичгийн дарга Б.Чимэд АИХ-ын Их танхимын индэр дээрээс танилцуулав.

АИХ-ын орлогч дарга Ж.Уртнасан Үндсэн хуулийг бүрэн эхээр нь уншиж, батлах санал хураажээ. АИХ-ын депутатын 99.0%-ийн саналаар 1992.01.13-ны өдрийн 11:35 цагт Монгол улсын Үндсэн хууль батлагдлаа. 1 хүн татгалзаж, 2 депутат түдгэлзжээ.



Үндсэн хууль батлагдсантай холбогдуулан Ерөнхийлөгч П.Очирбат баяр хүргэн, үг хэлжээ. Ерөнхийлөгч Үндсэн

хуулийн эх дээр гарын үсэг зуран баталгаажуулсан байна. Тэрээр “Төрийн тэргүүн болоод миний удирдаж зохион байгуулсан ажлын сор нь Монгол улсын Үндсэн хууль юм” гэж дурссан байдаг⁸⁶.



Үндсэн хуулийг хэлэлцэхэд анхны парламент тун ажил хэрэгч байж, хэт намчирхалгүй, нутгархаж жалгархалгүй ажилласан гэж үздэг. Үүнийг “УБХ-аар хэлэлцсэн хамгийн том асуудал нь Ерөнхийлөгчийн засаглалтай байх уу, парламентын засаглалтай юу гэдэг асуудал байсан. Мэдээж хоёр том гүрний дунд байдаг жижиг орны хувьд бид шийдвэр гаргахдаа олон хүний зөвшилцөөн дундаас гаргадаг байх юм бол Монгол улс аль нэг тал руугаа хэлбийгээд байхгүй. Энэ үүднээс одоогийн сонголтыг хийсэн... Парламентуудыг дүгнээд ярихад хамгийн ажилсаг нь Бага хурал байсан гэж боддог”⁸⁷, “Энд нэг зүйлийг цохон тэмдэглэхэд, тухайн үед УБХ дотор аж ахуй, бизнесийн ашиг сонирхол гэж байгаагүйг хэлэх хэрэгтэй. Бидэнд хувийн ашиг сонирхол байгаагүй. Ачааны хүндийг

бүх л гишүүд үүрэлцсэн”⁸⁸, “УБХ... шинэ нийгмийн суурь харилцааг зохицуулах үүрэг бүхий шинэ Үндсэн хуулийг боловсруулах нэр их ажилд дайчлагдсан юм. Монголын нэн шинэ түүхийн нэр хүндтэй зохиогчид байж чадсан АИХ-ын 12 дахь бөгөөд сүүлчийн сонгууль хүлээсэн тэр хүмүүст үе үеийн монголчууд, Монголын төр гүн хүндэтгэлтэй хандах ёстой гэсэн бодлоо нуух юун”⁸⁹ хэмээн догдлон бахдаж дурссан үгс нотолно.

УБХ шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулж хэлэлцээд, АИХ-аар хэлэлцүүлж батлуулахаар шилжүүлэхдээ олон улсын нэртэй хуульчид, НҮБ-аас мэргэжилтэн урьж, санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ дэлхийн ардчилсан орнуудын Үндсэн хуулийн хэв шинжийг судалжээ. Олон комисс, бүлэг ажиллажээ. Тухайн үед “Зөвхөн Монголын хуульчид ажиллаад, сайн хууль батлах боломжгүй байсан л даа” хэмээн ҮХЦ-ийн дэд дарга Н.Жанцан ардчилсан Үндсэн хууль баталсан өдрөөр 2009 онд дурссан нь буй⁹⁰.

Монгол улсын шинэ Үндсэн хууль нь хүнлэг ардчилсан тогтолцоог бий болгоход суурилсан, хүний эрх, өмчийг хамгаалсан, хууль шүүхийн өмнө иргэд эрх тэгш байх зарчмыг тусгасан хууль болсон юм.

Монгол улсын Үндсэн хуулийн төслийг 1991.11.11-ний өдөр нээгдсэн АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдаанаар АИХ-ын 432 депутат нийт 76 хоног хуралдаж, 1992.01.13-ны өдрийн 11:35 цагт баталжээ.

БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай Үндсэн хуулийн хавсралт хуулийг 1992.01.16-ны өдрийн 09:38 цагт баталж, “Монгол улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван

долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө” (70:2) гэж заажээ.

Тийнхүү үндсэн хуулийг бүтэн нэг жил гаруй хугацаанд боловсруулж, батлан гаргасан юм. Энэ түүхийг эл түүхийн гэрч болох зүтгэлтнүүд “Ардчилсан хүчнүүдээс хоёр жилийн турш явуулсан тэмцлийн гол үр дүн нь шинэ Үндсэн хууль батлагдсан явдал гэж үзэж байна. Монгол оронд хэвийн, эрүүл саруул нийгэм байгуулах хууль зүйн үндэс бий боллоо” (УБХ-ын гишүүн Д.Энхбаатар), “Шинээр гарсан Үндсэн хуулинд УБХ-аас оруулсан төслийн үзэл санаа бүрэн хадгалагдсан. Үндсэн хууль маань ардчилсан Үндсэн хуулийн дүр төрхийг бүрэн агуулсан гэж би үзэж байна. Одоо бид төсөл, Үндсэн хууль гэж ярих нь утга учиргүй юм. Одоо бид шинээр батлагдсан Үндсэн хуулиа мэдэгтүн, сахигтун гэж заасны дагуу яг таг биелүүлэх ёстой” (Монгол улсын дэд Ерөнхийлөгч, УБХ-ын дарга Р.Гончигдорж)⁹¹, “УБХ-ын хамгийн гол бүтээл бол Монгол улсын Үндсэн хууль гэж хэлж болно. УБХ-аас оруулсан Үндсэн хуулийн эх төсөл АИХ-ын чуулганаар төдийлөн их өөрчлөгдөж, өнгө зүсээ хувилгалгүйгээр бараг тэр чигээрээ батлагдсан. Үнэн хэрэгтээ Монгол улсын шинэ Үндсэн хуулийг УБХ баталж, АИХ батламж өгсөн ч гэж хэлж болно” гэх зэргээр үнэлж дүгнэсэн байдаг⁹².

Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэнд зориулсан цуглаан Д.Сүхбаатарын талбайд болж, Улаанбаатар хотын АДХГЗ-ны дарга Л.Энэбиш нээж, үг хэлжээ. Цуглаанд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, УБХ-ын дарга, дэд Ерөнхийлөгч Р.Гончигдорж, Ерөнхий

сайд Д.Бямбасүрэн, УБХ-ын орлогч дарга К.Зардыхан, нарийн бичгийн дарга Б.Чимид, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ч.Дашдэмбэрэл болон УБХ-ын БХ-дын дарга нар, Засгийн газрын гишүүд, албаны хүмүүс оролцжээ.

Үндсэн хууль баталсны 1 жилийн ойд зориулсан УИХ-ын чуулганы ёслолын хуралдаан дээр (1993.01.12) МСДН-ын дарга Б.Батбаяр “Өнөөдөр манай олон хүн, түүний дотор УИХ-ын гишүүдийн өөрсдийнх нь сайн болсныг нь шагшин, гадаад дотоодод нүүрээ тахлаж яваа энэ Үндсэн хуулийг энэ хэлбэрээр батлуулахад МоАН, МСДН, МҮДН голлох үүрэг гүйцэтгэснийг ганц жилийн дотор хэн ч мартаагүй яваа байх, гэтэл энэ намуудын албан ёсны дуу хоолой, үнэлэлт цэгнэлтийг сонсохгүй хэмээн элдэв арга саам хийж буйн үнэн учрыг олоход хэцүү л байна”⁹³ хэмээж байлаа.



НАМ ХҮЧНҮҮДИЙН НЭГДЭЛ... ШИНЭ НАМУУД

Намууд эвсэх, нэгдэх тухай ярилцсан нь

Ардчилсан хүчний удирдагчдын уулзалт зөвлөгөөн (1991.06.28-30)-д МоАН, МоАХ, МСДН, АСХ, МҮДН, ШДХ, МЧХН, Чөлөөт хөдөлмөр эрхлэгчдийн Холбоо, Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн Холбоо, МНН. Ногоонтны хөдөлгөөн, МШАН, Монголын Сүсэгтний холбоо, Монголын Ардын аж ахуйтны Холбоо оролцжээ.

Зөвлөгөөнөөр улс орны нийгэм, эдийн засгийн байдлын талаар хэлэлцэж, МАХН-аас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг шүүмжилжээ. Ардчиллын төлөө намууд улс төрийн талбар дээр хамтран тэмцэхээр тохирсны дээр улам яригдах болсон эвсэх, нэгдэх асуудал ч хүчтэй дэвшигдэн хэлэлцэгджээ. Ардчилсан хүчний удирдагчид Хамтарсан мэдэгдэл гаргасан юм. Үүнд,

- МАХН-ын хуучин, шинэ удирдлага улс орны өмнө тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг ардчилсан хүчинтэй холбон овжноор тайлбарлаж, өөрийн мэдэлд буй улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан, ардчилсан хүчний эсрэг эрээ цээргүй дайрч, нэр хүндийг нь ил далд аргаар гутаан, ард түмний сэтгэл санааг хуучин хувьсгалт коммунист үг хэллэгээр үймүүлж, аврагчийн дүрд илт тоглох боллоо.

- МАХН-аас өнөөгийн шатанд явуулж байгаа үйл ажиллагаа нь бүхэлдээ ардчиллын эсрэг хандаж, эдийн засгийн хямрал бэрхшээлийг дэврээн, улс төрийн зорилгодоо ашиглах, ард түмнийг урьдын адил өмч хөрөнгийн эрх мэдэлгүй, дуулгавартай гүйцэтгэгч байлгахыг санаархаж, өмч хувьчлалаас өрсөж сорчлон

ээгнэх идэвхтэй бодлого явуулж, бэл бэнчингээ зузаатгаж байна. Ардчилалд учирч буй бодит аюулаас сэрэмжилж, Монгол Улсын үндэсний эрх ашгийг эрхэмлэх үүднээс ардчиллын төлөө улс төрийн бүх хүчин коммунизмын аюулын эсрэг нэгдмэл хүчээр зохион байгуулалттай, улс төрийн өргөн тэмцэл хийхээр хэлэлцэж тохирсноо олон түмэнд зарлан мэдэгдэж байна гэсэн байв.

МАХН-ын доторх МАН-ын уламжлал шинэчлэлийн жигүүрийн удирдлагатай Ардчилсан хүчний зөвлөгөөнд оролцогчид уулзаж, санал солилцжээ.

АСХ, МСДН нэгдлээ

МСДН-ын V бага хурал “МСДН-ын Бага хурал, АСХ-ий салбаруудын төлөөлөгчдийн чуулган” гэсэн өргөтгөсөн хэлбэрээр 1991.09.14-15-нд боллоо.

Хурлаар МСДН, АСХ нь улс төрийн нэг хүчин болж нэгдэх тухай асуудлыг хэлэлцжээ. Холбогдуулан АСХ-ий Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Л.Бямбажаргал “Монгол орон дахь ардчиллын үйл явц, АСХ-ий цаашдын зорилт” илтгэлдээ

Анхны улс төрийн нам болох МАХН-аас эхлээд бараг хамгийн сүүлчийн гэж болох 281-ийн холбоо гэгч намуудын эсрэг нам хүртэлхийг хамарсан олон хөдөлгөөн байгууллагын үйл ажиллагаа нь улс төрийн хөдөлгөөний учир утгыг алдагдуулж, улс оронд буй болсон хүндрэлтэй байдал дээр дөрөөлөн, бидний тэмцэж олж авсан олон намын тогтолцооны мөн чанарыг гажуудуулж, устгаж ч болох аюул занал учруулж байна. Иймд ардчиллаа хамгаалахын тулд бид өнөөдөр нам, хөдөлгөөндөө зарчмын өөрчлөлт хийж, зохион байгуулалтын талаар ч тэр, ажлын арга хэлбэрийн хувьд ч тэр, шинэ утга агуулга

өгөх хэрэгтэй боллоо. Иймд АСХ-ий үндсэн зорилго болох ардчиллыг хөгжүүлэхийн тулд хамгийн эрс зоримог өөрчлөлт хийх шаардлагатай байна. Энэ тухай АСХ-ий Гүйцэтгэх зөвлөл дээр хуралдаж, дараах саналууд гарсныг та бүхэнд толилуулъя.

Хөдөлгөөн цаашид одоо байгаа хэлбэрээрээ оршин байж болохгүй гэж дийлэнх олонх нь үзлээ. Ингээд АСХ цаашид ямар хэлбэрийн, ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага байвал хамгийн зохимжтой байх талаар олон тооны хувилбарыг гаргаж, эдгээрээс дөрвийг нь сонгон авч, чуулганд оруулахаар боллоо. Үүнд, МСДН-ыг дэмжигч фонд болж хувирах, мөн аажмаар ҮЭ болох, фонд ҮЭ болох хосолсон хувилбар, дөрөв дэх нь өөрөө тарах гэсэн саналууд байна” хэмээн онцолсон юм.

Тус тусдаа улс төрийн хүчнүүд нэгдсэн нэг хүч болох тухай гаргасан саналыг авч хэлэлцээд, зорилго чиглэл нэгтэй эл хоёр байгууллага МСДН-ын нэрийн доор нэгдэх шийдвэр гаргасав.

Шийдвэрийг үндэслэн, АСХ, МСДН нэгдсэнтэй холбогдон гарах санхүү, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх эрхийг шинээр сонгогдох МСДН-ын УТЗ-д олголоо (Хамтарсан хурлын 1991.09.15-ны №01 тогтоол).

МСДН-ын бага хурлаас УТЗ-ийн гишүүнээр Ц.Адьяасүрэн, Н.Алтанхуяг, Б.Бат-Эрдэнэ, Р.Бурмаа, Л.Бямбажаргал, Ж.Бямбасүрэн, А.Ганбаатар, С.Идшинноров, Д.Ламжав, Ч.Лхагважав, Д.Моондой, С.Мэндсайхан, Р.Нарангэрэл, С.Рэндорж, Н.Түвшинтөгс, П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Г.Чулуун нар сонгогджээ.

Намын даргаар Б.Батбаяр, дэд даргаар А.Ганбаатар, Р.Хатанбаатар нарыг баталж, тус нам хоёр нарийн бичгийн даргатай байхаар тогтов.

Мөн Хамтарсан хуралдааны төлөөлөгчид "... АСХ, МСДН нь адилхан чиг баримтлалтай улс төрийн хүчин болохоо хүлээн зөвшөөрөлцөөд, МСДН нэрийн доор нэгдлээ. Иймээс АСХ-ий гишүүн хүн өөрөө хүсвэл АСХ-ий гишүүний үнэмлэх тань МСДН-ын гишүүний үнэмлэх болно. Хэрэв та өөр намын гишүүн байгаа бол Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэхийн тулд тэр намаасаа гарах шаардлагатай...

Социал-демократ үзэл нь яг одоогоор манайд оршин тогтнох нийгмийн тодорхой хөрс суурьтай. Харин энэхүү бааз суурь дээр тулгуурласан жинхэнэ нам байгуулан хөгжүүлэх нь дээрх үзэл баримтлагчдын нэг чухал зорилт болоод байна. Ийм учраас социал-демократ үзэл бодол баримталдаг хүмүүс, бүлэглэл, хөдөлгөөн, жигүүрээс МСДН-д ирж нэгдэх, хамтран ажиллахыг УРИАЛЖ БАЙНА.

Бид манайтай ойр дөт үзэл бодолтой МоАХ, ШДХ, МАХН-ын доторх бүлэглэл, жигүүрийн гишүүд болон өдгөө аль ч нам хөдөлгөөн, холбоо, эвсэлд ороогүй байгаа бүхий л социал-демократ үзэл бодолтонгуудад хандаж байна" хэмээн эвлэлдэн нэгдэхийг хүсэж уриаллаа.

МСДН-ын УТЗ-ийн хурал 09.17-нд болж, "Ардчиллыг дэмжих сан" байгуулах тухай тогтоол баталлаа. Тус сан нь АСХ-ий улс төр, олон нийтийн байгууллагын хувьд гүйцэтгэж байсан үүргээс бусад үүргийг өвлөн гүйцэтгэх зорилгоор байгуулагджээ.

Сангийн дүрмийг МСДН-ын УТЗ-ийн 10.02-ны хурлаар баталж, сангийн даргаар Ж.Бямбасүрэнг томилсон байна.



Намууд нэгдэж... Нэгдсэн нам байгуулагдсан нь

1992.01.30-нд БНН, МЧХН-ын удирдлага уулзаж, санал солилцон, “Цаашид улс төрийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэхэд улс төрийн намууд үзэл бодлын нийтлэг дээр ойртож, улмаар нэгдэх нь Монгол орны хувь заяаг шийдвэрлэхэд зарчмын ач холбогдолтой” гэсэн дүгнэлтэд хүрчээ. Улмаар тус хоёр нам нэгдэж, Нэгдсэн нам байгуулах талаар намуудын хамт олноороо хэлэлцүүлэх шийдвэр гаргажээ.

МоАН-ын дотор Г.Бошигт тэргүүтэй Иргэний ардчилсан жигүүр 1991.01.06-нд байгуулагдсан юм. Тус жигүүрийн бүгд хурал 02.01-нд болж, БНН, ЧХН-уудтай нэгдэх шийдвэр гаргажээ. Улмаар байгуулагдах Нэгдсэн намын их хуралд бэлтгэх ажлын зохион байгуулагчаар жигүүрийн тэргүүн Г.Бошигт, зохицуулагч Г.Цогзолмаа, тэргүүлэгч С.Эрдэнэ нарыг баталжээ.

1992.02.18-нд БНН, МЧХН, МоАН-ын Иргэний ардчилсан жигүүр хамтран хуралдаад, намууд, жигүүрийн нэгдэх асуудлыг ярилцжээ. Ингээд 1992.02.20-нд БНН, МЧХН, МоАН-ын Иргэний ардчилсан жигүүр нэгдэж, Нэгдсэн нам байгуулагдав.

Нэгдсэн намын их хурал 1992.03.23-нд болж, С.Зориг намын тэргүүнээр сонгогдов.

Намын үндсэн журам (дүрэм), суурь номлол (хөтөлбөр), үзэл баримтлалын үндсэн чиглэлийг Их хурлаас баталж, 103 хүнтэй намын удирдах дээд байгууллага (хуралдай)-ыг сонгон баталжээ.

Жич: 1991.02 сард Бүгд Найрамдах Нам (БНН) байгуулагдаж, тус намын “Түгээмэл тунхаг” есдүгээр сард гарчээ. Тунхагт “Монголчууд чөлөөт ертөнцийн нэг

хэсэг болохдоо үндэсний мэдрэмжээ хадгалсан байх учиртай юм. Тиймээс БНН өвөг дээдсийн зан суртахуун юугаа дээдлэн хамгаалах"-ыг эрхэмлэнэ... Өнөө үеийнхэн амьдрах цагаа өөрсдөө сонгоогүй билээ... төрийн зүгээс хүний амьдралын үнэ цэнийг өндөрт өргөх хэрэгтэй юм. Учир нь амьдрах эрх хүний хамгийн гол эрх байдаг" гэжээ.

БНН-ын Анхдугаар их хурал 1992.02.24-нд намын тэргүүнээр С.Зориг, Ерөнхий зөвлөлийн гишүүнээр Н.Баянжаргал, Ц.Ганхуяг, Н.Туяа, Б.Янжинлхам нарыг сонгож, намын Ерөнхий нарийн бичгийн даргаар З.Нармандахыг томилж байжээ.



МСДН СОЦИАЛИСТ ИНТЕРНАЦИОНАЛД ЭЛСЛЭЭ

Социалист интернационал (СИ)-ын намуудын дарга нарын бага хурал (Сиднэй (1991.03.09-10))-д МСДН-ын дарга Б.Батбаяр оролцох үедээ тус байгууллагад элсэх өргөдлөө албан ёсоор гаргаж, үг хэлжээ.

Тэрээр “МСДН яг нэг жилийн өмнө байгуулагдсан тул энд хамгийн залуу нам нь байж болох юм. Гэвч ерөөс Монголын нийт ард түмэн коммунист дарангуйллаас ардчилал руу хандсан алхам хийгээд нэг л жил болж байгаа билээ. Монголчууд бидний түүхэн эргэлт болсон энэ алхамд МСДН өөрийн үүргийг гүйцэтгэсэн. Хэдийгээр элдэв ов мэхтэй, бүрэн ардчилсан шинжийг олох яагаа ч үгүй байгаа боловч Монголд анхных нь болох чөлөөт сонгууль өнгөрсөн зун болж, МСДН ард түмнээс 8%-ийн санал авч, 50 гишүүнтэй парламентад 4 суудал авсан ба Монгол улсын дэд Ерөнхийлөгч МСДН-аас сонгогдсон... ардчилал Монголд ялан мандсан тухай шуугих боловч ардчиллын цагаан толгойгүй ард түмэн ардчилсан нөхцөлд ажиллаж амьдарч чадахгүй, үүнээс үүдээд эдийн засгийн бэрхшээл үүсэн, эмх замбараагүй анархи байдал нийгэмд ноёлох шинжийг олж байна... Чухам ийм л учраас ард түмний оюуны өөрчлөлтийг яаралтай хийж, тэднийг хүмүүнлэг ертөнцөд амьдарч ажиллаж, сурч чаддаг болгох явдал давын өмнө тулгамдсан зорилт болж байна” хэмээн онцлон тэмдэглэжээ⁹⁴.

Тус намыг СИ-д элсүүлсэн тухай мэдээг Фридрих Эбэртийн сангийн урилгаар Бонн хотноо сангийн үйл ажиллагаатай танилцаж, улмаар Францын Социалист намын их хурал (1991.12.06-15)-д оролцож ахуйдаа Н.Алтанхуяг, Б.Энэбиш нар “Чилид болсон Социалист-Интернационалын зөвлөгөөнөөс манай намыг СИ-д элсүүлэх шийдвэр гаргасныг мэдлээ. Их хурлаар зарлах

юм байна. Баяр хүргэе” хэмээн төв (Улаанбаатар)-рүүгээ цахилгаанаар мэдэгдэж байв⁹⁵.

Жич: Дээрх шийдвэрийг гаргасан СИ-ын зөвлөлийн чуулган Сантьяго хотноо 1991.09.26-27-нд хуралджээ.

МСДН-ыг СИ-д гишүүнээр элсүүлсэн тухай СИ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Аяала 1992.01.24-нд мэдэгдсэн байна.



УИХ-ЫН АНХНЫ СОНГУУЛЬ (1992)

Сонгуулийн хуулийн талаарх улс төрчдийн байр суурь

1992 оны онцлох гол үйл явдал нь шинэ Үндсэн хууль батлагдсанаар УБХ-ын бүрэн эрх дуусгавар болохоор болж хуулийн дагуу байнгын ажиллагаатай парламентыг сонгон байгуулах анхны УИХ-ын сонгууль болсон явдал юм.

УИХ-ын сонгуулийн хуулийг УБХ 40 хоног хэлэлцээд, 1992.04.04-нд баталжээ.

УИХ-ын тухай болон Сонгуулийн тухай хууль боловсруулах ажлын хэсгийг ахалсан Д.Лүндээжанцан сонгуулийн тогтолцоог хэрхэн шийдсэн талаар ингэж дурсжээ: “Пропорционал системийг сонгож авахад ямар ч байсан Үндсэн хуультай зөрчилдөхгүй, Үндсэн хуульд заасан шууд гэсэн зарчим алдагдахгүй гэж бид үзэж байв. Олон янзын хувилбар хэлэлцэн, олон ч буцаасан. Гишүүд өөр өөрийн нам, өөр өөрийн өнцгөөс, голдуу намын өнцгөөс харж, сонгуулийн хуулинд оролцож байлаа. Нийтдээ 17 хавтас материал болсон юм. Хамгийн сүүлд Ц.Товуусүрэн (Хөдөө аж ахуй, Хүнсний үйлдвэрийн яамны газрын дарга байгаад АИХ-ын депутат, УБХ-ын гишүүн болжээ)-гийн санал буюу томсгосон мажоритар тогтолцоог Р.Гончигдорж дарга санал болгож, Ц.Өөлд бид хоёр ярьж байгаад, гар өргөж, олонх болсон юм... Ингэж энэ сонгуулийн хууль төрсөн юм” гэжээ⁹⁶.

Энэ хуулийн талаар ямар бодолтой байснаа улс төр судлаач Б.Дэлгэрмаа “1992 онд томсгосон тойргоор явуулсан юм. Тухайн үед 16 субъект сонгуульд оролцож, АН өөрийнхөө мандатдаа бас л 10 гаруй субъектээс нэг нэг хүн нэр дэвшүүлээд, МАХН болохоор дангаараа мандатаа бүрдүүлж байлаа. Манайхан энэ жагсаалтыг харчихаад “МАХН-ын олон хүн танигдаагүй учраас соцдекээс

Баабарыг, МҮДН-аас Ганболдыг гэх мэтээр дугуйлна. Тэгээд МАХН-аас 1 хүнийг дугуйлаад, их сайхан парламент болно” гээд, намайг ирэхэд байдгаараа инээгээд сууж байсан юм. Би тэр үед гадагшаа гурван сар хэлний дамжаанд яваад ирсэн юм. Угаасаа томсгосон тойрог чинь өөрөө том улс төрийн хүчний талд илүү ашигтай хувилбар байхгүй юу. Нөгөө хүчин нийт суудлын 40 гаруй хувийг авч, үлдсэн саналыг нь тархай бутархай субъектүүд 30, 10, 5 гэх мэтээр хуваадаг. Энэ бүхэн зангидагдаж байж, хүч үздэг байхад энэ бол 70, эсвэл 76:0 шүү гэж би хэлсэн. Манайхан тэр үед “Бид МАХН-ыг ялна, сайхан хуультай болсон” гээд байхаар нь “Та нар ийм гэнэн хууль баталж болохгүй” гэсэн хэдий ч оройтсон байлаа. Тэгээд яах вэ, үр дүн нь 70:6 харьцаатай гарсан” гэж ярьжээ⁹⁷.

Харин нийтлэлч Баабар “1990 оны сонгуулийн тогтолцоог дугуй ширээний хэлэлцээгээр тохирч баталсан. Автор нь хуульч Чимид. 1992, 2008 оны тогтолцоо буюу олон мандаттай мажоритар системийн автор нь Товуусүрэн гэж байсан... Лав энэ тогтолцоогоороо өөрөө дивтат болж чадаагүй санагдана”⁹⁸. гээд үргэлжлүүлэн “олон газар явж, янз бүрийн сонгуулийн системтэй танилцаж ирсний дараа гишүүд олон хоног маргасан юм... Ингээд олон мандаттай мажоритар системийг сонголоо...

Юутай ч пропорционал утгаар бодож үзвэл ардчилсан хүчин 40-өөс доош хувь авсан байх учиргүй. Гэвч сонгуулийн гажгаас болж, нийт суудлын ердөө 7%-ийг эзэлсэн юм” гэжээ⁹⁹.

Сонгуулийн өмнө улс төрийн намуудын эргэн тойронд...



МСДН-ын Бага хурал 1992.04.03-04-нд эхлэн хуралдаад

- Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, МСДН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (Б.Батбаяр)

- МСДН-ын 2-р их хурлыг хуралдуулах тухай

- Нэр дэвшигчдийг тодруулах асуудал хэлэлцээд, улс орныг хямралаас гаргах “81 долоо хоног”, дэд бүтэц хөгжүүлэх “Монгол-21” хөтөлбөр дэвшүүлсэн юм.

Бага хурлын гишүүд намын идэвхтэний семинарт оролцоод, 04.08-ны өдөр Бага хурал өндөрлөсөн байна.

Улмаар МСДН-ын 2-р их хурал 05.30-31-нд хуралдлаа. Хурлаар,

- Намын даргын улс төрийн илтгэл (Б.Батбаяр)

- МСДН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (А.Ганбаатар)

- Намын дүрмийн төсөл (Р.Хатанбаатар) хэлэлцээд, шинэчлэгдсэн дүрмийн дагуу намын Их хурлын чуулганы гишүүдийг сонгон баталжээ. Намын хяналтын зөвлөлийг Шүүх зөвлөл болгон, бүтцийг өөрчлөв.

Их хурлаас УИХ-ын сонгуульд тус нам бие даан оролцохоор шийдвэрлэж, Бага хурлаас дэвшүүлсэн “Хөгжил дэвшил, нийгмийн хамгааллын төлөө” уриатай сонгуулийн мөрийн хөтөлбөрийг баталсан юм.

МСДН гишүүд дэмжигчиддээ хандан, уриалга гаргалаа.



МСМН-ын Улс төрийн гүйцэтгэх хорооны өргөтгөсөн 2-р хуралдаан 1992.04.11-нд болж, сонгуульд бие даан оролцох шийдвэр гаргажээ.

1992.04.15–16-нд МоАН-ын II их хурал хуралдав.

Хурлаар УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажил, ажлын явц, бусад нам хүчинтэй эвсэл байгуулах эсэх тухай хэлэлцжээ. МҮДН, Нэгдсэн намтай нэг эвсэл болж, сонгуульд оролцох шийдвэр гаргажээ.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, Улс төрийн зөвлөлдөх төвийг Үндэсний хороо болгон, бүтцийг өөрчиллөө. Намын даргын сонгууль болж, М.Энхсайхан намын даргаар, До.Ганболд намын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогджээ.

МҮДН-ын Зөвлөлийн ээлжит хурал 1992.04.19-нд болж,

- УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх
- Зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Хурлаас 1990 оны АИХ-ын сонгуульд дэвшүүлж байсан мөрийн хөтөлбөртөө зарчмын өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

МҮДН-ын Зөвлөлийн тэргүүлэгчдийг нууц санал хураалтаар сонгож (27 хүн нэр дэвшин өрсөлджээ), Ш.Алтангэрэл, Н.Батбаяр, Л.Бат-Очир, Ж.Ганболд, Г.Ганхуяг, Х.Дашзэвэг, Л.Зундуйсүрэн, Д.Мөнхбаатар, Ж.Наранцацралт, А.Ханчингэл, М.Чимиддорж нар сонгогджээ.

Нэгдсэн намын Ерөнхий зөвлөл 04.21-нд хуралдаж, МоАН, МҮДН-тай нэг эвсэл болж, УИХ-ын сонгуульд оролцох шийдвэр гаргасан байна.

МАХН-ын удирдлагын төлөөлөл 04.20-нд БНАСАУ-ын Ерөнхийлөгч Ким Ир Сений 80 насны ойн баярт коммунист ба ажилчны намууд, социализмын үйлсийг дэмжигч намуудын хамт оролцож, их баяр ёслол үйлдсэн байдаг. Тэдгээр намууд “Социализмын үйл хэргийг хамгаалан бэхжүүлє!” уриан доор Пхеньяны мэдэгдэлд нэгдсэн юм. Тус мэдэгдэлд нийт 70 намын төлөөлөгч (үүний 48 нь намын дарга нар) гарын үсэг зуржээ. Мэдэгдэлд,

- Социализмын намирах улаан тугийн доор, социализмыг капитализм, империализмээс хамгаалахын төлөө тэмцэж буй бүх дэвшилт улс төрийн нам, байгууллага болон дэлхийн улс түмэнтэй хамтран, бид цаашид урам зоригтойгоор урагшлан алхах болно.

- ... Социализмын төлөө туштай тэмцэгчдэд эцсийн ялалт зүй ёсоор оногдох болно. Социализмын үйл хэрэг сөнөхгүй гэх зэргээр дурдсан байдаг.

Ардчилсан хүчнүүд Эвсэл байгууллаа

1992.04.23. МоАН, МҮДН, Нэгдсэн намууд УИХ-ын сонгуульд эвсэл болон оролцохоор тогтож хамтын гэрээнд МоАН-ын дарга М.Энхсайхан, МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд, Нэгдсэн намын дарга С.Зориг нар гарын үсэг зуржээ.

Нам бүр гурван төлөөлөл томилж, есөн хүний бүрэлдэхүүнтэй Эвслийн зөвлөл байгуулагдаж, сонгуулийн

кампанит ажлын шуурхай удирдлагыг хангахаар болсон байна. МоАН-аас М.Энхсайхан, До.Ганболд, Ц.Элбэгдорж (Үндэсний зөвлөлийн гишүүн), МҮДН-аас Да.Ганболд, Даш.Ганболд, Ш.Алтангэрэл (Зөвлөлийн тэргүүлэгч), Нэгдсэн намаас С.Зориг, З.Нармандах, С.Эрдэнэ (Ерөнхий зөвлөлийн гишүүн) нар Эвслийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллахаар болжээ.

Тус эвсэл:

- Монгол Улсад ардчилсан нийгмийн тогтолцоог төлөвшүүлэн баталгаажуулах, ардчилалт үнэлэмжийг нийгмийн сэтгэлгээний салшгүй хэсэг болгон төлөвшүүлэх, нийгэмд хариуцлага, хамтын ажиллагаа, хэлэлцээ, биеэ хичээхүйн уур амьсгалыг бүрдүүлэх

- Эдийн засгийн хөгжлийн угтвар нөхцөл болсон чөлөөт өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжиж, түүнийг нэжгээд хүний бололцоо чадвараа дайчлан, эрдэм чадамж руу тэмүүлэх ба нийгмийн оюуны чадавхийг өндөржүүлэх хүчин зүйл болгосон

- Эртнээс улбаатай төрийн бодлогын залгамж чанарыг сэргээж, нийгмийн зөвшилцөө, зэрэг дэсийг хангахад төрийн үүргийг өндөржүүлэх

- Эдийн засгийн хямралыг богино хугацаанд гэтлэн давж, барааны хомсдолыг арилгахыг зорилгоо болгон

“Эвслийн нэгдмэл бодлогын зарчмууд” мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн юм.



Сонгуулийн дүнгээр...

1992.06.28-ны өдөр болсон УИХ-ын анхны сонгуульд 1 085 121 хүн оролцохоор бүртгэгдсэнээс 1 037 392 нь оролцож, сонгогчдын 95.6% нь санал өгчээ. Үүнээс 974 194 ширхэг (93.9%) нь хүчинтэй байсан бөгөөд хүн бүр хэд хэдэн нэр дэвшигчийн төлөө санал өгөх ёстой байсан учраас нийтдээ 3 023 234 санал тоологдсон ажээ.

УИХ-ын сонгуульд 7 нам (МАХН, МСДН, ММТНН, МХӨНН, МСМН, МХН, МНН), 2 эвсэл (МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвсэл, МШАН-МАН-ын эвсэл), бие даагчид, нийт 13 субъект оролцжээ. Сонгуульд оролцох эрх бүхий намуудаас МАХН 76 тойрогт нэр дэвшүүлж, бусад нам, эвсэл цөөн тойрогт нэр дэвшүүлж оролцсон. Үүнд, МАХН 76, МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвсэл 48, МСДН 28, ММТНН 20, МХӨНН 20, МТТН 23, МСМН 27, МХН 18, МШАН-МАН-ын эвсэл 9, МНН 6, бие даагч 18 (нийт 293) нэр дэвшигч өрсөлджээ. Сонгуулийн дүнгээр,

- МАХН-ын 70 (92.1%)
- МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвслээс 4 (8.3%)
- МСДН-ын 1 (3.6%)
- Бие даагч 1 (5.6%) хүн УИХ-д сонгогдсон байна.

МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвслээс Ц.Элбэгдорж (Хөвсгөл (55.2%)), Да.Ганболд (Хэнтий (46.6%)), С.Зориг (СБД (46.0%)), М.Энхсайхан (Октябрь дүүрэг (43.4%)), МСДН-аас Р.Гончигдорж (Архангай (71.2%)) нар сонгогджээ.

1992 оны УИХ-ын сонгуульд МАХН 39.3%, гурван намын Эвсэл 18.5%, МСДН 18.7%, бусад нам, хүчин 23.4%-ийн санал авчээ. Харин намуудын суудлын хуваарилалтаар МАХН 93.1%, Эвсэл 5.3%, МСДН 1.3%, бусад нь 1.3%-тай гарсныг сонгуулийн мажоритар тогтолцоотой холбон

тайлбарладаг. Нийтлэлч Баабар “тойргуудыг аймаг, дүүргүүдэд 26 тойрог болгон хувааж, олон мандаттай мажоритар сонгууль явуулав. Энэ тогтолцоо нь яльгүй ч бай илүү санал авсан нь бүх суудлаа авдаг учир цөөнх болсон нь огт суудалгүй хоцордог, тэдний дуу хоолой ор тас алга болно. Үнэхээр ч ийм дүн гарч, 60 хүрэхгүй хувийн санал ард түмнээс авсан МАХН 76 суудлын 70-ыг нь буюу 90%-ийг дангаараа авчиж билээ” хэмээн өгүүлсэн байдаг¹⁰⁰.

Өөрөөр хэлбэл, засаг захиргааны нэгжид хүн амын нь тоог харгалзан, мандат хуваарилаад, тухайн тойрогт бусдаасаа олон санал авсан нэр дэвшигчийг саналын нь дарааллаар жагсааж, (мандатын нь тоогоор) УИХ-ын гишүүнд сонгогдсонд тооцдог хувилбараар сонгууль явагдсан. Дийлэнх олонх буюу 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигч бус харин ердийн олонхийн санал авсан хүн энэ тогтолцоогоор сонгогдсон нь маргааны гол сэдэв бай болсон юм. Өөрөөр хэлбэл, 50%+1-ээр бус, харин 50-аас доош хувийн санал авсан ч тухайн тойрогтоо бусад нэр дэвшигчээсээ давуу саналтай байгаа л бол УИХ-д сонгогдохоор болсон юм.

Өмнө нь УБХ-д 20 гаруй төлөөлөлтэй байсан ардчилсан хүчний хувьд том ялагдал боллоо. Ялсан улс төрийн хүчин-МАХН ялалт амжилтдаа сагаж эрдэж эхэллээ. Үүнийг “Үнэн” сонины 1992.07.15-ны дугаарын тэргүүн өгүүллээс үзэж болно.

МСДН-ын 2-р их хурлын Анхдугаар чуулган болж, зохион байгуулалтын асуудал хэлэлцэв. Намын даргаар Б.Батбаяр, дэд даргаар Л.Бямбажаргал, Р.Хатанбаатар нарыг сонгожээ.

ШИНЭ ЗАСГИЙН ГАЗРЫГ П.ЖАСРАЙ ТЭРГҮҮЛЛЭЭ

МАХН-ын Засгийн газрыг П.Жасрай тэргүүлэхээр болж, 1992.07.21-нд Ерөнхий сайдаар томилогдов. (УИХ-ын даргаар Н.Багабанди (07.20), дэд даргаар Ж. Гомбожав (07.21) нар сонгогджээ). Ерөнхий сайд болохоор 13 хүний нэр яригдаж өрсөлдсөн нь сонирхолтой юм. Нэг намын олон хүн Ерөнхий сайд болох гэж өрсөлдсөн нь нэг талаар намын дарга нь Ерөнхий сайд болдоггүй байсантай, нөгөө талаар гүйцэтгэх засаглалыг тэргүүлж, мөнгөний уутны амыг барихтай холбоотой байж гэлтэй. Ямартай ч ялсан намынхан дээгүүрээ өрсөлдөж булаацалджээ.

Шинэ Ерөнхий сайд танхимаа бүрдүүлэв. Улмаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг УИХ-аар хэлэлцүүлсэнтэй холбогдуулан сөрөг хүчний төлөөлөл МоАН-ын дарга М.Энхсайхан үг хэлжээ. Тэрээр “Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг үзвээс олон сонгогчдын горьдлого хоосон мөрөөдөл болж, сонгуульд МАХН хоосон амлалтаар биднийг хуурчээ гэсэн дүгнэлт хийж болох юм.

Дэлхийн улс түмэн, олон улсын санхүү эдийн засгийн байгууллагууд Засгийн газрын хөтөлбөрөөс Монгол орон зах зээл рүү, ардчилалруу тууштай замнах юм байна гэсэн дүгнэлт хийхгүй нь лавтай. Учир нь Засгийн газрын хөтөлбөрт шингэсэн үндсэн санаа нь зах зээлийн онол, үзэл баримтлалд харш байна. Нөгөөтэйгүүр өмнөх Засгийн газрын бодлогоос чухам юу нь уламжлагдах вэ гэдэг тодорхойгүй болсноос гадаад талдаа итгэлгүй байдлыг төрүүлж, бүхэлдээ Засгийн газрын хөтөлбөр нь бусдыг “Болгоомжлогтун!” гэж уриалсан дохио болж байна.

УИХ-аас Засгийн газрын хөтөлбөрийг дахин боловсруулах шийдвэр гаргаасай. Ийм хөтөлбөрөөр

Монгол орон хямралаас гарч чадахгүй...

Мөнгөний ханш унаж, үнэ өсөх явдалтай тэмцэх явдал эдийн засагчид, улс төрчдийн тэргүүн зэргийн зорилт байх учиртай.

Харамсалтай нь энэ талаар Засгийн газрын хөтөлбөрт тодорхой арга хэмжээний баримжаалал алга байна” гэж дүгнэсэн нь цөөнхийн шүүмжлэл тул олонх чихнийхээ хажуугаар өнгөрөөжээ.

Өмнөх Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн 1992.09.29-ний өдөр хэлсэн үг олны анхаарлыг татсан юм.

“УИХ-ын чуулган, албан ёсоор тараасан мөрийн хөтөлбөрөөс гадна Ерөнхий сайдын илүү гүнзгий утгатай илтгэлийг сонслоо. Эдгээр мэдээллийг зэрэгцүүлбэл нийгмийн амьдралын тулгамдсан асуудлын талаар Засгийн газарт хоёр өөр үзэл бодол байна гэдгийг олж харахад түвэггүй. Үүний гол ялгаа нь Монгол орны одоо туулж байгаа түүхэн зурвасын агуулга бэрхшээлийг гэтлэх арга замын асуудалд нэн тод тусгалаа олж байна... Ерөнхий сайдын илтгэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зарчмын зөрүүтэй байдал хуучин тогтолцоог мөрөөдөх нийгмийн сэтгэхүй, нэгэнт эхэлсэн өөрчлөлтийн аль алины дэмжлэг олохыг хичээсэн хоёрдмол утгын илрэл гэж үзэж байна. Үүнийг гэтлэх аргыг Ерөнхий сайд 1960-70 онд Азид амжилт олсон хатуу дэглэмийн нөхцөлд зах зээлд шилжих туршлагаас олжээ. ХХ зууны эцэст ийм замнал оновчтой эсэхэд эргэлзэж байна. Учир нь ийм замаар замнахын тулд одоогийнхоос өөр Үндсэн хууль хэрэгтэй... Зах зээлийн харилцаанд шилжих талаар цаашид шинэ том алхам хийх ёстой. Түрүүчийн Засгийн газар шилжилтийн эхийг тавьсан...

Эдгээр байдлаас үндэслэн Засгийн газрын мөрийн

хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хоёр дахь хэлэлцүүлэг хийхээр УИХ-д оруулах нь зүйтэй гэсэн саналтай байна” хэмээсэн ч цөөнхийн санал дүгнэлт болохоор үнэмлэхүй олонх мөн эс хэрэгссэн байна.

Харин үл ойшоосны үр урхаг даруй гарсныг доорх нийтлэл харуулдаг. Үүнд, “Far Eastern Economic Review” сэтгүүл (1992.10.29)-д “ОУВС 1992 оны эцэс хүртэл Монголд үлдэж байгаа хөрөнгийг ашигтай зарцуулан, эдийн засгийн зорилтоо биелүүлэх эсэхээс шалтгаална гэсэн хатуу зарчим барьж байгаа юм. Мөн хоёр этгээдийн хэлэлцээр байгуулсан ивээн тэтгэгчид ч санаа буруулах төлөвтэй болов.

ОУВС зээл олгохоо зогсоосон нь Ерөнхий сайд Пунцагийн Жасрайг хүнд байдалд оруулсан байна. Зургаадугаар сард сонгогдсон энэ хүн танхимаа эмхлэн байгуулаад, эдийн засгийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажилд орж байгаа юм.

Аравдугаар сарын 14-15-ны өдөр хуралдсан ивээн тэтгэгчдийн бага хурлын төлөөлөгчдөөс Монголын удирдагчид... хэцүү өвлийг даван туулахад үлэмж хөрөнгө хэрэгтэй гэж гуйжээ. Гэвч нэгэнт сэтгэл дундуур болсон ивээн тэтгэгчид, юуны өмнө ОУВС энэ гуйлтад ихээхэн хүйтэн ханджээ... Ивээн тэтгэгчдийн тусламж ингэж багассан тул ирж буй хатуу өвлийг хэрхэн давахыг хэлэхэд хэцүү байна” хэмээжээ¹⁰¹.

Ер нь 1990-1992 оны өөрчлөлт шинэчлэлийг буруушаах, социалист зарчим руу эргэж буцах гэсэн хандлага их гаргаж байлаа.



НАМУУДЫН НЭГДЭЛ... МҮАН

Сонгууль болсноос хойш сар гаруйн дараа 1992 оны зун МоАН, МСДН, МҮДН, НН, МСМН-ын удирдлагын түвшинд ардчилсан хүчнүүд нэгдэх хэрэгтэй, нэгдэж 1 нам больё гэсэн санаа гарч байжээ. “Уг нь энэ таван нам нэгдээд, Шинэ Үндсэн хуулийн нам байгуулъя гэж ярьж байлаа. Бид нар “ШҮҮХЭН” гэж ярьдаг юм, бас түүхэнд тэмдэглэлтэй л дээ” гэж МСДН-ын дэд дарга асан Н.Алтанхуяг дурсаж байна¹⁰².

МСДН-ын шийдвэр өөрөөр гарсан нь

МУИС-ийн дугуй танхим. 1992.07.23-ны Их хурлын чуулган (Бага хурал)-ы хурлаар Ардчилсан хүчнүүд нэгдсэн удирдлага, үйл ажиллагаатай нэгдмэл байгууллага болж, ажиллах нь зүйтэй гэсэн саналыг эхний санал хураалтаар 41-5-5, хоёр дахь санал хураалтаар 32-9-11-ээр дэмжжээ. “Ардчилсан хүчнүүд нэгдсэн зохион байгуулалт, удирдлагатай нэгдмэл үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай байхыг дэмжсүгэй. 3 дахь санал хураалт 39-15-2. Цаашдын хэлбэрийн асуудлыг их хурлаар шийднэ” гэжээ¹⁰³.

07.23-нд хуралдсан МСДН-ын чуулган олонхийн саналаар асуудлыг өөрөөр шийджээ. Намын дарга Б.Батбаяр “Намууд эвсэхгүй гэж олон хүн саналаа хэлж байна. Хувь хүний хувьд эвсэх нь зайлшгүй гэж би бодож байна. Ийм үзэлтэй байж, ингэж ганцаараа үлдэж байгаа болохоор намыг толгойлж явж чадахгүй”¹⁰⁴. хэмээн мэдэгдэв.

Ийнхүү МСДН-ын чуулганы хурал бусад намтай

нэгдэхийг дэмжээгүй байна. Бусад дөрвөн нам нэгдээд, Монголын Үндэсний Ардчилсан Нам (МҮАН) гэсэн шинэ намыг байгуулсан юм. МСДН нэгдээгүй тухай асуултад Д.Дорлигжав, “МСДН хойш суугаад үлдчихсэн. Үүнийгээ тайлбарлахдаа “МАХН социал демократ байр суурь барьж магадгүй, бид тэднийг хааж байх хэрэгтэй” гээд нэгдээгүй”¹⁰⁵. гэж хариулсан байдаг.

МҮАН-ын нэгдэх их хурал

1992.10.25-ны өдөр ардчиллын төлөө намууд нэгдэх Анхдугаар их хурал болж, 1992 оны УИХ-ын сонгуульд нэг эвсэл болон оролцсон МоАН, МҮДН, Нэгдсэн нам болон үзэл баримтлал ойролцоо МСМН-ууд нэгдсэн юм. Нэгдэх их хурлын өмнө тус тус дөрвөн намын их хурлууд болж, намуудын нэгдлийг дэмжжээ.

“МоАН-ын дарга М.Энхсайхан, МҮДН-ын Зөвлөлийн дарга Да.Ганболд, Нэгдсэн намын дарга С.Зориг, МСМН-ын Улс төрийн гүйцэтгэх хорооны дарга Ц.Цолмон нар намуудынхаа их хурлаас гаргасан шийдвэрийг уншсанаар Монголын Үндэсний Ардчилсан Намын түүхэн их хурлын үйл ажиллагаа” эхэлжээ¹⁰⁶. Тус их хурлаар МҮАН-ын бодлого, зорилгыг тодорхойлсон эрмэлзэх есөн зүйл, намын Үндсэн журам (дүрэм)-ыг баталжээ. Мөн зураач Д.Цогтбаярын зохиосон хувилбараар намын тугийн загварыг баталсан байна. Эрдэмтэн зохиолч Л.Дашням тугийн тайлбарыг бичжээ.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, намын тэргүүн, Үндсэн журмын хороо, чуулганы гишүүдийг сонгосон. Намын тэргүүний сонгуульд нийт 18 хүний нэр дэвшсэнээс Э.Бат-Үүл, Да.Ганболд, Д.Дорлигжав, С.Зориг, Ц.Цолмон, М.Энхсайхан, Ч.Энхээ нарын долоон хүнээр

санал хураажээ. Хамгийн олон санал авсан Да.Ганболд (146), С.Зориг (131) нар дараагийн шатанд өрсөлдөөд, Да.Ганболд 53% саналаар намын тэргүүнээр сонгогдсон байна.

МҮАН-ын Анхдугаар их хурлын төлөөлөгчид ард иргэддээ хандан “Монгол орон хүнд сурталт, хамжлагат ёсноос ардчилсан тогтолцоонд шилжих амаргүй боловч зүй ёсны үйл явцыг өрнүүлж байна. Эдүгээ бид ардчилсан хүчний тэмцлийн ололтоор бахархах бүрэн эрхтэй...”

Монголын ардчилсан хүчин нэгдэн, зах зээлийн сөрөг үзэгдэлтэй тэмцэхдээ захиргааны хүч хэрэглэх аргаар бус зах зээлийнх нь хууль, эдийн засгийн аргыг ашиглах, өмч хувьчлалыг яаралтай, үр өгөөжтэй өрнүүлэх, эрх тушаалтнууд урьдынх шиг ард түмний өмч хөрөнгийг завшин баяжихад хаалт тавих, хувийн өмчийн жинг эрс дээшлүүлэх, шударга бус үйлдлийг таслан зогсоох, үйлдвэрлэл, хөдөлмөрийг дэмжих чиглэлээр цогцолбор арга хэмжээ авах, үүнд санхүү, зээлийн бодлогыг нийцүүлэх, гадны хөрөнгө оруулалтыг урамшуулах, үндэсний эрх ашигт нийцсэн санаачилга гаргах, хүнсний хангамжийг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэхийн төлөө хамтран тэмцэхийг уриалж байна...” хэмээн мэдэгдэл гаргасан юм.

МҮАН-ын Анхдугаар чуулганы хуралдаан Намуудын нэгдэх хурлын дараа 10.28-нд болсон. Ерөнхий зөвлөлийн гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгож, МҮАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргад намын тэргүүний санал болгосноор Ц.Баасанжав (52.94%)-ыг сонгожээ.

Намын Сонгуулийн хорооны даргаар Даш.Ганболд, Суртал мэдээллийн хорооны даргаар Ш.Алтангэрэл, Бодлогын хүрээлэнгийн захирлаар Э.Бат-Үүл томилогджээ.

МоАН, МҮДН, Нэгдсэн намын гаргаж байсан “Шинэ үе”, “Үндэсний дэвшил”, “Тэнгэр” сониныг нэгтгэн, “Эрх чөлөө” сонин гаргах болоод, С. Амарсанааг сонины эрхлэгчээр томилсон байна.

МҮАН 1992.11.17-ны өдөр УДШ-д бүртгүүллээ.



ОРОН НУТГИЙН СОНГУУЛИАР (1992)

Налгар намрын есөн сар (09.05-20)-д болсон орон нутгийн сонгуульд ардчилсан хүчин ялагдсан юм. Нэг үгээр хэлбэл бараг амжилт олоогүй гэхэд болно.

Бүх шатны Иргэдийн хурлын төлөөлөгчийг сонгох анхны сонгууль Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу баг хороо, сум дүүрэг, аймаг нийслэлийн гэсэн үе шаттай явагджээ.

Сонгууль эрх баригч намын аппаратын ажилтан, сум хорооны дарга, идэвхтний хооронд болж өнгөрсөн гэдэг. УИХ-ын сонгуулийн дараах удаан завсарлагаа, зуслан, найр наадмын цаг өнгөрөхөөс өмнө, барааны үнийг нэмэхээсээ өмнө орон нутгийн сонгуулийг явуулсан нь олон түмнийг мэдээгүй, сэхээрээгүй байхад нь завшаалж завдаж хийсэн хэрэг болсон.

Хороо, багийн хурал нь засаг даргыг сонгохтой зэрэг явагдаж, хуучин дарга нар, идэвхтнүүдийн хооронд болоод өнгөрсөн байна. Айлуудаар явж зар хүргээгүй, зарлал бичиг нааж анхааруулаагүй тул хүмүүс бараг мэдсэнгүй өнгөрчээ.

Нийслэлийн 12 дүүргийн ИТХ-д 613 төлөөлөгч сонгогдсон юм. Үүнээс,

- МоАН 17
- МҮДН 17
- МСДН 16
- Бусад нам 10
- Нам бус 203 хүн

сонгогдож, бусад суудалд МАХН-ын төлөөлөл сонгогджээ. Нийслэлийн ИТХ-д ардчилсан хүчин гурван төлөөлөгчтэй болжээ. Бусад 69 суудал МАХН-д оногдсон байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД

1993.03.07-нд МСДН, МҮДН, Дөрвөн холбоо (МоАХ, АСХ, ШДХ, МОХ)-ны хамтарсан арга хэмжээг зохиохоор болж, зохион байгуулах хэсгийг нам, холбоодын тэргүүн нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, нарийн бичгийн даргаар МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Рэнцэнтавхайг томилжээ¹⁰⁷.

Нийгмийн шударга ёсны төлөө цуглааныг Дөрвөн холбооны эвсэл 03.07-нд хийлээ.

1992 оны УИХ-ын сонгуулиар сонгогчдын 48%-ийн санал авсан боловч парламентад 6%-ийн суудал эзэлж байгаа МҮАН, МСДН-ын 5 төлөөлөл нь намын бүлэг байгуулан ажиллах, сөрөг хүчний үүрэг гүйцэтгэх бололцоогүй байгаа нь хэрэг дээрээ олон намын Их хурал гэж харагдуулах барьцааны хүмүүс болоод байгаа тул “дээрх бодит байдлыг харгалзан, улс төрийн эрүүл бус энэ тогтолцоог эвдэх эхний алхам болгож УИХ-д МҮАН, МСДН-аас нэр дэвшин сонгогдсон гишүүдийг эгүүлэн татах”-ыг МҮАН-ын Ерөнхий зөвлөл, МСДН-ын УТЗ-д хандан уриаллаа.

МСДН-ын 2-р их хурлын 2-р бага хурал 1993.03.28-нд хуралдаж, УИХ дахь намын төлөөллийн асуудал хэлэлцэн, УИХ дахь намын төлөөллөөс татгалзах эрхийг УТЗ-д олгож, тогтоол гаргасан байна.

Бага хуралд оролцогчид Монгол улсын иргэн, УИХ-ын дарга Н.Багабандийн гадаад орны зарим байгууллага, иргэдтэй тогтоосон холбоо харилцаа нь УИХ-ын Сонгуулийн хууль, УИХ-ын гишүүн, төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээнд харшилсан тухай тус

Бага хурлын төлөөлөгчдөөс хийсэн мэдээллийг магадлан шалгаж өгөхийг УИХ, Монгол Улсын Ерөнхий прокурор (н.Бахдал)-т хандан хүсжээ. Түүнчлэн хуулбарыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Даш-Ёндон, МАХН-ын Бага хуралд илгээжээ.

Тус Бага хурлаар Монгол улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн.

Ерөнхийлөгчийн сонгуульд хамтран оролцохыг уриаллаа

Ардчиллынхны хувьд 1993 оны хамгийн гол онцлох үйл явдал нь шинэ Үндсэн хуулийн дагуу болсон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан явдал болсон юм.

Үндсэн хуулийн 1 жилийн ойд зориулсан УИХ-ын чуулганы хуралдаан дээр хэлсэн үгэндээ МСДН-ын дарга Б.Батбаяр “Үндсэн хуульд хууль тогтоох дээд байгууллагыг олон намын тогтоцтой байх тухай заасан нь бий. Гэтэл сонгуулийн дүнд хамгийн болхи тооцоогоор, адаглаад л хүн амын 46%-ийн дэмжлэг авсан, бодит тооцоогоор бүр 62%-ийн дэмжлэгийг хүлээсэн хүчин парламентад дөнгөж 6% эзлэх тийм сонгуулийн хуулийг УБХ баталжээ. Энэ сонгуулийн үр дүнд хуучин хэв загварыг санагдуулам нэг намын парламент бүрдсэн нь нам ба нам бусчуудын эвсэл гэгчээс сонгогдон 96% намын гишүүдээс бүрддэг байсан АИХ-ын үлгэр хийгээд уламжлал боллоо...”

...Одоогийн Ерөнхийлөгчийг эрээ цээргүй доромжилж буй кампанит ажлыг ердийн нэг гэнэн тэнэгийн болчимгүй үг гэж үзэхгүй, харин эрх мэдлийн төлөөх цусгүй дайнд бэлтгэж буй бүлэг хүмүүсийн зориуд зохион байгуулсан дэс дараатай арга хэмжээний увайгүй цухалзалт гэж

үзэж буйгаа зориуд тэмдэглэе. Шинэ Үндсэн хуулийг амьдралын жам хэвшил болгох үүднээс улс орны цаашдын хувь заяаг нааштайгаар шийдэхийн тулд энэ жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийг тун ухаалаг хиймээр байна. Түрүүчийн сонгуулиар МАХН, Монголын ард түмний тал хувийн дэмжлэг авсан мөртлөө хууль тогтоох болон гүйцэтгэн захирах эрхийг бүтнээр нь авсан билээ. Энэ жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд мөн л ард түмний үлдсэн талын дэмжлэгийг хүлээдэг ардчилсан хүчний дэвшүүлсэн хүн Ерөнхийлөгч болох юм бол хүчний харьцаа зөв тэнцэхсэн. Чингэвэл магадгүй өнөөгийн улс төрийн болон эдийн засгийн хямралт байдлаас Монгол орныг хурдан гаргах хамгийн зөв гарц ч байж болох юм” хэмээн Ерөнхийлөгчийн сонгуулийн ач холбогдлыг дүгнэн тэмдэглэж байв¹⁰⁸.

Ерөнхийлөгчийн сонгуульд МҮАН-МСДН эвсэж, нэг нэр дэвшигчтэй орох тухай яригдаж, ардчиллын төлөө гол хоёр намын хурлаар хэлэлцжээ. Үүнээс өмнө 1992 оны УИХ-ын сонгуульд ардчиллын төлөө намууд салж ороод, дөрөвхөн суудалтай хэт цөөнх болсон, Ардчиллын удирдагчдын дийлэнх нь Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан нэр дэвшигчийн нас (45)-нд хүрээгүй байсан зэрэг нь сонгуульд эвсэхийн чухлыг сануулж байсан гэлтэй.

МСДН-ын дарга Б.Батбаяр МСДН-ын 3 жилийн ойг тохиолдуулан ТВ-ээр мэндчилж хэлсэн үгэндээ ардчилсан хүчний эв нэгдлийг онцлон, ирэх сонгуульд нэгдэж орохыг ахин уриалж “Саяхан хэд хэдэн нам нэгдэж МҮАН-ыг байгуулсан ба МСДН, МҮАН дараа дараагийн сонгуульд нэгдсэн нэг субъект болж орохоор тохирсон юм. Энэ бол урьдын алдаан дээрээ суралцаж буй хэрэг. Өнгөрсөн хугацаанд бидэнд алдсан зүйл их бийг хүлээх хэрэгтэй. Өнгөрсөн гурван жилд ардчилсан хүчнүүд нэгдэж,

нэг зорилго руу тэмүүлэхээсээ хоорондоо хагаралдаж тэмцэлдэх хандлага илүү байсны хор хохирол урьд хоёр сонгууль дээр гарсан. Үүнээс болоод өнөөдөр төр засгийн болоод хууль тогтоох бүх эрх хуучинсаг хүчний гарт орж, үүнээс болон улс орон хямралаас гарах байтугай улам бүр үгүйрэл гуйранчлалд хүрч байна. Ийнхүү салж бутрах болсонд МСДН, түүний удирдлага ч мөн хариуцлагаас нь хүлээх ёстой юм... ардчилсан хүчин улс орныхоо хувь заяаны төлөө эвлэлдэн нэгдэж чадахгүй бол хувь заяагаа хуучинсаг хүчний гараас салгаж чадахгүй, тэгж чадахгүй бол манай орныг ядуурал гачигдлаас гаргах боломж улам хомсдоно. Иймээс та бүхнийг ардчилсан хүчний нэгдсэн фронтыг дэмжихийг уриалж байна” гэсэн юм¹⁰⁹.

МҮАН, МСДН-ын хамтарсан хурлаар

П.Очирбат нэр дэвшив

МСДН-ын 2-р их хурлын 2-р бага хурал 1993.03.28-нд хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх асуудал хэлэлцэн, МСДН-ын УТЗ-ийн гишүүн Д.Ламжав, тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбат, УИХ-ын гишүүн Б.Чимэд нарын нэрийг МҮАН, МСДН-ын төлөөлөгчдийн хамтарсан хуралд оруулахаар тогтлоо.

МҮАН-ын 2-р чуулган 1993.04.06-нд хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ардын аж ахуйтан Р.Дашдооров (Дундговь. Дэлгэрхангай), эрдэмтэн зохиолч Л.Дашням, бэлтгэл генерал Л.Пүрэвдорж нарын нэрийг МҮАН, МСДН-ын төлөөлөгчдийн хамтарсан хуралд оруулж хэлэлцүүлэхээр тогтов.

Хоёр намын төлөөлөгчдийн хамтарсан хурал 04.12-нд бүтэн өдрийн турш үргэлжилж, Ерөнхийлөгчийн сонгуульд хамтран оролцох нь зүйтэй гэж үзсэн. Гол нь өөр намын

хүнийг нэр дэвшүүлээд, сонгуульд ялахгүй бол тун хүнд байдалд орно, тиймээс энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг өнжье ч гэсэн санал гарч мэтгэлцжээ.

Ингэж нэр дэвшигчдийн талаар удаан хэлэлцээд, П.Очирбат, Р.Дашдооров нарын нэрийг үлдээн, санал хураахаар болжээ. Зарим төлөөлөгч П.Очирбатаас тус хоёр намын эвслээс нэрээ дэвшүүлэхээ зөвшөөрснөө бичгээр илэрхийлэн, баталгаа өгөхийг шаардсанчлан П.Очирбат баталгаа өгсөн юм. Санал хураалтаар П.Очирбат олонхийн санал (30:20) авчээ.

“Үндэсний эв нэгдэл, улс орны эрх ашиг, улс төрийн тогтвортой байдлыг эш үндэс болгон МҮАН, МСДН-ын нэрийн өмнөөс Монгол Улсын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбатын нэрийг дэвшүүлэх нь зүйтэй” гэж үзэж, П.Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгүүлж, сонгуулийн компани ажлыг улс орон даяар зохион байгуулахыг намуудын эрх бүхий байгууллагуудад үүрэг болгон Хамтарсан хуралдаанаас тогтоол (№1, №2) баталлаа. Ерөнхийлөгчийн сонгуульд тус хоёр намын хамтран оролцох тухай гэрээг баталж, гэрээг мөрдөн ажиллахыг Сонгуулийн ажлыг зохион байгуулах МҮАН, МСДН-ын хамтарсан байгууллагад үүрэг болгов.

Хамтарсан хуралдааныг М.Энхсайхан, Л.Бямбажаргал нар даргалжээ.

Энэ хэр МАХН-аас тус намын гол хэвлэл “Үнэн” сонины эрхлэгч Л.Түдэвийн нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид дэвшүүлсэн юм.





Хамтарсан хурлын шийдвэрийг ёсчилж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг батлах ёслол 04.19-нд болов.

Хоёр намын эвслийн сонгуулийн штаб байгуулагдан, сонгуулийн штабын даргаар М.Энхсайхан, орлогч даргаар МСДН-ын нарийн бичгийн дарга Н.Алтанхуяг, МҮАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Баасанжав нар ажиллажээ. Улс төрийн ажлын хэсэг (Р.Гончигдорж, Д.Ламжав, Р.Хатанбаатар (МСДН), Д.Дорлигжав, Т.Лхагваа, Я.Мөнхжаргал, Ц.Хурцбилэг (МҮАН)), Зохион байгуулалт, санхүүгийн хэсэг (Ш. Батдэлгэр, Р.Бурмаа, Ч.Отгонбаяр, Д.Хадхүү (МСДН), С.Батчулуун, Д.Дагвадорж, Б.Энхжаргал (МҮАН)), Суртал мэдээллийн хэсэг (Л.Бямбажаргал, Ч.Чулуунбаатар (МСДН), Ш.Алтангэрэл, Д.Самдан (МҮАН) нарын бүрэлдэхүүнтэйгээр) байгуулагджээ.

Ерөнхийлөгчийн сонгуульд МНН, МШАН, Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн холбоо зэрэг улс төрийн хүчин, ТББ анхны Ерөнхийлөгч П.Очирбатыг дэмжин, уриалга гаргалаа.

П.Очирбат нэлээд хүчтэй өрсөлдөөнд ардчилсан хүчнийг төлөөлөн оролцох болжээ. Сонгуулийн компани ажлын хүрээнд 21 удаа уулзалт хийж, 10 200 сонгогчтой уулзсан нь санал өгсөн нийт сонгогчийн ганцхан хувьтай тэнцэж байжээ. Сонгогчдын 75% нь оршин суудаг хөдөө орон нутгаар явж, сурталчилгаа хийж чадаагүйнхээ учрыг “залуу намууд хөрөнгө мөнгөний бололцоо муу, байр сав, холбоо, тээвэр хүрэлцээгүй”-тэй холбон тайлбарлажээ¹¹⁰.

Эвслийн нэр дэвшигч П.Очирбат Ерөнхийлөгчөөр сонгогдлоо

Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны сонгууль 1993.06.06-нд болов.

Нийт сонгогчийн 92.73% (989 893 сонгогч) сонгуульд оролцож, П.Очирбат 57.78% (592 836 сонгогчийн)-ийн, Л.Түдэв 38.70% (397 057 сонгогчийн) санал авчээ. Сонгуулийн насны 1 сая 106 мянга 403 сонгогч бүртгэгдсэний 1 сая 25 мянга 970 нь сонгуульд оролцож, санал өгчээ. Саналын 3.52% (36 077) хүчингүй байжээ.

Жич: Энэ сонгуульд нутгархах сонин үзэгдэл гарсан нь МАХН-ын нэр дэвшигч Л.Түдэв төрөлх нутаг Говь-Алтайдаа нийт сонгогчийн 77.76% санал авсан байхад П.Очирбат ч өөрийн төрсөн нутаг Завхандаа 78.73% санал авсанаас харагдана.

МҮАН-МСДН-ын эвслээс нэр дэвшсэн П.Очирбат Монгол Улсын Ерөнхийлөгч боллоо. “Энэ бол бас нэг ахиц, хандлага” (Н.Алтанхуяг) байсан юм.

МҮАН, МСДН-ын Эвслийн сонгуулийн төв штаб 1993.06.08-нд “Монгол ах дүү нар аа” хэмээх илгээлт бичиг гаргалаа. Илгээлт бичигт:

“Сонгуулийн үр дүн нь Монголын ард түмэн Үндсэн хуулиа дээдлэн хэрэгжүүлэх хүсэл зоригийн илэрхийлэл боллоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд өөрийн итгэл үнэмшлээр идэвхтэй оролцсон танд гүн талархлаа илэрхийлье.

Сонгуулийн кампанийн үеэр хоёр нэр дэвшигчийг төв шударгаар хуулийн хүрээнд идэвхтэй сурталчилсан, санал хураалтыг зохион байгуулсан, сонгуульд ажиглагчаар оролцсон хүн бүрийн хүчин чармайлтыг бид өндрөөр үнэлж байна...

Ерөнхийлөгчийн сонгуульд иргэний зориг гарган өрсөлдсөн Лодонгийн Түдэв Танд хүндэтгэл илэрхийлж байна.

Пунсалмаагийн Очирбат Таныг Монголын ард түмэн Ерөнхийлөгчөөр сонгосон явдалд гүн талархал илэрхийлэхийн хамт сонгуулийн кампанийн үеэр сонгогч олны зүгээс захиж, шүүмжилж, сургаж байсан бүх зүйлд Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд онцгой анхааран хандана гэдэгт итгэж байна” хэмээн онцолжээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд олонхийн санал авсан П.Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг СЕХ-ны дарга С.Лхагвасүрэн 06.17-нд УИХ-ын чуулганы хуралдаанд өргөн мэдүүллээ.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай хууль гаргахтай холбогдуулан хоёр томъёоллоор



санал хураахад “Нэгэнт улсын Ерөнхийлөгчийг нийт ард түмнээс сонгосныг УИХ хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хурааж байгаа тул саналаа нэрээр хураалгая” гэсэн санал (Р.Гончигдорж) гарсан ч олонх дэмжээгүй байдаг. Ингээд “Анхан шатны сонгууль хүчин төгөлдөр болсон” гэсэн томъёоллоор санал хурааж, 61 гишүүн оролцож, 44 дэмжиж, 17 татгалзсан.

Үүний удаад, нэр дэвшигчийг “Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгоход харшлах шалтгаан байхгүй” гэсэн томъёоллоор санал хураасан. Санал хураалтад 60 гишүүн оролцож, 24 гишүүн харшлах шалтгаантай гэж үзсэн бол 34 нь П.Очирбатыг Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгоход харшлах шалтгаан байхгүй гэж үзсэн юм (Жич: Нэр дэвшигч гэмт хэрэг үйлдсэн нь анхан шатны сонгууль дууссанаас хойш шүүхээр тогтоогдсон болон сэтгэцийн хувьд эрүүл бус болох нь эмнэлгийн албан ёсны дүгнэлтээр батлагдсан байх нь харшлах шалтгаан юм).

**Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон
Пунсалмагийн Очирбатын тангараг өргөх ёслол
1993.06.18-нд болов.**

УИХ-ын гишүүн М.Энхсайхан Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллах болсон тул УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг УИХ-ын чуулганы 1993.06.15-ны хуралдаанаар хэлэлцээд зөвшөөрсөн юм. М.Энхсайханы ийнхүү ажиллах болсон талаар П.Очирбат “Энэ залуугийн эрдэм мэдлэг, чадварыг нь улс эх орны тусын тулд ашиглах л ёстой хүний нэг, бас Монголын нийгмийг олон цэгээс нь харж мэдрэх нь хаа хаанаа хэн хэндээ ач тустай байх талаас бодож, УИХ-ын гишүүнээс нь чөлөөлж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар

ажиллуулах санал тавьсан” гэж дурсжээ¹¹¹.

Орон гарсан М.Энхсайханы дараагийн хүн А.Ганбаатар (МСДН)-ыг УИХ-ын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцох тухай СЕХ-ны саналыг УИХ-ын 1993.10.04-ний чуулганы хуралдаанаар хэлэлцээд, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн юм.

Энэ талаар А.Ганбаатар “Үнэнийг хэлэхэд УИХ-ын гишүүн болчихно гэж зүүдлээ ч үгүй. Сонгуулийн хууль ёсоор онолын хувьд өнгөрсөн жилийн сонгуульд оролцсон хэнд ч ялгаагүй УИХ-ын гишүүн болох боломж бий. Хэрэв би татгалзсан бол миний дараагийн хүнд тэр боломж нь олдох байлаа” хэмээгээд “Амьдрал ахуй болон эрхэлж байсан ажил төрлийнхөө үүднээс хандвал татгалзмаар л байлаа. Гэвч намынхаа удирдлага, найз нөхөд, ойр төрлийнхөнтэйгээ зөвлөлдсөний эцэст УИХ-д орохоор шийдсэн. Ийм шийдвэр гаргахад хэд хэдэн бодитой хүчин зүйл нөлөөлсөн. Юуны өмнө Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн манай улс төрийн тавцан дээрх хүчний харьцааг харьцангуй тэнцвэржүүлэх боломж бүрдүүлээ. Энэ боломжийг ашиглахад УИХ дахь манай эвслийн таван гишүүн мэдээж ихээхэн үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болж байна. Хоёрдугаарт, аливаа нам парламентад аль болох олон суудалтай болохын төлөө байдаг. Тэгэхэд МСДН-ын гишүүний хувьд ч, намынхаа удирдлагад байдгийн хувьд ч татгалзах эрх байсангүй. Гуравдугаарт, сонгуульд миний авсан санал тооны хувьд ч, хувь процентийн хувьд ч Их хуралд ороход ичиж зовоод байхааргүй хэмжээнд байлаа” гэж сэтгэгдлээ өгүүлжээ¹¹².

Жич: Дархан хотод 52-р тойрогт нэр дэвшиж сонгогдсон Н.Жанцанноров (МАХН) өөрийн хүсэлт, биеийн эрүүл мэндийн байдлын улмаас УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдсөн

тул тус тойрогт 1992 онд нэр дэвшиж 40.6% санал авсан Т.Эрдэнэбилэг (МҮАН)-ийг нөхөн сонгогдсонд тооцож, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх СЕХ-ны саналыг 1993.11.15-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаас хүлээн зөвшөөрлөө.

Тавуулаа байсан цөөнх гишүүд ийнхүү зургуулаа болж, бүл нэмсэн.



ЭРХ БАРИГЧИД ОЛОНХООРОО ТҮРЭЭ БАРЬСААР...

Тэд сонгогчиддоо ил байж ажиллахаас цааргалсан юм

УИХ-ын чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг Улсын Нийтийн номын санд тавьж байх саналыг 1993.10.19-ний УИХ-ын чуулганы үдээс өмнөх хуралдаан дээр МҮАН, МСДН-аас сонгогдсон гишүүд тавьж, санал хураалгажээ. Санал хураалтад оролцсон 58 гишүүний 45 нь татгалзсанаар төсөл санаачлагч цөөнхийн санал унаж, УИХ-ын үйл ажиллагаа олон түмнээс далд нууцлаг хэвээр үлдэхээр болов. Холбогдуулан Ц.Элбэгдорж “Нэгэнт ард түмний засаглал юм бол засаг төрөө ард түмнээс хянаж байх ёстой. Илээр санал хураана гэж хэлчихээд тэр хурлын протокол УИХ-ын архивт хадгалагдаж байдаг. Тэр протоколыг үзэхээр болбол олон янзын шат дамжлагаар зөвшөөрөл авч үзнэ гэсэн байдалтай үлдэх юм бол илээр санал хураана гэдэг нь утгагүй болж байгаа юм... өөрийг нь сонгож байгуулсан ард түмнээс үйл ажиллагаагаа нууж далдалж байна гэсэн үг” хэмээжээ¹³.

1994 оны Хаврын чуулганы нээлт дээр цөөнхийг төлөөлж хэлсэн үгэндээ Ц.Элбэгдорж “Аливаа парламент сонгогчдын хүсэл зоригийг хэрэгжүүлэгч байдаг учраас тэдний зүгээс тавих хяналт туйлын чухал. Иймээс ч бид УИХ-ын нээлттэй хуралдааны дэлгэрэнгүй бичлэгтэй ард иргэд чөлөөтэй танилцах боломжийг хуулиар нээж өгөхийг санал болгосон. УИХ-ын гишүүд Монголын төрийг төрүүлээгүй, төрүүлдэг ч үгүй. Түүнийг Монголын ард түмэн сонгож бүрэлдүүлсэн гэдгийг байнга сануулж байх механизм бий болгохын тулд, гишүүд бие биендээ эрүүний шөл уулгаж, Монголын төр түмний цагийн ихэнхийг үр ашиггүй шатаадаг бус, олонх гэдгээрээ цэгцтэй байр

сууриа илэрхийлдэг байхын тулд ийм санал тавьсан юм” гэж тайлбарлан хэлж байлаа¹¹⁴.

Цөөнхийн статусыг эс хэрэгсэв

УИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 1993.10.21-нд баталсан юм.

Гэхдээ өмнөх чуулганаар хийгдсэн эхний хэлэлцүүлгээр тохирсон цөөнхийн статусын асуудал (цөөнхийн бүлэг байгуулж болох тухай санал) дэмжигдэж байсан бол энэ удаад хоёр дахь хэлэлцүүлгээр уналаа.

Чуулганыг нээж хэлсэн үгэндээ УИХ-ын дарга цөөнхийн бүлгийг ажиллуулахын ач холбогдлыг дурдаж байв. Ерөнхийлөгч П.Очирбат төсөл санаачлагчдын саналыг дэмжиж, “УИХ дахь цөөнхийн статусыг хуульчлан баталгаажуулах нь цөөнхийн хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, УИХ-ыг өөрийг нь бэхжүүлэн, үйл ажиллагааг идэвхжүүлэх, парламентад ёсыг улам хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн санал” гэж үзэн, хэлэлцүүлгийн үеэр албан тоот илгээж байсан. Харин Ерөнхийлөгч саналаа цаг хожимдуулж ирүүлсэн гэх шалтгаанаар хүлээн аваагүй юм.

Хэлэлцүүлгийн үеэр цөөнхийн саналыг дэмжиж Н.Багабанди, Д.Лүндээжанцан, Б.Чимид нарын гишүүд чамгүй тайлбарлаж ухуулсан ч хуучинсаг олонх хүчлэн эсэргүүцээр “УИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг хасаж танан баталсан юм. Өөрөөр хэлбэл цөөнхийн эрхийг баталгаажуулсан заалтыг хасжээ.

Энэ талаар Р.Гончигдорж “Хэдийгээр бид цөөнхийн статусыг баталгаажуулж чадаагүй боловч тодорхой зохион байгуулалттайгаар хамтарсан сөрөг хүчин болж ажиллана.

Сөрөг хүчин гэхээр ердийн ухамсрын түвшинд зүгээр л сөргөлдөж байдаг улс гэж ойлгодог бололтой... Бид эрх зүйн баталгаа олж авч чадаагүй. Гэсэн ч хэрэв олонхид хүсэл байвал үйл ажиллагааг нь зохион байгуулалтад оруулахыг чармайх болно”¹¹⁵ гэж мэдэгдэж байв.

МАХН-ын Бага хурал хуралдсантай холбогдуулан хийлгэсэн хэвлэлийн бага хурал дээр тус намын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Даш-Ёндонгоос “Саяхан УИХ ардчилсан хүчнээс сонгогдсон таван гишүүнд цөөнхийн статус олгосонгүй. Энэ асуудлыг танай намын Бага хурал авч хэлэлцсэн үү?” гэж асуусанд “Энэ асуудал Бага хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байгаа ч үгүй. Ерөөсөө авч хэлэлцэгдээ ч үгүй. УИХ дахь намын бүлэг тэрүүгээрээ л шийдсэн. Энэ асуудал тэгээд өнгөрсөн” гэж хариулжээ¹¹⁶.

МСДН-ын Бага хурлаар...

Бага хурал хуралдахаас нэг сарын өмнө 1993.09.10-нд МСДН, “Монголын нийгэм бүхэлдээ шилжилтийн бэрхшээлд мухардаж байхад нөгөө талаас албан тушаалаа урвуулан ашиглаж, хээл хахууль авах гаж ёс төрийн албаны бүх давхаргад хавтгайрлаа. Бага дунд тушаалтны төдийгүй төрийн дээд өндөрлөгт ч хүмүүс албан тушаалын хээл хахуульд автагдаж, УИХ-ын зарим гишүүд ч оролцжээ. Албан тушаалтан хээл хахуульд нэгэнт идэгдвэл ямар ч нийгэм ялзарч, улс орон доройтон, бүхий л с а й н сайхны зорилгыг улсын тусгаар тогтнолтой нь залгидаг жамтай...

Иймд МСДН-ын УТЗ Монголын нийт ард түмэн, улс төрийн бүх хүчний анхааралд толилуулан



- 1993.10.23-24-нд болох МСДН-ын Бага хурлаар улс оронд тулгарч буй бэрхшээл, түүний үр дагавар, шалтгаан, даван туулах арга замын тухай авч хэлэлцээд, УИХ, Засгийн газарт шахалт үзүүлэх болно.

- Манай нийгмийг улам бүр ялзруулж буй албан тушаалын хээл хахуультай тууштай тэмцэх болно.

- Тэмцлийн энэ үйл хэрэгт бидэнтэй хүчин хавсрахыг нийт ард түмэн, олон нийтийн байгууллага, улс төрийн хүчинд хандаж байна” хэмээн тус намын УТЗ мэдэгдэл гаргасан байв.

МСДН-ын 2-р их хурлын 3-р бага хурал 1993.10.23-24-нд МУИС-ийн хичээлийн байранд болсон юм. Бага хурлаар,

- Монгол орны өнөөгийн байдлын тухай (Б.Батбаярын үндсэн илтгэл)

- Хүн амын нийгмийн хамгааллын тухай (Л.Бямбажаргал)

- УИХ-ын үйл ажиллагааны тухай (Р.Гончигдорж)

- Хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах үзэгдлийн тухай (Р.Хатанбаатар)

- Засгийн газрын үйл ажиллагааны тухай (А.Ганбаатар)

- МҮАН, МСДН-ын хамтран ажиллах тухай гэрээний төслийн тухай (Б.Энэбиш) хавсралт илтгэлийг хэлэлцсэн юм.

Хурлаас гаргасан тогтоолд УИХ, Засгийн газар өдөр хоног аргацаасан, чадваргүй ажиллагаа явуулж байгаад дүгнэлт өгч, намын дотоод үйл ажиллагаанд шүүмжлэлтэй

хандсан нь цаг үеийн шаардлагад нийцсэн гэж үзжээ¹¹⁷.

Эрх баригч МАХН бодлогоо эрх мэдлийн давуутай нөхцөлд хэрэгжүүлж байгаад дүгнэлт хийн, МҮАН-тай хамтран ажиллах эвслийн гэрээний төслийг сайшаагаад, хурлын төлөөлөгчдийн санал шүүмжлэлийн дагуу уг гэрээний төсөлд хамтын ажиллагааны үр ашгийн хуваарилалт, сөрөг үр дагаврын хариуцлагын талаар нэмэлт оруулахаар шийдвэрлэжээ.

Бага хурлын үндсэн илтгэл (Б.Батбаяр)-д улс оронд бий болоод байгаа нийгэм, улс төрийн байдлыг дүгнэжээ. Үүнд,

“Завины жолоон дээр МАХН 72 жил завсарлагагүй сууж байна. Тэд хэдий бодит хандлагатай, эрүүл ухаантай, саруул боловсролтой байна, завь төдий бат бэх байна байх... Гэтэл МАХН энэ байдалдаа дүгнэлт хийн, улс орны хувь заяаны төлөө ухаалаг бодит алхам хийхийн оронд, дотроо бий болсон бухимдал, маргаан тэмцлийн уур амьсгалаа гадагш цацан, нэгэнт гарт байгаа төрийн эрх мэдлийг энэ бухимдлынхаа багаж болгон ашиглаж, Ерөнхийлөгчийн эсрэг бүдүүлэг кампани зохион байгуулж эхэллээ” гэсний дээр сөрөг хүчний ажиллагаа эрчимжихийн чухлыг зааж, бас ч шүүмжилсэн юм.

“Эрх барьж буй МАХН хийсэн шиг хийгээд, хариуцсан шиг хариуцдаг байхын тулд сөрөг нам байсан шиг байж, шүүмжилсэн шиг шүүмжилж чаддаг байх ёстой. Гэтэл манайд Засгийн газар байгуулалцаагүй, өөрсдийгөө сөрөг хэмээн нэрлэсэн намуудын байж байгаа царайг харагтун. Түрүүний Бямбасүрэнгийн Засгийн газрын үед энэ нэрийг МСДН хүлээсэн. Өөрсөддөө л тийм нэр өгсөн болохоос эдийн засгийн концепцийн хувьд шүүмжлэн, альтернатив санал тавьсан нь нэгээхэн ч үгүй. Эцсийн бүлэгт сөрөг

байхын тулд л хоосон шүүмжлэх нь хэнд ч, тэр байтугай өөрсдөд нь ч хэрэггүй. Жасрайн Засгийн газар бий болонгуут ямар нэг тоогоор парламентад суудал эзэлсний хувьд МҮАН, МСДН “сөрөг” нэр хүлээсэн. Хүлээх юу байх вэ, өөрсдийгөө л тэгж нэрлэсэн хэрэг. Гэтэл бүтэн жил гаран хугацаа өнгөрөхөд энэ хоёр нам эдийн засгийн концепцийн хувьд ямар сөрөг альтернатив санал тавив? Хувь хүнийхээ хувьд тодорхой хүнд дургүйгээ улс төржсөн байдлаар тавьснаас цааш огт хэтрээгүй. Энэ маань юу өгүүлж байна вэ гэвэл эрх баригч нам төлөвшиж чадахгүй, улс орныг эдийн засгийн тодорхой хандлага руу чиглүүлж чадахгүй, удирдсан ч биш, удирдаагүй ч биш бантан болгож байгаад нэлээд том хэмжээгээр МҮАН, МСДН ихээхэн буруутай” гээд “Бид хэдэн жилийн турш ардчилсан тогтоц нийгэмд бүрэлдүүлэх гэж зүтгээд, амжилт муутай л явна. Цаашид ингэж үргэлжлэхийг Монголын ард түмэн, Монгол орон дааж тэвчих бололцоогүй боллоо. Завь хөмөрвөл ардчилсан ардчилаагүй, шинэ хуучин, сайн муу хамаагүй бид бүгдээрээ цацаж үхнэ... ӨӨРИЙНХӨӨ ХУВЬ ЗАЯАНЫ ӨМНӨ ӨӨРӨӨ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЭРХ ҮҮРЭГТЭЙ ЧӨЛӨӨТ ИРГЭД БОЛСОН Монголын ард түмнийг хувь заяаныхаа төлөө нэгдэн хамтарч ажиллаж тэмцэхийг уриалж байна” гэж онцлон тэмэгдэглэсэн юм.

МҮАН-ын чуулган хуралдав (1993.11.13-14)

МҮДН-ын 3-р чуулган 1993.11.13-14-нд хуралдлаа. Намын дарга Да.Ганболдын “Монгол орны өнөөгийн байдал, төр засгийн үйл ажиллагаа, намын зорилт” үндсэн илтгэл, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Т.Лхагваагийн “Намын амьдралын төрх төлөв, цаашдын зорилт” хавсралт илтгэл хэлэлцжээ. Илтгэлд “Байгуулагдсанаасаа хойш нэг жилийн хугацаанд тус нам зохион байгуулалтын хувьд бүрэлдэн тогтож, үзэл

баримтлалын нэгдэл бий болж байгааг тэмдэглээд, цаашид намын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, төв орон нутгийн байгууллагын төлөвшилтийг түргэтгэх шаардлагатай"-г онцолж, чуулган Намын ажлыг эрчимжүүлэх тухай тогтоол баталжээ. Тогтоолд,

- Ойрын үед баримтлах улс төр, зохион байгуулалтын ажлын чиглэл, хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, намын орон нутгийн байгууллагуудад хүргүүлэх;

- Олон түмний эрх ашгийг хөндсөн УИХ, Засгийн газрын аливаа үйл ажиллагаанд тухай бүр бодитой үнэлэлт дүгнэлт өгч, намын байр суурийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон түмэнд шуурхай хүргэдэг журмыг цаашид тогтмолжуулах;

- Дархан, Эрдэнэт, Чойр хотын орон нутгийн сонгуульд бэлтгэн оролцох ажлыг зохион байгуулахыг Ерөнхий зөвлөлд даалгажээ.

Чуулганаар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, МҮАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар Э.Бат-Үүл (96.6% санал)-ийг томиллоо.

УИХ, Засгийн газрын үйл ажиллагааг хэлэлцсэн дүнтэй холбогдуулан сонгогч олонд хандан мэдэгдэл гаргасан байна.

Тус чуулганы дараагаас орон нутгийн намын байгууллагын ажлыг эрчимжүүлэх тал дээр улам илүү анхаарах болж, 1994 оны найман сараас Ерөнхий зөвлөлийн гишүүд тодорхой хуваариар орон нутагт ажиллажээ. МҮАН-ын Ерөнхий зөвлөлийн болон чуулганы гишүүд 1994.08 сараас мөн оны 12.10-ны хооронд 21 аймгийн 210 гаруй суманд ажиллажээ. Мөн МСДН-аас 1995.10 сараас 12.10-ны хооронд "МСДН-ын өдрүүд" арга хэмжээг нийслэл, 21 аймагт зохиожээ.

УЛС ТӨРИЙН ТЭМЦЭЛ ШИРҮҮССЭН НЬ (1994)

Хээл хахуулийн асуудлаар УИХ шалгалт хийлээ

Энэ хэр УИХ-ын нэр бүхий зарим гишүүн (Н.Багабанди, Ж.Гомбожав, П.Жасрай нар) хээл хахуулийн хэрэгт холбогдсон тухай мэдээлэл олон нийтэд тархаад байв. Мэдээллийг УАБХЕГ-ын Сөрөг тагнуулын хэлтсийн дарга Л.Санжаасүрэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөнтэй холбогдуулан УАБХЕГ-ын нууц материалын хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгах ажлын хэсгийг УИХ-ын 98-р тогтоолоор 1993.12.27-нд байгуулжээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Д.Базарсад, А.Ганбаатар, Г.Ганболд, С.Зориг, Ч.Зоригтбаатар, М.Зэнээ, Д.Лүндээжанцан, Ц.Шаравдорж нарын найман гишүүн оржээ.

Тус ажлын хэсэг 1993.12.28-1994.01.12-ныг хүртэл УАБХЕГ, ЦЕГ-т гүйцэтгэх ажлын чиглэлээр хийсэн шалгалтын дүнгийн талаар 1994.01.18-нд Төрийн ордонд хэвлэлийн бага хурал хийв.

Харин ажлын хэсэгт орсон сөрөг хүчний төлөөллүүд (А.Ганбаатар, Ц.Элбэгдорж) ажлын хэсэг олонхоороо дүгнэлт гаргасантай санал нийлэхгүй байгаагаа илэрхийлсэн юм. Тухайлбал, “Ажлын хэсгийн дүгнэлтэд оруулах санал” (1994.01.09)-даа “УИХ-ын дарга Н.Багабанди, Ерөнхий сайд П.Жасрай нар Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашигт хохирол учруулж болох асуудалтай холбоотой болох нь шалгалтын явцад илэрсэн юм... ажиллах явцад цугласан бичиг баримт, ярианы тэмдэглэл, ажлын хэсгийн дүгнэлтийг УАБЗ-д биш, харин тус Зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад танилцуулах нь зүйтэй. Ажлын хэсгийн дүгнэлтийг УИХ-д танилцуулах үед уг асуудлыг хэлэлцэх хуралдааныг дээр нэр нь гарсан

албан тушаалтан Н.Багабанди, Ж.Гомбожав нар даргалах ёсгүй, хамгийн ахмад настай гишүүн П.Жасрай чм ө н шалтгааны улмаас хурал даргалах эрхгүй болж байгаа тул дараах ахмад настай гишүүнээр хурал удирдуулах, УИХ-ын дарга Н.Багабанди, дэд дарга Ж.Гомбожав, Ерөнхий сайд П.Жасрай нарын аль аль нь цаашид Монгол Улсын төр засгийн өндөр албыг хаших ёс суртахууны эрхгүй гэж бид үзэж байна” гэж онцолжээ.

01.21-нд УАБХЕГ-ын хэлтсийн дарга асан Л.Санжаасүрэн “Ил товчоо” сонины газар хэвлэлийн бага зарлаж, мэдэгдэл хийлээ. Мэдэгдэлд,

- Одоогийн энэ хэвлэлийн бага хурлыг янз бүрийн шатны эрхтэн дархтан хүмүүс гэмт хэргийн болон ёс суртахууны шинж чанартай хэрэг үйлдчихээд байхад түүнийг нуун хаацайлах систем бүрэлдэж байгаад олон нийтийн анхаарлыг хандуулж сэрэмжлүүлэхэд зориулан хийж байгаагаа давтан хэлье...

- Манай аюулаас хамгаалах албаны хүлээж авсан мэдээн дотор засаг төрийн дээд тушаалын алба хашиж байгаа хүмүүс гадаадын хүмүүстэй харилцаатай байдаг тухай их эвгүй мэдээ дурсагдах болсон... Багабанди дарга шиг өндөр алба хашдаг хүнд олон асуудлаар зөвлөгөө өгөх олон тооны зөвлөх, туслахууд бий. Тэд нар нь даргадаа энэ асуудлаар зөвлөж туслаагүй гэхэд итгэхэд хэцүү. Албан ба албан ёсны бус хятад хэлний өчнөөн төчнөөн орчуулагч байсаар байхад яагаад манай нэг том дарга нэг жижиг пүүсийнхний өмнө ярианы дэвтэр дэлгэж жижигрэх болов? Тэр хятад нь чанд харуул хамгаалалттай Багабанди даргын өрөөнд хэрхэн нэвтэрч дайлуулах болов?..

- Гол нь уулзсан хүний нь даргадаа хэлсэн үг их ноцтой байгаа юм. Ер нь хятадуудын дотор УДШ-ийн орлогч дарга

байсан н. Цэрэндорж, Улсын прокурорын орлогч байсан н. Одонхүү нартай уулзсан уулзалтынхаа талаар даргадаа мэдээлэхдээ “Бид ямар ч үйл ажиллагаа явуулахад шүүх прокурорт ивээлийн хүмүүстэй боллоо” гэж ярьж байсан...

- Та нар “Багабанди даргыг хий хардаж байна. Энэ бол мэргэжлийн өвчин” гэж бүү бодоорой.

- Гадаадын иргэд, тухайлбал японы иргэдийн дотор манай өөр нэг том дарга Гомбожавын тухай олиггүй яриа багагүй гардаг. Японы нэг пүүсийн эзэн нөгөөдөө “Энэ Гомбожав гэдэг хүн үргэлж хувийн юм хөөцөлдөх юм. Бид Япон-Монголын харилцааг хөгжүүлэх гэсэн болохоос биш Гомбожав бид хоёрын харилцааг хөгжүүлэх гээгүй” гэх мэтээр ярьсан байдаг. Японд байгаа монголчуудын дотор Гомбожав даргаар асуудал шийдүүлэх гэвэл Шүрэнцэцэгээр нь дамжуулбал бүтнэ гэсэн яриа дэлгэрсэн. Сөрөг тагнуулын албаны хувьд Гомбожав даргын нууц амрагийн тухай асуудал хамаагүй юм. Японд байгаа монгол хүмүүсийн дотор Гомбожав даргын авсан хээл хахуулийн тухай яриа их байдаг.

- Сөрөг тагнуулын албаны хувьд дээрх хоёр хүнээс гадна гайхал төрүүлдэг хүн бол манай Ерөнхий сайд юм. УАБХЕГ, түүний сөрөг тагнуулын алба, бусад тусгай албадын үйл ажиллагааг үр дүнгүй төгсөхөд их нөлөөлдөг хүн бол Ерөнхий сайд өөрөө юм...

- Та бүхэн мэдэж байгаа, манай улсын дархан хилийг зөрчиж, манай хэд хэдэн хуулийн заалтыг огт тоолгүй орос монгол хоёр хүн суусан нэг нисдэг тэрэг Буянт-Ухаагийн нисэх буудал дээр буусан. Уг асуудлыг шалгаж эхлэхэд Ерөнхий сайдаас гэнэтхэн шахалт үзүүлсэн. Харин Баатар генералын шургуу эсэргүүцлийн үр дүнд бид энэ хэргийг шалгаад, зохих байгууллагад нь шилжүүлсэн юм. Одоо

хүртэл ямар ч арга хэмжээ аваагүй л байна. Ерөнхий сайд энэ хэргийг хаацайлан, хэдэн залуус бизнес хийж байгаа юм билээ гэх зэргээр тайлбарладаг. Гол нь хэдэн залуус бизнес хийсэнд юм биш, Улсын дархан хилийг зөрчсөн, нислэгийн хуулийг зөрчсөн зэрэг олон гэмт хэрэг үйлдсэнд байгаа юм...

- Гурван зүйл нэмж хэлэхэд,

1. Чухамхүү эдгээр хүмүүс, тэдгээрийг тойрогчид хууль ёс, ёс суртахууны хэмжээг зөрчиж байгаа учраас,

2. Манай эх орныг Хятадын хараат болгох, монголчуудыг хятадчилах бодлогыг эд санаачлан хийж байна. Энэ бол миний хувийн бодол.

3. Дээдсийн ийм замбараагүй байдлаас нийгэм доторх замбараагүй байдал улбаалж байна.

Иймд би төрийн чухал алба хашиж байсны хувьд, одоо жирийн иргэн сонгогчийнхоо хувьд энэ гурван хүнийг огцор гэж хэлэх эрхтэй гэж үзэж байна. Та бүхнийг анхаарал тавьсанд баярлалаа гэжээ¹¹⁸.

Энэ хэр УАБХЕГ-ын дарга Ж.Баатарыг Засгийн газрын хуралдаанд урьдчилан сануулалгүй дуудаж ирүүлээд, ажлаа өгөхийг шаардан халжээ. Энэ тухай ҮАБЗ-д танилцуулсангүй, Монгол улсын Ерөнхийлөгчид сүүлд нь мэдэгдсэн байдаг. Болсон явдал, хээл хахуулийн хэрэгтэй холбогдуулан МСДН-ын дэд дарга Л.Бямбажаргал “Энэ хэрэг гэнэт өнөөдөр ил болсон зүйл бус, урьд өмнө нь ард түмний дунд яригдаж л байсан зүйл. Харин өнөөдөр энэхүү яригдаж байсан зүйлийг манай тагнуулын мэргэжлийн байгууллага мэдсээр байсан төдийгүй мэргэжлийн үйл ажиллагаагаараа баталсан байсанд л хэргийн ноцтой чанар байгаа юм. Үүнийг нь мэдсэн нэр холбогдсон

албан тушаалтнууд, тодруулбал П.Жасрай, Н.Багабанди, Ж.Гомбожав нар УАБХЕГ-ын удирдлагыг солих замаар уг хэргийн сурвалж материалыг устгах, тагнан мөрдөх үйл ажиллагааг таслан зогсоох эрээ цээргүй арга хэмжээ авсан нь уг хэрэг хэчнээн ноцтой болохыг харуулж байна” гэж дүгнэв¹¹⁹.

Дээрх асуудалтай холбогдуулан 1994.01.30-нд МСДН-аас тэдгээр албан тушаалтны хээл хахууль, ёс суртахуунтай холбоотой олныг шуугиулсан асуудал гарсаар байгаа тул Н.Багабанди, Ж.Гомбожав, П.Жасрай нарыг албан тушаалаасаа яаралтай огцрохыг санал болгож, мэдэгдэл гаргажээ.

УИХ-ын Хаврын чуулганы нээлт дээр...

УИХ-ын Хаврын чуулган 1994.03.31-нд нээгдэж, Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлэв. Тэрээр УИХ дахь цөөнхийн эрх үүрэг, сүүлийн үед ихэд яригдаж байгаа өндөр албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар байр сууриа илэрхийлсэн юм. Үүнд,

“Чуулганы нээлт дээр Төрийн тэргүүн улс орны өмнө тулгамдсан болон хэтийн асуудлаар үг хэлдэг нь үндсэндээ төрт ёсны бас нэг уламжлал болж байна. Гэхдээ анхаарал төвлөрүүлж ярилцсан асуудал маань эцэстээ үр дүнгүй төгсдөг тийм уламжлал байх ёсгүй юм. УИХ-ын Намрын чуулган дээр би нэлээд шүүмжлэлтэй үг хэлэхдээ тавигдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар УИХ-аас авах арга хэмжээний төслийг УИХ-ын гишүүдэд танилцуулсан. Тэдгээрийн зарим нь УИХ-аар хэлэлцэгдэж шийдвэрлэгдсэн. Зарим санааг нь УИХ хэлэлцсэнгүй, хүлээж авсан эсэх нь тодорхойгүй үлдлээ...

МҮАН, МСДН-ын удирдах байгууллагууд УИХ дахь

намын төлөөллөөсөө татгалзах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргаж, хэвлэлээр мэдээ тараасныг та бүгд мэдэж байгаа. Энэ бол парламентын намуудын үйл ажиллагааны хямралын нэг илэрхийлэл даруй мөн... 1992 оны парламентын сонгуулиар УИХ-д улс төрийн хүчнүүдийн олонх цөөнхийн харьцаа хэт тэнцвэргүй болсон нь бодит үнэн билээ. Бид Сонгуулийн хуулиа хийхдээ олонх цөөнхийн асуудлыг “намын бүлэг” байгуулагдсанаар шийдвэрлэгдэнэ гэж үзэж байлаа. Гэтэл өнөөдрийн УИХ-д “МАХН-ын бүлэг” буюу зөвхөн олонхийн зохион байгуулалт хуулийн дагуу хийгдэж, УИХ-д суудал бүхий МҮАН, МСДН-уудын “намын бүлэг” байгуулах нөхцөл бүрдээгүй учраас цөөнхийн зохион байгуулалт зохицуулах механизмгүй үлджээ.

Сонгуулийн дүнд буй болсон ийм онцгой нөхцөлд хэрхэн ажиллах зарчим Сонгуулийн хуульд тусгагдаагүй юм...

МҮАН, МСДН УИХ дахь намын төлөөллөөсөө татгалзах нь Монголын үндэсний эрх ашигт нийцэхгүй.. Би энэ үзэл бодлынхоо талаар парламентад суудалтай намуудын удирдлагууд, УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-д МҮАН, МСДН-аас сонгогдсон гишүүдтэй зөвлөлдөн, намын удирдлагууд хоорондоо хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр УИХ-ын чуулганд дараах саналыг оруулж байна.

1. УИХ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, олонх цөөнхийг зохион байгуулах арга, эдлэх эрх үүргийг нарийвчлан тодорхойлж өгөх

2. УИХ-ын үйл ажиллагааг төрийн хэвлэл мэдээллээр сурталчлах зарчмыг тогтоож, түүндээ цөөнхийн эрхийг тодорхойлон зааж өгөх

3. 1996 онд болох УИХ-ын сонгуулийн хуулийг энэ

онд багтаан шинэчилж батлах зэрэг болно...

Төр засгийн дээд удирдлагын зүгээс хууль болон ёс суртахууны харш үйлдэл хийж, албан тушаалаа урвуулан ашигласан байж болзошгүй гэсэн шуугиан хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээтэй тарж яригдлаа...

Би өөрийн байр суурийг илэрхийлэхдээ уг хэрэг явдал үүсэх болсон шалтгаан, нөхцөл байдал, УИХ-аас байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтүүд, илтгэх хуудас, мэдэгдлүүд, УИХ-ын хаалттай хуралдаан, түүнээс гарсан шийдвэр, ТТГ, ЦЕГ-аас гаргасан дүгнэлт зэргийг үндэс болгож байна.

1. УИХ-ын дарга, орлогч дарга, Ерөнхий сайд нарын талаар УАБХЕГ (хуучин нэрээр)-ын шугамаар авагдсан мэдээлэлд дурдсан баримтууд зохих журмын дагуу шалгагдаж, гэм буруутай болох нь тогтоогдоогүй байна.

2. Төрийн албан тушаалтныг төрийн албан ажилд томилох, чөлөөлөх, гадаадын иргэд албаны хүмүүстэй уулзах, харьцах, харьяаллыг шийдвэрлэх зэрэг харилцаа нь төрөөс тогтоосон нарийн дэг журам, хуулиар зохицуулагддаг. Энэ дэг журмыг үйл ажиллагаандаа нарийн чанд баримтлах нь төр засгийн бүх шатны албан тушаалтны үүрэг, албан ажлын ёс зүйн хэм хэмжээ байх ёстой.

Өөрсдийн үйл ажиллагаанд дээрх зарчмыг баримтлаагүй явдлыг нэр бүхий албан тушаалтнуудын албан ажлын ёс зүйн хэм хэмжээний ноцтой алдаа гэж үзэх үндэстэй юм.

3. Уг асуудлыг тойрсон шуугиан нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах зарчим

зөрчигдөж, улсын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулсан гэсэн дүгнэлт хийсэн байна.

4. Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хоёр туйлшрал илэрч байна. Нэг нь хэвлэлийн эрх чөлөөг бүрэн хангахгүй, төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өрөөсгөлөөр ашиглах, нөгөө нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироох хүртэл задгайрдаг явдал байна. Энэ байдлыг аль алиныг ч өөрчлөх хэрэгтэй” гэж онцолсон юм. Мөн Сонгуулийн хуулийг шинэчлэх, УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цөөнхийн эрхийг тодотгож баталгаажуулах, “Ардын эрх” сонин, радио ТВ-д цөөнхөд зориулсан зай талбай, цаг минутыг нэмэгдүүлэх санал гаргасан.

Ардчилсан хүчнүүд шаардлагаа хүчжүүлэн... өлсгөлөн зарлалаа

МСДН-ын 2-р их хурлын 2-р чуулган 1994.03.19-20-нд МУИС-ийн хичээлийн байрнаа боллоо. Улс орны байдалд дүн шинжилгээ хийж, МСДН-ын үйл ажиллагааны талаар дүгнэн, төрийн дээд тушаалтнуудтай холбогдсон асуудлыг шүүх, ҮХЦ-ээр нэн даруй хэлэлцүүлж, арга хэмжээ авахуулахаар УИХ-д хандан мэдэгдэл гаргажээ.

Мөн зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, Б.Батбаярыг өөрийн нь хүсэлтээр намын даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн юм. МСДН-ын анхны дарга Б.Батбаярт талархал илэрхийлэн, тогтоол баталжээ. Ингээд МСДН-ын даргаар Р.Гончигдоржийг, дэд даргаар Н.Алтанхуяг, Л.Бямбажаргал нарыг сонгожээ.

УТЗ-ийн шинэ бүрэлдэхүүнд Ц.Адьяасүрэн, Н.Алтанхуяг, Б.Батбаяр, Л. Бямбажаргал, Ж.Бямбасүрэн,

Л.Галбадрах, А.Ганбаатар, Д.Ганхуяг, Р.Гончигдорж, Ч.Жүгдэрнамжил, Л.Зориг, Д.Ламжав, Г.Лхагважав, Ч.Лхагважав, С.Мэндсайхан, Ч.Отгонбаяр, К.Сайраан, Р.Хатанбаатар, Ч.Чулуунбаатар, З. Энхболд, Б. Энэбиш нарын 21 гишүүн сонгогджээ.

Үйл явдал эрчимтэй өрнөсөн юм. МоАХ, МОХ Засгийн газрыг огцруулах шаардлага тавьж байгааг МСДН дэмжиж, 04.09-ний өдөр “Ерөнхий сайдаасаа эхлэн ёс зүйн алдаа гаргаж, албан тушаалаа урвуулан ашигласан үйлдэлд орооцолдсон учир Монгол Улсын Засгийн газрыг огцруулахаар МоАХ, МОХ-ноос тавьсан шударга шаардлага, явуулж буй улс төрийн үйл ажиллагааг МСДН бүрэн дүүрэн дэмжиж байна. МСДН-ын гишүүд дэмжигчдийг энэ үйл ажиллагаанд нэгдэн оролцохыг уриалж байна” хэмээн мэдэгдэл гаргав.

Улмаар 1994.04.13-ны өдөр МоАХ, ШДХ, МОХ, МСДН хамтран Д.Сүхбаатарын талбайд цуглаан хийсэнд 50 мянга гаруй хүн оролцож¹²⁰, УИХ-ын гишүүн, МоАХ-ны дарга Ц.Элбэгдорж, МСДН-ын дарга Р.Гончигдорж, ШДХ-ны тэргүүн Д.Батсүх, МОХ-ны ерөнхийлөгч Д.Эрдэнэцогт нарын хүмүүс үг хэлж, сонгогчдын өмнө авсан амлалт, мөрийн хөтөлбөрөө биелүүлж чадахгүй байгаа болон албан тушаалаа урвуулан ашиглаж, хээл хахуулийн асуудалд холбогдсон П.Жасрайн тэргүүлсэн Засгийн газрыг огцрохыг шаардлаа. Дөрвөн жилийн өмнө 1990 онд болж байсан жагсаал цуглаан ийнхүү сэргэв.

Цуглааны дараа 04.13-нд МСДН, МоАХ, МОХ, ШДХ-ны төлөөлөл санаачлан, улс төрийн өлсгөлөн зарласан юм. Өлсгөлөнг зохион байгуулагчид “Бид засгийн эрхийн төлөө тэмцээгүй. Энэ бол шударга ёсны төлөө тэмцэл”

(Д.Баттулга) хэмээн мэдэгдлээ.

Өлсгөлөнд МСДН-ын дэд дарга Н.Алтанхуяг, МоАХ-ны ерөнхийлөгч Д.Баттулга, МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Рэнцэнтавхай нарын 40 гаруй хүн оролцсон юм. Үүнд, Д.Алтангэрэл, Н.Алтанхуяг, Г.Алтанхуяг, А.Ангараг, Г.Анхбаяр, Д. Арвин, П.Баатаржав, Д.Батбаяр, Л.Батжаргал, Д.Батсайхан, Д.Баттулга, З.Батхуяг, Х.Батцэнгэл, Ш.Баярсайхан, Ц.Баясгалан, М.Болдсайхан, Ц.Ганбат, Д.Ганболд, С.Ганзориг, Р.Гончигдорж, Х.Дандар, М.Дунгаржав, Л.Дэлхийцэцэг, Ч.Жамц, С.Жаргал, О.Лодон, Н.Мишиг-Иш, Х.Нурлан, Д.Нямаа, Д.Рэнцэнтавхай, А.Соёл-Эрдэнэ, С.Соёмбобаатар, Х.Суръяа, Д.Хувьтөгөлдөр, Д.Цогбадрах, Д.Цолмон, М. Чимэддорж, С.Энхбаяр, С.Энхмөнх, Ч.Энхтөр, Н.Энхээ нарын хүмүүс багтсан юм. С.Ганзориг, Д.Цолмон нар ус уух, эмчид үзүүлэхээс татгалзан, хуурай өлсгөлөн зарласан байна.



04.19-ний 17:00 цагийн байдлаар МоАХ-ны 22, ШДХ-ны 3, МСДН-ын 5, МҮАН-ын 2, МОХ-ны 5, нам, холбооны

гишүүн бус 4 хүн өлсгөлөн зарлаад байсны дунд эмэгтэй хүн нэг байлаа.

04.13-19-ний өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд 350 орчим хүн чөлөөт индрээс үг хэлж, Засгийн газрыг огцруулах шаардлагыг дэмжин, гучаад мянган хүн гарын үсгээ зураад байв.

Энэ хэр Эрдэнэт хотноо А. Амарын нэрэмжит талбайд “Ардчилал, төрт ёсыг бэхжүүлье” цуглаан болж, дээрх шаардлагыг дэмжиж, мэдэгдэл гаргажээ. Дарханаас Нийслэл хүртэл явган явж ирэх жагсаалд нэгдэхээ 60 орчим хүн илэрхийлж бүртгүүлжээ¹²¹.

Өлсгөлөн зарласнаас гурав хоногийн дараа 04.16-нд УИХ-ын гишүүн, МСДН-ын дарга Р.Гончигдорж УИХ-ын чуулганы хуралдаан дээр нөхцөл байдлын талаар яриад, өлсгөлөн зарлагчдыг дэмжиж, тэмцэлд нэгдэх тухайгаа мэдэгдсэн юм. Чингээд мөн өдрийн 13:30 цагт Д.Сүхбаатарын талбайд ирж, өлсгөлөн зарласан. “Ардчилсан Үндсэн хуулиа баталчихаад, тэр хуулийнхаа ачаар байгуулагдсан УИХ, энэ зургаан гишүүнийхээ тавьж байгаа асуудал, гадна талд өлсгөлөн зарлагчид шийдвэрлүүлж хэлэлцүүлэхээр тавиад байгаа асуудалд юу ч болоогүй юм шигээр хандаж байгаа нь хамгийн ихээр зүрх өвтгөж байсан... Тэдний үл анзаарсан, эс хэрэгссэн байдлыг яаж арилгаж болох вэ гэж бодоод, өлсгөлөнд өөрөө оролцох шийдвэр гаргасан. УИХ дотор битүү байгаа зүйлүүдийг гадагш нь гаргаж тавих зайлшгүй шаардлага байсан. Дэд Ерөнхийлөгч, УБХ-ын дарга гээд олон түмнээс надад олгосон алдар хүндийг би хаана юуны төлөө зарцуулах вэ, тэнд нь зарцуулсныхаа ачаар асуудлыг зөвшилцөлд оруулах ёстой гэдэг шийдвэр гаргасан” гэж Р.Гончигдорж дурссан байдаг¹²³.

Өлсгөлөн эхлээд хэд хонож, нэлээд хугацаа өнгөрөөд

байхад МҮАН-ын удирдлага байр сууриа илэрхийлээгүй байв. Харин тус намын Сурталчилгааны албаны дарга, “Эрх чөлөө” сонинны эрхлэгч Х.Дашзэвэг “Та бүхний зарим нь чөлөөт ардчилсан үзлээрээ МҮАН-д нэгдсэн гишүүд билээ. Бидний тулгуур үзэл нь улс төр, нийгмийн хурцадмал байдлыг зөвхөн ардчилсан сонгуулийн аргаар шийдвэрлэж, аливаа асуудалд зэвсгийн болон сэтгэл зүйн хүч үл хэрэглэхийг урьдал болгодог. Та бүхэн ардчилсан үзлээ дээдэлж, өөрсдийн болон хамтран зүтгэгч хүмүүсийнхээ амь насанд бодит аюул тулгарсныг хүмүүнлэг ёсоор ухаарч, улс төрийн өлсгөлөнгөө нэн даруй зогсоохыг уриалж байна” гэж 04.14-нд радио ТВ-ээр мэдэгдсэн¹²² нь МҮАН-ын байр суурь мөн эсэхийг тодруулахад хүргэжээ. Өлсгөлөнд оролцогчид МҮАН-ын байр суурийг тодруулах зорилгоор тус намын удирдлагад хандан, 04.16-нд мэдэгдэл гаргасан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 04.17-нд “Ардчилал шинэчлэлийн жилүүдэд бидэнд хийж бүтээсэн зүйл их бий. Үүнийг үгүйсгэх аргагүй. Одоогийн Засгийн газар ч нааштай зарим чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Гэвч Засгийн газрын үйл ажиллагаа ардчилал шинэчлэлийн үйл явцыг эргэлт буцалтгүй гүнзгийрүүлэх, нийгэм, эдийн засгийн тулгамдсан, нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудалд анхаарлаа төвлөрүүлэх талаар шаардлагын хэмжээнд хүртэл ажиллаж чадахгүй байна... Засгийн газрыг шүүмжлэх, тэр ч байтугай түүнийг огцрохыг шаардаж байгааг ойлгож болох юм... Гэхдээ амьдралаас урган гарсан асуудлыг дэвшүүлэн тавихдаа улс төрийн өлсгөлөнгийн хэлбэрийг ашиглаж байгааг зөвтгөж яасан ч болохгүй... Ийм учраас өлсгөлөн бол ардчилсан нийгэмд улс төрийн тэмцлийн хэлбэр байх учиргүй гэж үзэж байна” гээд өлсгөлөнгөө зогсоохыг шаардлага тавьсан улс төрийн

хүчнийхнээс хүсээд, дэвшүүлэн буй асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэх нь зүйтэй хэмээн радио ТВ-ээр байр сууриа илэрхийллээ.

Сөрөг өлсгөлөн зарлагдсан нь

Эрх баригчдын элдэв бусармаг явдлыг илчилж тэмцэн өлсгөлөн зарласан МСДН, МоАХ, МОХ, ШДХ-ны гишүүдийн эсрэг сөрөг өлсгөлөн зарлагдсан сонин явдал мөн болсон юм.

Сөрөг өлсгөлөнг 1994.04.16-ны 17:00 цагт хоёр хүн эхлүүлжээ.

Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж, улс төрийн өлсгөлөн зарласан улстай санаа нэгтэйгээ илтгэн, Тусгаар тогтнолыг хамгаалах 281-ийн холбоо байгууллага 04.19-нд Эрх чөлөөний талбайд цуглаан хийв. Сөрөг цуглаан дээр УИХ-ын гишүүн М.Зэнээ, Ц.Намхайнямбуу, зохиолч О.Дашбалбар, Б.Догмид, З.Дорж нарын арваад хүн үг хэлж, Засгийн газрыг өмгөөлжээ¹²⁴. Тус цуглаанаас Өлсөгчдийг дэмжих түр зөвлөл байгуулсан байна.

Хоёр дахь сөрөг цуглаан 04.21-нд болсон юм. Энэ хэр эхний хоёр өлсөгч өлсгөлөнгөө зогсоогоод байлаа. Цуглаанчид Засгийн газрыг дэмжих Түр хорооны мэдэгдэл уншиж, Д.Бямбасүрэнгийн Засгийн газрын алдаа завхралыг ил тод гаргаж тавих, Ерөнхийлөгч П.Очирбатын 4 жилийн ажлын тайланг УИХ-аар хэлэлцэх, хэрэв Засгийн газрын асуудлыг УИХ-аар хэлэлцвэл УИХ, Ерөнхийлөгчийг хамтад нь огцруулахын төлөө тэмцэхээ мэдэгдэв.

Түүнчлэн УИХ-ын зарим гишүүн (Ч.Баянжаргал, М.Зэнээ) Монгол улсын Ерөнхийлөгчийг огцруулахыг уриалан шаардаж байв. Сөрөг өлсгөлөнд МАХН-ын аппаратын ажилтнууд нэгджээ.

1994 оны дөрвөн сарын үйл явдлын үеэр улс төрийн гурав дахь хүчин нэрийн доор Малчин, тариачны нэгдмэл нам (1994.07 сар), Ажилчны нам зэрэг хэдэн шинэ нам байгуулагдсан юм.

МҮАН байр сууриа илэрхийлэв

Тухайн үед өдөр алгасахгүй болж байгаа цуглаан жагсаал, мөн үргэлжилсээр байгаа өлсгөлөнгийн талаар цухас мэдээг телевизийн “Цагийн хүрд” хөтөлбөрөөр иргэдэд буруу ойлголт өгөхүйцээр засамжлан (монтажлан) үзүүлж байв.

МҮАН-ын Ерөнхий зөвлөл 04.19-нд ЦЕГ-ын удирдлага (дарга Б.Пүрэв), Нийслэлийн Засаг дарга Ц.Баасанжав нарт хандан, өлсгөлөнгийн эсрэг явуулж байгаа үйл ажиллагааг шүүмжилж анхааруулсан албан бичиг илгээлээ. Албан бичигт “... Энэхүү тэмцэл нь Үндсэн хуулиар баталгаажсан улс төрийн эрх, эрх чөлөөний хэм хэмжээнд нийцэж, хуулийн хүрээнд явагдаж байна. Засгийн газар энэ ажиллагааг хууль бус хэмээн нотлохыг зүйл бүрээр оролдож, Үндсэн хуулийн хавсралтын тухай хуулиар нэгэнт хүчингүй болсон АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 86-р зарлигийг үндэс болгохыг оролдож байна. Байдал ийм байхад цагдаагийн байгууллагын ажилтны телевизээр хийсэн мэдэгдэл нь улс төрийн тэмцэл явуулж байгаа орчинд элдэв явуулга, өдөөн хатгалга гарвал түүнийг далимдуулан, уг арга хэмжээг хүчээр таслан зогсоож болох санааг агуулж байна. Цагдаагийн хууль ёсны үүрэг бол нийгмийн хэв журмыг сахиулах, улс төрийн ийм арга хэмжээг элдэв өдөөн хатгалга, явуулгаас хамгаалахад оршино. Өөрсдийн хууль бус, хариуцлагагүй байдлыг төр засаг, нам хэмээх том үгээр хавтгайруулан хаацайлж, улмаар улс төржүүлж өнгөрүүлэх гэсэн хэнийг ч

болов шударга ёс өршөөхгүй бөгөөд ийм тэмцлийг элдэв шалтаг ашиглан, зэвсэг хангинуулж, хүчээр дарах гэсэн санаа өөрөө хууль бус төдийгүй Монгол оронд төлөвшиж буй улс төрийн тайван шинэчлэл, улс төрийн зөвшлийг бусниулах алдаатай алхам юм. Уг үйлдэл нь эцэстээ хууль зүй, улс төрийн ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй гэдгийг анхааруулж байна” гэжээ. Мөн үеэр МҮАН-ын Суртал мэдээллийн хороо өдөр тутмын “Хүрээ” сониныг 2000-3000 хувь гаргаж, үнэгүй тарааж байсан юм. Уг сонин нь өлсгөлөн зарлагчдыг сэтгэл санааны хувьд дэмжих агуулгаар зураг намтрыг нь нийтэлж, санаа бодлыг олон түмэнд хүргэж байсан юм.

УИХ-ын чуулганы 1994.04.19-ний оройн хуралдаан дээр улс оронд үүсээд байгаа нөхцөл байдлыг хэлэлцэж, Ерөнхийлөгч П.Очирбат ҮАБЗ-ийн зөвлөмжийг уншиж танилцуулжээ. Үүнд,

2. Д.Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарласан хүмүүсийн Засгийн газрыг огцруулах талаар тавьж байгаа шаардлагыг хүлээж авах үндэсгүй гэж үзэх
3. Өлсгөлөнгөө даруй зогсоохыг өлсгөлөн зарлагчдад уриалах
4. Жагсаал цуглаан хийх журмыг нарийн тодорхойлсон хуулийг нэн даруй хэлэлцэн батлахыг УИХ-д зөвлөмж болгох
5. Хэвлэл мэдээллийн тухай хуулийг ойрын үед боловсруулж гаргах нь зүйтэй гэж үзэх. Энэ хууль батлагдан гартал “Улс төрийн намуудын индэр” радио, ТВ-ийн нэвтрүүлэг буй болгох зэрэг... зохицуулбал зохих цаг үеийн асуудлыг шуурхай шийдвэрлэж байхыг Засгийн газарт зөвлөмж болгох зэргээр заасан байв.

Улс төрийн зөвшилцөлд хүрэх

Өлсгөлөн зарласан найм дахь хоног дээр буюу 04.21-нд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат МАХН-ын дарга Б.Даш-Ёндон, МҮАН-ын тэргүүн Да.Ганболд, МСДН-ын дарга Р.Гончигдорж нарыг байлцуулан уулзжээ. Үүгээр улс оронд бий болсон хямралт байдлаас гарах улс төрийн арга замыг хэлэлцэн тохиролцож, улс төрийн зөвшилцөл хийсэн юм. Үүнд:

- Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн төслийг мөн оны 05.15-ны дотор санаачлан УИХ-д өргөн барихыг Засгийн газарт үүрэг болгох

- УИХ-ын 1994 оны Хаврын чуулганаар Жагсаал, цуглаан хийх журмын тухай болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан УИХ-д өргөн барих Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлын тухай хуулийг хэлэлцэх

- Улс төрийн дээд албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай хууль, Коррупцийн эсрэг хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг боловсруулан УИХ-ын 1994 оны Намрын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн барихыг Засгийн газарт даалгах,

- Улс орны нийгэм эдийн засгийн өнөөгийн байдалтай холбогдуулан, олон түмнээс Засгийн газарт тавьсан шаардлага, хүсэлтийг хэрхэн ханган биелүүлж буй явц, цаашдын хандлагын талаар УИХ-ын 1994 оны Хаврын чуулганд илтгэл оруулан хэлэлцүүлэхийг Засгийн газарт даалгах,

- Энэхүү илтгэлийн хэлэлцүүлгийг улс орон даяар радио, телевизээр нэвтрүүлэн мэдээлэх, УИХ-аар дүгнэлттэй тогтоол гаргах нь зүйтэй гэжээ.



УИХ-ын гишүүн Р.Гончигдорж, Да.Ганболд нар УИХ-ын дарга Н.Багабандид МСДН, МҮАН, МАХН-ын удирдлага улс төрийн зөвшилцөл байгуулсныг хэрэгжүүлэх үндсэн дээр УИХ-ын тогтоолын төслийг 04.21-нд өргөн барив.

Зөвшилцөл болсны дараа өдөр 04.22-ны 13:00 цагт ардчилсан хүчний ээлжит цуглаан Д.Сүхбаатарын талбайд боллоо. Э.Бат-Үүл цуглааныг удирджээ. Цуглаанд оролцогчид УИХ-ыг тараан, сонгуулийн хуулийг шинэчлэх, 1994 онд сонгууль шинээр явуулах шаардлага тавив. Өлсгөлөнгийн үеэр ардчилсан хүчний цуглаан өдөр бүрийн 13:00 цагт болж байсан юм.

Өлсгөлөнг зогсоохын өмнө 04.23-нд, 11 дэх өдрийн орой өлсгөлөн зарлагчдын төлөөлөл Д.Рэнцэнтавхай, Д.Баттулга, Н.Алтанхуяг, Ажилгүйчүүдийн эрх ашгийг хамгаалах хөдөлгөөний зохицуулагч Н. Энхээ, ШДХ-ны Дархан хот дахь салбарын тэргүүн М. Болдсайхан нар Ерөнхий сайд П.Жасрайтай Итгэлцлийн гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийсэн ч амжилтгүй болсон юм. П.Жасрай бээр “Ерөнхий сайд Засгийн газраар барьцаалж, хуульд заагаагүй үндэслэлээр хувь хүн, олон нийтийн байгууллагатай гэрээ байгуулах үндэсгүй байна” гэсэнд гэрээг санаачлагчид Итгэлцлийн гэрээ байгуулах боломжгүй болсонд харамслаа илэрхийлжээ.

Итгэлцлийн гэрээний талаар Н.Алтанхуяг “Бат-Үүл ирж, орой хариу өгнө, одоо судалж байна гэж хэллээ гэв... орой тийш Ерөнхий сайд уулзаж, шаардлагын хариуг өгье гэжээ. Тэгэхдээ өлсөгчдийг бүрэн эрхтэй төлөөлсөн хүмүүстэй л уулзана гэв. Таван хүн төлөөлөхөөр бүгд гарын үсгээ зурав. Шөнө 11:30 орчим Засгийн газрын ордны I давхрын визитийн өрөөнд уулзав. Ерөнхий сайд, Банзрагч, Даваадорж нар байв. Асуудлыг хуулийн хүрээнд

шийднэ. Ийм гэрээ байгуулах хууль журам байхгүй. Нөхцөл байдал бүрдвэл Засгийн газар өөрөө асуудлаа тавих чадвартай, итгэж болно. Та бүхнийг өлсгөлөнгөө зогсоохыг уриалж байна гэлээ. 00:20 цагийн үед гарч ирэв” хэмээн тэмдэглэжээ¹²⁵.

Зөвшилцлөөр хэлэлцсэн асуудлаа тохирсон гэж үзсэн тул 04.25-ны өдөр буюу 13 дахь хоног дээрээ улс төрийн өлсгөлөн зогссон байна. Өлсгөлөн зогссон талаар “МоАХ-ны тэргүүлэгчид тустаа хуралдаж, шийдвэр гаргахаар болов. Тэд нэлээд удаан хуралдаж эцэст нь буух шийдвэр гаргав. Бат-Үүл нарын олон хүн энэ талаар тайлбарлан хэлж, 18 цагийн үед өлсгөлөнг зогсоолоо гэж зарлав” гэж тэмдэглэжээ¹²⁷.

Зөвшилцлийн дүнд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдан гарах хүртэл хугацаанд парламентад суудалтай намуудад үзэл баримтлалаа тайлбарлахад нь зориулж, тодорхой цаг өгөхөөр болсон юм. Үүгээр “УИХ-д суудал бүхий намуудад үзэл баримтлалаа тайлбарлахад нь зориулан, тэдгээрийн УИХ дахь суудлын тоог харгалзан МАХН-д 20 минут, МҮАН, МСДН-ын тус бүрд нь 10 минутын тогтмол нэвтрүүлгийг телевизэд 14 хоног тутам, радиод 7 хоног тутам нэг удаа бэлтгэн явуулж байсугай” гэсэн Засгийн газрын 96-р тогтоол 05.18-нд гарсан. МСДН Монголын радиогийн хооронд тогтмол нэвтрүүлэг явуулж байх гэрээг 05.25-нд байгуулжээ.



МАСМН БАЙГУУЛАГДАВ

Монголын Ардчилсан Сэргэн мандлын нам (МАСМН)-ын зохион байгуулах Анхдугаар их хурал МҮЭСТО-д болж,
 - Монгол орны нийгэм, улс төрийн өнөөгийн байдал, МАСМН-ын үзлийн үндэс, ойрын зорилт (Л.Пүрэвдорж) улс төрийн илтгэл

- Зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ.

Үндсэн илтгэлд “Сүүлийн хоёр жилд нэг намын ноёрхол эргэж тогтлоо... Монгол Улсын төр ард түмнээсээ тасарч, хээл хахууль, албан тушаалын наймаанд идэгдэж байна. МАХН-ын одоогийн Засгийн газар далдуур ад үздэг ардчиллаараа нүүр тахалж, сүүлийн 2 жилд гадаад орнуудаас 594 сая ам.долларын зээл авсан нь одоогийн үнээр 237.6 тэрбум төгрөг болж, 1993 оны ҮНБ-ий үйлдвэрлэлээс 1.7 дахин давж байна. Монгол орон түргэн хөгжлийн голомт болох ирээдүй нь улс төрийн тогтолцоо, ардчиллыг тууштай гүнзгийрүүлж, хүн ардынхаа эрх чөлөөг баталгаажуулсан хөрсөн дээр өөрийн соёл иргэншлийн үнэт өвийг орчин үеийн шинжлэх ухаан технологийн ололтоор тэтгэх чадвартай оюуны эрчмээр амилуулсан ахуйг нэмснээр бодитой болно” гэж онцолсон байна.

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, намын даргаар Д.Бямбасүрэн, ерөнхий нарийн бичгийн даргаар Л.Пүрэвдорж нар сонгогджээ.

МАСМН 1994.06.30-нд УДШ-д бүртгүүлэв.

Жич: УБХ-ын Эдийн засгийн БХ-ны нарийн бичгийн дарга асан Ардчиллын алтан хараацайн нэг, ШДХ-ны анхны тэргүүн, үүсгэн байгуулагч Д.Батсүх 1994.07.03-нд албан үүргээ гүйцэтгэж яваад, Баян-Өлгий аймагт зуурдаар нас барсан гунигт явдал тохиолоо.

ЭРХ БАРИГЧДЫН ЭЭЛЖИТ БУЛХАЙ... АЙБЕКС, МОЛАМ

Энэ хэр Засгийн газар АНУ-д байрладаг АЙБЕКС (IBEX) групп гэх харилцагчтай багц гэрээ хэлцлийг нууцаар хийсэн байв. Лавтай хоёр гурван жилийн өмнөөс яригдсан яриа хэлцэл нэлээд урагшилжээ. Тус группийн зөвлөлийн дарга Халид Хоссэйн нь 1993.10.22-нд Монгол орноо хүрэлцэн ирж, ажил хэргийн уулзалт, гэрээ хэлцэл хийж, чамгүй түджээ. Гэрээ хэлцлийг Монголын талаас Ерөнхий сайдын орлогч Ч.Пүрэвдорж гардан эрхэлжээ.

Гэрээнд “Бүгд Найрамдах Монгол Улс энэхүү гэрээний хугацаанд өөрийн нутаг дэвсгэр дэх байгалийн баялгаар болон АЙБЕКС-ийн зүтгэл үйл ажиллагаанд бүрэн дэмжлэг, туслалцаа үзүүлж, эрх мэдэл олгох замаар эл түншлэлд оролцоно. Засгийн газар хэрэгтэй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах болон хөгжлийн програмыг дэмжих үүднээс хөрөнгө оруулалтын хуулийг эргэн хянах бөгөөд шаардлагатай бусад хууль гаргах үүрэг хүлээнэ. Засгийн газар зохицуулалт хязгаарлалтыг боломжийн хэмжээнд хүртэл хялбаршуулан багасгаж, чөлөөт зах зээлийн дэлхийн жишигт нийцэхүйц таатай нөхцөл бүрдүүлнэ... Энэхүү гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Хөтөлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцуулахаар АЙБЕКС группийн томилсон бусад аль ч пүүс буюу пүүсүүдэд хамааруулж болно.

АЙБЕКС-д хамаарах төслүүдэд олгосон болон энэ гэрээнд тусгасан бүх нөхцөл, эрх ашгийг Монгол Улс, Монголын Засгийн газар батлан хангаж, гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон цаашдын үйл ажиллагаагаар, түүнчлэн аливаа хууль тогтоомжоор

өөрчилж, засаж буцаахгүй” гэсэн байв¹²⁷.

Түншлэлийн гэрээний хавсралтад, “гэрээний хугацаанд” Монгол Улсаас дэнчин болгон тавьж оролцох “өөрийн нутаг дэвсгэр дэх байгалийн баялаг”-ийг “алт олборлолт ба цэвэршүүлэлт (Бороо, Бумбат, Заамарын алтны орд), зэсийн хүдэр баяжуулах үйлдвэрийн өргөтгөл ба зэс хайлуулах үйлдвэр (Эрдэнэт, Цагаан суваргын орд), нефть хайгуул, үйлдвэрлэл, цэвэршүүлэг (Дорнод Монголын Тамсаг, Баруун Монгол), нүүрс олборлолт (Шарын гол, Багануур, Шивээ Овоо)” гэж заасны сацуу хөдөө аж ахуй, тээвэрлэлт, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлалын салбарыг дэлгэрүүлэн зүйлчилжээ¹²⁸.

Ийм гэрээ хэлцэл хийгдээд, хэрэгжих шатандаа бараг ороод байхад ҮАБЗ-д ч, Монгол Улсын төрийн тэргүүнд ч, хууль тогтоох байгууллага УИХ-д ч мэдэгдэлгүй нууцалсан байв. Харин сөрөг хүчин ардчиллынхан тодорхой сурвалжаас олж мэдээд, олон нийтэд дэлгэн илчилсэн билээ.

ҮАБЗ 1995.02.25-ны өдрийн хурлаараа уг асуудлыг хэлэлцээд, Түншлэлийн гэрээ, бусад гэрээ хэлцэл нь тэдгээр компани, корпорацийг Монгол Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт дангаар нь удаан ноёрхох боломж олгосноороо сөрөг үр дагавартай бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжуудыг зөрчиж, үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа болсон байна гэж дүгнэжээ. Түншлэлийн гэрээг хүчингүй болгож, их хэмжээний хөрөнгө оруулахтай холбогдсон бусад гэрээ хэлцэл Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, УИХ-д мэдээлэх, ҮАБЗ-д мэдээлэл өгч байхыг ҮАБЗ-өөс Засгийн газарт даалгалаа.

Эл баримт бичигт “Энэхүү гэрээг байгуулснаас хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. “АЙБЕКС”-д хамаарах төслүүдэд олгогдсон болон энэ гэрээнд туссан бүх нөхцөл, эрх ашгийг Монголын Засгийн газар батлан хангаж, гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон цаашдын үйл ажиллагаагаар, түүнчлэн аливаа хууль тогтоомжоор өөрчилж, засаж буцаахгүй” гэсэн нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байсан нь тодорхой. Гэрээ зөвхөн англи хэлээр хийгджээ.

МСДН-ын УТЗ-ийн 1995.03.01-ний хурлаар Засгийн газар (Ерөнхий сайдын орлогч Ч.Пүрэвдорж)-ын “АЙБЕКС” групп (зөвлөлийн дарга Халед Ахмед Хоссэйн)-тэй Сан-Франциско хотод 1993.04.17-нд байгуулсан Түншлэлийн гэрээ, бусад гэрээ хэлцэл үндэсний эрх ашигт харшилж байгааг УИХ анхааран үзэж, Засгийн газрын уг үйлдлийг хэлэлцэж, иргэддээ мэдээлэхийг шаардсан юм.

УИХ-ын Хаврын чуулган нээгдэж байгаатай холбогдуулан дөрвөн өдрийн дараа 03.05-нд МСДН Монгол Улсын Засгийн газрын дээрх групптэй байгуулсан Түншлэлийн гэрээ, бусад гэрээ хэлцэл, “МОЛАМ” корпорацитай 1994.03.15-нд байгуулсан Хамтарсан үйлдвэр үндэслэн байгуулагчдын гэрээ нь Монгол орны эдийн засгийн гол гол салбарт гадаадын компани, аж ахуйн нэгж удаан хугацаагаар ноёрхох боломж олгосон, байгалийн баялгаараа дэнчин тавьж амиа аргацаан, ард түмнийхээ итгэлийг хөсөрдүүлж байгаа Засгийн газрын үйл ажиллагааг хойш тавилгүй хэлэлцэж, олон нийтэд илтгэхийг УИХ-аас шаардаж, мэдэгдэл гаргажээ¹²⁹.

МАСМН-аас “Монгол Улсын Засгийн газраас “АЙБЕКС” бүлэг, “МОЛАМ” корпорацитай байгуулсан гэрээнүүдийг Үндэсний аюулгүй байдлын үүднээс авч үзэх

нь” сэдвээр хэвлэлийн бага хурлыг таван сард хийлгэсэн юм. Хурлыг нээж хэлсэн үгэндээ тус намын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Пүрэвдорж “Бид “МОЛАМ” корпорацитай хийсэн хэлэлцээрийг 1994 оны найман сар гэхэд судалж дуусаад, намын байр суурь дүгнэлтийг гаргаж, Засгийн газарт мэдэгдсэн. “АЙБЕКС” бүлэгтэй холбоотой асуудлыг 1994.08.31-ний өдөр Засгийн газрын шадар сайд Ч.Пүрэвдоржид тавихад бидний хийсэн гэрээ гэж хүлээн зөвшөөрсөн юм. Энэ оны 11 сар гэхэд хүчингүй болгоно гэж хариу хэлсэн. 08.23-нд намын дарга бид хоёр Ерөнхийлөгчид ажил төрөл ярих далимд “МОЛАМ” корпорацийн асуудлыг таьсан. Гэтэл энэ гэрээ хэлэлцээрүүд хүчингүй болохгүй явсаар он давсан” гэж тэмдэглэсэн байдаг.

Хуралд оролцогчид байр сууриа илэрхийлсэн юм. Тухайлбал доктор С.Баатар “Энэ гэрээ хэлэлцээр нь манай орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүйг Ерөнхий сайд П.Жасрай зөвшөөрч, ҮАБЗ-өөс гаргасан зөвлөмжид гарын үсэг зурсан. Энэ гэрээ хэлэлцээр МАХН-ын дангаар байгуулсан Засгийн газар намынхаа удирдлагын идэвхтэй дэмжлэг оролцоотойгоор түүний бодлогын хүрээнд хийсэн алхам гэдэг нь ойлгомжтой. “АЙБЕКС” бүлгийн эзэн нь өөрийгөө Монгол улсын шадар сайдын зиндаанд өргөмжилсөн Халид Хоссэйн, “МОЛАМ” корпорацийн удирдагч нь Петер Александрович Лоренс Лэйн. Оросод суугаа манай улсын элчин сайдын оролцоотойгоор Кайманы арал дээр байгуулсан даруйд нь манай Дэд бүтцийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газрын идэвхтэй дэмжлэг түлхээсээр агаарын орон зайгаа тэдний мэдэл хяналтад өгсөн... Монгол Улсын Засгийн газар “АЙБЕКС” бүлгийн эрх ашигт нийцүүлэн, хуулиа өөрчилж, шинээр заримыг баталж, тэдний хүссэн бүх лицензийг нэн

даруй олгож, ирүүлэх гэсэн бүх хүнд нэрсийн жагсаалтаар виз олгож, өөрийн орны иргэдэд хуулиар олгоогүй газар өмчлөх эрхийг эдлүүлнэ гэсэн заалтууд гэрээнүүдэд байгаа нь даанч хачирхмаар. Шадар сайд Ч. Пүрэвдорж Түншлэлийн гэрээнд 1993.04.17-нд АНУ-д гарын үсэг зурсан. 5-р сард П.Жасрай хувийн биенесмэнүүдийн урилгаар тэдний зардлаар АНУ-д зочилсон. 9-р сарын эхээр дээрх гэрээг дагалдсан олон хэлэлцээрт гарын үсэг зурагдсан байна. Дөрвөн сарын дараа “МОЛАМ” корпораци байгуулагдсан. Энэ бүхэн хоорондоо холбоо бүхий нэгэн гинжин хэлхээс юм байна. Энэ бүхнийг П.Жасрай сайд мэдэж байсан бөгөөд уялдуулан зохицуулж байжээ. Тийм ч учраас П.Жасрай ҮАБЗ-ийн хуралдаан дээр “Бид кабинетээрээ мэдэж байсан” гэж мэдэгдсэн байна. 1993.06 сард Улсын Ерөнхийлөгчийг анх сонгосон ёслолын ажиллагаанд Ерөнхий сайд П.Жасрай гадаадад хувийн урилгаар яваад оролцож чадаагүйг санамсаргүй тохиолдол гэж үзэж болохгүй”.

Хэвлэлийн бага хурлын төгсгөлд Л.Пүрэвдорж “Гэрээнүүдийг харахад Засгийн газар огцроогүй байхад Монгол Улсад аврагдах бололцоо алга байна. Монгол Улс энэ хэцүү байдлаас гарах ганц сайн арга бол хэрэгжүүлэлгүй орхих арга байна. Торгууль мэдээж төлнө. “АЙБЕКС” бүлгийн цаана хэн хуулийн зөвлөгөө авч байгаа тухай мэдээлэл бий. Тухайлбал, “МОЛАМ” корпораци гаргасан зардлаа төлүүлнэ. Гэрээг хэрэгжүүлээд олох байсан ашгаа төлүүлнэ, бас корпорацийн нэр хүнд унасан төлбөрийг төлүүлнэ гэж судалж байгаа бололтой. “МОЛАМ” корпорацитай байгуулсан гэрээг цуцалсан тухай “Ардын эрх” мэдээлсэн нь худлаа юм. Хоёр талаас тус бүр долоон хүн гэрээнд гарын үсэг зурсан байна. Бээжинд цуцалсан гэсэн. “МОЛАМ” корпорациас гурван хүн л гарын үсэг зурсан. Манай талаас ДБХ-ийн сайд гарын

үсэг зураагүй байна. Иймд хоёр гэрээ хүчингүй болоогүй” хэмээн дүгнэжээ¹³⁰.

ДБХ-ийн сайд Р.Сандалхаан “МОЛАМ” корпорацитай хийсэн гэрээг шинээр үзэглэсэн хэмээн 06.28-ны өдөр УИХ-ын БХ-дын хамтарсан хуралдаан дээр мэдээлэл хийсэн байдаг¹³¹.

Асуудлыг 1995.07.04-нд УИХ-ын Хаврын чуулганы сүүлийн өдрийн хуралдаанаар хэлэлцэв.

Ерөнхий сайд П.Жасрай УИХ-ын гишүүдэд, “АЙБЕКС” групптэй гарын үсэг зурсан хүмүүс нь төслийн түвшинд ойлголцож байсан Түншлэлийн гэрээг цуцалсан, “МОЛАМ” корпорацитай байгуулсан Хамтарсан үйлдвэр үүсгэн байгуулах тухай гэрээг үйлчлэхгүй болгосон”, нэгэнт төсөл хэрэгжиж эхлээгүй байгаа тул албан ёсны гэрээ биш, мөнгө санхүүгийн хохирол учраагүй, батлагдаагүй байгаа болохоор Монгол Улсын олон улсын гэрээ болохгүй гэж танилцуулж мэдээлэв.

Төрийн байгуулалтын БХ “Түншлэлийн гэрээний зарим заалт нь Монгол Улсын төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагын бүрэн эрхийг хөндөж хязгаарласан агуулгатай, гэрээ байгуулагч өөрийн эрх мэдлээ хэтрүүлсэн үйл ажиллагаа болжээ... ДБХ-ийн сайд Р.Сандалхаан, “МОЛАМ” корпорацийн дарга Лоренс Лэйн нар 1994.03.15-нд гарын үсэг зурсан Хамтарсан үйлдвэр байгуулагчдын гэрээг байгуулахдаа Засгийн газрын танхимд танилцуулж, зөвшөөрөл авч, холбогдох яам байгууллагуудын санал дүгнэлт гаргуулаагүй юм байна...

Засгийн газрын гишүүн Ч.Пүрэвдорж, Р.Сандалхаан нар олон улсын гэрээ байгуулах талаарх тухайн үед мөрдөж байсан хууль журмыг хайхралгүй хайнга хандаж, ажлын хариуцлага алдсан гэж үзэх үндэслэлтэй байна” гэсэн дүгнэлт гаргасныг Г.Төртогтох танилцуулжээ.

Үүний удаад Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, холбогдох бусад албан тушаалтнаас УИХ-ын гишүүд асуулт асуужээ. Ерөнхийлөгч П.Очирбат “МОЛАМ” корпорацитай байгуулах гэрээг надад үзүүлээгүй, хэлээгүй. Харин УИХ-ын зарим гишүүн уг гэрээнд гарын үсэг зурах ёслолд оролцохоор явах гэхэд нь УИХ зөвшөөрөөгүй гэж би сонссон” гэж ярьжээ. Мөн Ерөнхийлөгч П.Очирбат “Дээрх гэрээнүүдээс улсад учирсан шууд хохирол байхгүй гэж дүгнэж байгаад учир дутагдал бий. Мөнгөний биш юм аа гэхэд Монгол Улс, байгууллагуудын нэр төрд эдгээр гэрээнээс болж, хохирол учирсан гэж би үзэж байгаа.

ҮАБЗ “АЙБЕКС”-тай байгуулсан зүйлийг гэрээ мөн гэж үзсэн. Гэрээ биш байсан юм бол цуцлах учиргүй. Хүчин төгөлдөр биш юмыг хүчингүй болгоно гэж юу байх вэ. Иймд гэрээ мөн бишийг нь, гэрээ мөн юм бол Монгол Улсын ямар хуулийг зөрчсөнийг нь УИХ хэлж өгөх ёстой... ҮАБЗ-ийн 05 тоот зөвлөмжийн тухайд ч УИХ үгээ хэлж, зөвлөмж мөн үү биш үү гэдгийг дүгнэх учиртай. Хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байхыг бид тунхагласан. Эдгээр гэрээ хууль зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хүмүүст хариуцлага хүлээлгэх ёстой” гэсэн юм.

Энэчлэн хэлэлцээд, Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа ноцтой дутагдалд дүгнэлт хийж, түүнийг арилгах, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хэрэгжүүлэхэд тавих хяналт шаардлагыг бүх шатанд сайжруулах, энэ

талаар Засгийн газрын гишүүд, холбогдох тушаалтны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, алдаа гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэхийг Засгийн газарт УИХ даалгасан байна¹³².

НАМУУДЫН ЭРГЭН ТОЙРОНД...

МСДН-ын 2-р их хурлын 4-р бага хурал 1995.05.29-нд хуралдаж,

- Монгол орны улс төр, эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал (Р.Гончигдорж)
- Ардчилсан нийгэм дэх иргэн ба төр (Л.Бямбажаргал)
- Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн таван чиглэл (Н.Алтанхуяг)
- Намын анхан шатны байгууллагуудыг бэхжүүлэх нь (ХЭГ-ын нарийн бичгийн дарга Н.Пүрэвжав) илтгэлүүдийг хэлэлцэв.

Бага хурлаар 1996 оны УИХ-ын сонгуульд баримтлах мөрийн хөтөлбөрийн үндсэн таван чиглэлийг тодорхойлсон байна. МСДН-ын энэхүү мөрийн хөтөлбөр нь:

- Бага хувьчлал, зөв татвар
- Баталгаатай амь, баталгаатай өмч
- Нийгмийн хамгаалал
- Иргэний төлөө төр
- Алт дилерээс “АЙБЕКС”-ийг... гэсэн таван үндсэн хэсгээс бүрдэж байв

УИХ-ын гишүүн Р.Гончигдорж 07.04-07-ны хооронд Далай ламын 60 насны ойн ёслол, “Шинжлэх ухаан, оюун санаа, ирээдүй” олон улсын хуралд очих байсан ч ГХЯ-наас Далай ламтай ийнхүү холбогдох нь Монгол, Хятадын харилцаанд сэв суулгана гэж үзэж, гадаад паспорт олгож болохгүй гэсэн шийдвэр гаргасныг МСДН-ын УТЗ эсэргүүцэж, 07.05-ны өдөр мэдэгдэл гаргажээ.

МСДН-ын 5-р бага хурал 1995.10.28-нд хуралдаж, өмнөх бага хурлаас томъёолон гаргаад, гишүүд дэмжигчдээр өргөн хэлэлцүүлж байгаа сонгуулийн мөрийн хөтөлбөрийн үндсэн таван чиглэлээ нарийвчлан хэлэлцэж, мэдэгдэл гаргав. Мэдэгдэлд “Монгол Улсын иргэд амьд явах эрхээр баталгаатай хангагдана гэж Монгол Улсын Үндсэн хуулинд заасан билээ... Гэтэл онгоцонд суухаар осолддог, машинаар явахаар онхолддог, гуанзанд орохоор хорддог, гудамжаар явахаар зодуулдаг, эмнэлэг баталгаагүй, эм олдохгүй, түлээ түлш цахилгаан дулааны системээс болоод өвөлдөө осгодог, ажил хийж, амь зуух хөдөлмөрийн фронтгүй байгаа нь амьд явах баталгаагаар хангагдаагүй нийгэмд бид амьдарч байгаагийн жишээ. Монголын төр Үндсэн хуулиар иргэдтэйгээ хийсэн гэрээгээ ийнхүү хөсөрдүүлж байхад түүнтэй хариуцлага тооцох ямар ч механизм үйлчлэхгүй байна. Төр хариуцлага хүлээх чадвартай төдийгүй үүрэгтэй боловсон хүчнээр өөрийгөө бүрдүүлэх ёстой. Үндсэн үүргээ гүйцэтгэж чадаагүй бол халж сольж, хариуцлагыг нь хүлээлгэдэг байх ёстой. Ард түмний хяналтаас гадуур төр байх ёсгүй.

МСДН-ын Бага хурлын төлөөлөгчид бид Монголын төрөөс, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, орон нутгийн ИТХ ба Тамгын газраас Монголын иргэдэд Үндсэн хуулийн дагуу амьд явах баталгаа гаргаж өгөхийг шаардах эрхтэй гэж үзэж, Монголын ард түмнийг амьд явах баталгаагаар бодитой хангах” шаардлага тавьсан байна.

Түүнчлэн Төрийн бус байгууллагуудын тухай хуулийн төслийг дэмжих тухай тогтоол батлан, ТББ-уудын төлөөлөгчдийн Анхдугаар чуулганы ажиллагаанд амжилт хүсэж, илгээлт явуулжээ.

МҮАН-ын Анхдугаар их хурлын ээлжит бус чуулган 11.18-19-нд хуралдаж, “Сонгууль-96” хөтөлбөрийг хэлэлцэн сайшаагаад, намын их хурлаар хэлэлцэхийг зөвшөөрчээ.



УИХ-ЫН СОНГУУЛИЙН ӨМНӨ

Эвсэн нэгдэхийн учир...

УИХ-ын анхдугаар сонгууль (1992.06.28)-д ардчилсан хүчин ердөө таван суудал авч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргалцах бүү хэл сөрөг хүчин гэхэд ч түвэгтэйхэн болоод чуулганы танхимд суудлынхаа гүн хөх өнгөөр л ялгарч байв. Эл сонгуульд МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвсэл дөрөв (Да.Ганболд, С.Зориг, Ц.Элбэгдорж, М.Энхсайхан), МСДН нэг суудал (Р.Гончигдорж), бие даагч Г.Зуунай нэг суудал авч, харин МАХН 70 суудалтайгаар дийлэнх олонх болсон билээ. Ердөө хоёрхон жилийн өмнө ардчилсан хувьсгалаа тайван замаар хийж чадсан оронд сонгуулийн дүн ингэж гарсан нь гадаад дотоодод санаанд оромгүй явдал болов, “Монголд экскоммунист нам ялсан явдал ардчилал зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцад бодитой бэрхшээл учруулж магадгүй, Монголд нэг намын ноёрхол эргээд тогтлоо” гэж дүгнэж байлаа¹³³.

Сонгуульд өвдөг шороодсоны учрыг туршлагагүйдсэн, бас нэр дэвшигч олон байснаас санал хуваагдсан, ардчиллын намууд эвсэж чадаагүй, хүчээ хамтатгаагүй (МоАН-МҮДН-Нэгдсэн намын эвслээс гадна МСДН, МСМН зэрэг ардчиллын төлөө бусад нам сонгуульд бие даан оролцсон) нь хүчний харьцааг саармагжуулах, санал хуваахад нөлөөлсөн зэрэг учир шалтгаанаар тайлбарлагддаг.

1992 оны сонгуулийн дүн эвлэн нэгдэх, нэг санаа зорилгоор хүчээ нэгтгэхийн чухлыг ардчилсан хүчнийхэнд мэдрүүлсэн хийгээд эрх баригчдын зоргоор аашилж, эрээгээ барсан дөрвөн жил бүр ч нотлон харуулав.

Чухам иймээс эвсэж нэгдэхийн чухлыг ардчилагчид онцолж, МСДН-ын зүгээс эвсэхийг санаачилсан. Сонгогч

ард түмэн ч тийн шаардсан буюу өөрөөр хэлбэл, эвсэн нэгдэх нийгмийн захиалга эрхгүй ирээд байлаа гэж болно.

“Ардчилсан Холбоо” эвсэл байгуулагдлаа

УИХ-ын сонгуульд МҮАН, МСДН хамтран “Таны итгэл-Бидний зүтгэл” уриан доор “Ардчилсан Холбоо” Эвсэл (АХЭ) байгуулан оролцох болсон тухай 1996.02.15-нд тус хоёр намын удирдлага Да.Ганболд, Р.Гончигдорж нар мэдэгдэв.

Үүнээс хэдхэн хоногийн хойно Цагаан сарын шинийн нэгэн - 02.19-нд МоАХ-ны байрнаа АХЭ-ийн гэрээнд гарын үсэг зуржээ. Энэ нь XVII жарны “Баригч” хэмээх гал хулгана жилийн бэлгэт сайн өдөр байв.



Эвсэл зохион байгуулалтын асуудал хэлэлцсэнээр, МҮАН-МСДН-ын АХЭ-ийн сонгуулийн штаб байгуулагдаж, эвслийн Ерөнхий нарийн бичгийн дарга (ерөнхий менежер)-аар М.Энхсайханыг хоёр намын даргын хамтарсан тушаалаар 02.26-нд томилсон юм.

Сонгуулийн төв штабыг МҮАН, МСДН-ын гишүүдээр бүрдүүлж байгуулжээ. 03.04-нд бүтцийн асуудал хэлэлцэж, УИХ-ын сонгуулийн ажиллагааг удирдах дөрвөн алба байгуулсны гурав нь МСДН, нэг алба нь МҮАН-д ногдсон. Үүнд, Улс төрийн албаны даргаар Ш. Алтангэрэл, Мэдээлэл, сурталчилгааны албаны даргаар Н.Алтанхуяг, Санхүүгийн албаны даргаар З.Энхболд, Зохион байгуулах албаны даргаар Ц.Сайнбаяр нар ажиллажээ.

Түүнчлэн АХЭ, МоАХ-ны хамтын ажиллагааны гэрээг 02.29-нд байгуулж, МҮАН-ын тэргүүн Да.Ганболд, МСДН-ын дарга Р.Гончигдорж, МоАХ-ны дарга Ц.Элбэгдорж нар гарын үсэг зуржээ.

1996.04.13. МҮАН-МСДН-ын АХЭ-ээс УИХ-д нэр дэвшигчид тодорч, Сонгогчидтой байгуулах гэрээнд гарын үсэг зурлаа. Нэр дэвшигчдийн намтар зураг, Сонгогчидтой байгуулах гэрээг нийтэлсэн “Сайн байна уу” сонин 04.15-нд хагас сая хувь хэвлэгдэн түгэв.

Эвсэл ийнхүү байгуулагдахад холбон зуучлах үүргийг Э.Бат-Үүл, Н.Алтанхуяг нар голлон зохион байгуулсан байдаг.



МҮАН-ЫН ТЭРГҮҮНИЙ СУНГАА БОЛОВ

Бас нэг кампанит ажил улс төрийн хүрээнд явагдаж байсан нь МҮАН-ын тэргүүний сунгаа (марафон) байлаа.

1996.01.06-нд МҮАН-ын Анхдугаар их хурлын 5-р чуулганаар УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг эцэслэн тодруулж шийдвэрлэх эрхийг намын Сонгуулийн хороонд олгожээ. Намын тэргүүнд өрсөлдөхөөр нэр дэвшсэн С.Билигсайхан, Да.Ганболд, Т.Лхагваа, Б.Цэрэнбадам, Ц.Элбэгдорж нарын дунд санал хураалт, сонгон шалгаруулалт явуулж, Ц.Элбэгдорж (78.5%), Да.Ганболд (49.3%) нар хамгийн олон санал авч, МҮАН-ын тэргүүнд нэр дэвшигчээр батлагдлаа. Чуулганд 79 гишүүн хүрэлцэн ирж оролцжээ¹³⁴.

Уг сунгаа МҮАН-ын нийт хамт олны дотор, бүх анхан шатны байгууллага, үүрүүдэд болж, намын тэргүүн Да. Ганболд, намын тэргүүнд нэр дэвшин өрсөлдөхөөр тодорсон Ц. Элбэгдорж нар 21 аймаг, 3 хотоор буюу Монгол орноор хөндлөн гулд зорчиж, мөрийн хөтөлбөрөө гишүүдээрээ хэлэлцүүлжээ. Тэд марафонд өрсөлдөхдөө “Монгол орныхоо 21 аймгаар явж, “жаран ес” машины тоостой кабинд, донсолгоотой хатуу замаар наад зах нь 15 мянган км хамт давхиж, наад зах нь 120 цагийн хуралд хамт сууж, 150-аад цагийн уулзалтыг хамт хийж, 30-аад санал хураалтыг догдлон хүлээж, 100 гаруй шөнө нэг өрөөнд хонож, 300 гаруй удаа хамт хооллосон” хэмээн МҮАН-ын ахмад зүтгэлтэн Д.Аззаяа дурсжээ¹³⁵. Ерөнхийлөгчийн сонгуульд намаас нэр дэвшигчийг тодруулахаар явуулдаг америк загвараар эл сунгаа зохион байгуулагдсан ажээ.

Сунгааны дүнд Ц.Элбэгдорж 13 аймаг, нийслэлийн зургаан дүүрэгт, Да.Ганболд долоон аймагт намын бага хурлын гишүүдийн олонхийн санал авчээ.

1996.01.06-02.08-ны хооронд бүтэн сар гаруй хугацаанд үргэлжилсэн марафоноор Ц.Элбэгдорж 59.5%, Да.Ганболд 40.5%-ийн санал цуглуулсан байна.

МҮАН-ын Хоёрдугаар их хурал 04-р сарын 04-05-нд хуралдаж, сунгаанд илүү олон санал авсан Ц.Элбэгдоржийг МҮАН-ын тэргүүнээр сонгожээ.

Энэ хэр УИХ-ын сонгуулийн кампанит ажил эхэлж, (2/3нь МҮАН-аас, 1/3 нь МСДН-аас дэвшсэн) АХЭ-ийн нэр дэвшигчид тус тусын тойрогт ажиллаад эхэлсэн байв. МҮАН-ын шинэ тэргүүн Ц. Элбэгдорж Баянхонгор аймагт, тэргүүн асан Да.Ганболд Хэнтий аймагт нэр дэвшжээ.

ЭВСЛИЙН НАМУУД СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЛЭЭ

МСДН-ын 2-р их хурлын 3-р чуулган 1996.04.07-ны өдөр хуралдаж,

- МҮАН-МСДН-ын АХЭ-ийн дүрмийг батлах
- АХЭ-ийн Сонгогчидтой байгуулах гэрээг хэлэлцэх
- МСДН-ын 3-р их хурлын товыг зарлах

- АХЭ-ээс УИХ-д нэр дэвшигчдийн жагсаалтад орох МСДН-ын нэр дэвшигчдийг дэвшүүлэх тухай асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ. Үүгээр УИХ-ын сонгуульд тус намаас нэр дэвшигчдийг тодруулах бүрэн эрхийг намын УТЗ-д шилжүүлжээ.

УИХ-ын сонгуульд баримтлах үндсэн баримт бичиг “АХЭ-ээс Сонгогчидтой байгуулах гэрээ”-г 04.11-нд гаргасан юм.

Уг гэрээ баримт бичигт:

- Улс төрийн хүрээнд хийх өөрчлөлт
- Эдийн засгийн хүрээнд хийх өөрчлөлт
- Нийгмийн хүрээнд хийх өөрчлөлт
- Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого гэсэн 4 бүлэг 183 багц асуудлыг тусгасан байв.

Сонгуульд нэр дэвшигчид гэрээг сахин биелүүлэхээ илэрхийлж, гарын үсэг зурах ёслол 04.13-нд Хүүхдийн урлан бүтээх төвд боллоо. Нийт 76 нэр дэвшигчийн 50 нь МҮАН-ын, 25 нь МСДН-ын, 1 нь МНН-ын гишүүн байв.



Харин энэ үед СЕХорооноос АХЭ-ийн нэр дэвшигч Х.Баянмөнх, Д.Нармандах нарыг хуучин намын харьяаллаа албан ёсоор солиогүй байж, өөр намын нэр дээр сонгуульд оролцохоор бүртгүүлээ гэсэн шалтгаанаар нэр дэвшигчдийн жагсаалтаас хассан юм. Эвслийн намууд үүнд эсэргүүцэл илэрхийлж, 06.11-нд сонордуулга гаргажээ.

МСДН-ын 3-р их хурал 05.26-нд Төрийн ордны их танхимд болж, намын дарга Р.Гончигдоржийн улс төрийн илтгэл сонсож, МСДН-ын дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсан байна.

УИХ-ын хоёр дахь удаагийн ээлжит сонгууль 1996.06.30-нд болсон билээ.

1992-1996 оны ардчиллын түүхийг маш товчоор базан өгүүлбэл доорх мэт буюу:

1992 оны УИХ-ын сонгуулиар ардчилсан хүчний намууд ялагдаад, нэгдэж хамтрах тухай яригдсан ч хараахан нэгдэж болоогүй байна. 1993 онд Ерөнхийлөгчийн сонгуульд МҮАН, МСДН эвсэж оролцсон нь ардчилсан хүчинд ялалт авчирч, тус эвслээс нэр дэвшсэн П.Очирбат Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогджээ.

1994 онд улс төрийн нэлээд хэцүү хямралт нөхцөлд ардчилсан хүчний гишүүд улс төрийн өлсгөлөн зарлаж, улмаар зөвшилцөл байгуулан, радио телевизэд цөөн минутын нэвтрүүлэг хийх эрх чөлөө олж авсан юм. 1995 онд дараа жилийн сонгуульд бэлдэцгээгээд, 1996 онд ардчилсан хүчнийхэн эвсэл байгуулан сонгуульд оролцож ялсан дүр зураг харагддаг аа.

Ном зүй

1. Ч.Галсан 1989 оны 11 сард Монголын Сэтгүүлчдийн эвлэлийн байрнаа Залуу сэтгүүлчдийн дугуйлангийн хичээл дээр ярьсан нь. Хувийн архив.
2. Мөнхтөр Д. Бид хийхгүй бол хэн хийх вэ, одоо хийхгүй бол хэзээ хийх вэ, - Эрх чөлөөний эрэлхийлэлд (1989. XII.07-2009.XII.07). Битпресс. УБ. 2009. х. 14
3. Энхбаяр С. Ховдын цэнхэр хязгаарт бид залуу явлаа, - Эрх чөлөөний эрэлхийлэлд (1989.XII.07-2009.XII.07). Битпресс. УБ. 2009. х. 61-62
4. Эрдэнэтийн Ардчилал 20 жил (ер. ред. С. Сувдаа). ВСІ. Эрдэнэт. 2011.
5. Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ. МН Технологи. 2011.
6. Гангаа Ж. Олон тэмцэл хувьсгалаас Д.Сүхбаатартай нь ялдаг, - ӨС. №289 (2004.11.23)
7. Дэлгэртуяа Б.Үүл бид хоёр. УБ. 2010. х. 111-112
8. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С.Мэндсайхан, П.Болд). УБ. 2009. х. 10 // МСДН (эмхт. Н.Алтанхуяг). Ганпринт. УБ. 2000.
9. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С.Мэндсайхан, П.Болд). УБ. 2009. х. 33-34
10. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С.Мэндсайхан, П.Болд). УБ. 2009. х. 38-40
11. Үг.№20 (1990.11.11-20)
12. МСДН (эмхт. Н.Алтанхуяг). Ганпринт. УБ. 2000. х. 100-102


13. ШДХ-г үүсгэн байгуулагчийн нэг Ж.Баасандашийн дурсамж, - Бат-Эрдэнэ Д.Асар их үнээр бүтээсэн АРДЧИЛАЛЫН ололтоо хайрлаж яваарай. Интерпресс. УБ. 2008. х. 50
14. Бат-Эрдэнэ Д. Асар их үнээр бүтээсэн АРДЧИЛАЛЫН ололтоо хайрлаж яваарай. Интерпресс. УБ. 2008. х. 75
15. Үнэн.№35 (1990.02.10)
16. МАХН-ын ТХ-ны УТТ-ны захидал,- Үнэн.№29 (1990.02.03)
17. МоАХ-ноос Олон түмэнд зарлан мэдэгдэх нь (зар). Хувийн архив.
18. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 138
19. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С Мэндсайхан, П Болд). УБ. 2009. х. 24-29
20. Т.Отгонбаярын дурсамж,- Оюунчимэг Т. Миний хүссэн ардчилал биш... АДМОН. 2011. х. 139
21. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С Мэндсайхан, П Болд). УБ. 2009. х. 24-29
22. Т.Отгонбаярын дурсамж,- Оюунчимэг Т. Миний хүссэн ардчилал биш... АДМОН. 2011. х. 139
23. Эрдэнэ С. Үхэх амархан, амьд явах хэцүү (баримтат тууж). Битпресс. УБ. 2007.
24. Батдорж Ц: Өлсгөлөнгийн үеэр Төрийн ордныг гурав хоног хамгаалсан (ярилц. Г. Эрдэнэбат),- ӨС.№ (2008.05.27)
25. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 36

26. Эрдэнэ С. Үхэх амархан, амьд явах хэцүү (баримтат тууж). Битпресс. УБ. 2007. х. 3
27. Эрдэнэ С. Үхэх амархан, амьд явах хэцүү (баримтат тууж). Битпресс. УБ. 2007. х. 38-39
28. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 138-139
29. Хурандаа (хожмын генерал) Л. Пүрэвдоржийн дурсамж,-Эрдэнэ С. Үхэх амархан, амьд явах хэцүү (баримтат тууж). Битпресс. УБ. 2007. х. 41-42
30. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 139
31. Хүрэлжанцан Ж. Ардчиллын халуун өдрүүд. Хэвлэлийн үйлдвэр сургалтын төв. УБ. 2004. х. 57-58
32. Энхээ Ч. МоАХ МоАН (бодол эргэцүүлэл). Улсын стандарт, үнийн жагсаалт хэвлэх газар. УБ. 1991. х.
33. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 139
34. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (эмхт. П.Улаанхүү, Р.Хатанбаатар, Ц.Адъяасүрэн, С.Мэндсайхан, П.Болд). УБ. 2009. х. 76-77
35. МСДН-ын дарга Б.Батбаяр МСДН-ын 3 жилийн ойд зориулж ТВ-ээр хэлсэн үг, - Үг.№06 (1993.03.01-10)
36. Улс төрийн илтгэл (Б.Батбаяр),- МСДН-ын Анхдугаар их хурал (эмхт. П.Улаанхүү). УБ. 1990. х. 6
37. Улс төрийн илтгэл (Б.Батбаяр), - МСДН-ын Анхдугаар их хурал (эмхт. П.Улаанхүү). УБ. 1990. х. 9
38. Майдар Ц. Нэн шинэхэн түүх. Зураг зүйн үйлдвэр. УБ. 1991. х. 20
39. МҮДН-ын Анхдугаар их хурал. Фото офсет хэвлэлийн газар. УБ. 1990. х. 1

40. МҮДН-ын Анхдугаар их хурал. Фото офсет хэвлэлийн газар. УБ. 1990. х. 21
41. МҮДН-ын Анхдугаар их хурал. Фото офсет хэвлэлийн газар. УБ. 1990. х. 21
42. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998.
43. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 147
44. Оюунчимэг Т. Миний хүссэн ардчилал биш... АДМОН. 2011. х. 33
45. Майдар Ц. Нэн шинэхэн түүх. Зураг зүйн үйлдвэр. УБ. 1991. х. 21
46. Чилхаажав Д. Хөвсгөлийн улс төрийн өлсгөлөн ба түүний улс төрийн үр дагавар,- ӨС.№103 . 2010.05.01)
47. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 59
48. Хүрэлжанцан Ж. Ардчиллын халуун өдрүүд. Хэвлэлийн үйлдвэр сургалтын төв. УБ. 2004. х. 88
49. Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ. МН Технологи. 2011. х. 225
50. Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ. МН Технологи. 2011. х. 229
51. Хүрэлжанцан Ж. Ардчиллын халуун өдрүүд. Хэвлэлийн үйлдвэр сургалтын төв. УБ. 2004. х. 88
52. Баабар. МАХН-ын түүхэн улаан замнал, - ӨС.№59 (2003.03.12)
53. Уулзалтын тэмдэглэл-ээс, - Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 343-349
54. Самбар (МОХ-ны чөлөөт хэвлэл). №8(1990.VIII сар)
55. Майдар Ц. Нэн шинэхэн түүх. Зураг зүйн үйлдвэр. УБ.

1991. х. 39
56. 119 Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 84-85
57. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 366
58. Дождоодорж Д. Арван халуун өдөр. "Хөдөлмөр" сонины газар. УБ. 1990. х. 46-51
59. Лүндээжанцан Д. Хэзээ ч бүү шантар. АМОН. 2010. х. 115-116
60. З.Билгээ. "Хүнтэй сууж байгаагүй" Д.Дорлигжав,- ӨС.№222 (2005.09.15)
61. Майдар Ц. Нэн шинэхэн түүх. Зураг зүйн үйлдвэр. УБ. 1991. х. 44
62. Хувийн архив.
63. ӨС. №224 (2004.09.10) // Улаанхүү П.Октябрийн баярын тухайд,- Үг.№20 (1990.11.11-20)
64. Дурсамж яриа,- Хувийн архив.
65. БААБАР үргэлжлүүлэн ингэж өгүүлэв (Зөн билгийн тулаан). НЕРКО. УБ. 2011. х. 175-176
66. АЭ.№88 (1991.04.17)
67. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 109
68. АЭ.№13 (1992.01.18)
69. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 110
70. АЭ.№19 (1992.01.25)
71. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. УБ. 1998. х. 129 //
72. г.№22 (1991.08.31)

73. Үг.№10 (1992.05.04)
74. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. Уб. 1998. х. 106
75. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 233
76. Баабар. Ерөнхий сайд нар,- ӨС.№266 (2009.11.04)
77. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. Уб. 1998. х. 102
78. Үг.№13 (1991.04.09-16)
79. Зориг Ц. Сүүлчийн долоон жил (эцгийн тухай тэмдэглэл) (орч. У.Амарсайхан). Шувуун саарал. Уб. 1993. х. 140
80. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996). Интерпресс. Уб. 1998. х. 97
81. Лүндээжанцан Д. Хэзээ ч бүү шантар. ADMON. 2010. х. 161
82. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 164
83. Төмөр С: Үндсэн хуулийг батлахад АИХ-ын дарга хүртэл хурал хаяж байлаа (ярилц. Г.Отгонбаяр),- ӨС.№09 (2000.01.11)
84. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 164
85. Ардчилсан намын 20 жилийн түүхэн товчоон (1989-2009). (эмхт. Ч.Цэрэнчимэд). Ганпринт. Уб. 2010. х. 41
86. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 166
87. Баярцогт С: Бага хурал хамгийн ажилсаг парламент байсан (тэмд. Д.Цолмон), - ӨС.№221 (2008.09.13)
88. Лүндээжанцан Д. Хэзээ ч бүү шантар. ADMON. 2010. х. 126
89. Элбэгдорж Ц. Манай ангийнхан,- Сайн байна уу.(1996.04.26), ӨС.№219 (2005.09.12)
90. Жанцан Н: Ардчилсан Үндсэн хуулийг батлах нь УБХ-

- ын хамгийн гол зорилт байсан юм (ярилц. Д. Уран),
- ӨС.№008 (2009.01.13)
91. Үндсэн хууль-ардчиллын баталгаа (ярилц. Д.Чимэгсайхан),- Үг.№2 (1992.01.20)
 92. Элбэгдорж Ц: Цахиагийн Элбэгдорж алтан хараацай мөн үү (ярилц. Т.Баасансүрэн),-Төрийн түшээ гэж хэн бэ? УБ. 2010. х. 46
 93. 1993.01.12-нд УИХ-ын ёслолын хуралдаан дээр МСДН-ын дарга Б.Батбаярын хэлсэн үг,-
 94. Үг.№11 (1991.03.24-31)
 95. Үг.№32 (1991.12.01-10)
 96. Лүндээжанцан Д. Хэзээ ч бүү шантар. ADMON. 2010. х. 173
 97. Дэлгэрмаа Б: Улс төрийн хог гялгар уутнаас ч аюултай (ярилц Л.Мөнхбаясгалан),-ӨС.№108 (2008.05.05)
 98. Баабар. Сонгууль,- БААБАР үргэлжлүүлэн ингэж өгүүлэв (Зөн билгийн тулаан). NEPKO. УБ. 2011. х. 248
 99. Баабар. Сонгууль,- БААБАР үргэлжлүүлэн ингэж өгүүлэв (Зөн билгийн тулаан). NEPKO. УБ. 2011. х. 248
 100. ӨС.№16 (2009.07.01) // baabar. niitelch. mn
 101. Ханнам П. Ивээн тэтгэгчид нь орхиод явжээ...,- Үг.№33 (1992.12.04)
 102. Хувийн архив.
 103. АН-ын архив. МСДН-ын 2-р их хурлын чуулганы хурлын протокол. х. 14
 104. АН-ын архив. МСДН-ын 2-р их хурлын чуулганы хурлын протокол. х. 20
 105. Бат-Эрдэнэ Д. Асар их үнээр бүтээсэн АРДЧИЛАЛЫН ололтоо хайрлаж яваарай. Интерпресс. УБ. 2008.х. 70
 106. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл. Интерпресс.
- 

- Уб. 1998. х.157
107. Үг.№5 (1993.II.20-28)
108. 1993.01.12-нд УИХ-ын ёслолын хуралдаан дээр МСДН-ын дарга Б.Батбаярын хэлсэн үг,- Үг.№02 (1993.01.11-20)
109. Үг.№06 (1993.03.01-10)
110. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. х. 15
111. Очирбат П. Тэнгэрийн цаг. The Bath press. L. 1996. р. 370
112. Ганбаатар А: Парламентын гишүүд нь улс төрч байх ёстой (ярилцлага),- Үг.№21 (1993.09.01-10)
113. Баярмагнай Б. 58 гишүүдээс 45 нь татгалзав,- Үг.№28 (1993.10.21-31)
114. Үг.№07 (1994.03.01-10)
115. Гончигдорж Р: Хамтарсан сөрөг хүчин болж ажиллана (ярилц. С.Идшинноров),- Үг.№28 (1993.10.21-31)
116. Үг.№30 (1993.11.01-10)
117. МСДН: цуврал эмхтгэл. Ганпринт. Уб. 2000. х. 50
118. Л.Санжаасүрэнгийн мэдэгдэл (дуу хураагуурын хальснаас сийрүүлсэн С.Идшинноров),- Үг.№03 (1994.01.20-30)
119. Бямбажаргал Л: УИХ-ын гишүүд ардчиллын наад захын ойлголтгүй хүмүүс (ярилц. Х.Бат-Эрдэнэ),- Үг.№06 (1994.02.21-28)
120. Ардчилсан намын 20 жилийн түүхэн товчоон (1989-2009) (эмхт. Ч.Цэрэнчимэд). Ганпринт. Уб. 2010. х.50
121. АЭ.№74 (1994.04.16)
122. Гончигдорж Р: МАХН С.Зоригийн хэргийг хурдан илрээсэй гэсэн олон түмний хүсэн хүлээсэн сэтгэлээр нь тоглосон (ярилц. Ж.Отгондаваа),- Дээдсийн амьдрал.

№01-02 (2001)

123. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).
Интерпресс. Уб. 1998. х. 189
124. АЭ.№76-77 (1994.04.21)
125. Н.Алтанхуягийн өдрийн тэмдэглэл-ээс. Хувийн архив.
126. Н.Алтанхуягийн өдрийн тэмдэглэл-ээс. Хувийн архив.
127. Түншлэлийн гэрээ (орчуулгын эх), - Үг.№2-3 (1995)
128. Түншлэлийн гэрээний Хавсралт, - Үг.№8 (1995)
129. МСДН: цуврал эмхтгэл №1. Ганпринт. Уб. 2000. х.
137// Ардчилсан намын 20 жилийн түүхэн товчоон
(1989-2009) (эмхт. Ч.Цэрэнчимэд). Ганпринт. Уб. 2010.
х.53
- 130.Хэвлэлийн бага хурлын тэмдэглэл,- Үг.№20 (1995)
131. АЭ.№132 (1995.07.06)
132. АЭ.№№132 (1995.07.06)
133. Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1996-2000).
Интерпресс. Уб. 1998. х.151-152
- 134.Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1996-2000).
Интерпресс. Уб. 1998. х. 221
135. Аззаяа Д. АН-ыг 2008 оны сонгуульд хэн бэлтгэх вэ, -
ӨС.№69 (2006.03.21)

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	3
ЗАЛУУ УРАН БҮТЭЭЛЧДИЙН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНӨӨР...	6
ХОВДЫН БАГШИЙН ДЭЭДИЙНХЭН ЖАГССАН НЬ...	8
МОАХ-НЫ АНХНЫ ЦУГЛААН - 1989.12.10	12
МОАХ УЛАМ ӨРГӨЖСӨӨР...	16
АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ХӨДӨЛГӨӨН..., ШДХ	21
ГУРАВ ДАХЬ ЦУГЛААНАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА	29
МОАХ-НЫ АНХДУГААР ИХ ХУРАЛ	34
АРДЧИЛСАН ХҮЧНҮҮДИЙН ЭВСЭЛ	44
03.04-НИЙ СҮРТ ЖАГСААЛ ЦУГЛААН	46
УЛС ТӨРИЙН ӨЛСГӨЛӨН ЗАРЛАЖ ТЭМЦЭВ	50
УЛС ТӨРИЙН ЭРГЭН ТОЙРОНД (1990)	62
АИХ-ЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНААР...	68
МСДН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ	72
МОАН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ	77
МҮДН-ЫН АНХДУГААР ИХ ХУРАЛ БОЛОВ	81
МӨРГӨЛДӨӨН ГАРЧ МЭДЭХ БАЙДАЛ ҮҮССЭН IV САР (ХӨВСГӨЛЧҮҮДИЙН) ТЭМЦЛИЙГ НУХЧИН ДАРАХ ГЭЭД...	84 88
АНХНЫ АРДЧИЛСАН СОНГУУЛЬ (1990)	100
ШИНЭ АИХ-ЫН ЧУУЛГАН ХУРАЛДЛАА	118
УЛСЫН БАГА ХУРАЛ	127
АРДЧИЛСАН ХҮЧИН ЭВСЛИЙН ГЭРЭЭГЭЭ ДҮГНЭВ	132
УБХ-ЫН ХУУЛЬ ТОГТООХ АЖЛЫН ГАРАА	134
Д.БЯМБАСҮРЭНГИЙН ЭВСЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР	136
ЗАСГИЙН ГАЗАРТ ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭСЭХИЙГ ХЭЛЭЛЦЭВ	141
УЛС ТӨРИЙН ЭРГЭН ТОЙРОНД (1990-1991)	146

АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛИЙГ БАТАЛЛАА (1992.01.13)	156
НАМ ХҮЧНҮҮДИЙН НЭГДЭЛ... ШИНЭ НАМУУД	164
МСДН СОЦИАЛИСТ ИНТЕРНАЦИОНАЛД ЭЛСЛЭЭ	170
УИХ-ЫН АНХНЫ СОНГУУЛЬ (1992)	172
ШИНЭ ЗАСГИЙН ГАЗРЫГ П.ЖАСРАЙ ТЭРГҮҮЛЛЭЭ	180
НАМУУДЫН НЭГДЭЛ... МҮАН	183
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИАР (1992)	187
ЭРХ БАРИГЧИД ОЛОНХООРОО ТҮРЭЭ БАРЬСААР...	199
УЛС ТӨРИЙН ТЭМЦЭЛ ШИРҮҮССЭН НЬ (1994)	206
ЭРХ БАРИГЧДЫН ЭЭЛЖИТ БУЛХАЙ... АЙБЕКС, МОЛАМ	225
НАМУУДЫН ЭРГЭН ТОЙРОНД...	232
УИХ-ЫН СОНГУУЛИЙН ӨМНӨ	235
МҮАН-ЫН ТЭРГҮҮНИЙ СУНГАА БОЛОВ	238
НОМ ЗҮЙ	242

